



ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ХҮРЭЭЛЭН

*Энэхүү судалгааны тайланг
зөвхөн албан хэрэгцээнд зориулав.*

“БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ”

КРИМИНОЛОГИ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2019

*Энэхүү судалгааны тайланг
зөвхөн албан хэрэгцээнд зориулав.*

“БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ” КРИМИНОЛОГИ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Захиалагч:

Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл

Гүйцэтгэгч:

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн

“Судлаач хуульчдыг дэмжих эрдэмтэн сан” ТББ

Дотоод хэргийн их сургуулийн Хэвлэх үйлдвэрт хэвлэв.

Хэвлэсэн тоо: 4 хувь

АГУУЛГА

Оршил	3
Бүлэг 1. Судалгааны арга зүй	5
Бүлэг 2. Баянзүрх дүүргийн гэмт хэрэг, зөрчлийн чиг хандлагад хийсэн дүн шинжилгээ судалгааны дэд тайлан	9
Бүлэг 3. “Баянзүрх дүүргийн оршин суугчид болон тодорхой бүлгүүдээс санал асуулгын аргаар авсан социологийн судалгаа”-ны дэд тайлан	31
Бүлэг 4. “Баянзүрх дүүргийн 5-р хорооны гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл” криминологийн судалгааны дэд тайлан	85
Бүлэг 5. “Баянзүрх дүүргийн 7-р хорооны гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл” криминологийн судалгааны дэд тайлан	136
Бүлэг 6. “Баянзүрх дүүргийн 20-р хорооны гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл” криминологийн судалгааны дэд тайлан	185
Бүлэг 7. “Баянзүрх дүүргийн 8-р хорооны зам тээврийн ослын шалтгаан, нөхцөл” криминологийн судалгааны дэд тайлан	244
Бүлэг 8. “Баянзүрх дүүргийн хэмжээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилт” судалгааны дэд тайлан	263
Бүлэг 9. “Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны гамшгийн эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг бууруулах” судалгааны дэд тайлан	287
Бүлэг 10. “Аюулгүй хот, дүүрэг болох шалгуур үзүүлэлт, индекс, аргачлалыг бий болгох” судалгааны дэд тайлан	301
Нэгдсэн зөвлөмж	318

ОРШИЛ

Дотоод хэргийн их сургууль өнөөдөр Цагдаагийн сургууль, Хилийн сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль, Онцгой байдлын сургууль, Эрх зүй, нийгмийн ухааны сургууль, Ахлагчийн сургууль, Ахисан шатны боловсролын сургууль, Удирдлагын академи, Шинжлэн магадлахуйн институт, Ерөнхий боловсролын ахлах сургууль гэсэн бүрэлдэхүүн 10 сургууль, Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн, Сургалтын бодлого, төлөвлөлтийн газар, Мэдээлэл технологи, хөгжлийн газар, Цэргийн албаны зохион байгуулалт, аюулгүй байдлын газар, Хангамж, үйлчилгээний газар, бусад алба, нэгжийн дэмжлэгтэйгээр мэргэжлийн боловсрол, бакалавр, магистр, докторын шаталсан сургалтын хэлбэрээр, 50 гаруй хөтөлбөрийг хэрэгжүүлж, судалгааны тэргүүлэх 30 орчим чиглэлээр эрдэм шинжилгээний үйл ажиллагаа явуулж байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Дотоод хэргийн их сургууль нь олон улсын их сургуулийн хөгжлийн жишгийн дагуу “Судалгааны их сургууль” хэлбэрээр хөгжих зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Уг зорилтын хүрээнд удирдлага, зохион байгуулалт, менежмент, эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт, технологи, инновацийн чиглэлээр аюулгүй байдал, дотоод хэрэг, хууль зүйн салбарт тулгамдсан асуудлыг шинжлэх ухааны арга зүйгээр судалж, түүнийг шийдвэрлэх гарцыг хөгжлийн стратеги, бодлого, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд нэвтрүүлэхэд анхааран ажиллаж ирлээ.

Дотоод хэргийн их сургууль Аюулгүй байдал, Гэмт явдал, Цагдаа судлал, Хил судлал, Шийдвэр гүйцэтгэл судлал, Шинжлэн магадлахуй судлал, Гамшиг судлал, Инноваци, Хууль, эрх зүйн чиглэлийн 8 судалгааны тэргүүлэх чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэж, эдгээр салбар судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж байна.

Гэмт явдал судлалын судалгааны тэргүүлэх чиглэлийн хүрээнд онол, арга зүйг судлан, тогтолцоо, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр сүүлийн 10 жилд эрчимтэй ажиллаж байна. Тухайлбал, Монгол Улсын төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогын баримт бичгийг боловсруулан, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүлсэн. Улмаар олон жилийн судалгааны үр дүнд орчин үеийн криминологийн шинжлэх ухааны хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төслийг боловсруулахад оролцож, батлуулсан.

Түүнчлэн, нутаг дэвсгэрийн эрүүгийн нөхцөл байдлыг судлах зорилгоор Баянгол, Сонгинохайрхан, Багануур дүүрэг, Хэнтий, Өвөрхангай аймгийн ИТХ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран тухайн нутаг дэвсгэрийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлах криминологи судалгааны ажлыг хийж, уг судалгааны үр дүнг үндэслэн гэмт явдалтай тэмцэх бодлого, үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлж байгаа нь үр дүнгээ өгч байна.

Энэ жишгийн дагуу Баянзүрх дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн газрын санаачилга, захиалгаар тус дүүргийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл, нөлөөлж байгаа хүчин зүйлийг шинжлэх ухааны үндэстэйгээр судалж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар санал, зөвлөмж боловсруулж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тодорхойллоо.

Цаашид Баянзүрх дүүргийг хөгжүүлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт явдалтай тэмцэх, гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэхэд Дотоод хэргийн их сургууль холбогдох байгууллагатай нягт хамтран ажиллах болно.

Дотоод хэргийн их сургуулийн эрдэмтэн, судлаач нарын “Судлаач хуульчдыг дэмжих эрдэмтэн сан” ТББ-тай хамтран гүйцэтгэсэн “Баянзүрх дүүргийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл” сэдэвт криминологи судалгааны үр дүн, санал, зөвлөмж бодит ажил хэрэг болж, амьдрал практикт үр дүнгээ өгнө гэдэгт итгэлтэй байна.

СУДАЛГААНЫ БАГИЙН АХЛАГЧ:

ДХИС-ИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ ЭРХЭЛСЭН ДЭД БӨГӨӨД ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ, ХУУЛЬ ЗҮЙН
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.БАТ-ЭРДЭНЭ

БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

1.1. Судалгааны ажлын хэрэгцээ, шаардлага

Гэмт явдалтай тэмцэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах асуудал төрийн бодлогын үндсэн чиглэл билээ. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг боловсруулахад, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, холбогдох албан тушаалтнаас аливаа бодлого, шийдвэр гаргахдаа шинжлэх ухаан, судалгаанд суурилж байна. Энэ ч үүднээс гэмт явдалтай тэмцэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт явдлаас урьдчилан сэргийлэх асуудалд төрөөс нэгдсэн бодлого, үзэл баримтлалаар хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Гэмт явдалтай төрөөс тэмцэх нэгдсэн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж байна.

Төрийн нэгдсэн бодлогод уялдуулан тодорхой нутаг дэвсгэрийн гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг нарийвчлан судалж, тухайн орон нутагт тохирсон бодлого, үйл ажиллагаанд судалгаанд тулгуурлан явуулах хэрэгцээ, шаардлага сүүлийн үед криминологийн шинжлэх ухааныг даган бий болж, практикт нэвтрээд байна.

Тухайлбал, нутаг дэвсгэрийн эрүүгийн нөхцөл байдлыг судлах зорилгоор Баянгол, Сонгинохайрхан, Багануур дүүрэг, Хэнтий, Өвөрхангай аймгийн ИТХ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл тухайн нутаг дэвсгэрийнхээ гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлах криминологи судалгааны ажлыг мэргэжлийн багаар хийлгүүлж, уг судалгааны үр дүнг үндэслэн гэмт явдалтай тэмцэх бодлого, үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлж байгаа нь үр дүнгээ өгч байна.

Энэ жишгийн дагуу Баянзүрх дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн газрын санаачилга, захиалгаар тус дүүргийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл, нөлөөлж байгаа хүчин зүйлийг шинжлэх ухааны үндэстэйгээр судалж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар санал, зөвлөмж боловсруулж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тодорхойлох судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

1.2. Судалгааны зорилго, зорилт

Зорилго: Монгол Улсын Их хурлаас эрх зүйн шинэтгэлийн хүрээнд суурь хуулиуд шинэчлэн батлагдсантай холбогдуулж, Баянзүрх дүүргийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл, нөлөөлөх хүчин зүйлс, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны өнөөгийн байдлыг криминологи, математик статистикийн шинжлэх ухааны үүднээс үнэлж, дүгнэн цаашид орон нутгийн хэмжээнд шинжлэх ухааны үр дүнд суурилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд судалгааны зорилго оршино.

Зорилт:

1. Баянзүрх дүүргийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлах, үйлдэгдсэн байдалд дүн шинжилгээ хийж, чиг хандлагыг тодорхойлох;
2. Баянзүрх дүүргийн хэмжээнд үйлдэгддэг үзүүлэлт өндөртэй, онцлог гэмт хэрэг, зөрчилд дүн шинжилгээ хийх;
3. Баянзүрх дүүргийн байгаль цаг уур, нийгэм-эдийн засаг, хүн ам зүйн өнөөгийн байдал хандлагыг гэмт хэргийн тоон үзүүлэлттэй харьцуулж бодит байдлыг тодорхойлох;
4. Баянзүрх дүүргийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, түүний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх;
5. Баянзүрх дүүргийн Цагдаагийн газар, Прокурор, Шүүх, ШШГА, ОБХ, ШША зэрэг байгууллагын үйл ажиллагааг судалж, дүн шинжилгээ хийх;
6. Судалгааны ажлын явцад анкетаар судалгаа авах болон ярилцлага хийх, газар дээр нь ажиглалт хийх;

7. Зөвлөмж тусгасан судалгааны тайлан бичиж захиалагчид хүлээлгэж өгөх;

1.3. Судалгааны арга зүй

Энэхүү ажлыг хийж гүйцэтгэхэд судалгааны дараах түгээмэл аргуудыг хэрэглэв. Ялангуяа тоон болон чанарын судалгааны аргыг хэрэглэсэн. Үүнд: Математик статистикийн шинжилгээ; Бодлого, үйл ажиллагаа, эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх; Харьцуулалт хийх; Баримт бичгийн судалгаа; анкет судалгаа явуулж, үр дүнг SPSS.21 программаар боловсруулав.

Дүүргийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн бодлого, үйл ажиллагаанд харьцуулалт хийх, нэгтгэн дүгнэх, холбогдох баримт бичигт дүн шинжилгээ хийх арга зүйг хэрэглэлээ.

1.4. Гүйцэтгэгч:

Судалгааны багийн ахлагч:

ДХИС-ийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд бөгөөд Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал, хууль зүйн доктор (Ph.D), профессор, цагдаагийн хурандаа Б.Бат-Эрдэнэ;

Судалгааны багийн гишүүдэд:

1. Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Гэмт явдал, Цагдаа судлалын хүрээлэнгийн эрхлэгч, доктор (Ph.D), цагдаагийн хошууч Б.Мөнхдорж, эрдэм шинжилгээний ахлах ажилтан-багш, цагдаагийн хошууч Г.Бямбадорж, эрдэм шинжилгээний ажилтан Б.Мөнхсэргэлэн, цагдаагийн дэслэгч Б.Билгүүн,
2. Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Инновацийн төвийн эрхлэгч, доктор (Ph.D), цагдаагийн хурандаа Т.Очирбат, эрдэм шинжилгээний ажилтан, цагдаагийн ахлах дэслэгч О.Уулзахжаргал, дэслэгч Б.Ганзагас,
3. Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч, доктор (Ph.D), хурандаа, дэд профессор Б.Алтангэрэл,
4. Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шинжлэн магадлахуй судлалын төвийн эрхлэгч, доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа Б.Даваа, эрдэм шинжилгээний ажилтан, цагдаагийн хошууч О.Одонтуяа,
5. Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Гамшиг судлалын төвийн эрхлэгч, доктор (Ph.D), хошууч Н.Батсайхан, эрдэм шинжилгээний ажилтан, хошууч Б.Золжаргал,
6. Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, цагдаагийн хурандаа А.Амарсайхан, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа Б.Баянмөнх, багш, цагдаагийн хошууч Д.Бямбахүү, Замын цагдаагийн тэнхимийн эрхлэгч, цагдаагийн хурандаа Б.Мөнхбаяр, Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн багш, цагдаагийн ахмад Б.Батцэрэн,
7. Онцгой байдлын сургуулийн Гамшгаас хамгаалах албаны тэнхимийн ахлах багш, хошууч Ц.Ганчимэг,
8. Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч Д.Бадамцэцэг, Эрх зүй нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн дэслэгч К.Ариунзул,
9. Зөвлөхөөр “Судлаач хуульчдыг дэмжих эрдэмтэн сан” ТББ-ын Гүйцэтгэх захирал, хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор М.Эрдэнэбаяр нар ажилласан болно.

1.5. Санхүүжилт

Энэхүү судалгааны ажлыг Баянзүрх дүүргийн ГХУСАЗСЗ-ийн санхүүжилтээр гүйцэтгэв.

1.6. Судалгаа явуулахад баримтлах зарчим:

• Судалгааг шинжлэх ухаан, криминологийн онолд суурилан практикт чиглэсэн байдлаар гүйцэтгэх;

- Судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон бодит байдалд үндэслэх;
- Захиалагч талын эрэлт, хэрэгцээ, шаардлагыг хангахуйц хэмжээнд судалгааг явуулж, тайланг бэлтгэх;
- Судалгааг аливаа улс төр, намын байгууллага, албан тушаалтны бодлого, нөлөөллөөс ангид хараат бусаар, бие даасан байдлаар гүйцэтгэх;
- Судалгааны баг нэгдмэл удирдлагыг баримталж, багийн ахлагч судалгааны үр дүнг хариуцна.

1.7. Судалгааны хязгаарлалт, шинэлэг тал

Судалгааны хязгаарлалт:

Судалгааны ажлын хамрах хүрээ, цаг хугацаа нь Баянзүрх дүүргийн хэмжээнд болон 5, 7, 20-р хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн хөдөлгөөнийг гаргахын тулд сүүлийн 5 жилийн статистикийн мэдээлэл, судалгааг ашигласан ба судалгааны зарим хэсэгт нөхцөл байдлыг тодруулах үүднээс сүүлийн 3-5 жил, 2018, 2019 оны жилийн эцсийн байдлаар гарсан мэдээллийг ашиглав.

Нөхцөл байдлын судалгааг тухайн үеийн цаг хугацаагаар тооцоолсон бөгөөд судалгааны хамрах хүрээ нь Баянзүрх дүүргийн 5, 7, 20-р хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд явагдав.

Монгол Улс, дүүргүүдийн нутаг дэвсгэрт сүүлийн 3 жилд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осол төдийгүй өргөдөл, гомдол, мэдээллийн бүртгэл, шийдвэрлэлтийг авч үзэн Баянзүрх дүүргийн хэмжээнд үйлдэгдэж болзошгүй гэмт хэргийн хандлага, прогнозыг дүгнэв.

Судалгааны шинэлэг тал:

Судалгааны ажлын хүрээнд боловсруулсан санал, зөвлөмж нь Баянзүрх дүүргийн хэмжээнд иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад чиглэсэн баримт бичиг болгон ашиглах бүрэн боломжтой;

Дүүргийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах, цаашид бусад дүүргийн ГХУСАЗСЗ-дэд жишиг туршлага болоход судалгааны шинэлэг тал тодорхойлогдоно.

1.8. Тайлангийн бүтэц, агуулга

Энэ судалгааны тайлан нь оршил, 10 дэд тайлан, нэгдсэн зөвлөмж зэргээс бүрдэнэ.

БҮЛЭГ 2. “БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ЧИГ ХАНДЛАГАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ” СУДАЛГААНЫ ДЭД ТАЙЛАН

Судалгааны дэд баг:

Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Гэмт явдал, Цагдаа судлалын хүрээлэнгийн эрхлэгч, доктор (Ph.D), цагдаагийн хошууч Б.Мөнхдорж, эрдэм шинжилгээний ажилтан Б.Мөнхсэргэлэн, цагдаагийн дэслэгч Б.Билгүүн, магистрант Б.Туяацэцэг, Б.Энхтуяа нар гүйцэтгэсэн болно.

2.1. Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэр, нийгэм, хүн ам зүйн онцлог

Баянзүрх дүүрэг 124.4 мянган га газар нутагтай, 2019 оны 1 дүгээр сарын 01-ны байдлаар 343619 хүн ам, 95714 өрхтэй¹. 28 хороотой. Нийслэл хотын хамгийн том дүүрэг юм.

Богд Хан уулын Бага тэнгэр, Богино Хүрхрээ, Чулуут, Бумбат, Залаат, Төр хурахын ам, Хар усан тохой зэрэг ан амьтан, цэцэг жимс, ой мод, рашаан ус, эмийн ургамал бүхий үзэсгэлэнт байгальтай.

Зураг 2.1. Баянзүрх дүүргийн газрын зураг



Баянзүрх дүүргийн онцлог:

1. Бусад дүүргээс нутаг дэвсгэрийн хувьд том.
2. Хүн ам хамгийн ихтэй дүүрэг.
3. Дүүргийн нутаг дэвсгэрт 4700 гаруй аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулдаг.
4. Ялангуяа худалдаа, үйлчилгээний чиглэлийн аж ахуйн нэгж ихээр байдаг. Тухайлбал, “Нарантуул” ОУХТөв, түүний “Өргөтгөл”, “Өгөөмөр”, “Авто эхспо” зэрэг техникийн захууд, Шөнийн зах, Сандэй, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Дүнжингарав, ВСВ,


Номин худалдааны төв, Баянзүрх худалдааны төв, Баянзүрх зах, Цайз модны зах, Сэлэнгэ зах, Хас маркет, Миний дэлгүүр, Норжин, Жуков худалдааны төв, Сансар худалдааны төв, Сансар шинэ зах, Имарт, Хоме плаза, Амгалан зах, Да хүрээ, Тэнгэр плаза зэрэг хүн ам олноор үйлчлүүлдэг худалдааны төвүүдтэй. Жишээ нь: Нарантуул ОУХ төвөөр өдөрт дунджаар 150-200 мянга орчим хүн, 40-50 мянга орчим автомашин үйлчлүүлдэг ба олон нийтийг хамарсан баяр, амралтын үеэр энэ тоо 2 дахин өсдөг судалгаа байна.

¹ Баянзүрх дүүргийн статистикийн хэлтэс “Хүн ам, өрхийн танилцуулга-2018” <http://ubstat.mn/Report>

Хүн ам зүйн онцлог

Баянзүрх дүүрэгт 2019 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар 95714 өрхийн 343619 хүн байнга оршин сууж байгаагийн 166363 эрэгтэй (48.4%), 177256 эмэгтэй (51.6%) байна.

График 2.1. Хүн ам, өрхийн тоо (хороогоор)



2018 оны жилийн эцсийн байлаар дүүргийн нийт өрхийн 45.8% нь орон сууцны хороололд үлдсэн **54.2% нь гэр хороололд амьдарч байна.**

Мөн 43500 (44.3%) нь нийтийн орон сууцанд, 632 (0.7%) нь бие даасан тохилог сууцанд, 24616 (25.7%) нь сууцны тусдаа байшинд, 26958 (28.2%) нь монгол гэрт амьдарч байна.

График 2.2. Хүн амын амьдарч буй орон сууц






График 2.3. Орон сууцны хэлбэр



2018 онд эдийн засгийн идэвхтэй хүн ам 151710 байгаагаас 140347 (92.5%) нь ажиллагчид, 11363 (7.5%) нь бүртгэлгүй болон бүртгэлтэй ажилгүй иргэд эзэлж байна.

График 2.4. Эдийн засгийн идэвхтэй хүн ам



Энэ нь 10 хүн тутмын ойролцоогоор 5 нь ямар нэгэн ажил эрхэлдэг хүмүүс үлдсэн хувь нь эдийн засгийн идэвхгүй, эсвэл ажилгүй хүмүүс байна.

2018 оны байдлаар хүн ам зүйн ачаалал 53.3%

Тайлбар: Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээгдэгчийн тоо (15-аас доош, 65 ба түүнээс дээш насны хүн амын тоо) буюу хөдөлмөрийн бус насны хүн амын нийгэмд үзүүлж буй ачааллыг хүн амын насны бүлгийн бүтцээр илэрхийлнэ.

2.2. Баянзүрх дүүргийн гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ

Баянзүрх дүүргийн суурийн хүн амын 28 жилийн динамикийг дараах графикаар дүрслэн үзүүлж, дүгнэлт хийв.

График 2.5. Баянзүрх дүүргийн суурин хүн амын өсөлт




Баянзүрх дүүргийн хүн ам 1991 оноос 2018 он хүртлэх хугацаанд 4.1 дахин, 1999 оноос 2.3 дахин өсчээ.

Сүүлийн 3 жилд дундажаар 7.7 мянган хүн амаар нэмэгдэж иржээ.

2018 оны байдлаар Монгол Улсын хэмжээний суурин хүн амын 10.9%, нийслэлийн суурин хүн амын 23.8% нь Баянзүрх дүүрэгт бүртгэлтэй байна.

Баянзүрх дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн сүүлийн 28 жилийн хөдөлгөөнийг дараах графикт дүрслэн үзүүлэв.

График 2.6. Баянзүрх дүүрэгт бүртгэгдсэн гэмт хэргийн хөдөлгөөн



Баянзүрх дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг 1991 оноос 2018 он хүртэл 13.9 дахин өсчээ. Харин 2019 онд өмнөх оны түвшингээс 27.3%-иар, 2017 оны түвшингээс 8.0%-иар тус тус буурсан байна.

Гэмт хэргийн гаралтын өсөлт, бууралтыг хүн амын өсөлт болон бусад хүчин зүйлсээс, нөгөө талаас эрүүгийн хууль тогтоомжийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна гэж үзэж болно.


Гэмт хэргийн гаралтын улсын хэмжээний 20.8%, нийслэлийн хэмжээний 29.3% нь Баянзүрх дүүрэгт бүртгэгдсэн байна.

Суурин хүн амын өсөлт, гэмт хэргийн гаралтын байдлаас харьцуулан дүн шинжилгээ хийж үзэхэд Баянзүрх дүүрэгт 343 мянган хүн ам бус, 656 мянган орчим хүн амьдардаг, ажилладаг байх магадлалтай байна.

Хүн амын байнгын өсөлт нь улс орны нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, нийслэл, дүүргийн хөгжлийн хөгжлийн асуудалтай холбон үзэх нь дамжиггүй юм.

Зураг 2.2. Баянзүрх дүүргийн 2018 оны гэмт хэргийн гаралт

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 2018 ОНЫ ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТ



Монгол Улсын Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн 20.8% нь, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 29.3% нь Баянзүрх дүүрэгт бүртгэгджээ.

Монгол Улсын Прокурорын байгууллагаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан эрүүгийн хэргийн 21.1% нь, нийслэлийн хэмжээнд прокурорын байгууллагаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан эрүүгийн хэргийн 27.8% нь Баянзүрх дүүрэгт байна.

Монгол Улсын Шүүхээс хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн 13.8% нь, нийслэлийн хэмжээнд шүүхээс хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн 26.0% нь Баянзүрх дүүрэгт байна.

Дээрх нөхцөл байдал, ачаалал, эзлэх хувиас хамааран гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах төсөв, хөрөнгийг хуваарилах, орон тоо, хүн хүчийг тэнцвэртэй болгох шаардлага байгаа нь харагдаж байна.

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 2019 ОНЫ ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТ




График 2.7. Баянзүрх дүүргийн 2019 оны гэмт хэргийн гаралт

Монгол Улсын Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн 20.8% нь, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 29.3% нь Баянзүрх дүүрэгт бүртгэгджээ.


Гэмт хэргийн түвшин

Гэмт явдлын түвшин гэдэг нь /level standart of criminality/ криминологид эрүүгийн хариуцлага хүлээлгэх насанд хүрсэн 1000, 10.000, 100.000 хүн тутамд ноогдох тодорхой хугацааны туршид тодорхой нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улсад бүртгэсэн гэмт явдлын түвшинг тогтооход ашигладаг эрүүгийн хариуцлага хүлээлгэх насыг 16 насаар авч үзэн тодорхойлдог. Олон улсын гэмт хэргийн түвшинг тодорхойлдог <https://www.numbeo.com> сайтад 2019 онд Улаанбаатар хот гэмт хэргийн түвшингээр 56.11 буюу дэлхийн 328 хотоос эхний 74 дүгээр байрт эрэмблэгджээ.

Баянзүрх дүүргийн хэмжээнд 2018 оны жилийн эцсийн статистик мэдээгээр 16 ба түүнээс дээш насны 232.610 хүн амтай бөгөөд 10.000 хүнд ногдох гэмт хэрэг түвшинөөр нь авч үзвэл 235 гэмт хэрэг ногдож байна.

Бусад дүүргийн 10.000 хүнд ногдох гэмт хэргийн түвшинтэй харьцуулбал хамгийн ихээсээ 3 дугаарт эрэмблэгдэж байна.

График 2.8. Дүүргүүдийн 10.000 хүнд ногдох гэмт хэргийн түвшин



Гэмт хэрэгт хохирсныг илэрхийлэх аюулгүй байдлын индекс:

Нийслэлийн ард иргэдийн аюулгүй байдлыг илэрхийлэх коэффициентийг 10000 хүнд ногдох байдлаар тооцож үзэв².

Энэ үзүүлэлт нь 10000 хүнд ногдох гэмт хэргийн тархалттай төстэйгээс гадна тухайн дүүргийн гэмт хэрэгт өртөж хохирох эрдслийн түвшинг илэрхийлж буй үзүүлэлт юм. 2019 онд Баянзүрх дүүргийн хэмжээнд 5293 хүн гэмт хэргийн улмаас хохирсон бөгөөд гэмт хэргийн халдлагад хохирсон хүний коэффициент Баянзүрх дүүргийн хэмжээнд 16 ба түүнээс дээш насны 10000 хүн амд 228 ногдож байна.

Бусад дүүргүүдийн 10.000 хүнд ногдох гэмт хэрэгт хохирсон байдлыг илэрхийлэх аюулгүй байдлын индексээс үзэхэд Баянзүрх дүүрэг хамгийн ихээсээ 3 дугаарт эрэмблэгдэж байна.




График 2.9. Дүүргүүдийн 10.000 хүнд ногдох гэмт хэргийн түвшин

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 2019 ОНЫ ГЭМТ ХЭРГИЙН гаралт /хороогоор/

Тус дүүрэгт бүртгэгдсэн гэмт хэргийн гаралтын хороодоор харуулбал 14 дүгээр хороонд 534 хэрэг бүртгэгдэж, нийт дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн хэргийн 9.8%-ийг, 5 дугаар хороо 319 гэмт хэрэг бүртгэгдэж, нийт дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн хэргийн 5.8%-ийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 2.1. Хороодод гарсан гэмт хэрэг

№	Хороо	2018 он	2019 он	Зөрүү	Эзлэх хувь
---	-------	---------	---------	-------	------------

²16 ба түүнээс дээш насны хүн амын тоог гэмт хэргийн халдлагад өртөж хохирсон иргэдийн тоотой харьцуулах байдлаар тооцов.

				Тоо	Хувь	
1	1-р хороо	394	199	-195	-49,5	3,6
2	2-р хороо	289	194	-95	-32,9	3,5
3	3-р хороо	239	262	23	9,6	4,8
4	4-р хороо	413	279	-134	-32,4	5,1
5	5-р хороо	442	319	-123	-27,8	5,8
6	6-р хороо	371	163	-208	-56,1	3,0
7	7-р хороо	392	254	-138	-35,2	4,6
8	8-р хороо	307	264	-43	-14,0	4,8
9	9-р хороо	137	123	-14	-10,2	2,3
10	10-р хороо	140	95	-45	-32,1	1,7
11	11-р хороо	257	224	-33	-12,8	4,1
12	12-р хороо	176	178	2	1,1	3,3
13	13-р хороо	235	179	-56	-23,8	3,3
14	14-р хороо	736	534	-202	-27,4	9,8
15	15-р хороо	201	120	-81	-40,3	2,2
16	16-р хороо	376	254	-122	-32,4	4,6
17	17-р хороо	124	120	-4	-3,2	2,2
18	18-р хороо	199	220	21	10,6	4,0
19	19-р хороо	158	145	-13	-8,2	2,7
20	20-р хороо	135	140	5	3,7	2,6
21	21-р хороо	199	151	-48	-24,1	2,8
22	22-р хороо	347	236	-111	-32,0	4,3
23	23-р хороо	171	107	-64	-37,4	2,0
24	24-р хороо	131	80	-51	-38,9	1,5
25	25-р хороо	246	179	-67	-27,2	3,3
26	26-р хороо	397	236	-161	-40,6	4,3
27	27-р хороо	216	142	-74	-34,3	2,6
28	28-р хороо	94	68	-26	-27,7	1,2

Хүснэгт 2.2. Хороодод бүртгэгдсэн хэргийг төрлөөр нь авч үзвэл:

Аймаг, нийслэл, дүүргийн цагдаагийн болон хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллага		1-р хороо	2-р хороо	3-р хороо	4-р хороо	5-р хороо	6-р хороо	7-р хороо	8-р хороо	9-р хороо	10-р хороо	11-р хороо	12-р хороо	13-р хороо	14-р хороо	15-р хороо	16-р хороо	17-р хороо	18-р хороо	19-р хороо	20-р хороо	21-р хороо	22-р хороо	23-р хороо	24-р хороо	25-р хороо	26-р хороо	27-р хороо	28-р хороо	
Хүний амьд явах эрхийн эсрэг 10.1-10.6	2018	1	6	2	3	8	2	1	8	3		6	2		10		4	4	2	2	7	3	8	6	4	2	4	4	2	
	2019	3	7	2	7	3		1	13	1	6	4	7	3	7	2	3	6	3	5	2	2	2	7	5	2	3	3	3	
Үүнээс Хүнийг алах 10.1	2018		1	1	1	1			2	1					3		1	2	1	1	2			2	1		1		1	
	2019	2	1		2	2			1			1	2	1	1		1	1	1	1	1	2			1	1	1	1		1
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 11.1-11.7	2018	51	62	63	73	104	53	91	100	38	42	52	47	45	141	21	91	32	30	47	43	43	89	59	27	42	73	41	20	
	2019	52	50	40	66	93	38	71	69	48	38	55	46	39	109	22	74	36	41	45	64	34	64	48	28	40	55	46	21	
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг 12.1-12.5	2018	2	7	1	3	6	5	2	5	2	1	2	1	3	6	1	4	2	1	3	4	9	5		3	3	2	4	3	
	2019	3	5		3	8		3	4	3	1	3			2		2	1	1	2	1	4	1		1	2	3	3	3	
Үүнээс: Хүчиндэх 12.1	2018	1	7	1	3	5	4	2	5	2	1	2		1	6	1	3	2	1	2	3	8	4		2	2	2	4	3	
	2019	2	4		3	7		3	4	3	1	3			1		1	1	1	2	1	4	1		1		3	3	3	
Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг 13.1-13.13	2018		2		1	3	1		1			1			2	1			3				1		1		1	1		
	2019	4	2	1	2	2	2	1							1	1	1		1	1						1	2			
Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг 14.1-14.9	2018																1													
	2019																													
Эрүүл мэндийн эсрэг 15.1-15.6	2018		1											3									1					2		
	2019						1							3					1				1							
Хүүхдийн эсрэг 16.1-16.11	2018														1								1				1	1		
	2019					1									2		1		1				1				4	1		
Өмчлөх эрхийн эсрэг 17.1-17.12	2018	330	200	164	314	309	293	285	174	92	94	180	116	163	544	166	266	84	155	104	77	140	234	100	92	190	297	164	64	
	2019	127	124	112	184	193	112	162	168	66	44	148	117	107	394	86	162	72	165	86	68	104	157	48	44	111	160	87	33	
Үүнээс: Хулгайлах 17.1 Дээрэмдэх 17.2 Залилах 17.3 Мал хулгайлах 17.12	Хулгайлах 17.1	2018	182	115	90	182	203	161	152	100	63	56	145	73	92	324	76	134	47	82	62	53	113	127	70	57	101	163	125	50
		2019	46	62	40	79	127	47	59	97	54	22	122	85	58	210	30	88	39	36	65	46	80	112	40	28	69	108	68	30
	Дээрэмдэх 17.2	2018	51	31	29	40	40	28	37	15	9	5	9	14	19	35	22	16	3	23	12	1	12	15	8	4	15	14	22	4
		2019	21	14	31	13	14	18	17	12	6		4	7	8	8	5	2	8	8	1	7	13	2	7	5	2	4		
	Залилах 17.3	2018	76	39	37	73	50	82	73	39	14	23	8	17	40	132	55	82	31	44	17	6	10	68	19	25	50	72	9	10
		2019	49	41	36	84	40	44	76	40	5	14	11	21	33	137	44	56	28	113	9	9	11	18	4	4	30	33	13	1
	Мал хулгайлах 17.12	2018										1	10										12							
		2019											5										10							
Эдийн засгийн 18.1-18.18	2018	2	1		7	1		6	2	1		1	1	3	10	4			1		1		2	1		2	1			
	2019	1	1		1					1		1	2	1	6	1	1	1	1					1			2			
Үндэний аюулгүй байдлын эсрэг 19.1-19.17	2018																													
	2019																													
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг 20.1-20.16	2018	3	1	3	2		4	1	3	1	1		1	2	10	4	3	1			2	2		1		3	4		1	
	2019	3		2	2	2	3	6	1	3					2	5	3	1	1	1	1	2	1		1	2	4	5		
	2018		2	1	2	1	1		2						1						1		1				1	2		

Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг 21.1-21.14	2019		4		1	2							2		1		1						1								
Авлигын 22.1-22.12	2018		1	1		1							11		1								1		1	1					
	2019			97		4							1	12	1	1	1	1									1				
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг 23.1-23.7	2018	1			3	1	1	1	2				1	2		3		3				2	2	1			1				
	2019	1			2	2	1	2	2	1		1		2		1		1				1				9					
Хүрээлэн байгаа орчны эсрэг 24.1-24.9	2018												1									1									
	2019				1				1	1			2		1	1		1													
Соёлын өвийн эсрэг 25.1-25.6	2018																														
	2019																														
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг 26.1-26.3	2018	1		1			1	1							2							1			1	3					
	2019	1			1	1	1								1		1								3	3					
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 27.1-27.11	2018	3	6	3	4	8	10	4	7		2	14	8	4	7	3	3	1	1	1					4	1	3	1	6	1	3
	2019	4	1	5	10	9	4	7	6	1	5	11	5	7	5	2	6		5	5	2	5	9	2		2	2	2	2	8	
Цэргийн албаны эсрэг 28.1-28.19	2018				1											1															
	2019																					1									
Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг 29.1-29.10	2018																														
	2019																														

УЛС, НИЙСЛЭЛД ТЭРГҮҮЛЖ БУЙ ГЭМТ ХЭРЭГ

Улсын хэмжээнд 2019 онд нийт 31524 гэмт хэрэг бүртгэгдсэнээс бүртгэгдсэн хэргийн 58.2%-ийг Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 26.2%-ийг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд эдгээр 2 төрлийн гэмт хэрэг нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 84.4%-ийг эзэлж байгаа бөгөөд энэ нь сүүлийн олон жилийн хугацаанд тогтвортой байгаа үзүүлэлт юм.

Мөн Хулгайлах гэмт хэрэг Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 48.9%, нийт гэмт хэргийн 28.4%-ийг дангаар эзэлж байгаа ба улсын хэмжээнд бүртгэгдсэн 4 хэрэг тутмын 1 нь Хулгайлах гэмт хэрэг байна.

Харин Нийслэлийн Баянзүрх дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн **5465** гэмт хэрэг бүртгэгдсэний 1432 буюу 26.2% нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 3441 буюу 63.0%-ийг Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд эдгээр 2 төрлийн гэмт хэрэг нь нийт гэмт хэргийн 89.2%-ийг эзэлж байна.

Мөн гэмт хэргийн төрлөөр нь авч үзвэл хулгайлах гэмт хэрэг 1947 бүртгэгдэж нийт хэргийн 35.6%, Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг 1282 бүртгэгдэж нийт хэргийн 23.5%, залилах гэмт хэрэг 1004 бүртгэгдэж нийт хэргийн 18.4%, дээрэмдэх гэмт хэрэг 237 бүртгэгдэж нийт хэргийн 4.3%-ийг тус тус эзэлж байна.

График 2.9. Өндөр үзүүлэлттэй гэмт хэргийн гаралт



Нийслэлийн цагдаагийн байгууллага оны туршид гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон төрлийн ажил, арга хэмжээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран тасралтгүй зохион байгуулж, иргэд, байгууллагаас ирүүлсэн дуудлага мэдээллийг шалгаж шийдвэрлэх, хуулиар харьяалуулсан зөрчил нэг бүрт тооцох хариуцлагыг бодитой хэрэгжүүлж, түүнд тавих бүх шатны удирдлагын хяналтыг дээшлүүлж, согтууруулах ундаа худалдан борлуулдаг цэг, гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй эмзэг цэгүүдийг байнгын хяналтад авч, хүн хүч, боломж, чадавхаа дайчлан оновчтой зохион байгуулж ажилласны үр дүнд нийслэлийн хэмжээнд 2019 онд бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оноос 21.0%-иар буурч, зөрчлийн илрүүлэлт 45.1%-иар өсч, түүний дотор Баянзүрх дүүргүүдэд бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс 27.3%-иар бууруулж чадсан байна.

Хүснэгт 2.3. Баянзүрх дүүргийн 2019 оны гэмт хэргийн төрөл:

№	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	
		2018.XII	2019.XII			
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	104	112	7,7	2,0	
	Үүнээс: Хүнийг алах	22	25	13,6	0,5	
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1620	1432	-11,6	26,2	
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	26	82	215,4	1,5	
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	90	59	-34,4	1,1	
	Үүнээс: Хүчиндэх	77	52	-32,5	1,0	
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	19	22	15,8	0,4	
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	1		-100,0	0,0	
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	7	6	-14,3	0,1	
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	4	11	175,0	0,2	
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	5391	3441	-36,2	63,0	
	Үүнээс	Хулгайлах	3198	1947	-39,1	35,6
		Залилах	533	237	-55,5	4,3
		Дээрэмдэх	1201	1004	-16,4	18,4
		Мал хулгайлах	23	15	-34,8	0,3
9	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг	47	21	-55,3	0,4	
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	53	51	-3,8	0,9	
11	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	15	13	-13,3	0,2	
12	Авлигын эсрэг гэмт хэрэг	23	120	421,7	2,2	
13	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	24	26	8,3	0,5	
14	Хүрээлэн байгаа орчны эсрэг	2	8	300,0	0,1	
15	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	12	12	0,0	0,2	
16	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	108	130	20,4	2,4	
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	106	130	22,6	2,4	
17	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	2	1	-50,0	0,0	

Бүртгэгдсэн байдал

Баянзүрх дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 459 буюу 8.4%-ийг согтуугаар, 482 буюу 8.8%-ийг эмэгтэй хүн оролцож, 196 буюу 3.5%-ийг хүүхэд оролцож, 178 буюу 3.3%-ийг гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдсэн бол бүртгэгдсэн хэргийн 2556 буюу 46.8% далд аргаар үйлдэгдсэн байна. Мөн дүүргийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 36.9% байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 13.1 нэгжээр өссөн.

Хэрэг бүртгэлтийн 5221 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2158 хэрэг буюу 29.2%-иар буурч, үүнээс 1928 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 9.5%-иар өсчээ.

Хүснэгт 2.4. Хороодод бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн байдал, гэмт хэргийн илрүүлэлтээр нь авч үзвэл:

№	Хороо	Согтуугаар үйлдэгдсэн	Мансуурсан үедээ үйлдсэн	Галт зэвгээр үйлдэгдсэн	Хүүхэд оролцсон	Эмэгтэй хүн оролцсон	Гадаадын иргэн үйлдсэн	Харваалалгүй хүн үйлдсэн	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	Далд үйлдэгдсэн гэмт хэрэг	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
1	1-р хороо	12	2		6	36	1		3	73	37,6
2	2-р хороо	15			5	23	1		6	64	29,6
3	3-р хороо	15	2		4	17			3	49	21,3
4	4-р хороо	19	2		4	26			7	137	35,5
5	5-р хороо	26	1		11	24	2		19	165	33,3
6	6-р хороо	10	2		5	14	1			89	37,2
7	7-р хороо	20	5		8	29			3	126	37,8
8	8-р хороо	21	1		20	24	1		3	58	45,3
9	9-р хороо	21	3		8	6			10	54	42,6
10	10-р хороо	22			7	11			3	30	54,7
11	11-р хороо	25			14	12	1		6	142	42,6
12	12-р хороо	27			4	11	1		8	109	31,4
13	13-р хороо	10			3	23	2		3	71	26,6
14	14-р хороо	23	2		7	44	1		10	275	35,0
15	15-р хороо	5	3		2	10			1	63	32,2
16	16-р хороо	13	1		12	29			10	80	36,4
17	17-р хороо	22	1	1	2	14			7	59	40,2
18	18-р хороо	11			21	25			2	139	59,9
19	19-р хороо	8			5	11			10	73	26,3
20	20-р хороо	40	2		9	12			12	63	58,0
21	21-р хороо	16	1		2	9			4	92	31,5
22	22-р хороо	11			4	15			6	139	30,3
23	23-р хороо	23	1		8	5			4	43	53,0
24	24-р хороо	5	2		1	4	1		13	34	34,2
25	25-р хороо	7	3		9	16	1		7	100	35,6
26	26-р хороо	8	4		6	15	3		7	134	28,6
27	27-р хороо	10			5	11			6	65	38,1
28	28-р хороо	14			4	6			5	30	58,5
Нийт		459	38	1	196	482	16		178	2556	36,9

Хураангуй:

- Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэгт эзлэх хувь **17.4**
- Улаанбаатар хотод эзлэх хувь **27.0**
- Хамгийн их бүртгэгдсэн **14-р хороо**
- Хамгийн бага бүртгэгдсэн **28-р хороо**
- Хороодын дундаж нь **195.3**
- Гэмт хэрэг хамгийн их үйлдэгддэг газар **Гэр орон сууц**
- Гэмт хэрэг хамгийн их үйлдэгддэг гараг **Даваа**
- Гэмт хэрэг хамгийн их үйлдэгддэг цаг **14-19**
- Гэмт хэрэг хамгийн ихээр үйлдэж байгаа хүний нас **18-24**

- Сogтуугаар үйлдсэн **459**
- Эмэгтэй хүн үйлдсэн **482**
- Хүүхэд үйлдсэн **196**
- Хохирогч иргэн **5293**
- Нас барсан **133**
- Гэмтсэн **1365**
- Хохирлын дүн **26095,1 сая**
- Нөхөн төлүүлсэн хэмжээ **5595,9 сая**
- Хамгийн их бүртгэгдсэн гэмт хэрэг **Хулгайлах**

Баянзүрх дүүрэгт 28 хороо байх бөгөөд хороо тус бүр дэх 2019 онд БГХ-ийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3, 12, 18, 20-р хороонуудад гэмт хэрэг өссөн бол 1, 26, 15 дугаар хороонуудад хамгийн их буурсан байна. 2019 онд Баянзүрх дүүрэгт бүртгэгдсэн 5465 гэмт хэргийн 9.8%-ийг 14-р хороо дангаараа эзэлж байгаа нь хамгийн өндөр дүнтэй байна.

Гэмт хэрэг хамгийн ихээр үйлдэгддэг гараг нь Даваа гараг байх бөгөөд энэ гарагт үйлдсэн гэмт хэрэг Лхагва, Пүрэв, Баасан гарагт үйлдсэн гэмт хэргээс 0.6-1%-ийн зөрүүтэй байна.


2.5. Гэмт хэргийн, нөхцөл байдал 2019 оны байдлаар

2019 онд Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүд нь иргэд, хуулийн этгээдээс 44434 гомдол, мэдээлэл хүлээн авснаас 12150 буюу 27.3%-ийг гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл эзэлж байна.

График 2.10. Гомдол мэдээлэл түүний шинж БЗД цагдаагийн хэлтсээр




График 2.12. Нийслэлийн дүүргүүдийн шийдвэрлэсэн гомдол мэдээлэл, Бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчил



Дээрх графикаас 2019 оны байдлаар Баянзүрх дүүрэг гомдол мэдээлэл, бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчил гэсэн үзүүлэлтээр нийслэлийн хэмжээнд нэгдүгээрт жагссан байна.

Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн 102 дугаарын утсанд 2019 оны 114476³ гэмт хэрэг, хэв журмын зөрчил, зам тээврийн ослын дуудлага, мэдээлэл хүлээн авчээ.

График 2.13. БЗД-т 2019 онд бүртгэгдсэн дуудлага



³ ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба

2.3. Зөрчлийн байдал

Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын хариуцсан нутаг дэвсгэрт 2019 оны эхний 12 сард 21758 зөрчлийг илрүүлж 1,230,470,000 төгрөгөөр торгосон байдлыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 7276 буюу 33,4%-иар, өссөн. 1920 иргэнийг баривчлуулж ажилласан байна.

Ердийн журмаар шийдвэрлэсэн:

Ердийн журмаар 14460 иргэнийг 589,200.000 төгрөгөөр торгож шийдвэрлэсэн бөгөөд уг зөрчлийг төрлөөр нь ангилан авч үзвэл :

- Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах /5.1/ зүйл ангиар 8789 иргэнийг 110175,000 төгрөгөөр
- Худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих /10.4/ зүйл ангиар 549 иргэнийг 31,060.000 төгрөгөөр
- Бусад зүйл ангиар 5083 иргэнийг 438130.000 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан байна.

Зөрчлийн хэрэг нээсэн болон материалжуулан шалгасан зөрчил:

Нийт зөрчил 3704 бөгөөд үүнээс 3395 иргэнийг 633,995,000 төгрөгөөр торгож 1920 иргэнийг шүүхээр баривчилж ажилласан байна.

Зөрчлийн 6558 хэрэг нээж 3451 иргэнийг 641,255,000 төгрөгөөр торгож 659 хэргийг хэрэгсэхгүй болгон ажиллаж үлдэгдэл 472 хэрэг байна.

Зөрчлийн хэрэг үүсгэн шалгасан байдлыг төрлөөр ангилан авч үзвэл:


- Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах / 5.1/ зүйл ангиар 94 иргэнийг 3.055.000 төгрөгөөр
- Танхайрах /5.2/ зүйл ангиар 32 иргэнийг 3.500.000 төгрөгөөр торгож 158 иргэнийг баривчлуулсан
- Хүний биед халдах /5.3/ зүйл ангиар 819 иргэнийг 8.200.000 төгрөгөөр
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих /5.4/ зүйл ангиар 19 иргэнийг 2.400,000 төгрөгөөр торгож 1622 иргэнийг баривчилж
- Нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах /5.5/ зүйл ангиар 227 иргэнийг 22.700.000 төгрөгөөр
- Хулгайлах /8.6/ зүйл ангиар 1 иргэнийг 105,000 төгрөгөөр, 104 иргэнийг баривчлуусан.
- Эд хөрөнгө устгах, гэмтээх /8.8/ зүйл ангиар 233 иргэнийг 46.400.000 төгрөгөөр
- Худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих /10.4/ зүйл ангиар 38 хуулийн этгээдийг 27,300.000 төгрөгөөр
- Хуурамч дуудлага мэдээлэл өгөх /15.9/ зүйл ангиар 1201 иргэнийг 60,050,000 төгрөгөөр арга хэмжээ авч ажилласан байна.
- Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих /6.5/ хуулиар 91 иргэнийг 47,830,000 төгрөгөөр торгож
- Хүүхдийн эрхийг зөрчих /6.20/ зүйл ангиар 138 иргэнийг 41,205,000 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан байна

Захиргааны зөрчлийг үйлдэгдэж байгаа газраар нь авч үзвэл:


- Гэр, орон сууцанд 4172
- Гудамж талбайд 1084
- Олон нийтийн газарт 1314

- Хүнсний дэлгүүрт 116
- Аж ахуй нэгж 326
- Бусад газарт 303 зөрчил тус тус илэрсэн байна

Зөрчил үйлдэгдсэн гаригаар ангилан авч үзвэл:



Захиргааны зөрчил нь даваа гаригт 3092 буюу 14.2%, мягмар гаригт 2583 буюу 11.8%, лхагва гаригт 2945 буюу 13.5%, пүрэв гаригт 2962 буюу 13.6%, баасан гаригт 2897 буюу 13.3%, бямба гаригт 3065 буюу 14%, ням гаригт 4214 буюу 19.3% тус тус үйлдэгдэж байгаагаас харахад даваа, ням гаригуудад зөрчил ихээр үйлдэгдэж байна.



Зөрчил гаргаж байгаа иргэдийн 2921 нь согтуугаар үйлдэгдэж байгаа бөгөөд үүнээс согтуугаар 755 эмэгтэй хүн зөрчил үйлдэж согтуугаар үйлдэгдсэн зөрчлийн 25,8%-ийг эзлэж байна.

2.3. Баянзүрх дүүрэг дэх гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл, хүчин зүйлс

“Баянзүрх дүүргийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл” сэдэвт криминологи судалгааны ажлын үр дүнг үндэслэн дараах шалтгаан, нөхцөл, хүчин зүйлс байна гэж дүгнэж байна.

Үүнд:

1. **Хүн амын хэт төвлөрөл, ачаалал.** Баянзүрх дүүрэгт албан ёсны тоогоор 343 мянган, албан бус тооцооллоор түүнээс илүү 2 дахин илүү хүн ам амьдарч, ажиллаж байна. Иймд хүн амын тоо, ачаалалд чиглэсэн төрийн бодлого, үйлчилгээг нэмэгдүүлэх, сайжруулах шаардлага байна.
2. Гэмт хэрэг, зөрчлийн үндсэн шалтгаан, нөхцөл, хүчин зүйл бол хүн амын хэт төвлөрлөөс үүдсэн **ядуурал ихтэй, гэр хороолол голдуу байгаа** нь нөлөөлж байна. Иймд иргэдийг ажил орлоготой болгох, эрх зүйн мэдлэг, ухамсар, соёлыг дээшлүүлэх, төлөвшүүлэх шаардлага байна.
3. Дүүргийн **газар нутгийг тэлэх, дэд бүтцийг өргөжүүлэх** бодлого баримтлах шаардлага байна. Шаардлагатай бол Гачуурт, Шар хад зэргийг тэлж өргөжүүлэх хэрэгтэй.

4. **Дүүргийн хэмжээнд нэгдсэн бодлого үгүйлэгдэж байна.** Баянзүрх дүүргийн урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх асуудал цогц байдлаар бүрэн тусгагдаж хэрэгжээгүй байна. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг дүүргийн хэмжээнд уялдуулан зохицуулж, зохион байгуулах үүрэг бүхий ажлын албыг байгуулж, орон тооны нарийн бичгийн даргыг бий болгон ажиллуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах; Цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, онцгой байдал, мэргэжлийн хяналт, худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс зэрэг төрийн байгууллагуудын үйл ажиллагааг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгод чиглүүлэн уялдуулан зохицуулах шаардлага байна.
5. Гэмт хэргийн гаралтын улсын хэмжээний 20.8%, нийслэлийн хэмжээний 29.3% нь Баянзүрх дүүрэгт бүртгэгдсэн байна. Эндээс дүүргийн гэмт хэргийн нөхцөл байдал шууд харагдаж байна. Энэ ачаалалтай дүйх хэмжээний **хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын орон тоо бусад аймаг, дүүрэгтэй харьцуулахад огт тэнцвэргүй байна.** Иймд “Баянзүрх дүүргийн хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын орон тоог нэмэгдүүлэх, алба хаагчдыг чадавхжуулах хөтөлбөр” хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.
6. **Худалдаа, үйлчилгээний аж ахуйн нэгж, томоохон худалдааны төвүүд ихээр үйл ажиллагаа явуулдаг гэмт хэрэг, зөрчлийн гаралтанд нөлөөлж байна.** Тухайлбал, “Нарантуул” ОУХТөв, түүний “Өргөтгөл”, “Өгөөмөр”, “Авто эхпо” зэрэг техникийн захууд, Шөнийн зах, Сандэй, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Дүнжингарав, ВСВ, Номин худалдааны төв, Баянзүрх худалдааны төв, Баянзүрх зах, Цайз модны зах, Сэлэнгэ зах, Хас маркет, Миний дэлгүүр, Норжин, Жуков худалдааны төв, Сансар худалдааны төв, Сансар шинэ зах, Имарт, Хоме плаза, Амгалан зах, Да хүрээ, Тэнгэр плаза зэрэг хүн ам олноор үйлчлүүлдэг худалдааны төвүүдтэй. Жишээ нь: Нарантуул ОУХ төвөөр өдөрт дунджаар 150-200 мянга орчим хүн, 40-50 мянга орчим автомашин үйлчлүүдэг ба олон нийтийг хамарсан баяр, амралтын үеэр энэ тоо 2 дахин өсдөг судалгаа байна
7. **Улс, нийслэлийн хэмжээнд 11 орчим үзүүлэлтээр өндөр үзүүлэлттэй байна. Иймд эдгээр өндөр үзүүлэлттэй байгаа тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг** бууруулах, сааруулах эрх зүй, нийгэм, эдийн засаг, зохион байгуулалтын цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлага байна.
8. Улмаар гэмт хэрэг, зөрчлийн гаралтаар **өндөр үзүүлэлттэй хороо, хэсэгт чиглэсэн цогц** арга хэмжээг хэрэгжүүлэх замаар гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, сааруулах бодлогыг шат шатандаа хэрэгжүүлэх шаардлагатай байна.
9. **Гэмт хэргийн гаралтын 80-90% нь согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэснээс үүдэлтэй судалгаа гарсан байдаг.** Иймд иргэд, хүүхэд, залуучууд архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөр санаачлан хэрэгжүүлэх шаардлагатай. Дүүргийн нутаг дэвсгэрт хүүхэд, залуучууд, иргэд, ахмад настнууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, спортоор хичээллэх таатай орчин бүрдүүлэхэд чиглэсэн **“Эрүүл дүүрэг”** дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үүнд **Хувийн хэвшилтэй хамтран ажиллах шинэ арга хэлбэрийг эрэлхийлэх;** - Байгууллага, хамт олны дунд биеийн тамир, спортыг дэмжих соёлыг түгээн дэлгэрүүлэх; - Спорт заал, усан бассейнуудыг барьж ашиглалтад оруулах; -Сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг, сургалт явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдэд дэмжлэг үзүүлэх; -Бүжиг, хөдөлгөөн дасгалаар хичээллэх орчинг бүрдүүлэх; -Явган аялах, ууланд авирах маршрутуудыг бий болгох, орчныг бүрдүүлэх
10. **Иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсар, соёлыг дээшлүүлэх сайжруулах шаардлагатай байна.** “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг дүүргийн

хэмжээнд холбогдох байгууллагуудтай хамтран төрийн бүх шатны байгууллага, хороо, иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулах нь зүйтэй.

11. Хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл сүүлийн үед нэмэгдэж байна. Иймд хүчирхийлэлтэй тэмцэх, ялангуяа гэр бүлийн хүрээний хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтыг ажлыг эрчимжүүлэх шаардлага байна.
12. Хүүхэд, оюутан, залуучуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах маркетинг хэрэгжүүлэх. Их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухааны байгууллагууд, эрдэмтэн, судлаач, энтерпренеруудтэй хамтран тус Дүүргийг хөгжүүлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр **think tank** судалгааны төв байгуулан ажиллуулах шаардлагатай.

2.4. Цагдаагийн алба хаагчдаас “Н форум”-ын аргаар авсан асуулгын дүн

		БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН КРИМИНОЛОГИ СУДАЛГАА											
		“Н форум” асуулга, хэлэлцүүлэг											
		Баянзүрх дүүргийн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал											
		Баянзүрх дүүргийн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал тоон үнэлгээ өгнө үү.											
		1	2	3	4	5	6	7	8	9	10		
<p>Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээрх зэрэг тал, тэргүүн туршлага /Менежмент/</p> <ol style="list-style-type: none"> 1. Хэвлэл мэдээлэл социал сүлжээгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ үр дүнгээ өгсөн. 2. Эргүүл зохион байгуулалтын ажлыг сайн төлөвлөж хийснээр зарим төрлийн гэмт хэргийг бууруулсан. 	<p>Гэмт хэрэгтэй тэмцэх, зөрчилтэй тэмцэх шийдэл, шинэ арга зам, гарц, аргачлал /Таны бодлоор/</p> <ol style="list-style-type: none"> 1. Царай таньдаг камерын системийг дүүргийн худалдааны төвүүдэд нэвтрүүлэх 2. Хорооны цагдаагийн албан хаагчийн тоог нэмэгдүүлэх 3. Хороо болгоныг автомашинтай болгох 4. ААН байгууллага, иргэдийн ороцоог нэмэгдүүлэх 5. Урамшуулалт эргүүлийн тоог нэмэгдүүлэх 6. Авто эргүүлийн тоог нэмэгдүүлэх 7. Архи согтууруулах ундаагаар үйлчилдэг байгууллагад тавих хяналтыг өндөрсгөж, зөвшөөрөл өгөх шалгуурыг өндөрсгөх. 8. Иргэдийн шилжилт хөдөлгөөнд тавих хяналтын механизмийг сайжруулах 9. Хэргийн байцаагчийн чиг үүргийг тодорхой болгон ажлын ачааллыг харгалзан зарим төрлийн ажлыг чиг үүргээс хасах 										<p>Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээрх сөрөг тал, дутагдал хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал</p> <ol style="list-style-type: none"> 1. Төсөв хүрэлцдэггүй 2. Хорооны хэсгийн хүн хүч дутмаг 3. Хороонд 1 албан хаагчид ноогдох ажлын ачаалал давхардал их учир урьдчилан сэргийлэх чиглэлийн ажил зохиож чаддагүй 4. Гудамж талбайн хяналтын камерын хяналт бага 5. Эргүүлийн хийх хүн хүч дутмаг 6. Автомашин дутмаг 7. Шатах тослох материалын хангалт муу 8. Бүртгэлгүй иргэдээс шалтгаалсан гэмт хэргийн гаралт их 9. Алба хаагчдын нийгмийн асуудал орхигддог 		

Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн газраас Архи согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл, ТҮЦ эрхлэгчдийн төлөөлөл, Нийтийн байр түрээслэгчдийн төлөөлөл зэрэг иргэдтэй уулзсан уулзалтаар гарсан санал, бидний явуулсан санал асуулгын дүнг харгалзан, зөвлөмжийг боловсруулсан болно.

2.5. Санал, зөвлөмж, шийдэл

“Баянзүрх дүүргийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл” сэдэвт криминологи судалгааны ажлын үр дүнг үндэслэн боловсруулсан санал, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах нь зүйтэй.

БҮЛЭГ 3. БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ОРШИН СУУГЧИД БОЛОН ТОДОРХОЙ БҮЛГҮҮДЭЭС САНАЛ АСУУЛГЫН АРГААР АВСАН СОЦИОЛОГИЙН СУДАЛГААНЫ ДЭД ТАЙЛАН

Судалгааны дэд баг: Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч Д.Бадамцэцэг,
багш, цагдаагийн дэслэгч К.Ариунзул, магистрант нар хийж гүйцэтгэв.

Нэг. УДИРТГАЛ

1.1. Судалгааны ажлын зорилго:

Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн захиалгаар “Баянзүрх дүүргийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл” сэдэвт криминологи судалгааны ажлын хүрээнд тус дүүргийн тодорхой бүлгийн иргэдээс гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүний шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, урьдчилан сэргийлэх ажлын мэдээ, мэдээлэл цуглуулах, энэ чиглэлээр холбогдох байгууллагуудын зүгээс хийсэн ажлын чиглэл, бодлого, үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч, цаашдын бодлогын шийдлийг боловсруулах зорилготой юм.

1.2. Судалгааны ажлын зорилт:

- Судалгааны хүрээг тогтоох;
- Судалгааны загварыг боловсруулах;
- Судалгааны анкетыг боловсруулж, төслийн багаар хэлэлцүүлэн төслийн багийн ахлагчаар батлуулах;
- Судалгааны загварын дагуу тогтоосон хүрээнээс мэдээлэл цуглуулах;
- Мэдээллийг боловсруулах /SPSS программд шивэх кодлох/;
- Мэдээлэлд дүн шинжилгээ хийх, тайлан боловсруулах хүлээлгэн өгөх;

1.3. Судалгааны арга зүй, зохион байгуулалт:

Баянзүрх дүүргийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох, иргэдийн сэтгэл ханамж, амьдралын чанар, аюулгүй байдлын түвшин, айдас, гэмт хэрэгт хохирох эрсдэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүн, цаашид анхаарах асуудлуудыг тодруулах зорилтыг тавин тус дүүргийн 28 хорооны оршин суугчид, хэсгийн байцаагч нар, худалдаа үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчид, оюутнуудаас санамсаргүй байдлаар болон фокус бүлгийн ярилцлагын аргыг ашиглан тус судалгааг авав. Түүнчлэн “Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх” чиглэлээр Баянзүрх дүүрэгт байрлах төрийн өмчит болон хувийн зарим ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, багш нараас тандалт судалгааг авч үр дүнг тайлагнасан болно.

Судалгааг хийхдээ судлаачийн үзэл бодлыг тусгахгүйгээр зөвхөн судалгааны үр дүнг гаргаж, нөхцөл байдлыг бодитоор тодорхойлсон.

Судалгааг явуулахын өмнө судалгааны асуултыг урьдчилан боловсруулж, туршилтын санал асуулга явуулж, судалгаа авахад дунджаар 25 минут зарцуулж байсан тул иргэдээс судалгаа авахдаа мөн хугацааг баримталж 2019 оны 10-р сарын 30-аас 2019 оны 11-р сарын 15-ны өдрийг хүртэл нийт ажлын 10 хоногт багтаан авсан болно. Түүнчлэн судалгааг авах ажилтанд судалгааг авах арга зүйн зөвлөмжийг урьдчилан бичгээр гаргаж танилцуулан, судалгааг авсан болно.

Хоёр. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

2.1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Тус судалгаанд Баянзүрх дүүргийн байнгын оршин суугч, түр хугацаагаар оршин суугч мөн тус дүүрэгт аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг иргэд зэрэг нийт 1100 иргэн оролцсон. Дээрх иргэдийн оролцсон ихэнх нь оршин сууж байгаа газартаа 5-15 жил амьдарч байгаа мөн урт хугацааны зээлээр авсан өөрийн орон сууц болон гэр хороололд өөрийн байшиндаа ихэнх нь оршин суудаг бол үлдсэн нь түрээсийн байр, хувийн эзэмшлийн орон сууцанд амьдардаг байна.

Боловсролын түвшингийн хувьд дээд боловсролтой 596 иргэн; бүрэн дунд боловсролтой 378 иргэн; бага боловсролтой 80 иргэн; үлдсэн нь бүрэн бус дунд болон боловсролгүй иргэд байв. Хүйсийн хувьд авч үзвэл эрэгтэй 408 иргэн; эмэгтэй 692 иргэд оролцжээ. Судалгаанд хариулсан байдлыг харвал эмэгтэйчүүд илүү идэвхтэй оролцож, асуултыг нэг бүрчлэн бөглөсөн байна. Үүнээс эмэгтэйчүүдийн гэмт хэрэг, зөрчлийн байдалд илүүтэй санаа зовж байна гэж үзэж болохоор юм.

Судалгаанд оролцсон иргэдийн 238 иргэн нь ганц бие, 804 иргэн нь гэрлэсэн, 58 нь бэлэвсэн, мөн гэр бүл цуцалсан байдалтай байна.


Хүснэгт №1 Баянзүрх дүүргийн хэмжээнд судалгаанд оролцсон иргэдийн статистик үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Үзүүлэлт	Давталт	Хувь, %
Хүйс	Эрэгтэй	408	37.1
	Эмэгтэй	692	62.9
Боловсролын түвшин	Боловсролгүй	8	0.7
	Бага	38	3.5
	Бүрэн бус дунд	80	7.3
	Бүрэн дунд	378	34.4
	Дээд	596	54.2
	Ганц бие	238	21.7
Гэрлэлтийн байдал	Гэрлэсэн	804	73.1
	Бэлэвсэрсэн /салсан/	58	5.3

2.1.2. Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын үнэлгээ


Баянзүрх дүүрэгт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг судалгаанд оролцсон иргэд дараах байдлаар дүгнэжээ.

График 1. Баянзүрх дүүрэгт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчил нөхцөл байдал



Баянзүрх дүүрэгт үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаарх судалгаанд 1100 иргэн оролцсоноос 138 хүн буюу 12.5% нь маш хүнд нөхцөл байдалд байгаа, 172 иргэн буюу 15.6% нь их хүнд байгаа, 424 иргэн буюу 38.5% нь хүндэвтэр байгаа, 50 иргэн бага хэмжээнд байгаа хэмээн хариулсанаас харахад Баянзүрх дүүргийн хэмжээнд гэмт, хэрэг зөрчлийн нөхцөл байдал хүндэвтэр байна гэж дүгнэж байна.

График 2. Дүүргийн хэмжээнд хамгийн их үйлдэгдэж буй гэмт хэрэг



Баянзүрх дүүргийн хэмжээнд хамгийн их үйлдэгдэж буй гэмт хэрэгт судалгаанд оролцогчдын 14.5% нь буюу 696 иргэн *гэр бүлийн хүчирхийлэл*, 11.4% нь буюу 562 хүн *халаасны хулгай*, 10.2% буюу 504 иргэн *дээрэмдэх*, 9.5% нь буюу 470 иргэн *бусдын биед гэмтэл учруулах*, 8.1% нь буюу 398 иргэн *тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын хөдөлгөөний эсрэг гэмт хэрэг*, 7.2% нь буюу 354 иргэн *хүүхдийн эсрэг гэмт хэрэг*, 7.1% нь буюу 348 иргэн *автомашин эд зүйлийн хулгай*, 6.8% нь буюу 298 иргэн *орон байрны хулгай*, 5% нь буюу 244 иргэн *авлигалын гэмт хэрэг*, 3.5% буюу 174 иргэн *хүчиндэх*, 1.9% нь буюу 96 иргэн *мансууруулах эм сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэг*, 0.9% нь буюу 46 иргэн *ан агнуурын хууль тогтоомж зөрчих*, 0.9% нь буюу 46 иргэн *хууль бусаар ашигт малтмал олборлох*, 0.6% нь буюу 30 иргэн *ой хээрийн түймэр тавих гэмт хэрэг* гэж хариулсан байна. Судалгаанаас үзэхэд сүүлийн жилүүдэд дүүргийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх болон хулгайн гэмт хэргүүд нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд ой хээрийн түймэр тавих, хууль бусаар ашигт малтмал олборлох, ан агнуурын гэмт хэрэг хамгийн бага гарсан бөгөөд энэ нь газар нутаг, хүн амын нягтаршилтай холбоотой байж болох юм.

Түүнчлэн тус асуултыг нээлттэй байдлаар судалгаанд оролцсон иргэдээс авахад дараах гэмт хэргүүдийг дүүргийн хэмжээнд их үйлддэг гэж нэрлэжээ. Үүнд:

1. Архихдах /гэр орондоо болон гудамж талбай, сансарын тунелийн орчимд/;
2. Бусдын бие махбодод хүнд болон хүндэвтэр гэмтэл учруулах;
3. Орчин тойрондоо аюул учруулж болох амьтаныг зохих хамгаалалтгүй байлгах / нохойгоо уяхгүй байснаас болж хүүхэд урах/;
4. Эмнэлгийн буруу үйл ажиллагаанаас үүдэлтэй эх, хүүхдийн эндэгдэл;
5. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ автомашин жолоодох;
6. Хэл амаар доромжлох;
7. Олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах;


8. Орон гэргүй согтуучууд, шил лааз түүгчид хөлдөх, осгох болон хүүхэд, хөгшүүл, ээжүүдийг айлгах, нийтийн эзэмшлийн газар танхайрах;
9. Хулгайлах /гар утас, өөртөө үйлчлэх дэлгүүрээс хулгай хийх/;

График 3. Зөрчлийн тухай хуульд заагдсан зөрчлүүдээс хамгийн их гардаг зөрчлүүд



Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлүүдээс нэрлэвэл 636 иргэн *замын хөдөлгөөний дүрэм зөрчих*, 17.7% нь буюу 606 иргэн *согтууруулах ундааг цаг хэтрүүлэн зарах, үйлчлэх*, 16.7% нь буюу 574 иргэн *танхайрах*, 15% нь буюу 514 иргэн *согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох*, 13.8% буюу 474 иргэн *хог хаягдлын тухай хууль зөрчих*, 9.6% нь буюу 330 иргэн *хүний биед халдах*, 5.1% буюу 174 иргэн *биеэ үнэлэх*, 3.6% нь буюу 122 иргэн *мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэг* гэж хариулжээ. Үүнээс үзэхэд *замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлүүд* хамгийн их хувийг эзэлж байна. Түүнчлэн уг анкетыг нээлттэй байдлаар авахад *гэр бүлийн хүчирхийлэл, шөнийн цагаар амгалан тайван байдал алдагдуулах зөрчлүүд их үйлдэгддэг* гэжээ. Мөн Зөрчлийн тухай хууль өөрөө дутуу, дулимаг боловсрогдсон гэж судалгаанд оролцогчдын 0,02 хувь буюу 5 иргэн үзсэн байна.

График 4. Гэмт хэрэг, зөрчлийн шалтгааны талаарх таны бодол



Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг тодорхойлоход судалгаанд оролцогчид хамгийн их нөлөөлж буй хүчин зүйл нь архидалт гэж хариулсан бөгөөд мөн хувь хүний хүмүүжил ухамсар, ажилгүйдэл, ядуурал ч ихээхэн нөлөөлж байна гэж хариулжээ. Дээрх судалгааг нээлттэй байдлаар судалгаанд оролцогчдоос авахад гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлд дараах байдлыг дурьдсан байна. Үүнд:


1. Согтууруулах ундаагаар үйлчилдэг газрыг хуваарийн дагуу ажиллуулах, цагийн хуваарийг мөрдөхгүй байх;
2. Амар хялбар аргаар мөнгө олох гэсэн санаатай хүмүүс олширсон;
3. Баянзүрх дүүрэг нь бусад дүүргээс хүн амын төвлөрлөөрөө хамгийн их мөн гэр хороолол ихтэй дүүрэг байдаг.
4. Камерын хяналт, гэрэлтүүлэг дутмаг;
5. Өндөр настай хүмүүс тэтгэвэрийн зээлтэй байгаа тул ядуурлыг нэмэгдүүлж байна;
6. Цагдаа нар ажлаа сайн хийхгүй байна;
7. Залуу гэр бүл, хөгшид, хүүхдүүдийг /хөгжлийн бэрхшээлтэй иргэд/ дэмжих, хамгаалах үйл ажиллагаа явагддаггүй.
8. Илүү цагаар ажиллахад цалин өгдөггүй.
9. Хувь хүний бодол, санаа, сэтгэхүй дорой.
10. Өс хонзон санах.
11. Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд шат шатандаа ажлаа хийдэггүй, хуулийн хэрэгжилт хангалтгүй ард иргэдийнхээ төлөө ажилладаггүй.
12. Дэлгүүрүүдээр архи болон согтууруулах ундааг ямар нэгэн хяналтгүй зардаг.
13. МУ-ын хүн амын амьжиргаанд нөлөөлөх төрийн бодлого байхгүй.
14. Улсад оронд асуудал, бэрхшээл гарах бүрт ард иргэдээс татвар татаас авдаг нь амьжиргаанд хүндээр нөлөөлж байна.
15. Иргэдэд архидалт, гэр бүлийн хүчирхийлэлийн талаар сургалт зохион байгуулах;
16. Гэмт хэрэг, зөрчлийн үр дагаврын талаар иргэд олон нийтэд сурталчилгааг тогтмол хийх;

2.1.3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үнэлгээ

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны өнөөгийн байдлын тухай иргэдийн санал бодлыг тодорхойлох зорилго бүхий дараах асуултуудыг судалгаанд оролцогчдод тавьж асуулт тус бүрээр дүн шинжилгээ хийв. Үүнд:

- Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд түүнийг илрүүлэх нь чухал хэдий ч түүнээс урьдчилсан сэргийлэх нь илүү чухал гэдэгтэй та санал нийлэх үү?
- Танай дүүрэгт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил хэрхэн явагддаг вэ?
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд таны оролцоо хэр чухал вэ?
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд ямар ажил арга хэмжээг түлхүү зохион байгуулбал илүү үр дүнтэй гэж үзэж байна вэ? /нээлтэй асуулт/
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аль байгууллага илүү сайн ажилладаг вэ?

График 5. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд түүнийг илрүүлэх нь чухал хэдий ч түүнээс урьдчилсан сэргийлэх нь илүү чухал гэдэгтэй та санал нийлэх үү?




Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд түүнийг илрүүлэх нь чухал хэдий ч түүнээс урьдчилсан сэргийлэх нь илүү чухал гэдэгтэй та санал нийлэх үү? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 85% нь буюу 948 иргэн санал нийлнэ гэж хариулсан бол 4.9% нь буюу 54 иргэн санал нийлэхгүй, 8.5% нь буюу 94 иргэн байж болно гэж хариулсан ба гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь маш чухал болох нь харагдаж байна.

Хүснэгт 2. Танай дүүрэгт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил хэрхэн явагддаг вэ?

	Оролцогчдын тоо	Хувь
Маш муу байдаг	54	4.9
Дунд зэрэг буюу хэвийн	948	86.1
Сайн явагддаг	94	8.5
Нийт	1100	100.5

График 6. Танай дүүрэгт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил хэрхэн явагддаг вэ?



Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан шийдвэрлэх ажиллагаа дүүргийн хэмжээнд хэрхэн явагддаг талаар судлахад судалгаанд оролцогчдын 85% нь буюу 948 иргэн дунд зэрэг буюу хэвийн, 4.9% нь буюу 54 иргэн маш муу байдаг, 8.5% нь буюу 94 иргэн сайн явагддаг гэж хариулсан байна. Үүнээс дүгнэн үзэхэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цогц ажлыг зохион байгуулж, боловсронгуй болгох дээр анхаарах нь зүйтэй юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10-р зүйлд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх иргэдийн эрх үүрэг-ийг хуульчлан заасан байдаг. Уг судалгаагаар иргэдээс өөрсдийнх нь оролцооны талаарх санал бодлыг асуусан бөгөөд судалгаанд оролцсон 1100 иргэний ихэнхи нь маш чухал гэж хариулсан бол цөөхөн хэд нь би гэхээс илүүтэйгээр төр засгийн ажил хэмээн үздэг үлдсэн нь энэ талаар сонирхдоггүй гэж хариулсан байна.

График 7. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд таны оролцоо хэр чухал вэ?




График 8. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд ямар ажил арга хэмжээг түлхүү зохион байгуулбал илүү үр дүнтэй гэж үзэж байна вэ?




Тус асуулгын бусад гэсэн хариултад дараах байдлаар хариулжээ. Үүнд:

1. Хуулийн хэрэгжилт маш сул, тэгш бус хэрэгждэг тул хуулийн хэрэгжилтийг тэгш, шударга хангах;
2. Сургууль, цэцэрлэгүүдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар тэдний нас, сэтгэхүйн онцлог тохирсон хичээл орох, сургалт зохион байгуулах;
3. Хүүхдийн хүмүүжилд сурган хүмүүжүүлэгчид, эцэг эх маш сайн анхаарах;
4. Хуулийг чангатгах, хуулиа хэрэгжүүлэх биелүүлэх;
5. Иргэдийг хууль, эрх зүйн мэдлэгтэй болгох;
6. Гэр хороололд эргүүл, цагдааг байнга ажиллуулах;
7. Харанхуй гудамжийг гэрэлтэй болгох;


8. Техник технологийн хөгжил, шийдлүүдийг ашиглах;
9. Арын хаалга, танил тал гэдэг ухагдахууныг болих;
10. Хэв журам сахиулах, иргэдийн эрх үүргийн талаар сургалт, сурталчилгааг сайжруулах, бага наснаас нь энэ талаар мэдлэг олгох;
11. Эрхэлсэн ажилдаа үнэнч, шударга албан хаагчид бэлтгэх, чин сэтгэлээсээ ажилдаа үнэнч байх
12. Камерыг оновчтой зөв газар байрлуулах;
13. Social орчныг ашиглаж хуулийн мэдлэг олгох;
14. Архи согтууруулах ундаагаар үйлчлэж байгаа ААН-г цөөлөх.
15. Биеэ үнэлж байгаа; хүмүүсийг албан ажил хийлгэх. хүмүүс ажил хийх сонирхолгүй байгаа, үүнийг албан ажил хийлгэх;
16. ЕБС-ийн сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих шаардлага;
17. Иргэдээ ажилтай орлоготой болгох нь чухал;
18. Бага насны хүүхэддээ монгол зан заншилд сургах;

График 9. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аль байгууллага илүү сайн ажилладаг вэ.




Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хамгийн их буюу 904 иргэн цагдаагийн байгууллага сайн ажилладаг гэж хариулсан нь нийт судалгаанд оролцсон хүний 57.5%-г эзэлж байна. Мөн хорооны засаг дарга, түүний ажлын алба гэж 256 иргэн буюу 16.3%, төрийн бус байгууллагууд гэж 144 иргэн буюу 9.2%, дүүргийн засаг дарга, түүний ажлын алба гэж 118 иргэн буюу 7.5%, нь хариулсан бол мэргэжлийн хяналтын байгууллага хэмээн 90 хүн буюу 5.7%, шүүхийн байгууллага 32 иргэн буюу 2%, үлдсэн 28 хүн буюу 1.8%-г прокурорын байгууллага эзэлж байна.

График 10. Улаанбаатар хотын бусад дүүрэгтэй харьцуулахад таны амьдарч байгаа хороо юугаараа онцлог гэж та үзэж байна вэ.




Улаанбаатар хотын бусад дүүрэгтэй харьцуулахад таны амьдарч байгаа хороо юугаараа онцлог талаарх асуултанд хамгийн их буюу 40.1% нь буюу 412 иргэн *гэрэлтүүлэг сайтай*, 166 иргэн буюу 16.1% нь *камержуулалт хангалттай*, 172 иргэн буюу 16.7% *хөршийн холбоо сайн ажилладаг* гэж хариулсан, *хувийн хэвшлийн байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхитэй оролцдог* гэж 154 иргэн буюу 15% нь үлдсэн *гэмт хэргээс айх айдас бараг байхгүй* гэж 124 иргэн буюу 12.1% нь хариулсан байна.

График 11. Улаанбаатар хотын бусад дүүрэгтэй харьцуулахад таны амьдарч байгаа дүүрэг юугаараа онцлог гэж та үзэж байна вэ?




Улаанбаатар хотын бусад дүүргүүдтэй харьцуулахад таны амьдарч байгаа дүүрэг юугаараа онцлог вэ гэсэн асуултанд 25.2% нь камержуулалт хангалтгүй, 22.8% нь хотын захын дүүрэг, 19.6% нь гэрэлтүүлэггүй гудамж, булан ихтэй, 16.8% томоохон худалдааны төвүүдтэй, 15.7% нь замын чанар муу, тэмдэг тэмдэглэгээ муу хэмээн хариулсанаас үзэхэд энэ дүүргийн хүмүүс амьдардаг, оршин суудаг газартаа сэтгэл хангалуун бус байдаг нь харагдаж байна.

График 12. Зам дээр гардаг ослын шалтгааныг юу гэж үздэг вэ?



Зам дээр гардаг ослын шалтгааныг нийт судалгаанд оролцсон хүмүүсээс хувь хүний анхаарал болгоомжгүйгээс хэмээн 674 иргэн буюу 29.9% нь замын хөдөлгөөнөөс ихэвчлэн болдог гэж 312 иргэн буюу 13.8% нь хариулсан. Үлдсэн хариултуудад хурдаа тохируулж явдаггүйгээс, согтууруулах ундааны зүйл хэрэглэснээс болдог гэж хариулсан байна.

График 13. Та гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?



Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн талаарх мэдээллийг хаанаас олж авдаг талаарх асуултанд нийт хүмүүсийн ихэнх нь хааяа өөр өөр мэдээллийн хэрэгслээр олж авдаг гэсэн байна.

2.1.4. Орон нутгийн нөхцөл байдал:

Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн нэг гол хүчин зүйл нь орон нутгийн нөхцөл байдлыг тодорхойлох үнэлгээ юм.

Судалгаанд оролцогчдоос өөрийн оршин суудаг орон нутгийн нөхцөл байдлыг дараах байдлаар үнэлсэн байна. Үүнд:

- Миний оршин сууж буй нутаг дэвсгэр орчны бохирдол хог хаягдал ихтэй.
- Харанхуй, гэрэлтүүлэг муутай болон ганцаараа явахад айдас төрөхүйц газар олон байдаг.
- Эзэнгүй, хоосон хашаа байшин болон хүн орогнох боломжтой хаягдал машин, гараж гэх мэт зүйлс байдаг
- Хууль дүрэм зөрчдөг хүн олон байдаг. Тухайлбал замын хөдөлгөөний дүрэм зөрчих, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж орилж чарлах, мөрийтэй тоглодог.
- Гэмт хэрэг үйлддэг, зөрчил гаргадаг болон тэнэмэл хүмүүсийн бүлэг бөөгнөрлийг байнга хардаг.
- Маргалдаж, зодолдож байгаа хүмүүсийг байнга хардаг.
- Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, хэрүүл шуугиан гаргадаг хүмүүсийг байнга хардаг.

Миний оршин сууж буй нутаг дэвсгэр орчны бохирдол хог хаягдал ихтэй гэдэгтэй ихэнх иргэд бүрэн дүүрэн нийцэж байна гэсэн хариулт өгсөн бол харанхуй, гэрэлтүүлэг муутай болон ганцаараа явахад айдас төрөхүйц газар олон байдаг гэдэгтэй санал нийлж байна гэсэн хариултийг их, эзэнгүй, хоосон хашаа байшин болон хүн орогнох боломжтой хаягдал машин, гараж гэх мэт зүйлс байдаг гэдэгт харьцангуй бага хүмүүс хариулт өгсөн байна. Мөн хууль дүрэм зөрчдөг хүн олон байдаг гэдэгтэй нилээд хувь нь саналаа өгчээ.

2.1.5. Оршин суугчдын харилцааны түвшин:

Иргэдийн аюулгүй байдлын нэг гол хүчин зүйл нь олон нийт, иргэдийн хамтын ажиллагаа, оршин суугчдын харилцааны түвшин, хөршийн нэгдэл билээ.

Баянзүрх дүүргийн хэмжээнд иргэд өөрийн хөрш, саахалтын талаар үнэлэхдээ дараах асуултыг судалгаанд оролцогчдод тавьж, асуулт тус бүрээр дүн шинжилгээ хийв. Үүнд:

- Манай саахалт айл, хөршүүд бие биеэ сайн мэддэг;
- Манай саахалт айл, хөршүүд нийгмийн тулгамдсан асуудлаар хоорондоо ярилцдаг;
- Манай саахалт айл, хөршүүд хүнд хэцүү үед бие биедээ тусалдаг;
- Манай саахалт айл, хөршүүд олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцдог;
- Манай саахалт айл, хөршүүд халдлагад өртөж буй хүүхдэд болон эмэгтэйчүүдэд туслахад бэлэн байдаг;
- Гэмт хэрэг үйлдэж байгааг харсан тохиолдолд манай саахалт айл, хөршүүд цагдаагийн байгууллагад мэдээлэл өгдөг;
- Манай орон нутгийн нутгийн иргэд гэмт хэргээс урьдчилэн сэргийлэх сайн дурын эргүүл хийх, бүлэг холбоонд нэгдэж ажиллахад бэлэн байдаг.


Судалгаанд оролцсон иргэдээс: Манай хорооны иргэд гэмт хэргээс урьдчилэн сэргийлэх сайн дурын эргүүл хийх, бүлэг холбоонд нэгдэж ажиллахад бэлэн байдаг гэдэгт ихэнх хүмүүс тодорхой бус буюу 3 оноо өгсөн байна. Манай саахалт айл, хөршүүд бие биеэ сайн мэддэг санал нийлж байвал 4 оноо, манай саахалт айл, хөршүүд олон нийтийн асуудлаар хооронд ярилцдаг 2 оноо санал нийлэхгүй, манай саахалт айл, хөршүүд хүнд хэцүү үед бие биедээ тусалдаг тодорхой бус 3, манай саахалт айл, хөршүүд халдлагад өртөж буй хүүхдэд болон эмэгтэйчүүдэд туслахад бэлэн байдаг санал нийлнэ 4 оноо, гэмт хэрэг үйлдэж байгааг харсан тохиолдолд манай саахалт айл, хөршүүд цагдаагийн байгууллагад мэдээлэл өгдөг санал нийлнэ, манай хорооны иргэд гэмт хэргээс урьдчилэн сэргийлэх сайн дурын эргүүл хийх, холбоонд нэгдэж ажиллахад бэлэн байдагт 3 оноо буюу тодорхой бус гэсэн хариултууд ирсэнийг харахад айл хөршүүд хоорондоо төдийлөн харилцдаггүй, гэмт хэргээс урьдчилэн сэргийлэх ажилт хамт оролцдоггүй гэж харагдаж байна.

Хүснэгт 3. Оршин суугчдын харилцааны түвшин

Харилцааны түвшин	Судалгаанд оролцсон иргэдийн тоо	Дундаж үнэлгээ	Стандарт хазайлт	Бүрэн санал нийлнэ	Санал нийлнэ	Тодорхой бус	Санал нийлэхгүй	Огт санал нийлэхгүй
Манай саахалт айл, хөршүүд бие биеэ сайн мэддэг	1100	100	100	9.6	30.4	30.5	16.4	13.1
Манай саахалт айл, хөршүүд олон нийтийн асуудлаар хооронд ярилцдаг	1100	100	100	4.5	18.7	33.1	30.2	13.3
Манай саахалт айл, хөршүүд хүнд хэцүү үед бие биедээ тусалдаг	1100	100	100	5.8	23.1	33.1	24.2	13.6

Манай саахалт айл, хөршүүд олон нийтийн арга хэмжээ болон цуглаанд идвэхтэй оролцдог	1100	100	100	4.7	26.4	35.8	20.4	12.7
Манай саахалт айл, хөршүүд халдлагад өртөж буй хүүхдэд болон эмэгтэйчүүдэд туслахад бэлэн байдаг	1100	100	100	7.1	31.5	40.9	12.2	8.4
Гэмт хэрэг үйлдэж байгааг харсан тохиолдолд манай саахалт айл, хөршүүд цагдаагийн байгууллагад мэдээлэл өгдөг	1100	100	100	9.5	38.9	34.5	12.5	4.4
Манай хорооны иргэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сайн дурын эргүүл хийх, бүлэг холбоонд нэгдэж ажиллахад бэлэн байдаг	1100	100	100	10.2	26.7	39.1	15.8	8.2
Баянзүрх дүүргийн дундаж	1100	100	100	7.3	28.9	35.3	18.8	10.5

График 14. Оршин суугчдын харилцааны түвшин



3.1.6. Иргэдийн цагдаад хандах хандлага:

Баянзүрх дүүргийн иргэдийн цагдаад хандах хандлагыг дараах асуултыг судалгаанд оролцогчдод тавьж, асуулт тус бүрээр дүн шинжилгээ хийв. Үүнд:

- Тухайн нутаг дэвсгэрт цагдаагийн алба хаагч эргүүлийн үүргийг маш сайн гүйцэтгэдэг.
- Цагдаагийн алба хаагч иргэдээс хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг шуурхай бөгөөд хуулийн дагуу шийдвэрлэдэг.
- Иргэд гэмт хэрэг үйлдэгдсэн талаар мэдээлсэн тохиолдолд цагдаагийн байгууллага гэмт этгээдийг заавал олж тогтоон саатуулдаг.
- Цагдаагийн байгууллага гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг оновчтой хэрэгжүүлдэг.
- Цагдаагийн алба хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах мэргэжлийн ур чадвар болон тусгай мэдлэгтэй.
- Цагдаагийн байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах чадвартай.
- Цагдаагийн байгууллага манай гэр бүлийн аюулгүй байдлыг хангадаг.
- Манай ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид авлига, хээл хахуулиас ангид хуулийн хүрээнд шударгаар ажилладаг.
- Манай орон нутагт ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид харилцааны соёл, ёс зүйн төлөвшил сайтай.
- Цагдаагийн байгууллага ажлаа огт хийдэггүй. Тэднийг юу хийж байгааг би мэдэхгүй.

Тухайн нутаг дэвсгэрт цагдаагийн алба хаагч эргүүлийн үүргийг маш сайн гүйцэтгэдэг /5 оноо/ 675 иргэн, цагдаагийн алба хаагч иргэдээс хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг шуурхай бөгөөд хуулийн дагуу шийдвэрлэдэг тодорхой бус 3 оноо гэж 358 хүн, иргэд гэмт хэрэг үйлдэгдсэн талаар мэдээлсэн тохиолдолд цагдаагийн байгууллага гэмт этгээдийг заавал олж тогтоон саатуулдаг 4 оноо санал нийлж байна гэсэн хариулт, цагдаагийн байгууллага гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг оновчтой хэрэгжүүлдэг гэдэгт санал хийлж байна 4 оноо, цагдаагийн алба хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах мэргэжлийн ур чадвар болон тусгай мэдлэгтэй тодорхой бус 3 оноо гэж 152 хүн хариулж, үлдсэн нь цагдаагийн байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах чадвартай, цагдаагийн байгууллага манай гэр бүлийн аюулгүй байдлыг хангадаг, манай ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид авлига, хээл хахуулиас ангид хуулийн хүрээнд шударгаар ажилладаг, Манай орон нутагт ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид харилцааны соёл, ёс зүйн төлөвшил сайтай гэдэгт тус тус 3 оноо буюу тодорхой бус гэсэн хариултыг өгч, Цагдаагийн байгууллага ажлаа огт хийдэггүй, тэднийг юу хийж байгааг би мэдэхгүй гэдэгт 2 оноо санал нийлэхгүй байна гэсэн хариулт өгсөн ба цагдаагийн байгууллага ажлаа хийдэг хэдий ч иргэдийн сэтгэлд нийцэхээр бус хийдэг гэж харагдаж байна.

Асуултууд	Судалгаанд оролцсон иргэдийн тоо	Дундаж үнэлгээ	Стандарт хазайлт	Бүрэн санал нийлнэ	Санал нийлнэ	Тодорхой бус	Санал нийлэхгүй	Огт санал нийлэхгүй
Тухайн нутаг дэвсгэрт цагдаагийн алба хаагч эргүүлийн үүргийг маш сайн гүйцэтгэдэг	1100	100	100	9.1	32.7	33.6	19.1	5.5
Цагдаагийн алба хаагч иргэдээс хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг шуурхай бөгөөд хуулийн дагуу шийдвэрлэдэг	1100	100	100	6.9	37.3	36.2	14.2	5.5
Иргэд гэмт хэрэг үйлдэгдсэн талаар мэдээлсэн тохиолдолд цагдаагийн байгууллага гэмт этгээдийг заавал олж тогтоон саатуулдаг	1100	100	100	6.4	35.3	40.2	12.7	5.5
Цагдаагийн байгууллага гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг оновчтой хэрэгжүүлдэг	1092	99.3	100	6.5	29.5	44.7	14.9	4.4
Цагдаагийн алба хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах мэргэжлийн ур чадвар болон тусгай мэдлэгтэй	1098	99.8	100	13.8	39.3	32.2	11.6	2.9
Цагдаагийн байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах чадвартай	1056	99.8	100	11.6	36.9	34.1	12.9	4.5
Цагдаагийн байгууллага манай гэр бүлийн аюулгүй байдлыг хангадаг	1052	95.6	100	13.1	35.6	30.6	15.0	5.7
Манай ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид авлига, хээл хахуулиас ангид хуулийн хүрээнд шударгаар ажилладаг	1056	96.0	100	10.2	24.4	43.5	10.9	7.1
Манай орон нутагт ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид харилцааны соёл, ёс зүйн төлөвшил сайтай	1066	96.9	100	9.6	30.9	33.5	15.6	7.3
Цагдаагийн байгууллага ажлаа огт хийдэггүй. Тэднийг юу хийж байгааг би мэдэхгүй	1044	94.9	100	4.7	14.2	39.6	23.8	12.5
Баянзүрх дүүргийн дундаж	1100	98.2	100	9.2	31.6	36.8	15.1	6.1

График 15. Тухайн нутаг дэвсгэрт цагдаагийн албан хаагч эргүүлийн үүргийг маш сайн гүйцэтгэдэг




График 16. Цагдаагийн алба хаагч иргэдээс хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг шуурхай бөгөөд хуулийн дагуу шийдвэрлэдэг




График 17. Иргэд гэмт хэрэг үйлдэгдсэн талаар мэдээлсэн тохиолдолд цагдаагийн байгууллага гэмт этгээдийг заавал олж тогтоон саатуулдаг




График 18. Цагдаагийн байгууллага гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг оновчтой хэрэгжүүлдэг




График 19. Цагдаагийн алба хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах мэргэжлийн ур ча




График 20. Цагдаагийн байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах чадвар




График 21. Цагдаагийн байгууллага манай гэр бүлийн аюулгүй байдлыг хангадаг




График 22. Манай ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид авлига, хээл хахуулиас ангид хуулийн хүрээнд шударг




График 23. Манай орон нутагт ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид харилцааны соёл, ёс зүйн төлөвшил сайтай.





График 24. Цагдаагийн байгууллага ажлаа огт хийдэггүй. Тэднийг юу хийж байгааг би мэдэхгүй.



2.1.7. Гэмт хэргийн талаарх чиг хандлагын үнэлгээ

Баянзүрх дүүргийн иргэдийн гэмт хэргийн талаарх төсөөллийг дараах түвшинд авч дүн шинжилгээ хийв. Үүнд:

- Улсын хэмжээнд гэмт хэргийн түвшин
- Улаанбаатар хотын хэмжээнд гэмт хэргийн түвшин
- Таны оршин сууж буй нутаг дэвсгэрийн хэмжээнд




Улсын хэмжээнд гэмт хэргийн түвшин ирээдүйн гэмт хэргийн түвшинтэй харьцуулахад ихэнх хүмүүс өснө 4 оноог өгч, тодорхой бус 3 онооны хариулт өгсөн байна. Харин Улаанбаатар хотын хэмжээнд өснө гэсэн 4 онооны хариулт 674 иргэн өгч, их өснө гэсэн хариулт мөн байна. Оршин сууж байгаа нутаг дэвсгэрийн хэмжээнд тодорхой бус хэмээн дийлэнх хүмүүс хариулт өгсөн байхыг харахад иргэд гэмт хэрэг их гардаг гэдэгт бүгд санал нэг байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 5. Гэмт хэргийн түвшиний үнэлгээ

Асуултууд	Судалгаанд оролцсон иргэдийн тоо	Дундаж үнэлгээ	Стандарт хазайлт	Их өснө	Өснө	Тодорхой бус	Буурна	Их буурна
Улсын хэмжээнд гэмт хэргийн түвшин	1094	99.5	100	3.6	16.4	55.6	21.8	2.0
Улаанбаатар хотын хэмжээнд гэмт хэргийн түвшин	1092	99.3	100	6.0	16.7	51.1	23.6	1.9
Таны оршин сууж буй нутаг дэвсгэрийн хэмжээнд	1098	99.8	100	1.3	14.5	55.6	26.9	1.5
Баянзүрх дүүргийн дундаж	1095	99.5	100	3.6	15.9	54.1	24.1	1.8

Хүснэгт 6. Гэмт хэргээс түгших ерөнхий хандлага

Асуултууд	Судалгаанд оролцсон иргэдийн тоо	Дундаж үнэлгээ	Стандарт хазайлт	Их айдастай байдаг	Айдастай байдаг	Тодорхой бус	Айдасгүй байдаг	Огт айдасгүй байдаг
Оройн цагаар гэртээ ганцаараа байх үед	1100	100	100	2.7	38.4	16.5	29.8	12.5
Оршин суудаг газартаа шөнийн цагаар ганцаараа алхах үед	1096	99.6	100	9.5	49.8	18	16.5	5.8
Хүүхдээ ганцааранг нь үлдээх үед	1092	99.3	100	23.3	49.3	14.8	9.5	2.6
Баянзүрх дүүргийн дундаж	1096	99.6	100	11.8	45.8	16.4	18.6	6.9




Судалгаанд оролцсон иргэдээс оройн цагаар гэртээ ганцаараа байх үед айдастай байдаг 4 оноог 43.2% нь өгсөн бол, тодорхой бус хариултыг мөн дийлэнх хүмүүс өгсөн байна. Оршин суудаг газартаа шөнийн цагаар ганцаараа алхах үед 4 оноо айдастай байдаг хариулт дийлэнх өгсөн ба хүүхдээ гганцааранг нь үлдээх үед их айдастай буюу 5 онооны хариулт их ирсэн байхыг харахад иргэд маань айдас дунд амьдардаг байна.




2.1.8. Гэмт хэргийн айдсын талаарх судалгаа:

Доорх асуултууд нь Таны болон бусад хүмүүсийн гэмт хэргээс айх явдлын түвшинг илэрхийлнэ.

Хүснэгт 7. Та доорх байдлаар гэмт хэрэгт хохирч болзошгүй гэж хэр зэрэг айдаг вэ?

Асуултууд	Судалгаанд оролцсон иргэдийн тоо	Дундаж үнэлгээ	Стандарт хазайлт	Их айдастай байдаг	Айдастай байдаг	Тодорхой бус	Айдасгүй байдаг	Огт айдасгүй байдаг
Өөрийгөө гэмт хэрэгт хохирч болзошгүй гэж	1100	100	100	6.5	42.9	26.9	18.2	5.5
Миний эхнэр, нөхөр эсвэл хамтран амьдрагч гэмт хэрэгт хохирч болзошгүй гэж	1090	99.1	100	4.7	46.5	31.5	11.8	4.5
Миний хүүхэд гэмт хэрэгт хохирч болзошгүй гэж	1096	99.6	100	14.5	43.6	22.2	14.5	4.7
Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй гэж	1094	99.5	100	6.9	27.5	30.9	22.0	12.2
Баянзүрх дүүргийн дундаж	1095	99.5	100	8.2	40.1	27.8	16.6	6.7





Өөрийгөө гэмт хэрэгт хохирч болзошгүй гэдэгт ихэнх хүмүүс айдастай байдаг 4 оноо, миний эхнэр, нөхөр эсвэл хамтран амьдрагч гэмт хэрэгт хохирч болзошгүй их айдастай 5 оноо өгсөн ба миний хүүхэд гэмт хэрэгт хохирч болзошгүй гэдэгт 758 хүн их айдастай байдаг 5 онооны хариулт өгсөн байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй гэдэгт тодорхой бус гэсэн хариулт их гарсан ба иргэд маань гэр бүл, ойр дотны хүмүүсээ гэмт хэрэгт өртөх вий хэмээн айдаг байна.

2.1.9. Тодорхой төрлийн гэмт хэргийн айдас:

Хүснэгт 8. Хүн бүр гэмт хэргийн хохирогч болохоос айдаг. Тиймээс дараах асуултууд нь Таны өдөр тутмын амьдрал дахь гэмт хэргийн айдсын төрлийг илэрхийлнэ.

Асуултууд	Судалгаанд оролцсон иргэдийн тоо	Дундаж үнэлгээ	Стандарт хазайлт	Их айдастай байдаг	Айдастай байдаг	Тодорхой бус	Айдасгүй байдаг	Огт айдасгүй байдаг
Хэн нэгэн миний амь нас, эрүүл мэндэд халдаж хохироож болзошгүй гэж	1100	100	100	5.3	39.8	34.4	16.4	4.2
Хэн нэгэн миний мөнгө болон эд хөрөнгийг хүч хэрэглэж авна гэхээс	1096	99.6	100	4.7	45.3	27.3	15.8	6.5
Хэн нэгэн миний мөнгө болон эд хөрөнгийг хулгайлна гэхээс /малын болон автомашин, халаасны хулгай/	1100	100	100	7.8	51.1	22.0	15.1	4.0
Хэн нэгэн миний эд хөрөнгийг залилан мэхлэж авна гэхээс	1092	99.3	100	7.8	37.1	27.6	21.8	4.9
Хэн нэгний бэлгийн халдлагад өртөнө гэхээс	1062	96.5	100	6.4	32.7	32.5	17.8	7.1
Хэн нэгэн миний эд хөрөнгийг санаатай устгаж, гэмтээж болзошгүй гэхээс	1096	99.6	100	9.1	38.9	32.5	14.5	4.5
Хэн нэгэн миний орон байранд хууль бусаар нэвтэрнэ гэхээс	1096	99.6	100	9.1	38.9	32.5	14.5	4.5
Хэн нэгэн намайг хууль бусаар мөрдөж сэтгэл санааны дарамтад оруулна гэхээс	1086	99.7	100	9.5	50.5	21.1	12.7	4.9
Нийгэм тэр чигээрээ гэмт хэрэгт автаж буйгаас айдаг	1086.4	97.6	100	14.4	48.2	19.6	12.4	3.1
Гэмт хэргээс болж үр хүүхэд минь амар тайван амьдрах боломжгүй болж буйгаас айдаг.	1078	98.0	100	20.7	43.5	21.8	8.9	3.1
Миний амьдарч буй газарт гэмт хэргийн гаралт асар их тул би айдаг.	1070	97.3	100	9.5	35.1	36.0	13.1	3.6
Баянзүрх дүүргийн дундаж	1095	98.7	100	9.5	41.9	27.9	14.8	4.6

Хэн нэгэн миний амь нас, эрүүл мэндэд халдаж хохироож болзошгүй гэж хүмүүс айдастай байдаг 4 оноо ихэвчлэн өгсөн бол, хэн нэгэн миний мөнгө болон эд хөрөнгийг хүч хэрэглэж авна гэхээс тодорхой бус айдастай 3 оноо өгсөн, хэн нэгэн миний мөнгө болон эд хөрөнгийг хулгайлах буюу малын болон автомашин, халаасны хулгай гэсэнд их айдастай явдаг гэж ихэнх хүмүүс хариулсан байна, Хэн нэгэн миний эд хөрөнгийг залилан мэхлэж авна гэхээс тодорхой бус 3 оноо, хэн нэгний бэлгийн халдлагад өртөнө гэхээс, хэн нэгэн миний эд хөрөнгийг санаатай устгаж, гэмтээж болзошгүй гэхээс, хэн нэгэн миний орон байранд хууль бусаар нэвтэрнэ гэхээс тус бус адилхан тодорхой бус 3 оноо өгсөн байна. Хэн нэгэн намайг хууль бусаар мөрдөж сэтгэл санааны дарамтад оруулна гэхээс айдасгүй дийлэнх нь 2 оноо өгч, нийгэм тэр чигээрээ гэмт хэрэгт автаж буйгаас айдаг 4 оноо айдастай явдаг, гэмт хэргээс болж үр хүүхэд минь амар тайван амьдрах боломжгүй болж буйгаас айдаг, миний амьдарч буй газарт гэмт хэргийн гаралт асар их тул би айдаг гэдэгт их айдастай 5 оноо өгсөн байна.

2.1.10. Сүүлийн 2 жилд гэмт хэрэгт хохирсон байдал (2017, 2018 он):

Хүснэгт 9. Та өнгөрсөн хоёр жилийн хугацаанд дор дурдсан хэлбэрээр хохирч байсан уу?

Асуултууд	Тийм	Үгүй эсвэл мэдэхгүй байна
Бусдын халдлагад өртөж бэртэж гэмтсэн	240	860
Эд хөрөнгөө хулгайд алдаж	406	694
Эд хөрөнгөө залилан мэхлүүлж	242	858
Эд хөрөнгөө дээрэмдүүлж болон булаалгаж	180	920
Зам тээврийн осолд өртөж	296	804
Хуурамч бараа бүтээгдэхүүн худалдан авч	312	788
Цахим гэмт хэрэгт өртөж	178	922
Авлига, хээл хахуулийн улмаас эрх ашиг хөндөгдөж	174	926
Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис (хар тамхи) хэрэглэж	132	968
Гүтгэгдэж, доромжлогдож	276	824
Хилсээр хэрэгт шийтгэгдэж	94	1006
Бэлгийн дарамт, хүсээгүй бэлгийн харьцаа	122	978
Гэр бүлийн хүчирхийлэл	130	970

Бусдын халдлагад өртөж бэртэж гэмтсэн 90% буюу ихэнх хүмүүс тийм гэсэн мхариулт өгсөн, эд хөрөнгөө хулгайд алдаж тийм 1 оноо, эд хөрөнгөө залилан мэхлүүлж тийм 1, эд хөрөнгөө дээрэмдүүлж болон булаалгаж, зам тээврийн осолд өртөж, хуурамч бараа бүтээгдэхүүн худалдан авч ихэнх хүмүүс тийм, цахим гэмт хэрэгт өртөж тийм 1, авлига, хээл хахуулийн улмаас эрх ашиг хөндөгдөж, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис (хар тамхи) хэрэглэж, гүтгэгдэж, доромжлогдож, хилсээр хэрэгт шийтгэгдэж, бэлгийн дарамт, хүсээгүй бэлгийн харьцаа, гэр бүлийн хүчирхийлэл гэсэн асуултанд ихэнх хүмүүс өртөж байсан байна.

2.1.11. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд Таны гэр бүлийн гишүүд, төрөл садан эсвэл сайн таньдаг хүмүүсийн чинь хэн нэгэн гэмт хэрэгт хохирч байсан уу?

Таны гэр бүлийн гишүүд, төрөл садан эсвэл сайн таньдаг хүмүүсийн чинь хэн нэгэн гэмт хэрэгт хохирч байсан бол ямар арга хэмжээ авсан талаарх асуултанд цагдаагийн байгууллагад мэдэгдсэн тохиолдол 321 нь тийм, гэр бүлийн гишүүдэд мэдэгдсэн 569 тийм, бусад хүнд мэдэгдсэн тохиолдол үлдсэн хүмүүс тийм гэх хариулт өгсөн байна.

Хүснэгт 10. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд Таны гэр бүлийн гишүүд, төрөл садан эсвэл сайн таньдаг хүмүүсийн чинь хэн нэгэн гэмт хэрэгт хохирч байсан уу?

Асуултууд	Хариулт	Дүүргийн хэмжээнд
Бие махбодын хувьд хохирсон	Тийм	22.7
	Үгүй	77.3
	Нийт тоо	1100
Эд хөрөнгийн хувьд хохирсон	Тийм	38.6
	Үгүй	61.5
	Нийт тоо	1100
Авилга, хээл хахуулийн улмаас хохирсон	Тийм	16.5
	Үгүй	83.5
	Нийт тоо	1100
Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис (хар тамхи) хэрэглэж хохирсон	Тийм	10.3
	Үгүй	89.6
	Нийт тоо	1100
Гэр бүлийн аливаа хүчирхийлэлд өртөж хохирсон	Тийм	45.1
	Үгүй	54.9
	Нийт тоо	1100

График 31. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд Таны гэр бүлийн гишүүд, төрөл садан эсвэл сайн таньдаг хүмүүсийн чинь хэн нэгэн гэмт хэрэгт хохирч байсан уу?



Бие махбодын хувьд хохирсон гэсэн тохиолдлыг дийлэнх оролцогчид буюу 567 иргэн тийм гэсэн хариулт өгсөн, эд хөрөнгийн хувьд хохирсон тохиоллыг 156 иргэн тийм гэсэн хариулт, авилга, хээл хахуулийн улмаас хохирсон 258 иргэн, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис (хар тамхи) хэрэглэж хохирсон 25 иргэн, гэр бүлийн аливаа хүчирхийлэлд өртөж хохирсон 121 иргэн тийм гэсэн хариулт өгсөн байна

Хүснэгт 11. Хэрэв Та өөрөө эсвэл Таны гэр бүлийн гишүүд, төрөл садан эсвэл сайн таньдаг хүмүүсийн чинь хэн нэгэн гэмт хэрэгт хохирч байсан бол ямар арга хэмжээ авсан бэ?

	Цагдаагийн байгууллагад мэдэгдсэн		Гэр бүлийн гишүүдэд мэдэгдсэн		Бусад хүнд мэдэгдсэн	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Тийм	496	45.0	496	45.1	318	28.9
Үгүй	604	54.9	604	54.9	782	71.1

График 32. Хэрэв Та өөрөө эсвэл Таны гэр бүлийн гишүүд, төрөл садан эсвэл сайн таньдаг хүмүүсийн чинь хэн нэгэн гэмт хэрэгт хохирч байсан бол ямар арга хэмжээ авсан бэ?






График 33. Хэрэв Та эд хөрөнгөө хулгайд алдах, дээрэмдүүлэх, залилан мэхлүүлэх гэмт хэрэгт өртөж байсан бол ямар эд хөрөнгийн хохирол амссан бэ?




Эд хөрөнгөө хулгайд алдах, дээрэмдүүлэх, залилан мэхлүүлэх гэмт хэрэгт өртөж байсан тохиолдлоос хамгийн их нь хувийн эд зүйлс буюу гар утас, хувцас зэргээ алдсан хүн 266 буюу судалгаанд оролцогчдын 22.4% нь байна. Харин үлдсэн хэсэг нь түрийвч, гар цүнх гэх мэт бусад зүйлсээ алдсан тохиолдлууд гэж хариулсан байна.

График 34. Хэрэв та гэмт хэргийн улмаас хохирч байсан бол дор дурдсан тодорхой газруудын хаана хохирч байсан бэ?



Таны гэр бүлийн гишүүд, төрөл садан эсвэл сайн таньдаг хүмүүсийн чинь хэн нэгэн гэмт хэрэгт хохирч байсан бол ямар арга хэмжээ авсан талаарх асуултанд цагдаагийн байгууллагад мэдэгдсэн тохиолдол 321 иргэн тийм, гэр бүлийн гишүүдэд мэдэгдсэн 569 тийм, бусад хүнд мэдэгдсэн тохиолдол үлдсэн хүмүүс тийм гэх хариулт өгсөн байна.

График 35. Хэрэв Та гэмт хэрэгт өртөж байсан бол дор дурдсан гэмт хэрэг үйлдэх арга эсвэл төстэй хэлбэрийн алинаар нь өртөж байсан бэ?




Гэмт хэрэгт өртөж байсан тохиолдлоос хамгийн их нь хувийн эд зүйлс буюу гар утас, хувцас зэргээ алдсан хүн 266 иргэн буюу 22.4% нь байна. Харин үлдсэн хэсэг нь түрийвч, гар цүнх гэх мэт бусад зүйлсээ алдсан тохиолдлууд гэж хариулсан байна.

Хүснэгт 12. Та дор дурдсан хүмүүсийн хэнийх нь халдлагад өртөж байсан бэ?

	Их, дээд сургуулийн оюутан, коллежийн болон дунд сургуулийн сурагч		Найзууд, хамтран амьдрагч болон хөрш оршин суугчид		Гэр бүлийн гишүүд болон төрөл садан		Байгууллагын дарга, хамт ажиллагсад		Бусад танил хүн		Танихгүй хүн	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Тийм	52	4.7	34	3.1	50	4.5	38	3.5	48	4.4	274	24.9
Үгүй	1048	95.3	1066	96.9	1050	95.5	1062	96.5	1052	95.6	820	74.5

График 36. Та дор дурдсан хүмүүсийн хэнийх нь халдлагад өртөж байсан бэ?



2.1.12. Өөрийгөө хамгаалах үйлдэл

Хүснэгт 13. Та өөрийгөө эсвэл эд хөрөнгөө гэмт халдлагаас хамгаалахын тулд дараах аргуудын аль нэгийг нь хэрэглэдэг үү.

Асуултууд	Судалгаанд оролцсон иргэдийн тоо	Дундаж үнэлгээ	Стандарт хазайлт	Бүрэн санал нийлнэ	Санал нийлнэ	Тодорхой бус	Санал нийлэхгүй	Огт санал нийлэхгүй
Би унтахаасаа өмнө хаалга болон цонхоо шалгадаг	1096	99.6	100	33.0	54.0	6.9	6.4	2.4
Би өөрийгөө хамгаалах зорилгоор бие хамгаалах болон дохио өгөх ямар нэгэн хэрэгсэл авч явдаг. (тухайлбал шүгэл, нулимс асгаруулагч, ангийн буу гэх мэт)	1090	99.1	100	8.2	20.5	26.2	23.6	20.5
Би оройн цагаар гадуур гарахдаа хэн нэгнээс хамт явахыг хүсдэг	1096	99.6	100	21.8	45.1	10.0	13.5	9.3
Би хохирогч болохгүй байх үүднээс аюултай газраар явахаас зайлсхийдэг	1094	99.5	100	30.7	48.7	8.7	7.1	4.2
Би оройн цагаар ганцаараа явах үедээ такси барихаас зайлсхийдэг	1088	98.9	100	17.6	36.4	25.8	11.8	7.3
Би хэдэн өдрөөр гэрээсээ хол явах үедээ хөршөөсөө манай гэрийг харж байхыг хүсдэг	1096	99.6	100	21.6	44.9	17.5	7.5	8.2
Мөнгө, гар утас, үнэт эдлэл зэргийг байнга найдвартай газар хадгалдаг	1068	97.1	100	29.6	43.8	16.5	3.6	3.5

Би өөрийгөө хамгаалах зорилгоор бие хамгаалах болон дохио өгөх ямар нэгэн хэрэгсэл авч явдаг. (тухайлбал шүгэл, нулимс асгаруулагч, ангийн буу гэх мэт)	1100	100	100	21.8	45.1	10.0	13.5	9.7
Нийт	1091	99.2	100	23	42.3	15.2	10.9	8.1

2.1.13. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон мэдээлэл харилцааны технологийн хэрэглээ

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын “Хөгжлийн төлөө дэлхийн нийтийн түншлэлийг хөгжүүлэх” зорилгын хүрээнд “Мэдээлэл холбооны шинэ технологийг хөгжүүлэх, мэдээлэлжсэн нийгэм байгуулах” зорилт дэвшүүлсэн билээ. Орчин үед мэдээлэл технологийн хэрэглээ эрчимтэй өсч, энэ төрлийн мэдээллийн хэрэгцээ нэмэгдсээр байгаатай холбогдож гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглах, сурталчлах нь нилээд ач холбогдолтой юм. Иймд судалгаанд оролцогчдоос олон нийтийн мэдээллийн хэрэгслийг хэр ашигладаг эсэхийг дараах асуултаар тодорхойллоо. Үүнд:


- Сонин хэвлэл хэр их уншдаг вэ?
- Радио хэр их сонсдог вэ?
- Телевиз хэр их үздэг вэ?

Хүснэгт 14. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон мэдээлэл харилцааны технологийн хэрэглээ

Асуулт	Хариулт	Судалгаанд оролцсон иргэдийн тоо, хувь	
		Тоо	Хувь
<i>Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглээ</i>			
Та сонин хэвлэл хир их уншдаг вэ?	Сард наад зах нь 1 удаа	250	22.7
	7 хоног наад зах нь 1 удаа	304	27.6
	Өдөр бүр	184	16.7
	Огт уншдаггүй	362	32.9
Та радио хэр их сонсдог вэ?	Огт сонсдоггүй	550	50.0
	Өдөр бүр	226	20.5
	Сард наад зах нь 1 удаа	130	11.8
	7 хоногт наад зах нь 1 удаа	194	17.6
Та телевиз хэр их үздэг вэ?	Огт үздэггүй	68	6.2
	Сард наад зах нь 1 удаа	40	3.6
	7 хоногт наад зах нь 1 удаа	212	19.3
	Өдөр бүр	780	70.9
<i>Гар утас, интернетийн хэрэглээ</i>			
Та гар утастай юу?	Тийм	1082	98.4
	Үгүй	18	1.6
Та гар утсаа сүүлийн 6 сар хэр их хэрэглэсэн бэ?	Огт хэрэглээгүй	10	0.9
	Сард наад зах нь 1 удаа	40	3.6
	7 хоногт наад зах нь 1 удаа	18	1.6
	Өдөр бүр	1032	93.8
Таны гар утасны төрөл?	Ухаалаг	946	86.0
	Жирийн	154	14.0
Та гар утсаараа цаг агаарын болон урьдчилан сэргийлэх мэдээ авдаг уу?	Тийм	836	76.0
	Үгүй	262	23.8
Та интернет хэрэглэж үзсэн үү?	Тийм	978	88.9
	Үгүй	122	11.1
	Мэдэхгүй	2	0.2


Хэрвээ та интернет хэрэглэдэг бол?	Сард наад зах нь 1-2 удаа	156	14.2
	Өдөр бүр	942	85.7
Та фейсбүүк, твиттер зэрэг хаягтай эсэх	Тийм	970	90.0
	Үгүй	130	11.8
Та фейсбүүк хаягтай бол орон нутгийнхаа ямар нэгэн групп бүлэгт нэгдсэн үү?	Тийм	754	68.6
	Үгүй	346	31.5

График 37. Та сонин хэвлэл хир их уншдаг вэ?



- сард наад зах нь 1 удаа
- 7 хоногт наад зах нь 1 удаа
- өдөр бүр
- огт уншдаггүй

График 38. Та радио хэр их сонсдог вэ?



- огт сонсдоггүй
- өдөр бүр
- сард наад зах нь 1 удаа
- 7 хоногт наад зах нь 1 удаа

График 39. Та телевиз хэр их үздэг вэ?




График 40. Та гар утастай юу?




График 41. Та гар утсаа сүүлийн 6 сар хэр их хэрэглэсэн бэ?




График 42. Таны гар утасны төрөл




График 43. Та гар утсаараа цаг агаарын болон урьдчилан сэргийлэх мэдээ авдаг уу?




График 44. Та интернет хэрэглэж үзсэн үү?




График 45. Та интернетийг хэр их хэрэглэдэг вэ.






График 46. Та фэйсбүүк, твиттер хаягтай юу.



Судалгаанд оролцсон иргэдийн 970 буюу 88.2% нь фэйсбүүк, твиттер зэрэг ашигладаг. Үлдсэн 130 иргэн фэйсбүүк хаяг, твиттер нээгээгүй байна. Үүнээс үзэхэд иргэд фэйсбүүкээр дамжуулан төрөл бүрийн мэдээ, мэдээлэл авдаг байна.

График 47. Та фэйсбүүк хаягтай бол орон нутгийнхаа ямар нэгэн групп бүлэгт нэгдсэн үү?



Судалгаанд оролцсон иргэдийн 754 иргэн буюу 68.6% нь фэйсбүүк хаягтай ямар нэгэн групп бүлэгт нэгдсэн, харин 346 нь буюу 31.5% нь фэйсбүүк хаяг, группд нэгдээгүй гэсэн хариулт өгсөн байна.

2.1.14. Судалгааны зарим нээлттэй асуултад оролцогчдын өгсөн хариултауд

1. Дүүргийн хэмжээнд хамгийн их үйлдэгдэж байгаа гэмт хэргийг нэрлэнэ үү.

- Архидалт /гудамж, олон нийтийн газар, гэр орондоо/;
- Хүний эрүүл мэндэд гэмтэл учруулах;
- Орчиндоо аюул учруулж болох амьтныг хамгаалалтгүй байлгаснаас хүүхэд хөгшидийг айлгах, нохойгоор уруулах;
- Эмнэлгийн буруу үйл ажиллагаанаас үйлдсэн эх, хүүхэд эндэгдэх;
- Архи, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ автомашин жолоодох;
- Сансарын тунелийн эргэн тойронд шөнийн цагаар байнгын зодоон, архидалт, дээрэм болдог.
- Сэтгэл санааны дарамтанд оруулах;
- Хэл амаар доромжлох;
- Орон гэргүй хүмүүс, согтуу хүмүүс, шил лааз түүгчид хөлдөх, осгох болон хүүхэд, хөгшүүл, ээжүүдийг айлгах, нийтийн эзэмшлийн газар танхайрах;
- 4-р хорооны цагдаа хулгайн /халаасны/ хэрэгтэй тэмцэхгүй байна. Камерууд нь оновчтой газар байрлаагүй;
- Хулгай /гар утас, өөртөө үйлчилдэг дэлгүүрээс хулгай хийх, орон байрны хулгай, автомашины эд зүйлийн хулгай/;
- Хүн алах;
- Гэр бүлийн хүчирхийлэл;
- Дээрэмдэх;

2. Зөрчлийн тухай хуульд заагдсан зөрчлүүдээс хамгийн их гардаг зөрчлийг нэрлэнэ үү?

- Гэр бүлийн хүчирхийлэл
- Шөнийн цагаар амгалан тайван байдал алдагдуулж, амраахгүй шуугилдах, архидах;
- Хог хаягдлын тухай хууль зөрчид хаа сайгүй хогоо хаях

3. Гэмт хэрэг, зөрчлийн шалтгааны талаар Таны бодол...

- Амар хялбар аргаар мөнгө олох гэсэн санаа;
- Ажилгүйдэл;
- Хувь хүний сэтгэлгээний онцлог;
- Ажил хийх дургуй, амар аргаар мөнгө олох гэсэн сонирхол ихтэй болсон.
- Бусад дүүргээс хүн амын төвлөрлөөрөө хамгийн их мөн гэр хороолол ихтэй дүүрэг, тиймээс зам талбай гудамжинд камерын хяналт, гэрэлтүүлэг дутмаг болон байхгүй учир гэмт хэрэг үйлдэгдэх таатай нөхцлийг бүрдүүлж байна
- Өндөр настай хүмүүс тэтгэвэрийн зээлтэй байгаа нь ядуурлыг бий болгож байна.
- Хувь хүн өөрийн хариуцлагаа дээшлүүлэх, сонор сэрэмжтэй байх;
- Цагдаа ажлаа сайн хийхгүй байна.
- Авилга, хээл хахууль;
- Замын түгжрэл;
- Залуу гэр бүл, хөгшид, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах төрийн бодлого хангалтгүй.
- Ёс бусын үйлдэл-авилгал, замын түгжрэл, залуу гэр бүл, хөгшид, хүүхдүүдийг /хөгжлийн бэрхшээлтэй иргэд/ дэмжих, хамгаалах, илүү цагаар ажиллахад цалинг бодож өгөх зэрэгт огт анхаардаггүй;
- Гэмт хэрэг гараад цагдаа нар ирж үзлэг шинжилгээ хийгээд өөрсдөө хулгай хийсэн эзнийг нь олж чадахгүй. Гэмт хэргийн золиос болсон хүн нь хэрэгтнийг олж өгчөөд байхад бэд-н цагдаа ажиллаж хүний хэргийг шийдэж өгч чадахгүй байхыг БЗД-ийн цагдаа сайн ажиллаж байна гэх үндэс байна уу.
- Өс хонзон санах;
- Сэтгэлгээний ядуурал, ухамсар доройтол;
- Хууль тогтоох гүйцэтгэх байгууллагууд шат шатандаа ажлаа хийдэггүй, төрийн бодлого алдагдсан.
- Дэлгүүрүүд өдөр бүр хямд архи зарж эр эмгүй архиддаг.
- Хувь хүн ямар хүн болж хүмүүжих нь ар гэр болон орчин тойрон, нийгэм бол хамгийн гол хүчин зүйл гэж боддог. Мөн ажилгүйдлийг багасгаж насанд хүрсэн хүмүүсийг заавал ажил хийлгэвэл гэмт хэрэг, архидалт, танхайрал тодорхой хэмжээгээр буурна гэж бодож байна
- Монгол Улсын хүн амын амьжиргаанд нөлөөлөх төрийн бодлого, оролцоо маш муу байгаатай холбоотой гэж бодож байна. Улс оронд бэрхшээл гарах бүрд ард иргэдээс татвар татаас авдаг нь амьжиргаанд хүндээр нөлөөлж байна. Улсаас хүний ухамсард нөлөөлөх бодлого ерөөсөө алга. Улсаа гэх ухамсарыг, эх орны хөгжилд цэцэглэлтэнд төлөөлөх ажлыг хийхгүй байгаа нь харамсалтай байдаг
- Иргэдэд архины хор уршиг, гэр бүлийн хүчирхийлэлийн талаар санал бодлоо сургалт, сурталчилгаа явуулах;
- Хувь хүмүүсийг хэрэг зөрчил гаргахгүй амьдралдаа хариуцлагатай, үүргээ ухамсарлаж байх талаар мэдээлэл өгөх, зарим архичдыг албадан ажил хийлгэх амьдралын хариуцлагыг нь албадан үүрүүлэх хэрэгтэй.

4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд ямар ажил арга хэмжээг түлхүү зохион байгуулвал илүү үр дүнтэй гэж үзэж байна бэ?

- Хуулийн хэрэгжилт маш сул, оногдуулж буй шийтгэл нь үйлдсэн гэмт хэрэг, зөрчилтэйгээ нийцдэггүй. Хуулийг ялгавартай хэрэгжүүлдэг, хууль тэгш үйлчлэх боломжоор ханга.

- Сургууль, цэцээрлэгт нас сэтгэхүйн онцлогт нийцсэн хичээл, сургалт зохион байгуулах;
- Хүүхдийн хүмүүжилд сурган хүмүүжүүлэгчид, эцэг эх маш сайн анхаарах;
- Хуулийг чангатгах, хуулиа хэрэгжүүлэх биелүүлэх;
- Иргэдийг хууль, эрх зүйн мэдлэгтэй болгох;
- Гэр хороололд эргүүл, цагдааг байнга ажиллуулах;
- Харанхуй гудамжийг гэрэлтэй болгох;
- Техник технологийн дэвшлийг ашиглах;
- Арын хаалга, танил тал гэдэг ухагдахууныг болих;
- Хэв журам сахиулах сургалт, цагдаагийн байгууллагын эрх, үүргийн тухай сурталчилгааг хийх, бага наснаас нь энэ талаар мэдлэг олгоход анхаарах;
- Үнэнч шударга албан хаагчид бэлтгэх, чин сэтгэлээсээ ажилдаа үнэнч байх;
- Камержуулалтыг оновчтой зөв газар байрлуулах;
- Ухуулга сурталчилгаа, ухуулга хуудас болон сургалт зохион байгуулахаас илүүтэйгээр *social* орчинд түгээх нь илүү хүргэлттэй байна.
- Архи согтууруулах ундаагаар үйлчлэж байгаа ААН-г цөөлөх.
- Хүмүүс ажил хийх сонирхолгүй байгаа, үүнийг албан ажил хийлгэх
- Гэмт хэрэг урьдчлан сэргийлэх ажил хөрсөн дээр буудаггүй, ард иргэдэд сайн хүрдэггүй
- ЕБС-д сурч боловсрох эрх маш ихээр зөрчигдөж байна.
- Иргэдээ ажилтай орлоготой болгох нь чухал
- Иргэдийг Монгол зан заншилд сургах, эх оронч үзэл төлөвшүүлэх.

5. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар ямар үйл ажиллагаа явуулвал зохистой вэ?

- Тодорхой бүлэгт чиглэсэн сургалт зохион байгуулах, албадан сургах;
- Цагдаа сайн ажиллах хэрэгтэй.
- Хөршийн харилцаа сайн байх;
- Эцэг эх, гэр бүлд хүчирхийлэл үйлдэж байгаа насанд хүрэгчдийг хүмүүжлийн эсрэг арга сургалт, гэр бүлд хүчирхийлэгч байх нь ямар эрсдэлтэй талаар сургалт зохион байгуулах;
- Айл өрх бүрт хүрч ажиллах;
- Иргэн болон хорооны ажилтанууд хоорондын харилцаа холбоог сайжруулах;
- Хувь хүний үнэлэмжийг дээшлүүлэх;
- Хамгийн гол нь архидалт, архи уусан иргэд л гэр бүлээ хүчирхийлдэг.
- Өрхийн тэргүүлэгчийн үүрэг хариуцлагыг үр хүүхдээ өсгөх хайрлах халамжлах анхааруулах;
- Архидаж гэр бүлдээ хүчирхийлэл үйлдэж байгаа хүмүүсийг албадан ажил хийлгэж, үүргийг нь ухамсарлуулах;
- Сургалт, сурталчилгаа хийх. Гэр бүлийн андгай тангараг өргүүлж байх;
- Гэр бүл төлөвлөлтөнд анхаарах;
- Нийгмийн сүлжээнд маш хүчтэй сурталчилгаа хийх хэрэгтэй.
- Хүүхэд болон залуучуудын, гэр бүлийн хүмүүжил хариуцлага ёс зүйг дээшлүүлэх сургалт, хичээлүүдийг тэдний онцлогт нийцүүлэн заах;
- Хүчирхийлэл хийж буй хүний талаар мэдээлэл өгсөн иргэнийг хамгаалах;
- Хорооны дарга нар болон хэсгийн ахлагч нарын анхаарал хэрэгтэй.
- Хүчин, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд оногдуулах ялыг чангатгах, ялыг нээлттэй байдлаар гүйцэтгэх;
- Ард иргэдтэй холбоотой байх, байнга хяналт тавих;
- Дор бүрнээ ухамсартай байх;
- Хөршийн холбоог үүсгэх, дахин сэргээх;
- Нийгэмд ил тод мэдээлэл ухуулга явуулах нь чухал.
- Гэр бүлийн хичээлд суулгах, дэлхийн зөнгөөс зохион байгуулдаг архины эмчилгээг явуулах

- Албадан ажил хөдөлмөр эрхлүүлэх, түүнчлэн өөр төрлийн шийтгэл ногдуулах;
 - Ажилгүйдлийг багасгах;
 - Гэр бүлийн хүчирхийллийн талаар хууль тогтоомжийг тодорхой болгох;
 - Гэр бүлийн дотоодын харилцаа буюу эцэг, эх, хүүхэд хоорондын бие биенээ гэсэн сэтгэлгээг сайжруулах;
 - Гэр бүл салах байдал дээр хариуцлага хуулиа чангалах, улсын бодлого явуулах, гэр бүлийн харилцааны тухай байгууллага иргэдэд яриа хийх;
 - Саатуулан хорих;
 - Хуулийн дагуу тууштай арга хэмжээ авах /ялгаж харгалзахгүйгээр/ жигд шудрага байх;
 - Нарийн судалгаа маш чухал. Судалгаанаас олон боломжууд гарч ирнэ.
 - Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүнийг хандах байгууллагыг тодорхой болгох
 - Гадны сайн туршлагаас суралцах;
 - Хуулийн мэдээлэл иргэдэд өгөх;
 - Хараа хяналттай байх;
 - Хүүхдүүдийг хайрлах, гэр бүлийн боловсролтой болгох сургалт зөвлөгөө өгөх, үр дүнтэй өгөх хэрэгтэй.
 - Бүр багаас нь сургуульд энэ талын мэдлэг боловсрол олгох, мөн их сургуульд үздэг байвал зүгээр байна. Энэ асуудал гэр бүлийн суурь хүмүүжилтэй холбоотой.
 - Согтууруулах ундаа худалдах, мөн үйлчилгээ явуулдаг байгууллагуудын үйл ажиллагаанд байнга хяналт тавьж 23.59 цагаас хойш согтууруулах ундаа зарахгүй байх
 - Сургууль цэцэрлэгийн багш нараар дамжуулж хүүхдүүдэд сургалт явуулах;
 - Ядуурлаас болж хүчирхийлэл явагддаг.
 - Хогоо хаяхгүй байх;
 - Тухайн хүчирхийлэгчийг албан ажил хийлгэх, өөрөөр нь ажил хийлгэж торгуулийг нь төлүүлэх хэрэгтэй.
 - Цагдаагийн байгууллага шуурхай ажиллагаатй болох, хөршүүд хамтран ажилагсдын мэдээлэл, ажиглалтыг сайжруулж мэдээллийг сайн дамжуулах;
 - Далд хүчирхийллийг илрүүлэх;
 - Хаалттай судалгаа явуулах.
 - Анх гэр бүл болж байгаа залуучууд бие биенээ сайн тавьж мэддэг болсны дараа гэр бүл болох, гэр бүлийн нандиын харилцааг бий болгох;
 - Архи зарах нөхцлийг сард 2-3 болгох.
 - Ихээр үйлдэгдэгдэж байгаа гэмт хэргийн талаар иргэдэд тухай бүр анхаарулга, сэрэмжлүүлэг өгөх;
 - Эрт гэр бүл болох нь сөрөг үр дагавартай байна.
 - Гэрлэхээс өмнөх сэтгэл зүйчид хандаж гэр бүлийн харилцааны үүрэг, хариуцлагын тухай сургалтанд хамруулах
 - Гэр бүлийн харилцааны талаар , эр эмээр нь, зөвөлгөө өгөх клубтэй болох, мэргэжлийн сэтгэл зүйч байх;

6. Хүрээлэн буй оряны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар Таны санал бодолб

- Сургалт явуулах;
- Камержуулалт;
- Хүрээлэн буй орчинд гарч болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд айл хөршийн хяналтын холбоог сайжруулах ажил зохион байгуулах. Хүн ихээр зорчдог гудамж талбайд гэрэлтүүлэгч камер зэргийг суурилуулах;
- Архидалт багасгаж ажлын байр бий болгох;
- Хүмүүсийн ухамсрын төвшин нь дорой. Нийгэм нь эмх замбраагүй байна.
- Ил цоожтой өрх бүрийг далд цоожтой болгох.

- Иргэдийн оролцоотой урьдчилан сэргийлэх талаар заавар зөвлөгөө өгөх;
- Айл бүр хогийн савтай, нохой нь уяатай, хашаа нь бүтэн эзэнтэй, архидалгүй байвал гэмт хэрэг, зөрчил гарахгүй.
- Хөршийн холбоо бүлэг нөхөрлөл зэргийг сайн зохион байгуулж ажиллах;
- Ойн байцаагчийн байшинг сайжруулах, техник хэрэгслээр хангах;
- Эх орны элс ширхэг шороо бүрийг үнэтэй гэдгийг хүүхдүүдэд ойлгуулах;
- Хяналт шалгалт маш сул байгаа нь үүнд нөлөөлдөг байх;
- Оройн цагаар автобусны буудал гудамжинд эргүүл тавих;
- Техник технологи, гэрэлтүүлэг сурталчилгаа ухуулга;
- Илүү сайн хяналттай, цагдаагийн пост оройн цагаар их гарах
- Хүн бүрийн хүмүүжил орчноо хамгаалах ухамсар их чухал;
- Торгууль шитгэлийг нэмэгдүүлэх;
- Хуулийг чангалах;
- Гадаа бие засахыг болиулах;
- Хороо, хорин багаар ажиллах, урьдчилан сэргийлэх хэрэгтэй.
- Гэрэлтүүлэг сайн хийх, аав ээжийн хараа хяналт сайн байх;
- Гудамжны камер холын тусгалтай байх;
- Ухуулга сайн хийх. Үүрэг нь сайн ухамсарлуулж, хууль хяналтаа танилцуулж тэрийг улам чангатгах;
- Хувь хүмүүст байгаль орчинтойгоо зөв зохистой харьцах соёлын талаар сургалт суртчилгаа явуулах;
- Цагдаа, төрийн бус байгууллага оройн цагаар эргүүл жижүүр цагийн хувиараар хийх
- Хувь хүний сонор сэрэмжтэй байдал.
- Орой үдэш сонор сэрэмжтэй явах;
- Айл бүрийг бүртгэлжүүлэх;
- Иргэний ухамсарт нөлөөлөх уриалгууд, торгууль өндөр байх;
- Хотын соёлд сургах хэрэгтэй. Торгодог эрхтэй байцаагч нарыг бэлтгэх;
- Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг түлхүү идэвхтэй явуулах;
- Энэ чиглэлээр мэргэшин ажиллаж буй хувь хүн, ТББ зэргийг дэмжих, хамтран ажиллах;
- Агаар, ус, ой, хөрсөө хамгаалах, ухуулга сурталчилгаа явуулах;
- Олон нийтийн цагдаа хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Дуудсан дуудлагын дагуу цаг тухайдаа ирж арга хэмжээ авах;
- Хууль шүүхийн байгууллагад анхаарлаа хандуулах хэрэгтэй.
- Согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээний газруудыг хяналтанд байлгах;
- Цаазын ялыг сэргээх;
- Архины хэмжээг багасгах;
- Хог хаягдлаа цаг хугацаанд нь авах;
- Ард иргэдийн ухамсрын төвшинг дээшлүүлэх;
- Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс сэргийлэхэд тухай орон сууцны СӨХ ажиллах ёстой.
- Ард иргэдийн амьдрал ахуй тааруу байгаа учраас өөр арга хэрэгслээр хуулийг ойлгуулах
- Авто машины хязгаарлалтанд хяналт тавих 1 өрхөд 1-3 авто машин байна. Дор хаяж 1-3 машинтай баян хүмүүс ч байдаг.
- Сайн дурын ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх;
- Бусдын хэрэг гэж тоохгүй байхаа болих;
- Шийтгэл нь хатуу байлгах;

7. Хүүхэд алга болох, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар:

- Хөршийн холбоог сайжруулж хүүхэд зорчих зам талбайг гэрэлтүүлэг камерын ажлыг хийж байнгын хяналт тавьж ажиллах. Олон газар байх тусам үр дүн нь сайн байна.

- Хүүхдийн орчин нөхцөл, хараа хяналт тавьж харгалзан хамт том хүнтэй байлгах;
- Эцэг эхчүүд үр хүүхдээ өөрсдөө зөөж анхаарал тавих. Сургууль, цэцэрлэг багш нар хамтарч уялдаа холбоотой ажиллах;
- Эргүүлийн цагдааг нэмэх шаардлагатай.
- Сайн сургалт цэцэрлэг сургуульд зохион байгуулах, сургалтын агуулгыг анхаарах.
- Их хэмжээний айдастай байдаг. Яг яах аргаа мэддэггүй.
- Сонор сэрэмжтэй байх;
- Сургуулийн эргэн тойронд хараа хяналт сайжруулах. Бага ангийн хүүхдийг асран хамгаалагч нь ирж авах;
- School police ажлыг идэвхижүүлэх;
- Эргүүл, цагдаа болон бусад байгууллагатай холбоотой ажиллах;
- Одоогийн байдлаар ямар ч урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа огт байхгүй улмаас хүүхэд маш ихээр алга болж байна.
- Гэрээс нь орой үдшийн цагаар гаргахгүй байх.
- Багш нартай тухай бүрт холбогдож мэдээлэл авах;
- Ер нь бүх гэмт хэргийг шийдвэрлэдэг цаазын ялтай болгох хэрэгтэй.
- Аав ээж багш сурган хүмүүжүүлэгч хажуу хавьд нь явж байгаа хүмүүс сонсор сэрэмжтэй байж, хүүхдүүдэд сайн хэлж сануулах;
- Ядуурал, иргэн ажил хийх сонирхолгүй бэлэнчлэх дуртай болсон.
- Facebook, twitter, instagram-аар суртчилгаа явуулах;
- Хүүхдэдээ цаг гаргаж, зөв амрах
- Хуулийн хүрээнд маш хатуу цээрлүүлж ухамсар суулгах
- Гэмт хэрэг хийсэн хүнийг хатуу шийтгэх. Яаж ямар арга хэмжээ авснаа тодорхой мэдээлдэг байвал/мөнгөн торгууль хэрэггүй/
- Гэр бүлийн хүчирхийлэлд байдаг хүүхэд алга болох шалтгаан болоод байна.
- Гэр бүлийн тогтворгүй байдал нөлөөлж байна.
- Энэхүү гэмт хэргийг үйлдвэл ямар ял, шийтгэл авдаг тухай сайн зарлах, үйлдсэн ялтанг харуулах, яриулах;
- Хүүхдийг гараас гарт өгөх;
- Гаалиар гарч байгаа зорчигчдыг сайн шалгах;
- Өөрийгөө хамгаалах наад захын мэдлэгтэй байх;
- Орчин тойрны хүмүүсийг сэтгэл зүйн оношилгоонд оруулах;
- Хятадуудыг эх орноосоо хөөн гаргах;
- Нийгмийн эмзэг бүлэгийг маш их хянах;
- Сэжигтэй хүнийг цагдаагийн газарт мэдэгдэх шаардлагатай.
- Сургуулийн орчинг цэгцлэх, зогсоол олгох, авах хүргэх зам олгох;
- Хүүхдүүдэд анхааруулж, эцэг эх хүүхэд л мэдэх хэлц, нэр, хочтой болох;
- Хүүхэд болон хүн худалдах хэрэг хийдэг баригдсан бол шууд нийтэд мэдэгдэх;
- Хүүхдэд сургалт, хичээл заах, мэдээллийн бүх сувгийг идэвхтэй ажиллуулах;
- Алга болсон гэдэг ч олсон үгүй нь мэдэгдэхгүй, дахин мэдээлэл нь муу байдаг.

8. Улаанбаатар хотын бусад дүүрэгтэй харьцуулахад Таны амьдарч байгаа дүүрэг юугаараа онцлог гэж үзэж байна вэ?

- Ядуурал, ажилгүйдэл;
- Гэр хороолол ихтэй;
- Хүн ам ихтэй, захын задгайд задгай байдаг өрх их, цэцэрлэг сургууль чанар муу учир хүмүүс ихэнхдээ хотын төв рүү хол хүүхдүүдээ явуулдаг. Хөршийн холбоо муу;
- Оршин суудаг хаягийн бус иргэд ихтэй;
- Ямар нэгэн онцлог байхгүй. Ямарч бүтээн байгуулалт хөгжил байхгүй. Зам гудамж муу.
- Архидалт ихтэй
- Танхай ихтэй.

- Эргүүлийн цагдаа огт байхгүй
- Хорооны засаг дарга, дүүргийн удирдлагууд ажлаа хийдэггүй
- Гудамжинд нохой эзэнгүй явдаг, хашаандаа нохойгоо уядаггүй, эзэнгүй нохой ихтэй.
- Явуулын түр оршин суугч олноор байршдаг. Гудамж талбай орц хонгил гэрэлтүүлэг муутай. Байршил нь замбраагүй.
- Чанаргүй гэрэлтүүлэг. Ажиллагаа нь муу камержуулалт
- Би СХД-т амьдардаг иргэн, БЗД-т ажилладаг. Харьцангуй СХД-с ялгаатай нь амьдралын боломж, архидалт харьцангуй бага гэж боддог.
- Машины зогсоол бага.
- БЗД-ийн 12-р хороо хогоо ачдаггүй, хүнд сурталтай
- Бохир заваан хогийн тээвэрлэлт муу, тохижуулалт муу
- Мод их хэмжээгээр тарих, эерэг сайхан орчинтой нийтийн эзэмшлийн талбайтай болох;
- Хүн ам олонтой учир гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ маш сайн авах хэрэгтэй
- Гэр хороолол руугаа камержуулах хэрэгтэй байна
- Ганц нэг архи үргэлжлүүлж уудаг хог түүгч нарыг хараа хяналтандаа авч хамгаалах хэрэгтэй юм шиг санагддаг юм.
- Энэ дүүрэгт баар, ресторан, дэн буудал ихтэй болохоор архидалт их, шөнө 0-5 цагт хөдөлгөөн намждаггүй.
- БЗД түгжрэл багатай, амьдрахад тайван орчинтой.
- Дэд бүтэц муу.
- Амьжиргааны түвшин доогуур тул ажилгүйдэл, амьжиргааны түвшин доогуур.
- Замын түгжрэл ихтэй.
- Хүн амын түвшинд ядуурал, гэмт хэргийн шинжтэй хэрэг их гардаг.
- Төрийн үйлчилгээ удаан хугацаагаар гацдаг.
- Согтуу орлиж чарласан хүн ихтэй, тайван амарч болдоггүй.
- Амарч зугаалах талбай байхгүй.

9. Улаанбаатар хотын бусад хороотой харьцуулахад Таны амьдарч байгаа хороо юугаараа онцлог гэж үзэж байна вэ?

- Орон байрны хулгай их гардаг.
- Хороонд ажилладаг албан хаагчид ажлаа сайн хийдэг.
- Хүн ам ихтэй, төрийн албан хаагч хүрэлцдэггүй, 27-р хороог хуваах хэрэгтэй
- Зам түгжрэлгүй;
- Нутаг дэвсгэр том;
- Улаанбаатар хотын төвөөс алслагдан байршдаг, иргэдийн дийлэнх нь мал аж ахуй эрхэлдэг учир гэмт хэрэг гарахад төлөөлдөг.
- Гэмт хэрэг;
- Хүн ам цөөн, баар буудал цөөн;
- Гэр хороолол ихтэй;
- Бар ихтэй, архичин олонтой;
- Цэвэрлэгээ, тохижилт, гэрэлтүүлэг;
- Хятад иргэд маш ихээр оршин суудаг.
- Гэрэлтүүлэг, камержуулалт сайн гэдэгт итгэдэггүй. Гэмт хэрэг бас л гараад байдаг/цагдаагийн ажиллах чадвар чухал/;
- БЗД-ийн зарим хороод хогоо цэвэрлэх хэрэгтэй.
- Гэр хороолол ихтэй, захууд ихтэй. Жишээ нь, да хүрээ нарантуул, дүнжингарав гэх мэт
- Цэнгээний газар ихтэй болохоор камержуулалт сайжруулах, шөнө ажиллаж байгаа газруудыг багасгах шаардлагатай;
- Гэрэлтүүлэг муу, хөршийн холбоо муу;

- Олон баар, дисконы газартай чимээ шуугиан ихтэй. Тайван амрах боломж муу. Орилж чарласан, агсам тавьсан хүн их;
- Хүн ам, ядуурал ихтэй;

10. Авто зам дээр гадраг ослын шалтгааныг Та юу гэж үздэг вэ?

- Жолооч, явган зорчигч дүрмээрээ явдаггүй;
- Хүлээцгүй, тэвчээргүй, амиа бодсон ууртай, ухамсаргүй, соёлгүйгээс болдог
- Анхааралгүй, болгоомжгүй;
- Ер нь ухамсартай холбоотой. Бүх л зүйлээс шалтгаална.
- Сурталчилгаа ухуулга, жолооны курсын чанар, стандартыг сайжруулах;
- Явган гарц тэмдэг тэмдэглээ маш муу;
- Замын эвдрэл гэмтэл.
- Автобусны зогсоол шийдэх;
- Жолооны үнэмлэхгүй сонирхогч жолооч манай нутаг дэвсгэрт их явдаг.
- Өөдөөс ирж байгаа машин гэрэл шилжүүлэхгүй байх.
- Хүүхдүүд замаар дураараа гүйдэг.
- Иргэд замын хөдөлгөөний хууль дүрмийн талаар ойлголт багатай.
- Дүрмээ зөрчдөг.
- Замын хувьд давчуу, замын түгжрэл ихтэй.
- Хүмүүсийн онгиороо зангаас их болдог байх, зарим жолооч нар би л гэсэн шиг байдаг.
- Соёлжуулах, амиа хичээсэн зангаас салах.
- Жолоо барьж явж байгаагаа жирийн ажил хийж байгаа мэт үздэг, нэг нэгнээсээ өрсөх гэж улайрдаг.
- Эгнээ байрлалаа буруу эзэлдэг.
- Согтууруулах ундааны зүйл хэрэглэснээс болдог юм боловуудаа, зарим жолооч нар маш их анхаарах нь зүйтэй.
- Хол ойрын гэрэл харагдах орчин, замын хальтиргаа, тэмдэг тэмдэглэгээ муу.
- Явган хүн хөдөлгөөнд оролцохдоо гарцын тэмдэг тэмдэглэгээтэй гарцаар гардаггүй.
- Хүмүүсийн тэвчээргүй зан.
- Замын хөдөлгөөний хэт их ачааллаас өсөл гарах шалтгаан илүү.
- Нэмэлт гэрэл, дохио муу.
- Замын буруу зохицуулалт;
- Нэг нэгэндээ зам тавьж өгөх, хүлээцтэй хандах соёлд суралцаагүй;
- Хөдөөний голдуу хүмүүс их байна.
- Жолоо бариж байх үед ээ бие биенээ хүндлэх , хэт их сүлжэж явахгүй байх;

11. Цагдаад хандах хандлага /үзэл бодлоо бичнэ үү/

- Сайн нь сайн, муу нь муу л байгаа харагддаг.
- Цагдаагийн албан хаагчид сайн ажилладаг гэж бодож байна.
- Ер нь цагдаагийн албан хаагчид гоц хийдэг зүйл хомс.
- Үнэнч шудрага байж танил талыг халах хэрэгтэй.
- Эргүүлийн үүрэг сайн гүйцэтгэж байх;
- Цагдаа иргэн 2 шууд хоорондоо уялдаа холбоотой ажиллах;
- Цагдаагийн байгууллагын ажлыг сайжруулах;
- Хорооны цагдаагийн мэдээлэл муу;
- Цагдаа нар миний бодлоор ажлаа сайн хийж чаддаггүй, хэтэрхий эдийн сонирхолтой худлаа хүмүүс, үнэн шүү.
- Дуудлага өгөхөд хүндрэлтэй. Гомдлыг хялбар шийдэх гээд байдаг.
- Цагдаагийн байгууллага нь харилцааны тал дээр асуудалтай.
- Хувь хүний нууцлалтай холбоотой учир цагдаагийн байгууллага ажилаа яаж хийж байгаа иргэд мэдэхгүй;
- Ёс зүй, харилцааны соёлтой байх.

- Миний амьдарч байгаа хороололд цагдаагийн ажилтан бараг л байдаггүй.

12. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар таны санал

- Ухуулга сурталчилгааг сайн явуулах;
- Хүмүүсийг амьдралд идэвхтэй болгох, үүргийг нь ухамсарлуулах, өөрсдөө хянуур болгоомжтой байж, эд хөрөнгөө хамгаалах хэрэгтэй.
- Эргүүлийн албан хаагчдыг илүү ихээр нэмэх шаардлагатай. Гэрэлтүүлэг хийх, камержуулах, гудамж зам талбайг илүү их цэгцтэй хороо, дүүрэг, хотхон бодлого хийх хэрэгтэй.
- Хүүхдийн хүмүүжилд маш бага наснаас нь анхаарах. Гэр бүлийн боловсрол эцэг, эхэд нийтээр нь өгөх;
- Гэр хорооллыг бүрэн камержуулах;
- Хариуцлагатай байх;
- Хуулийг чангатгасанаар ял шийтгэлээс айж гэмт хэргийн гаралт багасна.
- Хувь хүний хандлагыг сайжруулах;
- Цагдаа албан хаагч оройн цагаар эргүүлд явуулах;
- Өөрөөсөө л гэмт хэрэгт өртөх өртөхгүй нь шалтгаална гэдгээ ухамсрлах;
- Шөнө оройн цагаар архидуулдагаа болих. Энэ цагдаа нартай шууд холбоотой шүү. Цагдаад бүх эрх нь байхад яагаад гэмт хэрэг буурахгүй байгаа юм бэ.
- Иргэн хүн өөрөө маш хянамгай байх, аюулаас зайлсхийх, сэрэмжтэй байх;
- Ядуурал, ажилгүйдлийг төрийн бодлогын хэмжээнд авч үзэж, хяналт шалгалт сайжруулах;
- Цагдаагийн байгууллагын албан хаагчдыг чадваржуулах. Нэг цэг дээр хурдан шуурхай ажилуулах. Дадлага сургуулилт хийх. Камержуулалт эрс нэмэгдүүлэх;
- Иргэдэд урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл байнга өгч байх, хяналт, камержуулалт сайжруулах. Цагдаагийн байгууллага хурдан шуурхай гэмт хэрэгтэй тэмцэх;
- Хүүхэд болон замын хөдөлгөөнд болгоомжтой оролцох;
- Хөршийн холбоог сайжруулах, иргэдийн хараа хяналтыг идэвхжүүлэх;
- Иргэн бүр хуулийн мэдлэгтэй болох хэрэгтэй.
- Сурталчилгаа чухал /жишээ нь: яараад яахав дээ гэдэг арга хэмжээтэй адил;/
- Хувь хүн өрөө биедээ хамгаалалттай явах;
- Гэмт хэрэг үйлдэгдэж байгаа газрын ойролцоо тусламж авах цагдаагийн хэсэг байдаггүй, дуудлага өгөхөд бүх зүйл дууссан хойно ирдэг;
- Архины үйлдэвэрүүдийг багасгах иргэдийг ашигтай орлоготой байлгах;


Гурав. ХҮҮХДИЙГ ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТАНДАЛТ СУДАЛГААНЫ САНАЛ АСУУЛГЫН ДҮН

Судалгааны ажлын хүрээнд Баянзүрх дүүрэгт байрлах төрийн болон хувийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, багш нарыг оролцуулан “Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх” чиглэлээр нийт 147 хүнээс санал асуулгын судалгаа авснаас 141 нь хүчинтэй, 6 нь хүчингүй буюу дутуу бөглөсөн байна.

3.1. Судалгааны үр дүн

Хүснэгт 15. ЕБС-ийн хичээлийн хөтөлбөрт замын хөдөлгөөний талаарх сургалтыг оруулах шаардлагатай эсэх.


Нэн чухал шаардлагатай	67
Шаардлагатай	73
Шаардлагагүй	1
Мэдэхгүй	2



Хүснэгт 16. Хэрвээ ЕБС-ийн хичээлийн хөтөлбөрт замын хөдөлгөөний талаарх сургалтыг оруулах шаардлагатай гэж үзвэл, хэддүгээр ангиас уг хичээлийг заах нь зүйтэй вэ?

1-5 ангид нь	122
5-8 ангид нь	28
8-12 ангид нь	6
Мэдэхгүй	1

График 49.



Нээлттэй санал.

- 1-12 дугаар ангийн сурагчдад шат дараатай сургалт явуулах;
- Цэцэрлэгт замын хөдөлгөөний хичээл оруулах;
- Эцэг эхчүүдэд албан ёсоор сургалт, мэдээлэл хийх шаардлагатай.

Хүснэгт 17. “School police”-ийг ажиллуулах нь хир үр дүнтэй гэж үздэг вэ?

Хамгийн чухал	70
Үр дүнтэй	70
Үр дүн муутай	3
Шаардлагагүй	0


График 50.



Хүснэгт 18. Танай сургуулийн 1-5 дугаар ангийн хүүхдүүдийг автобусаар зөөх шаардлагатай эсэх


Нэн чухал шаардлагатай	50
Шаардлагатай	62
Шаардлагагүй	24
Мэдэхгүй	7

График 51.



Хүснэгт 19. Танай сургуулийн ойр орчим нь зам тээврийн осол гарах эрсдэлтэй бүс гэж та үздэг үү?


График 53.



Хүснэгт 21. БЗД-ийн хэмжээнд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээрх ажил ямар хувшинд хийгдэж байна вэ?

Тийм	Их	7
	Дунд	49
	Бага	36
Үгүй		11
Мэдэхгүй		40

График 54.



Хүснэгт 22. Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажил нь зөвхөн замын цагдаагийн албаны хариуцах ажил мөн үү?

Тийм	12
Үгүй	131



Хүснэгт 23. Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон ТББ-ыг татан оролцуулах нь үр дүнтэй юу?

Нэн чухал шаардлагатай	82
Шаардлагатай	59
Шаардлагагүй	2



Хүснэгт 24. Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажилд төсөв хөрөнгө шаардлагатай эсэх

Нэн чухал шаардлагатай	48
Шаардлагатай	83
Шаардлагагүй	11



Хүснэгт 25. Хүүхдийн ойр орчимд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахгүй байх нь хүчирхийлэл мөн үү?

Тийм	117
Үгүй	5
Мэдэхгүй	20



2. Нээлттэй асуулт: Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэхэд ямар ажил хийх шаардлагатай вэ?

2.1. Төрийн зүгээс:

- Замын тэмдэг тэмдэглэгээ болон төмөр үзүүлэнг нэмэгдүүлэх;
- Замыг өргөн болгох;
- Замын цагдаагийн тоог нэмэгдүүлж, хотын захад ажиллуулах;
- Сургалт, сурталчилгаа, лекц, кино, видео хийх;
- Явган хүний гарцыг нэмэгдүүлэх;
- Гэрлэн дохио, хурд сааруулагчийн тоог нэмэх;

- Гэр хорооллын доторх замыг засаж, зориулалтын гарц, тэмдэглэгээг олноор бий болгох;
- Жолооны курсын чанарыг сайжруулах (хугацааг 3 сар болгох);
- Сургууль, цэцэрлэгийг барихдаа байршлыг зөв сонгох;
- Хороо дүүргийн хэмжээнд сайн дурын ажилчдыг ажиллуулах;
- Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх талаар төсөл хэрэгжүүлэх;
- Сургууль хариуцсан цагдаагийн ажилтантай болох, сургуультай хамтын ажиллагаагаа сайжруулах;
- Сайн жолооч, сайн зорчигчыг шалгаруулж медал, шагнал олгох;
- Цагдаагийн байгууллагаас сургуулиудад улирал тутам сургалт зохион байгуулах;
- Дугуйн зам бий болгох;
- Нүхэн гарц хийх;
- Камержуулалтыг нэмэгдүүлэх;
- Social media-аар дамжуулан мэдээлэл олгох;
- Архи зарахыг хориглох;

2.2. Эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс:

- Эцэг эхийн замын хөдөлгөөнд оролцох боловсролыг нэмэгдүүлэх;
- Хүүхдийн цүнхэнд цацруулагч оёх;
- Замын хөдөлгөөний дүрмийг сахих;
- Хүүхдийг ганцааранг нь явуулахгүй байх;
- 1-5 ангийн сурагчдыг эцэг, эхчүүд хичээл тарахад нь авах;
- Хүүхдүүддээ зөв үлгэр дуурайлал үзүүлэх;
- 10 хүртэлх насны хүүхдийг замын хөдөлгөөнд ганцааранг нь оролцуулахгүй байх;
- Хүүхдийг жолоочийн хажуугийн суудалд суулгахгүй байх;
- Цацруулагч хантааз, ханцуйвч өмсгөх

2.3. Сургуулийн зүгээс:

- Сургуулийн хашаа хашлагыг сайжруулах;
- Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх талаар хүүхдүүдэд мэдээлэл олгох;
- Эцэг эхтэй хамтран ажиллах;
- Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;
- Сургуулийн автобустай болох;
- Эцэг эх, асран хамгаалагч ирж авсан тохиолдолд хүүхдийг явуулах;
- School police-ийн үйл ажиллагаанд хяналт тавих;
- Сургууль орчмын осол гэмтлийн тоог багасгах;
- Анги удирдсан багш нарт замын хөдөлгөөний хичээл, сургалт явуулах;
- Сургуулийн зүгээс санаачлан тодорхой үр дүнтэй ажил зохион байгуулах;
- Судалгаанд үндэслэж тодорхой ажил зохион байгуулах;
- Ухамсарт боловсрол олгох;
- Багш хичээлийн төгсгөлд 3-5 минутын хугацаатай сургалт явуулах

2.4. Бусад:

- Жолооч нар явган зорчигчыг хүндэтгэх

3.2. ДЭД ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ

Баянзүрх дүүргийн зөрчил, гэмт хэрэг нөхцөлийн талаарх авсан судалгаанд нийт 1100 хүн оролцсон ба эрэгтэй 408, эмэгтэй 692 иргэн оролцсон бөгөөд Баянзүрх дүүрэгт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчил нөхцөл байдлын судалгаанд оролцсон алба хаагчдаас 138 хүн буюу 12.5% нь маш хүнд нөхцөл байдалд байгаа, 172 иргэн буюу 15.6% нь их хүнд байгаа, хамгийн их буюу 424 иргэн буюу 38.5% нь хүндэвтэр байгаа, үлдсэн 50 иргэн бага хэмжээнд байгаа хэмээн хариулсанаас харахад гэмт, хэрэг зөрчлийн нөхцөл байдал хүндэвтэр байгаа гэж харагдаж байна.

3.3. ЗӨВЛӨМЖ

3.3.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

- Камержуулалт хийх. /Камерын тусгал хол, 24 цагаар ажилладаг байх/

- Цагдаагийн алба хаагчийн хүрэлцээг нэмэгдүүлэх;
- Гэр бүл төлөвлөлтийн чиглэлээр үнэ төлбөргүй сургалт явуулах;
- ЕБС-д гэр бүл төлөвлөлт, эрх зүйн чиглэлээр сургалтууд явуулах;
- Цэцэрлэгт гэмт хэрэг, зөрчил, гэр бүлийн хүчирхийлэл, хүний эрхийн тухай сургалт явуулах;/насны онцлогт тохируулж олгох, соёл урлагаар дамжуулах гэх мэт/
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цахим сүлжээг ашиглах аян явуулах;
- Хөршийн холбоог сэргээх, сайжруулах
- Эх оронч үзэл төлөвшүүлэх;
- ЕБС болон СӨБ-ийн багш нарын боловсролыг дээшлүүлэх;
- Гадаад орнуудын туршлага судлах;
- Архи зарах нөхцөлийг тодорхой болгох;
- Гадаа бие засах, нүхэн жорлонг багасгах;
- Гэрэлтүүлэг сайжруулах;
- Ажлын байрыг нэмэгдүүлэх;
- Хувь хүмүүст байгаль орчноо хайрлах, хамгаалах чиглэлээр сургалт зохион байгуулах;
- Хэсгийн байцаагчийн орон тоог нэмэх;
- Хэсгийн байцаагч нарын ажиллах нөхцөл, тухайлбал ажлын байр, өрөө тасалгаа, ширээ сандал, компьютерээр хангах;
- Иргэдийн хотыг соёлд сургах /хог хаяхгүй байх/;
- School police-ийн ажлыг идэвхижүүлэх
- Хууль бусаар амьдарч буй гадаадын иргэдийн гаргах;
- Зам гудамжны засвар үйлчилгээг хийх, тохижилт хийх;
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд оногдуулах хариуцлагыг чангатгах, зарим хууль зүйн хариуцлагыг нээлттэй байдлаар оногдуулах ;/олон нийтийн өмнө/
- ДХИС байрладаг тул багш, суралцагчдын хүчийг авах, дайчлах;
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжих, сурталчлах;
- Орцны жижүүрийн үйл ажиллагааг сайжруулах, хариуцлагажуулах;
- Архи согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуйн нэгжийг сар бүрийн тогтмол өдөрт үйлчилдэг болох;
- Хэсгийн байцаагч нарын орон тоог нэмэх. /урьдчилан сэргийлэх ажил хариуцсан байцаагчийн орон тоог бий болгох/
- Алслагдсан, томоохон нутаг дэвсгэртэй хороодын хэсгийн байцаагч нарыг тээврийн хэрэгслээр хангах;
- Гэр хорооллын айлуудын хаалганы түгжээг далд болгох;
- Монгол ёс заншлыг мэдүүлэх;
- Иргэдийн эрх зүйн ухамсар, соёлыг дээшлүүлэх талаар энгийн, хялбар байдлаар сургалт зохион байгуулах;

3.3.1.2. Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр:

- 55 дугаар сургууль БЗД-ийн захиргаа, БЗД-ийн НДХ-т ойрхон байдаг тул хөдөлгөөний эрчим ихтэй, эрсдэл өндөр байдаг. Эдгээр төрийн байгууллагаар үйлчлүүлдэг иргэд сургуулийн хашаанд орж ирж машинаа байрлуулдаг тул зогсоолыг нь зорчих замаас хол байрлуулж, хурд сааруулагч хийх.
- ҮБХИС-ийн хойд замын явган хүний гарцанд сурагч хүүхдийн төмөр үзүүлэн байрлуулж өгөх.
- 120-р сургууль гэр хороолол дунд байрладаг. Хашаа байшингийн булан тохой их, тэмдэг, тэмдэглэгээ хийх, Хужир булангийн “Тэгш хэм” дэлгүүрийн ойролцоох зам дээр хурд сааруулагч хийх шаардлагатай.
- Түгээлт, хүргэлтийн машинууд ялангуяа MSC үйлдвэрийн машинууд хурд хэтрүүлж их зорчдог.
- Сургууль орчмын авто замыг сайжруулах санаачилга гаргаж, бүх сургуульд төсөл хэрэгжүүлэх.

- “Шинэ Монгол” Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтарч сургагч багш бэлдэх, хамтарч ажиллах.
- Техникийн захын ойролцоо, авто замд ойрхон тул эрсдэл өндөр.
- 13-р хороололд машины хөдөлгөөн, төвлөрөл их, ойрхон гэртэй сурагчид ганцаараа зорчдог.
- 44-р сургууль 2 талаар зам байдаг, гурван ээлжээр хичээллэдэг тул эрсдэл өндөр.


БҮЛЭГ 4. “БАЯН ЗҮРХ ДҮҮРГИЙН 5-Р ХОРООНЫ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ” КРИМИНОЛГИ СУДАЛГААНЫ ДЭД ТАЙЛАН

Судалгааны дэд баг: Цагдаагийн сургуулийн
Цагдаагийн эрх зүйн тэнхимийн дэд профессор,
цагдаагийн дэд хурандаа Б.Баянмөнх, магистрант
Ч.Ганбат нар хийж гүйцэтгэв.

4.1. Хорооны нутаг дэвсгэр, хүн ам, нийгмийн байдал, онцлог

4.1.1. Хорооны нутаг дэвсгэрийн онцлог, хил хязгаар

БЗД-ийн 5 дугаар хороо нь 1961 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор Найрамдлын районд байгуулагдсан, 447 га газар нутгийг хамарсан нутаг дэвсгэртэй, баруун талаараа Жуковын музейгээс чигээрээ хойшоо, зүүн талаараа Кино үйлдвэрийн жалгаар чигээрээ хойшоо 4, 22-р хороотой хиллэдэг.



Тус хорооны нутаг дэвсгэр рүү орж гарсан 65 зам байгаагаас засмал зам 20 буюу 31.2%, шороон зам 45 буюу 68.8%-ийг тус тус эзэлж байна.

4.1.2. Хорооны хүн ам, бүтэц, тэдгээрийн онцлог

БЗД-ийн 5 дугаар хороо нь 6300 өрхийн 23600 орчим хүн амтай, хорооны нутаг дэвсгэрт 199 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулдаг томоохон хороо юм.

Тус 5-р хорооны хүн амын өсөлтийг 5 жилийн байдлаар авч үзвэл 2015 онд 2125 нэгж буюу 11.2%, 2016 онд 772 нэгж буюу 3.6%, 2017 онд 1263 буюу 5.8%, 2018 онд 542 нэгж буюу 2.3% тус тус өссөн байна. Энэ нь 5 жилд дунджаар 1175.5 нэгж буюу 5.72%-ийн өсөлтийн хурдтай байна.

Хорооны нутаг дэвсгэрт 2014 онд 1 га-д 60.8 хүн ногдож байсан бол 2015 онд 6.8 буюу 11.1%, 2016 онд 2.5 буюу 3.6%, 2017 онд 4.1 буюу 5.8%, 2018 онд 1.7 буюу 2.2%-иар тус тус өссөн байна. Энэ нь 5 жилийн дунджаар 1 га-д 5.67% нягтаршилтайгаар хүн ам нэмэгдэж байна.


Үүнийг хорооны нутаг дэвсгэрт нийтийн орон сууц ихээр баригдаж, шинэ оршин суугчид шилжин ирж байгаатай холбон үзэж болохоор байна.

Хорооны өрхийн өсөлтийн хурдыг 5 жилийн байдлаар авч үзвэл 2015 онд 619 нэгж буюу 11.2%, 2016 онд 256 нэгж буюу 4.19%, 2017 онд 1263 буюу 5.8%, 2018 онд 542 нэгж буюу 2.3% тус тус өссөн байна. Энэ нь 5 жилд дунджаар 1175.5 нэгж буюу 5.72%-ийн өсөлтийн хурдтай байна.

БЗД-ийн 5-р хорооны хүн ам зүйн онцлогийн хувьд 2014 онд 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх 197, өрх толгойлсон эцэг 156, өрх толгойлсон эх 138, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 311 байна. 2017 онд 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх 84.1%-иар буурсан буюу 107, өрх толгойлсон эцэг 3.3%-иар буурсан буюу 151, өрх толгойлсон эх 1.4%-иар буурсан буюу 136, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 10.6%-иар нэмэгдсэн байна.

2016 онд 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх 2015 оныхоос 36%-иар нэмэгдсэн, өрх толгойлсон эцэг 40%-иар нэмэгдсэн, өрх толгойлсон эх 33.3%-иар нэмэгдсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 20.9%-иар буурсан байна.


График 4.1. Хүн амын бүтэц



2017 оны хувьд хүн амыг өмнөх оныхтой харьцуулвал 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх 10.%-иар нэмэгдсэн, өрх толгойлсон эцэг 22.6%-иар буурсан, өрх толгойлсон эх 20.6%-иар буурсан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 88%-иар буурсан байна.


2018 оны хувьд өмнөх онтой харьцуулахад 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх 13.6%-иар нэмэгдсэн, өрх толгойлсон эцэг 6.1%-иар буурсан, өрх толгойлсон эх 7.4%-иар буурсан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 92.3%-иар өссөн байна.

График 4.2. Хүн амын онцлог



5-р хороонд 2014 онд ус түгээх байр 13 байсан бол 2015 онд 12, 2016 онд 12, 2017 онд 11, 2018 онд 9 болж буурсан байна. Халуун усны газар 2014 онд 4, 2015 онд 5, 2016 онд 5, 2017 онд 4, 2018 онд 6 болсон байгаа нь жилд дунджаар 20%-иар өссөн дүн гарч байна.

График 4.3. Баянзүрх дүүргийн 5-р хорооны гэрэлтүүлгийн үзүүлэлт




Гэрэлтүүлэгтэй гудамж 2014 онд 10 байсан бол 2015 онд 17 буюу 70%, 2016 онд 19 буюу 11.7%, харин 2017 онд 18 болж 5.2%-иар буурч, 2018 онд 18 хэвэндээ гэсэн судалгаа гарч байна.

Хүүхдийн тоглоомын талбай 2014, 2015, 2016, 2017 онуудад 14 байсан бол 2018 онд 18 болж 4 буюу 28.5%-иар өссөн байна.

Тус 5-р хороонд иргэд, олон нийт чөлөөт цагаа өнгөрөөх цэцэрлэгт хүрээлэн, усан оргилуур зэрэг тохижуулсан олон нийтийн газар байдаггүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 43 байгаагаас асаргаатай 34, асаргагүй 9 хүүхэд байна. Эдгээр хүүхдүүдээс сургуульд сурдаг 14, гэртээ байдаг 18, цэцэрлэгт явдаг 4, бага насны 7 хүүхэд байна.

График 4.4. Насанд хүрээгүй хүмүүсийн нийгмийн үзүүлэлт




Хөдөлмөрийн төрөлхийн чадваргүй 69, хараа хяналтгүй 1 хүүхэд байдаг. Тус хороонд 2019 оны 09 дүгээр сарын 13-ны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 287 иргэн амьдарч байна.

Эрхэлсэн тодорхой ажилгүй иргэдийн судалгаа 2019 он

2019 оны байдлаар тус хороонд нийт ажилгүй 167 иргэн байгаагаас 100 буюу 40% нь эмэгтэй, 67 буюу 60% нь эрэгтэй байна.


Ажилгүй иргэдийн насны байдлыг авч үзвэл 88 буюу 53% нь 18-34 насны, 58 буюу 35% нь 35-50 насны, 21 буюу 12% нь 51 ба түүнээс дээш насныхан эзэлж байна.

График 4.5. Хүн амын ажил эрхлэлтийн байдал



Эрхэлсэн тодорхой ажилгүй иргэдийн мэргэжил эзэмшсэн байдлын хувьд эрх зүйч-4 буюу 2%, техникч-1 буюу 0.5, багш-1 буюу 1%, эм найруулагч-1 буюу 0.5%, мэргэжилгүй 160 буюу 96%-ийг тус тус эзэлж байна.

График 4.6. Эрхэлсэн тодорхой ажилгүй иргэдийн мэргэжил эзэмшсэн байдал



Дээрх иргэдийн 96%-ийг мэргэжилгүй бөгөөд 146 буюу 88%-ийг хөдөлмөр эрхлэх насны залуучууд эзэлж байна. Энэ нь дүүргийн ажилгүй иргэдийг мэргэжилтэй болгох, ажлын байраар хангах ажил хангалтгүй явагдахгүй байгаа, нөгөө талаараа иргэд өөрсдөө ажил хийх хүсэл сонирхол байхгүй байгаатай холбон үзэж болохоор байна.


4.1.3. Баянзүрх дүүргийн 5-р хорооны субьктийн судалгаа

Гэр орондоо болон ойр орчиндоо түгшүүр төрүүлдэг архаг архичин хүмүүсийн судалгаа

2019 оны эхний 11 сарын байдлаар тус хороонд гэр орондоо болон ойр орчиндоо түгшүүр төрүүлдэг архаг архичин 11 иргэн байгаагаас ажил хөдөлмөр эрхэлдэг 4 буюу 36%, ажил хийдэггүй 7 буюу 64% нь байна.

Дээрх 11 иргэнээс 2 буюу 18 % нь өмнө нь албадан эмчилгээнд хамрагдаж байсан, харин 9 буюу 82 % нь огт хамрагдаж байгаагүй гэсэн судалгаа гарч байна.


График 4.7. Албадан эмчилгээнд хамрагдсан архаг архичдын үзүүлэлт



Тухайн иргэдийг сайн дураар архинаас гарах эмчилгээнд хамруулах боломжийг олгох, хамрагдахгүй байгаа тохиолдолд албадан эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах нь гэмт хэрэг, зөрчлийг бууруулах нэг хүчин зүйл болно.

Архаг архичдын 4 буюу 36% нь тодорхой мэргэжилтэй, 7 буюу 64% нь мэргэжилгүй, хүйсийн байдлыг авч үзвэл 1 буюу 9% нь эмэгтэй, 10 буюу 91% нь эрэгтэй байна.

График 4.8. Архаг архичдын мэргэжил эзэмшсэн байдал



Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, хяналтад байдаг иргэдийн судалгаа

2019 оны 11-р сарын байдлаар тус хороонд гэр бүлийн хүчирхийлэл үйлдээд хэсгийн байцаагчийн захиргааны хяналтанд орсон 10 иргэн байна.

Эдгээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч иргэдийн үйлдлийн хэлбэрийг нь авч үзвэл бие махбодийн хүчирхийлэл -1 буюу 10%, сэтгэл санааны хүчирхийлэл—4 буюу 40%, эдийн засгийн хүчирхийлэл—2 буюу 20%, бэлгийн хүчирхийлэл—1 буюу 10%, сэтгэл санаа, бие махбодийн хосолсон хүчирхийлэл – 2 буюу 20%-ийг тус тус эзэлж байна.

Хүчирхийлэл үйлдсэн шалтгааныг судлан авч үзвэл хардал 1 буюу 10%, шашин шүтлэг болон эдийн засгийн 1 буюу 10%, гэр бүлийн маргаан – 5 буюу 50%, эдийн засгийн маргаан – 2 буюу 20%, гэр бүлийн маргаан – 1 буюу 10%-ийг тус тус эзэлж байна.

График 4.9. Хүчирхийллийн хэлбэр






График 4.10. Хүчирхийллийн шалтгаан



Дээрх хүчирхийлэл үйлдэгч иргэдийн ажил хөдөлмөр эрхлэлтийн байдлыг авч үзвэл 1 буюу 10% нь ажил хөдөлмөр эрхэлдэггүй, 9 буюу 90% нь тодорхой ажил хийдэг иргэд байна.

Насны байдлыг авч үзвэл 25-35 насны иргэн 7 буюу 70%, 36-50 насны иргэн 3 буюу 30%-ийг тус тус эзэлж байна.

График 4.11. Хүчирхийлэгчийн нас хүйс, ажил эрхлэлт




Захиргааны хяналтад байдаг иргэдийн судалгаа

2019 оны 11-р сарын байдлаар тус хороонд хэсгийн байцаагчийн захиргааны хяналтанд байдаг 20 иргэн байна.

Эдгээр иргэний захиргааны хяналтанд орсон хэргийн үйлдлийн хэлбэрийг нь авч үзвэл бусдын биед хүндэтэр гэмтэл учруулсан - 3 буюу 15%, бусдыг дээрэмдэх - 1 буюу 5%, бусдын эд хөрөнгийг хулгайлах - 6 буюу 30%, танхайрсан - 5 буюу 25%, хүчиндэх гэмт хэрэг - 1 буюу 5%, албан тушаалын гэмт хэрэг - 1 буюу 5%, зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдсэн - 1 буюу 5%, бусдыг санаатай алах гэмт хэрэг үйлдсэн - 2 буюу 10%-ийг тус тус эзэлж байна.

График 4.12. Захиргааны хяналтанд байгаа хүмүүсийн үйлдсэн гэмт хэргийн тоо



Дээрх судалгаанаас харахад танхайрах, хулгайлах, хүний биед хүнд гэмтэл учруулах гэмт хэрэг үйлдсэний улмаас хорих ял эдэлсэн, тэнсэн харгалзах ялаар шийтгэгдсэн иргэд 14 буюу нийт хяналтад байгаа иргэдийн 70.0%-ийг эзэлж байгаа нь асуудал болж байна.

Захиргааны хяналтад байгаа иргэдийн оршин суугаа байршил, орчин нөхцлийг нь авч үзвэл гэр хороолол 13 буюу 65%, орон сууцанд 7 буюу 35% нь тус тус амьдарч байна.

Энэ нь хорооны төв хэсгээс алслагдсан, хяналтад байгаа иргэдэд тавих хяналтыг бууруулж байгаа, нөгөө талаараа хэсгийн байцаагч уг иргэдийн ажилд орох, амьдрах орчин нөхцөлд нь хяналт тавих үүрэг хүлээдэггүй, гагцхүү дахин гэмт хэрэг, зөрчил гаргуулах байлгах чиглэлээр хяналт тавих үүрэг хүлээдэг.

График 4.13. Захиргааны хяналтад байгаа иргэдийн амьдарч буй орчин




Сэтгэцийн өвчтэй иргэдийн судалгаа

Тус хороонд сэтгэцийн өвчтэй нийт 16 иргэн байгаа бөгөөд хүйсийн харьцааг авч үзвэл эрэгтэй 5, эмэгтэй 11 иргэн байна.

Өвчний төрлөөр нь авч үзвэл оюуны хомсдолтой - 8, сэтгэцийн өөрчлөлтэй 4, ДЦП-тэй 1, Резидуальны 4-6-б - 1, мэдрэлийн сааталтай - 1, Оюуны хүндэвтэр хомсдол - 1 байна.

График 4.14. Сэтгэцийн өвчтэй хүмүүсийн байдал



Дээрх иргэдээс гэмт хэрэг, зөрчил үйлдэх боломжтой бөгөөд гагцхүү үйлдсэн гэмт хэрэг, зөрчил нь тооцогдохгүй байх магадлалтай боловч түүнд тавих хяналт байхгүй нь асуудал болоод байна.

Оршин суух хаяг нь тодорхойгүй, тэнүүчлэн амьдардаг иргэдийн судалгаа

Тус 5-р хороонд байнгын оршин суух хаяг нь тодорхойгүй, тэнүүчлэн амьдардаг 7 иргэний судалгаа байна. Гэвч эдгээр иргэд рүү хандсан дүүргээс явуулж буй тодорхой нийгмийн халамжийн чиглэл ажил, арга хэмжээ учир дутагдалтай байна гэж судлаачийн хувьд үзэж байна.


График 4.15. Оршин суух хаяггүй тэнэмэл иргэдийн тоон үзүүлэлт



4.2.Хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагааны явуулж буй үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, төрийн болон төрийн байгууллага, түүний онцлог

4.2.1.Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний аж ахуйн нэгжийн судалгаа

График 4.16. Аж ахуйн нэгж байгууллагын тоон үзүүлэлт



5-р хороонд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг үйл ажиллагааных нь чиглэлээр авч үзвэл түргэн үйлчилгээний цэг 12 буюу 6%, нийтийн хоолны чиглэлээр 19 буюу 10%, гэр ахуйн засвар үйлчилгээний чиглэлээр 9 буюу 5%, зөөврийн худаг 9 буюу 5%, дэлгүүрийн үйл ажиллагааны чиглэлээр 104 буюу 55%, аж ахуйн үйлчилгээ 30 буюу 16%, жолооны курс 3 буюу 2%-ийг тус тус эзэлж байна.

Өөрөөр хэлбэл, аж ахуйн нэгж, байгууллагын дийлэнх хувийг худалдаа, үйлчилгээний дэлгүүр эзэлж байгаа бөгөөд үүнийг хорооны нийт хүн амтай харьцуулбал 226.9 хүн тутам 1 дэлгүүр ногдож байна.

4.2.2.БЗД-ийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг сууц өмчлөгчдийн холбоодын судалгаа

Хүснэгт 4.1. СӨХ-ийн судалгаа


№	СӨХ нэр	Хариуцдаг байр
1	Амь нэг	89, 75-р байр
2	Эрдэм 60	74А-р байр
3	Сансар өргөө 42	42-р байр
4	Ус чандмань Эрдэнэ	71а байр
5	Хамтын хүч	6-байр
6	Баян өргөө	202, 203, 205, 15-р байр
7	Жуков СӨХ	50/1, 50/2 байр
8	Аска	66/5-р байр
9	Сэлэнгэ 888	Тарвилан хотхоны 48А,Б, В, Г, Д-р байрууд
10	Өрнөлт	9а, 9б, 11-р байр
11	МТА өргөө	87-р байр
12	85А,Б байрны СӨХ	85 а,б-р байр
13	Эвсэг-57	81-р байр
14	Булна Ар	Хаппи таун хотхоны 71, 72, 73-р байр
15	Баян хаан	30-р байр
16	Жукав Таун	47б байр
17	Роме жульята	46А,Б байр
18	Эрч хишиг	

Гэвч сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагаа нь гагцхүү байрны тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээ рүү чиглээд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээ авч хэрэгжүүлдэггүй нь гэмт хэрэг, зөрчил гарахад тодорхой хэмжээгээр нөлөөлж байна гэж үзэж байна.

4.2.3. Оршин суугчдын сууцны төрөл

2019 оны 10 сарын 08-ны байдлаар 5-р хороонд 367 иргэн түр оршин сууж байна. Тус хороонд 6458 өрх байгаагаас 2379 өрх буюу 37% нь монгол гэрт, 2605 өрх буюу 40% нь нийтийн орон сууцанд, 1347 өрх буюу 21% нь байшинд, 127 өрх буюу 2% нь нийтийн байранд тус тус амьдарч байна.

График 4.17. Баянзүрх дүүргийн 5-р хорооны орон сууцны судалгаа



Тус хороонд оршин суух өрхүүдийн телевизор, компьютер, интернетийн тоо, хэрэглээ, амьдарч буй сууцны төрөл тус бүрээр гаргасныг доорх “Хүснэгт 4.2”-с үзнэ үү.


Хүснэгт 4.2. Баянзүрх дүүргийн 5-р хорооны орон сууцны судалгаа

№		МД	5-р хороо						
			Бүгд	Үүнээс: Сууцны төрлөөр					
				Монгол гэрт	Нийтийн орон сууцанд	Сууцны тусдаа байшинд	Нийтийн байранд	Бусад	
А	Б	1	2	3	4	5	6		
1	Нийт өрхийн тоо	1	6458	2379	2605	1347	127	0	
2	Үүнээс: Телевизортой өрх	2	6458	2379	2605	1347	127	0	
3	Өрхөд байгаа телевизорын тоо	1	3	5917	2375	2095	1320	127	0
		2	4	463	4	432	27	0	0
		3	5	78	0	78	0	0	0
		4	6	0	0	0	0	0	0
4	Телевизор - Бүгд	7	7104	2383	3193	1374	127	0	
5	Бүгдээс:	Өнгөт	8	7104	2383	3193	1374	127	0
Хар, цагаан		9	0	0	0	0	0	0	
7	Компьютертэй өрхийн тоо	10	3077	517	1844	701	15	0	
8	Үүнээс: Интернэтэд холбогдсон өрх	11	2602	293	1792	502	15	0	
9	Өрхөд байгаа компьютерийн тоо-Бүгд	12	3077	517	1844	701	15	0	

10	Үүнээс: Зөөврийн компьютер (Laptop)	13	587	85	400	92	10	0
----	-------------------------------------	----	-----	----	-----	----	----	---

4.2.4. Хүн амын бүтцийн судалгаа
2-39 насны хүн амын сургуулийн өмнөх боловсрол, сургуульд хамрагдалтын байдал, хүйсээр

График 4.18. Баянзүрх дүүргийн 5-р хороон хүн амын сургуулийн өмнөх боловсрол эзэмшсэн байдал



2-39 насны хүн амын сургуулийн өмнөх боловсрол, сургуульд хамрагдалтын байдал

Тус хороонд 7676 иргэн нь сургууль, боловсролын байгууллагад хамрагдаагүй, 1822 нь Сургуулийн өмнөх боловсролд, 1458 нь их дээд сургуульд, 79 нь ТМБСБ-д, 4566 нь ЕБС-д суралцаж байна.

График 4.19. Баянзүрх дүүргийн 5-р хорооны хүн амын сургуульд хамрагдсан байдал



2-39 насны хүн амын СӨБ, сургуульд хамрагдалтын байдал

Хүснэгт 4.3. Баянзүрх дүүргийн 5-р хороон хүн амын сургуулийн өмнөх боловсрол эзэмшсэн байдал

Хүйс	Байршил	ЕБС	ТМБСБ	Их, дээд сургууль	СӨБ	Хамрагдаагүй
Эр	5-р хороо	2,372	47	661	959	3,799
	Нийт	2,372	47	661	959	3,799
Эм	5-р хороо	2,194	32	797	863	3,877
	Нийт	2,194	32	797	863	3,877

Бүгд		4,566	79	1,458	1,822	7,676
------	--	-------	----	-------	-------	-------

Зургаа, түүнээс дээш насны хүн амын тоо, насны бүлэг, боловсролын түвшингээр

График 4.20. Баянзүрх дүүргийн 5-р хорооны хүн амын боловсролын түвшин






График 4.21. БЗД-ийн 5-р хорооны зургаа ба түүнээс дээш насны хүн амын тоо хүйс, боловсролын түвшингээр



4.3.БЗД-ИЙН 5-Р ХОРООНЫ ХҮН АМЫН ТҮҮВЭР СУДАЛГАА

График 4.22. Зургаа, түүнээс дээш насны хүн амын тоо хүйс,боловсролын түвшингээр




Суурин хүн амын тоо, хүйсээр

5-р хороонд суурин амьдардаг иргэд 21876 байгаа бөгөөд үүнийг хүйсээр авч үзвэл 10687 буюу 49% нь эрэгтэй, харин 11189 буюу 51% нь эмэгтэй иргэд тус тус эзэлж байна.

График 4.23. БЗД-ийн 5-р хорооны хүн амын тоо хүйсээр




График 4.24. БЗД-ийн 5-р хорооны хүн амын насны байдал болон хүйсээр



Хүн амын тоо, үндэс угсаа

5-р хороонд амьдарч байгаа иргэдийн яс үндсээр авч үзвэл халх 20683 буюу 90%, баяд 355 буюу 1%, захчин 169 буюу 1%, урианхай 137 буюу 1%, буриад 383 буюу 2%, казак 102 буюу 0.7%, дарьганга 244 буюу 1%, өөлд 139 буюу 0.8%, бусад 151 буюу 1%, дөрвөд 570 буюу 2%, торгууд 123 буюу 0.8%-ийг тус тус эзэлж байна.

График 4.25. БЗД-ийн 5-р хорооны хүн амын яс үндэс угсаа



Хүн амын гэрлэлтийн байдал

Хорооны насанд хүрсэн хүн амын гэрлэлтийн байдлыг авч үзвэл бэлэвсэн 577 буюу 2%, гэрлээд батлуулсан 7450 буюу 24%, өрх тусгаарласан 197 буюу 1%, огт гэрлээгүй 538 буюу 17%, гэрлэсэн боловч батлуулаагүй 1650 буюу 5%, гэрлэлтээ цуцлуулсан 151 буюу 1%-ийг тус тус эзэлж байна.

Судалгаанаас харвал гэрлэлтээ батлуулаагүй, хамтран амьдрагчийн хэв маягтай амьдарч байгаа иргэд 5%-ийг эзэлж байгаа нь хүчирхийлэл гарах нэг хүчин зүйл болох магадлал өндөр байна.

Нөгөө талаараа 151 гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан байгаа нь өрх толгойлсон гэр бүл нэмэгдэх, хүүхдэд тавих хяналт сулрах, цаашлаад иргэний маргаан үүсэх замаар хүчирхийлэл гарах нэг шалтгаан болох нөхцлийг нэмэгдүүлж байна.

График 4.26. БЗД-ийн 5-р хорооны хүн амын гэрлэлтийн байдал




Иргэдийн ажил хөдөлмөр эрхлэлтэй холбоотой судалгаа

Тус хорооны иргэдийн ажил хөдөлмөр эрхлэлтийн байдлыг авч үзвэл хөдөлмөр эрхлэх насны 15656 иргэн байгаагаас 7361 нь эрэгтэй, 8295 нь эмэгтэй хүн байна.

Түүнээс ажилгүй 7230 иргэн ажилгүй байгаагаас 3022 нь эрэгтэй, 4208 нь эмэгтэй хүмүүс эзэлж байна. Харин ажил хөдөлмөр эрхэлдэг 8426 иргэний 4339 нь эрэгтэй, харин 4087 нь эмэгтэй байна.

График 4.27. БЗД-ийн 5-р хорооны хүн амын ажиллах хүчний судалгаа




Ажиллагчдын тоо, насны бүлэг, ажил эрхлэлтийн байдал, хүйсээр

Тус хороонд амьдардаг иргэдийн хөдөлмөрийн насны 15696 иргэний 4935 буюу 31.8% нь түр ажлын байранд ажил хөдөлмөр эрхэлдэг, 19 иргэн буюу 0.82% нь аж ахуйн эрхэлдэг, 1615 буюу 9.7% нь өрхийн аж ахуйн эрхэлдэг, 33 буюу 0.47% нь тодорхой компанийн хувь эзэмшдэг, 95 буюу 1.65% нь тохиолдлын ажил хийдэг, 19 буюу 0.82 зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн эрхэлдэг, 1 хүн гэрээтээр ажил гүйцэтгэдэг гэсэн судалгаа гарч байна.

Хүйсийн байдлаар авч 4338 буюу 36.1 нь эрэгтэй, 38.4% нь эмэгтэй хүн байна. Бусад иргэд нь ямар нэгэн ажил төрөл эрхэлдэггүй байна.

График 4.28. БЗД-ийн 5-р хорооны хүн амын ажил эрхлэлтийн байдал



Тус хорооны 1212 иргэн гадаадад оршин сууж, ажиллаж, сурч, амьдарч байна гэсэн судалгаа байна. Тус хороонд жил дунджаар 99 иргэн нас барж байгаагийн 64 буюу 64.6% нь эрэгтэй, 35 буюу 35.4% нь эмэгтэй хүн байна.

Нас баралтын тоо, байршил, хүйсээр


Хүснэгт 4.4.

Байршил	Нийт	Эр	Эм
5-р хороо	99	64	35
Бүгд	99	64	35

Нийгмийн халамжид хамрагдсан хүний тоо, халамжид хамрагдсан байдал

Тус хороонд амьдарч байгаа иргэдийн 172 буюу 2% нь асаргааны тэтгэмж авдаг, 7205 буюу 79% нь хүүхдийн мөнгөн тэтгэмж авдаг, 451 буюу 5% нь хөгжлийн үйлчилгээ авдаг, 115 буюу 5% нь халамжийн үйлчилгээ авдаг, 98 буюу 1% нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 24 буюу 0.7% нь амжиргааны доод түвшний иргэний тэтгэмж, 155 буюу 2% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр, 9 буюу 0.45% нь өрх толгойлсон 4 хүүхэдтэй эцэг, эхийн тэтгэвэр, 1 буюу 0.01% н одой хүний тэтгэвэр, 885 буюу 10% нь өндөр насны тэтгэвэр 885 буюу 10%-ийг тус тус эзэлж байна.

График 4.29. БЗД-ийн 5-р хорооны хүн амын халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоон үзүүлэлт



Олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн амын судалгаа

Тус хороонд олдмол хөгжлийн бэрхшээлтэй 151 иргэн амьдарч байгаагаас харааны бэрхшээлтэй 14 буюу 9.2%, ярианы бэрхшээлтэй 1 буюу 0.15%, сонсголын бэрхшээлтэй 17 буюу 11.2%, хөдөлгөөний бэрхшээлтэй 33 буюу 21.8%, сэтгэцийн хувьд бэрхшээлтэй 21 буюу %, бусад зүйлийн бэрхшээлтэй 65 буюу %-ийг тус тус эзэлж байна.

График 4.30. БЗД-ийн 5-р хорооны хүн амын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаа



Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын судалгаа

Тус 5-р хороонд төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 288 иргэн байгаагаас харааны бэрхшээлтэй 54 буюу 18.7%, ярианы бэрхшээлтэй 12 буюу 4.1%, сонсголын бэрхшээлтэй 31 буюу 10.7%, хөдөлгөөний бэрхшээлтэй 82 буюу 28.4%, сэтгэцийн өөрчлөлтэй 36 буюу 12.5%, бусад зүйлийн бэрхшээлтэй 73 буюу 25.3%-ийг тус тус эзэлж байна.

Түр эзгүй хүн амын тоо, нас, хүйсээр

5-р хороонд орон байрандаа амьдраагүй, түр эзгүй байгаа 112 иргэн байгаагийн 50 буюу 45% нь эрэгтэй, 62 буюу 55% нь эмэгтэй хүмүүс байна.

График 4.31. БЗД-ийн 5-р хорооны хүн амын түр эзгүй хүмүүсийн тоон үзүүлэлт




Хорооны ажил эрхлээгүй хүн амын тоо, шалтгаан

Тус хороонд хөдөлмөрийн насны ажил эрхлээгүй 6714 хүн байгаа бөгөөд 2742 буюу 40.8% нь сургуульд сурдаг, 1235 буюу 18.3% нь өндөр насны тэтгэвэрт байдаг, 215 буюу 3.2% нь хөдөлмөр эрхлэх чадваргүй, 630 буюу 9.3% нь тохирох ажил олдохгүй байгаа гэсэн шалтгаантай, 22 буюу 3.2%

нь ажил хийх сонирхолгүй, 793 буюу 11.8% нь бусад шалтгааны улмаас ажил хайдаггүй гэсэн судалгаа гарч байна.

График 4.32. БЗД-ийн 5-р хорооны хүн амын ажил эрхлээгүй шалтгаан



Тус хороонд ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж үйлчилгээний төвд бүртгэлтэй, бүртгэлгүй нийт 335 иргэн байгаагийн 178 буюу 53.1% нь эрэгтэй, 157 буюу 46.9% нь эмэгтэй иргэд байна.

Үүнээс Хөдөлмөр, халамж үйлчилгээний төвд бүртгэлтэй 129 хүн ажил хайж байгаагийн 64 буюу 49.6% нь эрэгтэй, 65 буюу 50.4% эмэгтэй хүн байна.

Харин Хөдөлмөр, халамж үйлчилгээний төвд бүртгэлгүй ажил идэвхтэй хайж байгаа 206 хүн байгаагийн 114 буюу 55.3% нь эрэгтэй, 92 буюу 44.7% эмэгтэй хүн байна.

График 4.33. БЗД-ийн 5-р хорооны ажилгүй иргэдийн идэхитэй ажил хайж буй хүмүүсийн тоон үзүүлэлт





График 4.34. БЗД-ийн 5-р хорооны хүн амын өндөр настны нас, хүйсийн тоон үзүүлэлт



Тус хороонд 55-94 насны 1686 өндөр настан амьдардаг ба үүнээс 1105 буюу 66% нь 55-65 насны, 411 буюу 24% нь 66-75 насны, 143 буюу 8% нь 76-85 насны, 27 буюу 2% нь 86-94 насныхан эзэлж байна.

Тус хороонд 1215 буюу 72% нь эмэгтэй, 471 буюу 28% нь эрэгтэй өндөр настнууд амьдарч байна.

4.4.БЗД-ИЙН 5-Р ХОРООНЫ ӨРХИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА

Өрхийн тоо, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг эсэх

5-р хороонд 199 буюу 3% нь үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг, 36 буюу 0.5% нь хөрөнгө түрээслүүлдэг, 6361 буюу 96.4% нь үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэггүй байна.

График 4.35. Үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг иргэдийн тоон үзүүлэлт



Өрхийн зарим үзүүлэлт

Хүснэгт 4.5.

Үзүүлэлт	М/Д	Бүгд
Ихэр хүүхэдтэй өрхийн тоо	1	70
2 ихэр хүүхдийн тоо	2	140
3, түүнээс дээш ихэр хүүхдийн тоо	3	
18 хүртэлх насны 4, түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо	4	214
6, түүнээс дээш гишүүнтэй өрхийн тоо	9	896
Ганц биеэрээ амьдарч буй ахмад настай өрхийн тоо	10	223
60, түүнээс дээш настай эрэгтэй	11	49
55, түүнээс дээш настай эмэгтэй	12	174

Өрхийн тоо, өрхийн тэргүүлэгчийн хүйс, ам бүлийн тоогоор

Хүснэгт 4.6.

Байршил	Өрхийн тэргүүлэгчийн хүйс	Бүгд	Үүнээс: Ам бүлийн тоогоор									
			1	2	3	4	5	6	7	8	9	10
5-р хороо	Эр	4,245	707	501	684	987	665	388	162	76	36	39
	Эм	2,214	468	555	496	330	168	98	54	23	10	12
	Нийт	6,459	1,175	1,056	1,180	1,317	833	486	216	99	46	51
Нийт		6,459	1,175	1,056	1,180	1,317	833	486	216	99	46	51

Өрхийн тоо, өрхийн тэргүүлэгчийн хүйс, хүүхдийн тоогоор


Хүснэгт 4.7.

Байршил	Өрхийн тэргүүлэгчийн хүйс	Бүгд	Үүнээс: Хүүхдийн тоогоор									
			0	1	2	3	4	5	6	7	8	
Улаанбаатар	Эр	4,224	1,267	885	1,172	601	233	47	13	3	3	
	Эм	2,191	657	711	519	214	67	19	4			
	Нийт	6,415	1,924	1,596	1,691	815	300	66	17	3	3	
Нийт		6,415	1,924	1,596	1,691	815	300	66	17	3	3	

Өрхийн тоо, сууц эзэмшлийн хэлбэрээр

Тус хороонд 6072 өрх буюу 92% нь өөрийн эзэмшлийн орон сууц, хашаа байшин, гэрт байдаг бол 284 буюу 4% нь бусдын орон сууц, байр, гэрийг түрээслэн амьдардаг, 224 буюу 4% нь бусдын сууцанд түрээсгүй амьдардаг, 14 буюу 0.9% нь бусад хэлбэрээр амьдардаг байна.

График 4.36. Өрхийн тоо, сууц эзэмшлийн хэлбэрээр



Өрхийн тоо, сууцны төрлөөр

5-р хорооны өрхүүдийг амьдарч буй сууцны төрлөөр авч үзвэл гэрт 2229 буюу 34%, орон сууцанд 2711 буюу 41%, бие даасан тохилог сууцанд 13 буюу 0.1%, байшинд 1563 буюу 24%, нийтийн байранд 71 буюу 1%, бусад орон сууцанд 10 буюу 0.53% нь тус тус амьдарч байна.

График 4.37. Өрхийн тоо, сууцны төрлөөр



Өрхийн тоо, тээврийн хэрэгслийн тоон үзүүлэлт

Хүснэгт 4.8.

Байршил	Бүгд	Үүнээс					
		Суудлын	Ачааны	Автобус	Мотоцикл	Тусгай зориулалтын	Тээврийн хэрэгсэлгүй
5-р хороо	6,659	2,528	170	25	5	19	3,912
Нийт	6,659	2,528	170	25	5	19	3,912

Өрхийн тоо, усан хангамжаар

Хүснэгт 4.9.

Байршил	Бүгд	Үүнээс				
		Төвлөрсөн усан хангамж - халуун, хүйтэн устай	Бие даасан систем - халуун, хүйтэн устай	Зөөврийн	Төвлөрсөн усан хангамж - хүйтэн устай	Бие даасан систем - хүйтэн устай
5-р хороо	6,596	2,778	23	3,780	6	9
Нийт	6,596	2,778	23	3,780	6	9

Өрхийн тоо, халаалтын эх үүсвэрээр

Хүснэгт 4.10.

Байршил	Бүгд	Үүнээс				
		Газрын гүнийн дулаан	Төвлөрсөн систем	Нам даралтын зуух	Цахилгаан халаагуур	Ердийн галлагаа
38	6,596	1	2,791	142	123	3,539
Нийт	6,596	1	2,791	142	123	3,539

4.5. ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ГАРЧ БУЙ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

4.5.1. Гэмт хэргийн нөхцөл байдал

5-р хорооны нутаг дэвсгэрт гарч буй гэмт хэрэг, зөрчлийн хэрэг бүртгэгч илрүүлсэн 2015 онд 1, мөрдөн байцаагч илрүүлсэн 2016 онд 1, 2018 онд 2, прокурор илрүүлсэн 2015 онд 6, 2016 онд 17, 2017 онд 100%-иар өссөн буюу 8, 2019 онд 62,5%-иар өссөн буюу 13 хэрэг бүртгэгдсэн байна.

Нийт гэмт хэргийн гүйцэтгэх ажлын шугамаар илрүүлсэн хэрэг 2016 онд 2 байна. 2017-2019 онуудад гүйцэтгэх ажлын шугамаар илрүүлсэн гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

Оны эхнээс бүртгэгдсэн гэмт хэрэг 2015 онд 68 байгаа бол 2016 онд 238 болж 205%-иар өссөн байна. 2017 онд өмнөх оныхоос 67,2%-иар буурч 78 хэрэг бүртгэгдсэн бол 2018 онд 56,4%-иар нэмэгдэж 122, 2019 онд 56,6%-иар буурч 53 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Эдгээрээс хэрэг бүртгэлтийн хэрэг 2016 онд 9, 2017 онд 78, 2018 онд 120, 2019 онд 50 хэрэг эзэлж байна.

Нийт гэмт хэргийн согтуугаар үйлдэгдсэн 2015 онд 7, 2016 онд 27 болж 285.7%-иар өссөн, 2017 онд 88.9%-иар буурч 3 хэрэг, 2018 онд 66.6%-иар нэмэгдэж 5 хэрэг, 2019 онд 20%-иар буурч 4 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

БЗД-ийн 5-р хороонд 2017 онд 359 гэмт хэрэг бүртгэгдэж байсан бол 2018 онд 442 гэмт хэрэг болж 83 нэгжээр өссөн байна. Харин хэрэг илрүүлэлтийн хувьд 2017 онд 19.5% байсан бол 2018 онд 22.5% болж 3%-иар өссөн байна.

График 4.38. Гэмт хэрэг илрүүлэх чиг үүрэгтэй албан тушаалтан



2015-2019 оны 5 жилийн хугацаанд БЗД-ийн 5-р хороонд харъяалалтай нийтдээ 504 гэмт хэрэг, зөрчлийн гомдол, мэдээлэл ирсэн нь жилд дунджаар 100.8 болж байна.

Харин дээрх хугацаанд 5-р хороонд нийтдээ 559 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хэрэг бүртгэлтийн хэрэг 258 буюу 46.1%, мөрдөн байцаалтын хэрэг 49 буюу 8.7% нь шалган шийдвэрлэгдсэн байна.

График 4.39. Бүртгэгдсэн гэмт хэрэг




Хэрэг илрүүлэлтийн байдлыг 5 жилээр нь авч үзвэл хэрэг бүртгэлтийн явцад 1 буюу 2%, мөрдөн байцаалтаар 5 буюу 9%, прокурор хяналтаар 48 буюу 86%, гүйцэтгэх ажлын шугамаар 2 буюу 3%-ийг тус тус эзэлж байна.

График 4.40. Бүртгэгдсэн гэмт хэрэг илрүүлсэн арга



Бүртгэгдсэн гэмт хэрэг үйлдэгдсэн хэлбэр, оролцооны байдлыг 5 жилээр нь авч үзвэл согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 46 буюу нийт гэмт хэргийн 27%, хүүхэд оролцсон хэрэг 11 буюу 0.64%, эмэгтэй хүн оролцсон хэрэг 34 буюу 20%, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 21 буюу 12%-ийг тус тус эзэлж байна.

График 4.41. Гэмт хэрэг үйлдэгчдийн оролцооны хэлбэр



Үйлдэгдсэн гэмт хэргүүдийн гэм буруугийн хэлбэрийг авч үзвэл санаатай 80.1% буюу 368, болгоомжгүй 16.9% буюу 78, холимог 2.8% буюу 13 хэрэг бүртгэгдсэн байна. Гэмт хэргүүдийн дийлэнх хувийг санаатайгаар үйлдэгдсэн гэмт хэрэг эзэлж байгаа нь тэд хэрэг үйлдээд үүсэх хор уршгийг мэдэж байсан ч үйлдэж байгаа нь асуудлыг бий болгож байна. Гэм буруугийн хэлбэрийг графикаар үзүүлбэл:


График 4.42. Гэмт хэрэг үйлдэгчдийн гэм буруугийн хэлбэр



Хөнгөн гэмт хэрэг сүүлийн 5 жилийн хугацаанд 329 бүртгэгдэн шалгагдсанаас 84.8% буюу 279 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, 28.5% буюу 94 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татсан байна.

Хөнгөн гэмт хэрэг 2015 онд 16 байсан бол 2016 онд 5 дахин өсч үйлдэгдсэн бол 2017 онд гэмт хэрэг буурсан боловч 2018 онд 107 гарч 84%-иар өссөн байна. Харин 2019 онд 17.5%-иар буурсан байна.

График 4.43. Тус хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн хөнгөн гэмт хэргийн тоон үзүүлэлт



Харин хүнд гэмт хэрэг 5 жилийн хугацаанд 50 гарч шалгагдсан бөгөөд хамгийн их үйлдэгдсэн хугацаа бол 2017 он байна.

Гэмт хэргийн илрүүлэлтийн байдлыг авч үзвэл хэрэг бүртгэлтийн тасаг 2015 онд 9 байсан бол 2016 онд 85 болж 8.4 дахин өссөн байна. Гэвч 2017 онд илрүүлэлт байхгүй, харин сүүлийн 2 жил 2-4 болж өсөх хандлагатай болсон байна.

Харин мөрдөн байцаах тасгийн алба хаагчид 2015-2019 оны хугацаанд мөрдөн байцаалтын шатанд 151 гэмт хэрэгтнийг олж тогтоосон боловч үүнийг 5 жилээр нь багцлан авч үзвэл энэхүү ажиллагаа тогтвортой бус, харилцан адилгүй өсөх, бууралттай байна.

Тухайлбал 2015 онд 21 гэмт хэрэг илрүүлж байсан бол 2016 онд 82 болж 3.9 дахин өссөн боловч 2017 онд 5 болж огцом буурсан. Харин 2018 онд 28 буюу 5 дахин өссөн ч 2019 онд эргээд 86.5%-иар буурсан дүнтэй байна.

Гэхдээ илрүүлэлт харилцан адилгүй, тогтвортой бус байгаад холбогдох алба, нэгжийн дарга нар анхаарлаа хандуулж, тодорхой ажил зохион байгуулах шаардлага байгааг харж болохоор байна. Үүнийг графикаар үзүүлбэл:

График 4.44. Тус хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийг олж тогтоосон арга



Гэмт хэрэг үйлдсэн гарагийн хувьд 5 жилийн дунджаар авч үзвэл даваа гарагт 91 буюу 91%, мягмар гарагт 78 буюу 14%, лхагва гарагт 71 буюу 13%, пүрэв гарагт 90 буюу 16%, баасан гарагт 83 буюу 15%, бямба гарагт 67 буюу 12%, ням гарагт 71 буюу 13% нь гарсан байна.


График 4.45. Тус хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг гаригаар



Дээрх гарагуудад хийсэн судалгаанаас харвал даваа гарагт нийт гарсан гэмт хэргийн 17% буюу хамгийн их гэмт хэрэг гарсан, харин бямба гарагт нийт гэмт хэргийн 12% буюу хамгийн бага гэмт хэрэг гарсан дүр зураг харагдаж байна.

Үүнээс харвал гэмт хэрэг заавал аль нэг гарагт түлхүү гараад байгаа бус, харин тохироо бүрдвэл хаана ч, хэдийд ч гарч болно гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна.

График 4.46. Тус хорооны нутаг дэвсгэрт сүүлийн 5 жилийн хугацаанд үйлдэгдсэн гэмт хэрэг гаригаар



5-р хороонд гарсан гэмт хэргүүдийн үйлдэгдсэн газруудыг авч үзвэл гудамж талбай 367, гэр хорооллын гудамж 110, орон сууцны гудамж 97, ил зогсоол 43, автобусны буудал 29, бусад газарт 28 гэмт хэрэг тус тус үйлдсэн байна.

График 4.47. Тус хорооны нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдэгдсэн газар



График 4.48. Тус хорооны нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан багаж зэвсэг хэрэгсэл



БЗД-ийн 5-р хороонд 2017 онд 359 гэмт хэрэг бүртгэгдэж байсан бол 2018 онд 442 гэмт хэрэг болж 83 нэгж буюу 23.1%-аа өссөн байна. Харин хэрэг илрүүлэлтийн хувьд 2017 онд 19.5% байсан бол 2018 онд 22.5% болж 3%-иар өссөн байна.

БЗД-ийн 5 хороонд бүртгэгдсэн гэмт хэрэг /сүүлийн 5 жилээр/

Хүснэгт 4.11.

№	Гэмт хэргийн Төрөл	2015	2016	2017	2018	2019	Дундаж				
1.	Хүнийг санаатай алах	Тоо	-	1	100%	1	0%	1	0%	2	100%
		Б.Э	-	-	-	1	100%	-	-100%	1	100%
		Ял	-	-	-	1	100%	-	-100%	1	100%
2.	Бусдыг амиа хорлоход хүргэх	Тоо	3	4	25%	2	-50%	7	250%	-	- 0%
		Б.Э	-	-	-	-	-	-	-	-	-
		Ял	-	-	-	-	-	-	-	-	-
3.	Гэр бүлийн хүчирхийлэл	Тоо	-	-	-	-	-	2	100%	-	-
		Б.Э	-	-	-	-	-	2	100%	-	-
		Ял	-	-	-	-	-	-	-	-	-
4.	Бусдын бие махбодод гэмтэл учруулах	Тоо	61	63	3.17%	93	47.6%	104	11.8%	100	3.8%
		Б.Э	15	22	46.6%	57	159%	104	82.4%	100	-3.8%
		Ял	11	18	61.1%	24	75%	65	169%	47	
5.	Хүчиндэх	Тоо	1	-	-	3	-	5	0.66%	6	20%
		Б.Э	1	-	-	1	-	4	300%	6	50%
		Ял	1	-	-	-	-	1	-	4	300%
6.	Хулгайлах	Тоо	73	100	36.9%	164	64%	203	23.7%	116	-42.8%
		Б.Э	69	96	43.4%	164	70.8%	202	23.1%	113	44%
		Ял	31	50	61.2%	16	-68%	9	43.7%	13	44.4%
7.	Иргэдийн өмчийн хулгай	Тоо	71	87	22.5%	149	71.2%	177	18.7%	98	44.6%
		Б.Э	67	85	27.6%	149	75.2%	176	18.1%	95	-46%
		Ял	30	44	46.6%	14	-68.1%	8	-42.8%	12	-50%
8.	Авто тээврийн хулгай	Тоо	-	5	500%	2	60%	4	50%	8	100%
		Б.Э	-	5	500%	2	60%	4	50%	8	100%
		Ял	-	3	300%	1	-66.6%	1	0%	1	0%
9.	Халаасны хулгай	Тоо	2	8	300%	13	62.5%	20	53.8%	10	
		Б.Э	2	6	200%	13	116.6%	20	53.8%	10	
		Ял	1	3	200%	1	-166%	-	-	-	
10.	Булаах	Тоо	1	3	200%						

		Б.Э	1	3	200%						
		Ял	1	1	0%						
11	Дээрэмдэх	Тоо	1	6	500%	25	316%	40	60%	15	-166%
		Б.Э	1	6	500%	25	316%	39	56%	15	-160%
		Ял	-	3	300%	2	33.3%	4	50%	4	0%
		Тоо	10	11	10%	26	136.6%	50	92.3%	42	-16%
12	Залилан мэхлэх	Б.Э	3	8	166%	25	470%	50	100%	38	-24%
		Ял	0	2	200%	5	150%	8	60%	8	0%
		Тоо	25	19	24%	7	-171%	-	-	-	-
13	Танхайрах	Б.Э	12	15	25%	7	-114%	-	-	-	-
		Ял	6	2	-200%	4	100%	-	-	-	-
		Тоо	9	16	77.7%	7	56.2%	8	14.2%	9	12.5%
14	ТХХАБАЖЭ	Б.Э	3	4	33.3%	5	33.3%	8	60%	9	12.5%
		Ял	3	4	33.3%	3	-25%	5	66.6%	6	20%
		Тоо	18	15	-16.6%	31	106.6%	24	22.5%	26	8.3%
15	Бусад	Б.Э	5	8	60%	29	380%	24	17.2%	25	4.1%
		Ял	2	5	150%	6	20%	5	-33.3%	4	-33.3%
		Тоо	203	238	17.2%	359	50.8%	442	23.1	316	28.5%
16	Бүгд	Б.Э	110	162	47.2%	313	93.2%	431	95.8%	307	28.7%
		Ял	55	93	69%	61	-34.4	97	39.5%	87	-9.7%
		Илрүүлэлт	50%	57.4%	14.8%	19%	-66.8%	22.5%	18.4%	28.3 %	25.7%

Хүнийг санаатай алах гэмт хэрэг 2016, 2017, 2018 онуудад тус тус 1 гарсан бол 2019 онд 2 гэмт хэрэг гарсан байна.

Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 2015 онд 3, 2016 онд 4, 2017 онд 2, 2018 онд 7 хэрэг гарсан байна. 2018 онд өмнөх оныхоос 5 нэгжээр өссөн байна.

Хүн амины гэмт хэрэг 2016, 2017, 2018 онуудад тус тус 1 гарсан бол 2019 онд 50%-иар нэмэгдэж 2 гэмт хэрэг гарсан байна.

Бусдын бие махбодид гэмтэл учруулсан гэмт хэрэг 2015 онд 61, 2016 онд 63, 2017 онд 93, 2018 онд 104, 2019 онд 100 гэмт хэрэг гарсан байна.

Хүчиндэх гэмт хэрэг 2015 онд 1, 2018 онд 5, 2019 онд 1 нэгжээр өссөн буюу 6 хэрэг гарсан байна. 2016 болон 2017 онуудад бүртгэгдээгүй байна.


График 4.49. Тус хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн тоон үзүүлэлт



Хулгайлах гэмт хэрэг 2015 онд 73, 2016 онд 36.9%-иар өссөн буюу 100, 2017 онд 64%-иар өссөн буюу 164, 2018 онд 23.7%-иар өссөн буюу 203, 2019 онд 42.8%-иар буурсан буюу 116 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

Иргэдийн өмчийн хулгайн гэмт хэрэг 2015 онд 71, 2016 онд 22.5%-иар өссөн буюу 87, 2017 онд 71.2%-иар өссөн буюу 149, 2018 онд 18.7%-иар өссөн буюу 177, 2019 онд 44.6%-иар буурсан буюу 98 хэрэг бүртгэгдсэн байна.


График 4.50. Тус хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн тоон үзүүлэлт



Автотээврийн хулгайн гэмт хэрэг 2015 онд бүртгэгдээгүй бол 2016 онд 5, 2017 онд 60%-иар буурсан буюу 2, 2018 онд 50%-иар өссөн буюу 4, 2019 онд 50%-иар өссөн буюу 8 хэрэг бүртгэгдсэн байна.

Халаасны хулгайн хэрэг 2015 онд 2, 2016 онд 8, 2017 онд 62.5%-иар өссөн буюу 13, 2018 онд 53.8%-иар өссөн буюу 20, 2019 онд 50%-иар буурсан буюу 10 хэрэг бүртгэгдсэн байна. Үүнээс үзэхэд 2018-2019 онд халаасны хулгай 50%-иар буурсан байна.


График 4.51. Тус хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн тоон үзүүлэлт



Залилах гэмт хэрэг 2016 онд 1 нэгжээр, 2017 онд 31.2%, 2018 онд 48%-иар өссөн бол 2019 онд 19%-иар буурсан байна.

Дээрэмдэх гэмт хэрэг 2015-2016 онд 5 нэгжээр өссөн бол, 2017 онд өмнөх оны мөн үеэс 76%, 2018 онд 37.5%-иар өссөн байна. 2019 онд 25 нэгжээр буурсан байна.


График 4.52. Тус хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах, дээрэмдэх гэмт хэргийн тоон үзүүлэлт



ТХХАБЖЭ гэмт хэрэг 2016 онд 7 нэгжээр өссөн буюу 16, 2017 онд 9 нэгжээр буурсан буюу 16 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. 2018, 2019 онд тус тус 1 нэгжээр өссөн буюу 9 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

Бусад гэмт хэргийн хувьд 2016 онд 15 хэрэг гарсан нь өмнөх оныхоос 3 нэгжээр буурсан байна. 2017 онд 93.7%-иар өссөн буюу 31 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. 2018 онд 7 нэгжээр буюу 22.5%-иар буурсан байна. 2019 онд 26 гэмт хэрэг бүртгэгдсэн буюу өмнөх оныхоос 2 нэгжээр өссөн байна.

График 4.53. Тус хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн ТХХАБЖЭ гэмт хэрэг болон бусад гэмт хэргийн тоон үзүүлэлт



4.5.2. Аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд хүргүүлсэн албан мэдэгдэлд хийсэн судалгаа

БЗД-ийн Цагдаагийн 2-р хэлтсээс дүүргийн өөрийн хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 2015 оноос 2019 оны 12-р сар хүртэл 5 жилийн хугацаанд хүргүүлсэн нийт 8828 албан мэдэгдэл өгч, 5145 хариу хүлээн авсан бөгөөд гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцлийг арилгуулах мэдэгдэл 58.2%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.


Хүснэгт 4.12.

№	Нэгж	2015		2016		2017		2018		2019		Нийт		5 жилийн дундаж	
		Мэдэгдэл	Хариу	Мэдэгдэл	Хариу	Мэдэгдэл	Хариу	Мэдэгдэл	Хариу	Мэдэгдэл	Хариу	Мэдэгдэл	Хариу	Мэдэгдэл	Хариу
1.	Хэрэг бүртгэх тасаг	17	14	12	10	5	5	24	18	33	29	91	76	18.2	15.2
2.	Мөрдөн байцаах тасаг	606	375	467	303	426	298	466	335	458	316	2423	1627	484.6	325.4

3.	Нийтийн хэв журам хамгаалах тасаг	212	199	121	113	1746	1011	2216	2122	2042	-	6337	3445	1267.4	68.9
	Нийт	835	588	600	423	2177	1314	2686	2475	2530	345	8828	5145	1765.6	1029


Хэрэг бүртгэх тасаг 2015 онд 17 мэдэгдэл хүргүүлсний 14 буюу 82.3% нь хариу ирүүлсэн, 2016 онд 12 мэдэгдэл хүргүүлсний 10 буюу 83.3% нь хариу ирүүлсэн, 2017 онд 5 мэдэгдэл хүргүүлж 5 буюу 100% хариу ирүүлсэн, 2018 онд 24 мэдэгдэл хүргүүлсний 18 буюу 75% нь хариу ирүүлсэн бол 2019 онд 33 мэдэгдэл буюу өмнөх оныхоос 9 буюу 28%-иар нэмэгдсэн мэдэгдэл хүргүүлж 29 буюу 87.8% нь хариу ирүүлсэн байна.

График 4.54. Хэрэг бүртгэх тасгаас бичиж хүргүүлсэн албан мэдэгдэл, шаардлага



Мөрдөн байцаах тасаг 2015 онд 606 мэдэгдэл хүргүүлсний 375 нь буюу 61.8% нь хариу ирүүлсэн, 2016 онд 467 мэдэгдэл хүргүүлсний 303 буюу 64.8% нь хариу ирүүлсэн, 2017 онд 426 мэдэгдэл хүргүүлсний 298 буюу 69.9% нь хариу ирүүлсэн, 2018 онд 466 мэдэгдэл хүргүүлсний 335 буюу 71.8% нь хариу ирүүлсэн байна. Харин 2019 онд 458 мэдэгдэл хүргүүлснээс 316 буюу 68.9% нь хариу ирүүлсэн байна. 2016 онд 29.7%, 2017 онд 9.6%-иар буурсан бол 2018 онд 8.5%-иар өссөн байна. 2019 онд өмнөх оныхоос 1.7%-иар буурсан үзүүлэлттэй байна.

График 4.55. Мөрдөн байцаах тасгаас бичиж хүргүүлсэн албан мэдэгдэл, шаардлага



Хэв журмын тасаг 2015 онд 212 мэдэгдэл хүргүүлсний 199 нь хариу ирүүлсэн, 2016 онд өмнөх оныхоос 75.2%-иар өссөн буюу 121 мэдэгдэл хүргүүлсний 113 нь хариу ирүүлсэн, 2017 онд өмнөх оныхоос 93%-иар өссөн буюу 1746 мэдэгдэл хүргүүлсний 1011 хариу ирүүлсэн, 2018 онд өмнөх оныхоос 22%-иар өссөн буюу 2216 мэдэгдэл хүргүүлсний 2122 нь хариу ирүүлсэн, 2019 онд 8.5%-иар буурсан буюу 2042 мэдэгдэл хүргүүлээд байна.

График 4.56. Хэв журмын тасгаас бичиж хүргүүлсэн албан мэдэгдэл, шаардлага



5 жилийн нийт дүнгээр харвал хэрэг бүртгэх тасаг 91 мэдэгдэл хүргүүлсний 76 буюу 83.5% нь хариу ирүүлсэн, мөрдөн байцаах тасаг 2423 мэдэгдэл хүргүүлсний 1627 буюу 67.1% нь хариу ирүүлсэн, нийтийн хэв журмын тасаг 6337 мэдэгдэл хүргүүлсний 3445 буюу 54.3% нь хариу ирүүлсэн байна. Нийт хүргүүлсэн мэдэгдэл 8851 байгаагаас хэрэг бүртгэлийн мэдэгдэл хамгийн бага буюу 1.02%-ийг, мөрдөн байцаалтын мэдэгдэл 27.3%-ийг, нийтийн хэв журмын мэдэгдэл ихэнх хувийг буюу 71.5%-ийг эзэлж байна.


Гэвч энэхүү мэдэгдлүүдийг нэгдсэн бүртгэлд бүртгэдэггүй, цахим сан байхгүйгээс нэг байгууллагад хэдэн удаа өгсөн ч мэдэх боломж бага байгаа нь мэдэгдлийн үр нөлөөг бууруулж байна.

Нөгөө талаараа мэдэгдлийн хэрэгжилтийг биечлэн шалгаж, үр дүнг тооцож байгаа байдал байхгүй байгаа нь үр нөлөөг бууруулах нэг хүчин зүйл болж байна.

Дээрх тасгууд нь 2015 онд нийт 835 мэдэгдэл хүргүүлсний 588 буюу 70.4% нь хариу ирүүлсэн, 2016 онд 600 мэдэгдэл хүргүүлсний 423 буюу 70.5% нь хариу ирүүлсэн, 2017 онд 2177 мэдэгдэл хүргүүлсний 1314 буюу 60.3% нь хариу ирүүлсэн, 2018 онд 2686 мэдэгдэл хүргүүлсний 2475 буюу 92.1% нь хариу ирүүлсэн, 2019 онд 2530 мэдэгдэл хүргүүлсний 345 буюу 13.6% нь хариу ирүүлсэн байна. 2017 онд нийт хүргүүлсэн мэдэгдэл өмнөх оныхоос 72.4%, 2018 онд 18.1%-иар өссөн бол 2019 онд өмнөх оныхоос 6.1%-иар буурсан мэдэгдэл хүргүүлсэн байна. 2018 онд хамгийн их мэдэгдэл хүргүүлж байсан бол 2016 онд хамгийн бага мэдэгдэл хүргүүлж байсан байна.

Гэвч мэдэгдэлд хариу ирүүлээгүй, арга хэмжээ аваагүй аж ахуйн нэгж, байгууллагуудад бүрэн хариуцлага тооцож чадахгүй байгаа нь мэдэгдлийн үр нөлөөг бууруулах нэг хүчин зүйл болж байна.

График 4.57. Мэдэгдэл шаардлагын хариу авсан байдал сүүлийн 5 жилээр




4.5.3. Зөрчлийн нөхцөл байдал /2017-2019 он/

БЗД-ийн 5 хорооны нутаг дэвсгэрт 2017-2019 оны 12 сарын 01-ны хүртэлх 3 жилийн хугацаанд нийт 3108 зөрчил гарч, шийдвэрлэгдсэнийг зөрчил тус бүрээр авч үзлээ.

Тус хороонд зөвшөөрөлгүйгээр худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах зөрчил гарч байгаа бөгөөд энэ зөрчил 2018 онд 119 гарсан бол 2019 оны 11 сарын байдлаар 83 гарч байгаа нь энэ зөрчил төдийлөн буурахгүй байгааг графикаар харуулбал:

График 4.58. Худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээний журам зөрчих зөрчил




Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлд заасан төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах зөрчил сүүлийн 3 жил дараалан өссөн дүнтэй байна. Тухайлбал 2017 онд 8 гарч байсан бол 2018 онд 114 гарч өмнөх оны мөн үеэс 13.2 дахин өссөн. Харин 2019 оны 11 сарын байдлаар 176 гарч өмнөх оноос 54.3%-иар өссөн байна.

Энэхүү асуудлыг Баянзүрхийн цагдаагийн газар анхааралдаа авч энэ чиглэлээр дагнасан тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулах шаардлага бий болсныг харуулж байна.

Зөрчлийн талаарх мэдээллийг графикаар үзүүлбэл:

График 4.59. Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд саад учруулах зөрчил




Зөрчлийн тухай хуулийн 15.9 дүгээр зүйлд заасан хуурамч дуудлага, мэдээлэл өгөх зөрчил сүүлийн 3 жил дараалан өссөн байна. Тухайлбал 2017 онд 2 гарч байсан бол 2018 онд 50 болж 24 дахин өссөн бол 2019 оны эхний 11 сарын байдлаар 159 болж даруй 3.2 дахин өссөн байна.

Мөн Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйл. Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах зөрчил сүүлийн 3 жил дараалан өссөн дүн гарч байна. Тухайлбал, 2017 онд 8 гарсан бол 2018 онд 23 гарч даруй 2.8 дахин, 2019 онд өмнөх оны мөн үеэс 1 дахин өссөн байна. Энэ нь гудамж талбай, олон нийтийн газар урьдчилан сэргийлэх цагдаагийн эргүүл бага гарч байгаатай холбон үзэж болохоор байна.

Танхайрах зөрчил буурсан судалгаа байгаа боловч бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан зөрчил өссөн дүн гарч байна. 2017 онд 52 гарч байсан бол 2018 онд 3 гарч даруй 17 дахин буурсан бол 2019 онд өмнөх оноос даруй 14 дахин өссөн судалгаа гарч байна.

График 4.60. Танхайрах зөрчлийн үзүүлэлт



Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой зөрчил тус хороон дээр их гарч байгаа бөгөөд зөрчлийн хэлбэрийг авч үзвэл 5.4. дүгээр зүйлийн 4.1 буюу зодсон зөрчил сүүлийн 3 жил дараалан өссөн дүн гарч байна. 2017 онд 31 байсан бол 2018 онд 72 гарч 1.4 дахин өссөн бол 2019 онд 243 гарч өмнөх оноос даруй 2.3 дахин өссөн байна.

Түүнчлэн 4.2-д заасан хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албасан зөрчил 2017 онд 21 гарч байсан бол 2018 онд 58 гарч 1.7 дахин, 2019 онд 217 гарч 3.1 дахин өссөн судалгаа гарч байна.

График 4.61. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийн үзүүлэлт



Дээрх тоо мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзвэл гэр бүлийн хүчирхийлэл нь ахуйн хүрээнд буюу гэр бүлийн үйлдэгдэж байдгаас урьдчилан сэргийлэх боломж харьцангуй бага байгаа, нөгөө талаараа иргэдийн мэдээлэл дутмаг байгаагаас энэ төрлийн зөрчил буурахгүй байх нэг хүчин зүйл болж байна.

Түүнчлэн, тус хороонд Зөрчлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлд заасан нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах зөрчил сүүлийн 3 жил дараалан өссөн байна.

Энэ зөрчил 2017 онд 17 гарч байсан бол 2018 онд 14 болж 17.6%-иар буурч байсан бол 2019 онд 71 болж даруй 4 дахин өссөн байна.

Энэ нь сүүлийн жилүүдэд шинэ орон сууц барих ажил эрчимтэй явагдаж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор энэ төрлийн зөрчил нэмэгдэх нэг хүчин зүйл болсон гэж үзэж байна.

График 4.62. Нийтийн зориулалттай орон сууцанд бусдын амгалан тайван байдал алдагдуулах зөрчлийн үзүүлэлт



Тус хороонд Зөрчлийн тухай хуулийн 5.7 дугаар зүйлд заасан мөрийтэй тоглоом зохион байгуулах зөрчил өсөх хандлагатай байна. 5.7.1-д заасан мөрийтэй тоглоом зохион байгуулсан зөрчил 2017 онд 8 гарч байсан бол 2018 онд 4 болж 1 дахин буурсан боловч 2019 оны эхний 11 сарын байдлаар 11 гарч 1.8 дахин өссөн дүн гарч байна.

Харин 5.7.2-д заасан хориглосон мөрийтэй тоглоомын газар байгуулсан, ажиллуулсан зөрчил 2017 онд 7 гарч байсан бол 2018 онд 17 гарч 1.4 дахин өссөн боловч 2019 оны эхний 11 сарын байдлаар 11 гарч 54.5%-иар буурсан дүн гарч байна.

Энэ төрлийн зөрчил буурахгүй байгаа нэг хүчин зүйл нь нууц далд байранд явагддаг нь урьдчилан сэргийлэх ажил явуулахад хүндрэлийг үүсгэж байна.

Түүнчлэн, тус хороонд Зөрчлийн тухай хуулийн 5.9 дүгээр зүйл. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль зөрчих гэсэн зөрчил сүүлийн 3 жил дараалан өссөн судалгаа гарч байна.

Энэ төрлийн зөрчил 2017 онд 1 бүртгэгдэж байсан бол 2018 онд 20 болж даруй 19 дахин өссөн, 2019 оны эхний 11 сарын байдлаар 95 гарч 3.9 дахин өссөн дүн мэдээ гарч байна.

Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил өссөн шалтгааныг эрх бүхий албан тушаалтны бичгээр өгсөн гэмт хэрэг, зөрчлийн шалтгааны нөхцлийг арилгах, ажил, арга хэмжээ зохион байгуулах мэдэгдлийн дагуу ажил зохион байгуулж, хариу хугацаандаа ирээгүйгээс авсан арга хэмжээ юм.

Нэг талаараа мэдэгдлийн ач холбогдлыг нэмэгдүүлж байгаа боловч хариуцлага тооцоод орхих бус тухайн мэдэгдлийг хэрэгжүүлэх арга хэмжээг дахин авах шаардлага байгааг харуулж байна.

График 4.63. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль тогтоомж зөрчих зөрчлийн үзүүлэлт



Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаагийн нэг жишээ бол уг зөрчилд хүлээлгэж байгаа хариуцлагаас харж болох бөгөөд графикаар үзүүлбэл:

График 4.64. Тамхины хяналтын тухай хууль тогтоомж зөрчих зөрчлийн үзүүлэлт



Үүний зэрэгцээ Зөрчлийн тухай хуулийн 6.5 дугаар зүйлд заасан Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих гэсэн зөрчил сүүлийн 3 жил дараалан өссөн байна.

Тухайлбал энэ төрлийн зөрчил сүүлийн 3 жилд нийтдээ 358 гарсаныг задалж авч үзье. 2017 онд 22 гарч байсан 2018 онд 161 болж 31.9%-иар өссөн бол 2019 оны эхний 11 сарын байдлаар 74 болж 54%-иар буурсан байна.

График 4.65. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомж зөрчих зөрчлийн үзүүлэлт



Энэ төрлийн зөрчил гарсаар байгаа нь бусад гэмт хэрэг, зөрчил гарах нэг том шалтгаан болж байна.

Түүнчлэн 8.6-д заасан хулгайлах зөрчил гарсаар байгаа нь бага хохирол учруулсан хулгайлах гэмт хэргийг зөрчилд тооцсонтой шууд холбоотой. Хулгайлах зөрчлийг сүүлийн 3 жилийн байдлаар графикт оруулан авч үзвэл:

График 4.66. Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр нууцаар авах зөрчлийн үзүүлэлт



Түүнчлэн, Зөрчлийн тухай хуулийн 8.8 дугаар зүйлд заасан бусдын эд хөрөнгийг хууль бусаар устгасан, гэмтээсэн гэх зөрчил сүүлийн 3 жил дараалан өссөн судалгаа гарч байна.

Тухайлбал, 2017 онд 13 гарч байсан бол 2018 онд 62 гарч даруй 3.7 дахин өссөн бол 2019 онд 75 гарч 20.9%-иар өссөн байна.

Тус хороонд гарсан бүх зөрчлийг Зөрчлийн тухай хуулийн зүйл, заалт бүрээр нь задалж, 2017, 2018 болон 2019 оны эхний 11 сарын байдлаар нь хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4.13.

№	Зөрчлийн төрөл	Нийт	Он				
			2017	2018	2019		
1.	10.4 дүгээр зүйл. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих 1.Зөвшөөрөлтэйгөөр эрхлэх худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээг зөвшөөрөлгүйгээр явуулсан	218	16	119	7.4 дах	83	-30.3
2.	10.4 дүгээр зүйл. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих	17	1	6	5 дах	10	87.5%

	2.Эрх бүхий байгууллагын шийдвэрээр хориглосон газар, цэгт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсан						
3.	13.5 дугаар зүйл.Мал, махны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх журам зөрчих 1.1.мал, мах бэлтгэлийн зориулалтаар гарал үүслийн гэрчилгээгүй мал тууварласан, эсхүл мал, мах тээвэрлэсэн;	2	-	1	-50.0	1	0.0
4.	13.5 дугаар зүйл.Мал, махны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх журам зөрчих 1.2.тусгайлан бэлтгэсэн төвлөрсөн цэгээс өөр газарт мал, мах бэлтгэсэн	1	-	-	0	1	-
5.	14.4 дүгээр зүйл.Авто замын тухай хууль зөрчих 2.2.авто замын зорчих хэсэг, хөвөө, зурвас газар дээр хог, бохир ус, чулуу, төмөр, бусад зүйлсийг хаясан, эсхүл байрлуулсан, эсхүл овоолсон;	1	-	1	-	-	-
6.	14.7 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих 52.3.оршин байгаа газартаа хамаарах замын бохирдол, цас, мөсийг цэвэрлэх үүргээ биелүүлээгүй	1	-	1	-	-	-
7.	15.2 дугаар зүйл.Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах 1.1.тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүй байхыг бусдад уриалсан;	37	-	19	-48.6	18	-5.3
8.	15.2 дугаар зүйл.Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах 1.2.хууль ёсны дагуу шаардсан холбогдох мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл санаатайгаар худал мэдээлэл өгсөн, эсхүл төөрөгдүүлсэн;	9	-	6	-33.3	3	-50.0
9.	15.2 дугаар зүйл.Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах 1.3.хийсэн үйл ажиллагаанд нь саад учруулсан, эсхүл хөндлөнгөөс нөлөөлөхийг оролдсон	11	2	6	200.0	3	-50.0
10.	15.2 дугаар зүйл.Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах 2.1.төрийн албан хаагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүй байхыг уриалсан;	196	2	55	2650.0	139	152.7
11.	15.2 дугаар зүйл.Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах 2.2.төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд нь саад учруулсан;	15	1	10	900.0	4	-60.0
12.	15.2 дугаар зүйл.Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах 2.3.төрийн албан хаагчийг хүч хэрэглэхгүйгээр эсэргүүцсэн, эсхүл доромжилсон	30	3	18	500.0	9	-50.0
13.	15.7 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах 2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч шүүхэд хүрэлцэн ирэх, эсхүл шүүхэд мэдүүлэг өгөхөөс татгалзсан, зайлсхийсэн, эсхүл шүүхийн иргэдийн төлөөлөгч, шүүхийн захиргааны ажилтны үйл ажиллагаанд саад учруулсан	4	-	-		4	-
14.	15.9 дүгээр зүйл.Хуурамч дуудлага, мэдээлэл өгөх	211	2	50	2400.0	159	218.0

	1.Гэмт хэрэг, зөрчил, түргэн тусламж, гамшиг, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, гал түймрийн талаар эрх бүхий байгууллагад хуурамч дуудлага, мэдээлэл өгсөн						
15.	5.1 дүгээр зүйл.Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах 1.Олон нийтийн газар, авто зам, орон сууцны орчны газар, гудамж, талбайд бие зассан, эсхүл нус, цэр, тамхины иш, хог хаясан	8	1	2	100.0	5	150.0
16.	5.1 дүгээр зүйл.Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах 2.Согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон газарт архидан согтуурсан, эсхүл ажил, үйлдвэрлэлийн зайлшгүй шаардлагатай нөхцөл, эсхүл заншлын дагуу хэрэглэж байгаагаас бусад тохиолдолд хот, суурин газарт биедээ хутга, эсхүл хүний биед гэмтэл учруулж болох тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл авч явсан	23	9	4	-55.6	10	150.0
17.	5.1 дүгээр зүйл.Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах 3.Мансуурсан	34	2	19	850.0	13	-31.6
18.	5.2 дугаар зүйл.Танхайрах 1.Олон нийтийн газарт:	134	107	16	-85.0	11	-31.3
19.	5.2 дугаар зүйл.Танхайрах 2.бусдыг өдөөн хатгаж;	4	3	1	-66.7	-	-
20.	5.2 дугаар зүйл.Танхайрах 3.бусдын амгалан тайван байдал алдагдуулж	98	52	3	-94.2	43	1333.3
21.	5.2 дугаар зүйл.Танхайрах 4.олон нийтийг үл хүндэтгэж;	5	3	2	-33.3	-	-
22.	5.2 дугаар зүйл.Танхайрах 5.үйлчилгээний болон дарааллын журам зөрчиж биеэ авч явах нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг зөрчсөн, эсхүл аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан	2	1	-		1	-
23.	5.3 дугаар зүйл.Хүний биед халдах 1.Хүний биед хохирол учруулахгүйгээр халдаж зодсон	352	54	122	125.9	176	44.3
24.	5.4 дүгээр зүйл.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих 1.Гэр бүлийн хүчирхийллийн талаар хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ биелүүлээгүй	12	10	2	-80.0	-	-
25.	5.4 дүгээр зүйл.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих 2.Түр хамгаалах байрны журам зөрчиж нэвтэрсэн	2	2	-		-	-
26.	5.4 дүгээр зүйл.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих 4.1.зодсон;	346	31	72	132.3	243	237.5
27.	5.4 дүгээр зүйл.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих 4.2.хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан;	290	21	52	147.6	217	317.3
28.	5.4 дүгээр зүйл.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих 4.3.бусадтай харилцахыг хязгаарласан;	1	1	-		-	-
29.	5.4 дүгээр зүйл.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих 4.4.хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан	10	-	4		6	50.0
30.	5.5 дугаар зүйл.Нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах	102	17	14	-17.6	71	407.1

	1.Нийтийн зориулалттай орон сууцанд шөнийн цагаар бусад оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулсан						
31.	5.6 дугаар зүйл.Хууль бусаар зэвсэг эзэмших 1.Хууль бусаар тусгай хэрэгсэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, агсамжийг биедээ авч явсан, хадгалсан	1	-	-		1	-
32.	5.Галт зэвсэг бүртгүүлэх, хадгалах, ашиглах, эзэмших, худалдан авах журам зөрчсөн 5.6 дугаар зүйл.Хууль бусаар зэвсэг эзэмших	1	-	-		1	-
33.	5.7 дугаар зүйл.Мөрийтэй тоглоом зохион байгуулах 1.Олон нийтийн газар ашиг олох зорилгоор шоо, хөзөр, бусад эд зүйл ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог мөрийтэй тоглоом зохион байгуулсан	23	8	4	-50.0	11	175.0
34.	5.7 дугаар зүйл.Мөрийтэй тоглоом зохион байгуулах 2.Үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог хуулиар хориглосон мөрийтэй тоглоомын газар байгуулсан, эсхүл ажиллуулсан	35	7	17	1.4 дах	11	-35.3
35.	5.9 дүгээр зүйл.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль зөрчих 1.байгууллагынхаа дотоодод болон үйл ажиллагаа явуулж байгаа хүрээндээ гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авах;	18	1	10	9 дах	7	-30.0
36.	5.9 дүгээр зүйл.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль зөрчих 2.ажилтнууддаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах;	6	-	-		6	-
37.	5.9 дүгээр зүйл.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль зөрчих 3.гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах талаар шүүхийн энгийн магадлал, прокурорын болон бусад эрх бүхий албан тушаалтны мэдэгдэл, зөвлөмжийг хүлээж авсан байгууллага, аж ахуйн нэгж түүний дагуу тодорхой арга хэмжээ авч, хариуг хугацаанд нь өгөх үүргээ биелүүлээгүй	95	-	10		85	750.0
38.	6.18 дугаар зүйл.Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль зөрчих 4.Биеэ үнэлэн бусадтай бэлгийн харьцаанд орсон, эсхүл бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орсон	33	3	15	4.25 дах	15	0.0
39.	6.18 дугаар зүйл.Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль зөрчих 7.Өөрийн эзэмшлийн байр, газарт биеэ үнэлэхийг зохион байгуулсан, биеэ үнэлэхэд зуучилсан	37	9	15	66.7	13	-13.3
40.	6.20 дугаар зүйл.Хүүхдийн эрхийг зөрчих 9.Хүүхдийн бие махбодод халдсан, эсхүл үл хайхарсан, эсхүл хүүхдийн дэргэд архидан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн	24	1	1	0.0	22	2100.0
41.	6.21 дүгээр зүйл.Гүтгэх 1.Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан	5	1	4	3 дах	-	-
42.	6.3 дугаар зүйл.Тамхины хяналтын тухай хууль зөрчих 1.Утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татсан, эсхүл татах боломж олгосон	27	12	6	-50%	9	50.0

43.	6.3 дугаар зүйл.Тамхины хяналтын тухай хууль зөрчих 2.Монгол Улсын нутаг дэвсгэрт утаат тамхи.импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн	37	1	8	7 дах	28	250.0
44.	6.3 дугаар зүйл.Тамхины хяналтын тухай хууль зөрчих 4.1.санхүүгийн, эсхүл эд материалын хандив, тусламж үзүүлсэн;	1	-	1	0%	-	-
45.	6.3 дугаар зүйл.Тамхины хяналтын тухай хууль зөрчих 4.2.бусдад дэмжлэг үзүүлсэн;	1	-	-		1	-
46.	6.5 дугаар зүйл.Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих 11.1. Согтууруулах ундаа үйлдвэрлэх;	122	32	82	1.56 дах	8	-90.2
47.	6.5 дугаар зүйл.Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих 11.4.борлуулах;	1	-	-		1	-
48.	6.5 дугаар зүйл.Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих 11.5.худалдах, түүгээр үйлчлэх ажилд арван найман насанд хүрээгүй хүн ажиллуулсан, эсхүл хорин нэгэн насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсэн	161	7	26	2.7 дах	128	392.3
49.	6.5 дугаар зүйл.Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих 13.Зохих зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд зааснаас бусад газарт, эсхүл гар дээрээс согтууруулах ундаа худалдсан, эсхүл түүгээр үйлчилсэн	74	11	19	72.7%	44	131.6
50.	8.6 дугаар зүйл. Хулгайлах 1.Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	93	20	47	1.3 дах	26	-44.7
51.	8.7 дугаар зүйл.Хөрөнгө завших 1.Бусдын итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг завшсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	2	1	1	0.0	-	-
52.	8.8 дугаар зүйл.Эд хөрөнгө устгах, гэмтээх 1.Бусдын эд хөрөнгийг хууль бусаар устгасан, гэмтээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	150	13	62	3.7 дах	75	21.0
Нийт		3108	468	928		1712	

Зөрчил гаргасан иргэдийн байдлыг авч үзвэл архаг архичин - 21, биеэ үнэлэгч - 48, гаж донтон - 1, гэр бүлийн хүчирхийлэгч - 712, урьд нь захиргааны арга хэмжээ авагдсан - 21, урьд нь ял шийтгэгдсэн - 14, хөдөө орон нутгаас шилжин ирсэн - 15 байна.


Хүснэгт 4.14.

№	Гэр бүлийн хүчирхийлэгч	Тоо
1.	Бусад	34
2.	Нөхөр	410
3.	Ах	8
4.	Төрсөн дүү	15
5.	Төрсөн хүү	9
6.	Төрсөн эгч	2
7.	Төрсөн эх	8
8.	Төрсөн эцэг	30
9.	Хадам аав	1
10.	Хадам ээж	1
11.	Хамтран амьдрагч	160

12.	Хойд эцэг	5
13.	Хүргэн	6
14.	Хүргэн дүү	1
15.	Эхнэр	22
Нийт		712

Зөрчил гаргасан иргэдийг нийгмийн байдлаар авч үзвэл: ажилгүй иргэн 745 буюу 33%, малчин -12 буюу 0.1%, оюутан - 46 буюу 2%, сурагч - 5 буюу 0.2%, сургууль завсардсан хүүхэд - 1 буюу 0.001%, төрийн албан хаагч - 41 буюу 0.97%, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын ажилтан - 10, төрийн бус байгууллагын ажилтан 63 буюу 0.85%, тэнэмэл - 10 буюу 0.03%, тэтгэвэрийн иргэн - 33 буюу 0.67%, хоригдол - 7 буюу 0.02%, хувиараа хөдөлмөр эрхэлдэг 1080 буюу 48%, хувийн хэвшлийн байгууллагад ажилладаг - 211 буюу 9%, ЦАХ - 2 буюу 0.001%, цэцэрлэгийн яслийн багш - 3 буюу 0.003% байна.

График 4.67. Зөрчил үйлдсэн хүмүүсийн нийгмийн байдал




Зөрчил гаргасан иргэдийн нийгмийн байдалд дүн шинжилгээ хийж үзвэл зөрчил гаргасан дийлэнх буюу 48%-ийг хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, 9%-ийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа иргэд гаргасан байгаа нь тэд тодорхой хэмжээний санхүүгийн байнгын орлогын эх үүсвэрээсээ согтууруулах төрлийн ундаа худалдан авч хэрэглэх боломжтой байгаа нь зөрчил гарах нэг хүчин зүйл болсон байна. Түүнчлэн, зөрчил гаргагчдын 33%-ийг ажилгүй иргэд эзэлж байгаа нь тэднийг ажил хөдөлмөр эрхлүүлэх чиглэлээр тодорхой ажил арга хэмжээ авахгүй байгаатай, нөгөө талаараа тэдний ар тал тодорхой хэмжээний санхүүгийн боломжтой болоод зөрчил гаргаж байна гэж үзэж байна.

Зөрчил гаргасан иргэдийн насны байдлыг авч үзвэл 0-16 хүртэл настай - 11 буюу 0.98%, 17-25 настай - 515 буюу 17%, 26-35 настай - 1301 буюу 42%, 36-45 настай - 767 буюу 25%, 46-55 настай - 398 буюу 13%, 56-65 настай - 106 буюу 3%, 66 ба түүнээс дээш настай - 3 буюу 0.85%-ийг тус тус эзэлж байна.

5-р хороонд гарсан зөрчлийг шийдвэрлэсэн алба хаагчдыг албан тушаалынх нь байдлаар авч үзвэл мөрдөн байцаагч - 7 буюу 0.94%, хэв журмын алба хаагч - 681 буюу 22%, хэрэг бүртгэгч - 81

буюу 3%, хэсгийн байцаагч - 1468 буюу 47%, хэсгийн төлөөлөгч - 6 буюу 0.54%, эргүүлийн цагдаа - 4 буюу 0.35%, шүүгч - 861 буюу 28%-ийг тус тус эзэлж байна.

График 4.68. Зөрчил шийдвэрлэсэн албан тушаалтан



Дээрх зөрчил шийдвэрлэсэн албан тушаалтны байдлыг авч үзвэл дийлэнх зөрчлийг хороо хариуцсан хэсгийн байцаагч шийдвэрлэж байгаа нь тэдний үндсэн үүрэг болох гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлаа хийх боломж бага байгаа, ихэвчлэн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаан дээрээ ихэнх цагаа зарцуулж байгаа нь зөрчил гарахад сөргөөр нөлөөлөх нэг хүчин зүйл болсон гэж үзэж байна.

2017 онд 468 зөрчлийг хэсгийн байцаагч, 41 хэрэг бүртгэгч, 1 эргүүлийн цагдаа, 16 хэв журмын алба хаагч, 96 шүүгч 96 зөрчилд захиргааны журмаар баривчлах, 5 зөрчилд торгох шийтгэл оногдуулсан байна.

Гэр бүлийн хүчирхийлэл

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой зөрчлийн 3 жилийн тоо бүртгэлийг авч үзвэл 2017 онд 65 буюу 9%, 2018 онд 137 буюу 20%, 2019 оны эхний 11 сарын байдлаар 496 буюу 71% нь тус гарсан байна.

Зөрчлийн өсөлтийг авч үзвэл гэр бүлийн хүчирхийлэл 2018 онд өмнөх оноос 1.1 дахин, 2019 оны эхний 11 сарын байдлаар 496 буюу 2018 оныхоос даруй 2.6 дахин өссөн судалгаа гарч байна.

График 4.69. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил




Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн иргэдийн хүйсийн байдлыг авч үзвэл 661 буюу 95% нь эрэгтэй, харин 37 буюу 5% эмэгтэй байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн иргэдийн насны байдлыг авч үзвэл 18-25 настай 42 буюу 6%, 26-35 настай 218 буюу 31%, 36-45 настай 265 буюу 38%, 46-55 настай 136 буюу 20%, 56-65 настай 34 буюу 5%, 66-72 настай 3 буюу 0.2%-ийг тус тус эзэлж байна.

Тус хороонд гарсан нийт 698 зөрчлийн 639 буюу 92%-ийг баривчлах шийтгэл, харин 59 буюу 8%-ийг шийтгэвэрээр торгох шийтгэлийг тус тус ногдуулсан байна.

График 4.70. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд хүлээлгэсэн хариуцлага



Хүчирхийлэл үйлдсэн иргэдийн нийгмийн байдлыг авч үзвэл ажилгүй иргэн 316 буюу 54%, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн 189 буюу 32%, хувийн хэвшлийн байгууллагад 43 буюу 8%, төрийн алба хаагч 9 буюу 2%-ийг тус тус эзэлж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийг шийдвэрлэсэн албан тушаалтныг авч үзвэл хэв журмын алба хаагч 26 буюу 4%, хэсгийн байцаагч 20 буюу 3%, хэрэг бүртгэгч 3 буюу 0.2%, хэсгийн төлөөлөгч 1 буюу 0.1%, шүүгч 648 буюу 93%-ийг тус тус шийдвэрлэн шийтгэл ногдуулсан байна.

4.5.4. ДҮГНЭЛТ

БЗД-ийн 5-р хороо нь нийслэлийн хүн ам хамгийн их төвлөрсөн, 23600 орчим хүн амтай, 6458 өрх айлтай, 1 га дунджаар 75.9 хүн амьдран суудаг, гэр хороолол, нийтийн орон сууцны хороолол хосолсон, урдаас хойшоо чиглэсэн сунасан байршилтай өвөрмөц онцлог бүхий хороо юм.

Хорооны нутаг дэвсгэр рүү орж гарсан 65 зам байгаагаас засмал зам 20 буюу 31.2%, шороон зам 45 буюу 68.8%-ийг тус тус эзэлж байна.

Хорооны 167 иргэн ажил хөдөлмөр эрхэлдэггүй нь нийт хүн амын 7%-ийг эзэлж байгаа бөгөөд 7 буюу 4% нь тодорхой мэргэжилтэй, үлдсэн 160 буюу 96% нь мэргэжилгүй байгаа нь тулгамдсан асуудал болж байна. Харин хүүхдийн тоглоомын талбай 18 байна.

2019 оны байдлаар 5-р хороонд 199 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 8 нэрийн хүнсний дэлгүүр 78 буюу 41.2%, 6 нэрийн дэлгүүр 17 буюу 8.9%, мини болон супермаркет 9 буюу 4.7%-ийг эзэлж байгаа бөгөөд зөвхөн 104 дэлгүүр гэхэд нийт аж ахуйн нэгж байгууллагын 55%-ийг дангаар эзэлж байна.

Дэлгүүр ажиллуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудыг хорооныхоо нийт хүн амтай харьцуулбал 226*12үн тутам 1 дэлгүүр ногдож байна. Түүнчлэн тус хороонд иргэд, олон нийт чөлөөт цагаа өнгөрөөх цэцэрлэгт хүрээлэн, усан оргилуур зэрэг тохижуулсан олон нийтийн газар байхгүй байгааг анхаарах шаардлагатай болжээ.

Гэмт хэргийн талаар:

Гэмт хэрэг зөрчил буурахгүй байгаа нь камерын хяналт гудамж талбай, автобусны буудал, орон сууцны гудамжинд бага, урьдчилан сэргийлэх эргүүлийн үйл ажиллагаа тогтмолжоогүй, олон нийтийн оролцоо хангалгүй байгаатай холбон үзэж болохоор байна.

Дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангаас холбогдох зардлыг гаргуулан хорооны нутаг дэвсгэрт орж, гарч байгаа 65 шороон болон засмал замуудад багцлан камержуулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.



Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаанд дараах хүчин зүйл нөлөөлж байна гэж дүгнэж байна. Үүнд:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эргүүл хийхэд цагдаагийн хүч хүрдэггүй, нөгөө талаар олон нийтийн эргүүлийг зохион байгуулдаггүй;
- Камерын хяналт сул, хэсгийн байцаагчийн урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй явагддаг, ихэвчлэн өргөдөл, гомдол шалгахад ихэнх цагаа зарцуулдаг;
- Бүртгэл, судалгаа хангалтгүй хийгддэг;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хороо болон цагдаагийн хэсгийн байцаагч, цагдаа нарын харилцан, хамтын ажиллагаа хангалтгүй явагддаг;
- Монел задгай хүртэл 5.2 км газар хэсгийн байцаагч, цагдаа нар явган явж цаг их алддаг;
- Алслагдсан газар /Монел/-т хууль тогтоомжийн хэрэгжилтэнд тавих хяналт шалгалт сул;
- Хороо болон цагдаагийн хэсгийн харилцан хамтын ажиллагаа хангалтгүй, мэдээллээ солилцож, ажлаа төлөвлөдөггүй.

Зөрчлийн талаар:

БЗД-ийн 5 хорооны нутаг дэвсгэрт 2017-2019 оны 12 сарын 01-ны хүртэлх 3 жилийн хугацаанд нийт 3108 зөрчил гарч, шийдвэрлэгдсэн байна.

Зөрчил гаргасан иргэдийн нийгмийн байдалд дүн шинжилгээ хийж үзвэл зөрчил гаргасан дийлэнх буюу 48%-ийг хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, 9%-ийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа иргэд гаргасан байгаа нь тэд тодорхой хэмжээний санхүүгийн байнгын орлогын эх үүсвэрээсээ согтууруулах төрлийн ундаа худалдан авч хэрэглэх боломжтой байгаа нь зөрчил гарах нэг хүчин зүйл болсон байна. Түүнчлэн, зөрчил гаргагчдын 33%-ийг ажилгүй иргэд эзэлж байгаа нь тэднийг ажил хөдөлмөр эрхлүүлэх чиглэлээр тодорхой ажил арга хэмжээ зохиохгүй байгаатай, нөгөө талаараа тэдний ар тал тодорхой хэмжээний санхүүгийн боломжтой болоод зөрчил гаргаж байна гэж үзэж байна.

5-р хороонд гарсан зөрчлийг шийдвэрлэсэн алба хаагчдыг албан тушаалынх нь байдлаар авч үзвэл дийлэнх зөрчлийг хороо хариуцсан хэсгийн байцаагч шийдвэрлэж байгаа нь тэдний үндсэн үүрэг болох гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлаа хийх боломж бага, ихэвчлэн зөрчил шалган

шийдвэрлэх ажиллагаанд ихэнх цагаа зарцуулж байгаа нь зөрчил гарахад сөргөөр нөлөөлөх нэг хүчин зүйл болжээ гэж үзэж байна.

Түүнчлэн, тус хороонд гэр бүлийн хүчирхийлэл 712 гарсан нь ихээхэн анхаарал татаж байгаа боловч энэ нь ихэвчлэн ахуйн хүрээнд буюу гэр бүлийн орчинд гардагаас урьдчилан сэргийлэх боломж хязгаарлагдмал байгаатай салшгүй холбоотой.

Нөгөө талаараа гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг гарахгүй, гагцхүү зөрчлийн шинжтэй байгаагаас тэдэнд тавих хяналтын эрх зүйн орчин бүрдэхгүй, нөгөө талаараа хяналтын дагнасан нэгдсэн бүртгэлийн сан байхгүйгээс хяналт тавих боломжийг бууруулж байна.

Дээрх бүгдийг нэгтгэн дүгнэж үзвэл 5-р хороо нь гэр хороолол давамгайлсан нутаг дэвсгэртэй, алслагдсан газарт урьдчилан сэргийлэх цагдаагийн эргүүл тэр бүр яваад байхгүй боломж бага, цагдаагийн хүч хэрэгсэл хүрдэггүй, иргэдийн оролцоонд тулгуурласан нийтийн эргүүл явахгүй байгаагаас гудамж талбайд гэмт хэрэг, зөрчил гарч байгааг холбон үзэж болохоор байна.

Түүнчлэн гудамж талбай, олон нийтийн газар хяналтын камер бага, цагдаагийн хөдөлгөөнт эргүүл зөвхөн гэмт хэрэг, зөрчил гарсан хойно нь очиж шалган шийдвэрлэж байгаа нь урьдчилан сэргийлэх үндсэн хэлбэр болох эргүүлийн үйл ажиллагаа багассантай холбоотой.

Тус хороонд 1 хэсгийн байцаагч, 1 хэсгийн цагдаа болон олон нийтийн цагдаа гэсэн 3 алба хаагч ажиллаж байгаа боловч тэд ихэвчлэн зөрчлийн шинжтэй хэрэг бүртгэлт, өргөдөл, гомдлыг шалган шийдвэрлэдэг, урьдчилан сэргийлэх ажил хийх боломж нөхцөл бага, объектын судалгаа хийхгүй байгаа нь гэмт хэрэг, зөрчил гарахад тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.

Нөгөө талаараа хороонд оршин сууж байгаа эрхэлсэн тодорхой ажилгүй иргэдийг дүүргийн захиргаанаас мэргэжил олгох сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, ажилд зуучлах асуудал хангалтгүй байгаатай салшгүй холбоотой.

Мөн хорооны төвөөс алслагдсан Монелын хэсэгт гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах төвийг дүүргийн захиргааны дэмжлэгтэйгээр байгуулах нь ач холбогдолтой гэж үзэж байна.

Үүний зэрэгцээ дүүргийн Засаг даргын захирамжаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, алба хаагчдаар нийтийн эргүүлийг сард нэг удаа гэмт хэрэг, зөрчил хамгийн их гардаг цаг болон газраар гаргах эрх зүйн орчныг бүрдүүлж өгөх шаардлагатай байна.

Хорооны нутаг дэвсгэрээс гарсан, орсон бүх замыг багцлан камер байршуулан, нэгдсэн системд холбох замаар хяналтыг сайжруулах нь гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх боломжийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

ЗӨВЛӨМЖ

Дүүргийн Засаг дарга, ИТХ

1. БЗД-ийн 5 хорооны нутаг дэвсгэрийг Моносын замын урд талын замаар зааглан дахин нэг хороо шинээр байгуулах саналыг дүүргийн Засаг даргаар уламжлуулан Нийслэлийн ИТХ-д танилцуулан шийдвэрлүүлэх /гэр хороолол болон орон сууцжсан төрөлжсөн хороо бий болох/
2. Хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, алба хаагчдыг тухайн хорооны Засаг дарга, Иргэдийн нийтийн хурлын даргын шийдвэрээр сар бүр нэг удаа нийтийн эргүүлд гарч байх, түүнд тавих хяналтыг хорооны хэсгийн байцаагч, цагдаа, олон нийтийн цагдаагийн ажилтан болон зохион байгуулагч, хэсгийн ахлагч нар ээлжлэн хяналт тавьж байх зохицуулалтыг бүрдүүлэх ажлыг санаачлан хэрэгжүүлэх;
3. Хорооны нутаг дэвсгэрт нэн шаардлагатай байгаа гудамжны гэрэлтүүлэг болон хяналтын камер тавих, түүнтэй холбоотой санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж өгөх;
4. Хөршийн хяналтын хөтөлбөрийг гэр хорооллын гудамжинд хэрэгжүүлэх, “Гэрэлт аюулгүйн баян бүрд” төсөлт ажлыг хорооноос санаачлан зохион байгуулж, гудамж бүр ахлагчтай болох ба ахлагч нь хорооны хэсгийн ахлагч болон хэсгийн байцаагчтай үнэ төлбөргүй харилцах боломжийг бүрдүүлэх замаар мэдээллийн шуурхай байдлыг хангах;

/харилцаа холбооны байгууллагатай гэрээ байгуулах замаар сүлжээндээ үнэгүй ярьдаг утсаар хангах, гудамжны ахлагчийн урамшуулал болон утасны зардлыг ГХУС ажлын төсвөөс гаргуулах/;

5. Хорооны хэсгийн байцаагч, цагдаа нарт алслагдсан газруудад хяналт тавих, гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээллийг шуурхай шалгахад шаардлагатай мотоцикл олгох, түүний санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж өгөх;

Дүүргийн цагдаагийн газар:

1. Хорооны Монел, Моносын чиглэлээр явган эргүүл ажиллуулах боломж нөхцлийг судалж, зөвхөн 18-23 цагийн хооронд явган эргүүлийг ажиллуулах;
2. Цагдаагийн хэсгийн байцаагчийн шалгах өргөдөл, гомдлын хүрээ, хязгаарыг нарийвчлан тодорхойлох замаар зөрчлийн өргөдөл, гомдол шалгах ажилд зарцуулж байгаа цагийг багасгаж, урьдчилан сэргийлэх ажил хийх боломж нөхцлийг бүрдүүлэх;
3. Цагдаагийн хэсгийн байрны гадна талд мэдээллийн самбар байрлуулах замаар харьяалан шалгах өргөдөл, гомдлын хүрээ, хязгаар, ажлын цагийн хуваарийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх;
4. Гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгуулах чиглэлээр өгч байгаа мэдэгдлийг бүртгэх нэгдсэн мэдээллийн цахим санг бий болгох замаар үр дүнг тооцдог болох, мэдэгдлийн үр дүнг биечлэн шалгах ажлын тусгайлсан цаг гаргаж өгөх /Лхагва гараг бүр 09-13 цаг/;
5. Хэсгийн байцаагчийн зөвхөн объектын судалгаа хийдэг өдрийг тусад нь гаргаж өгөх /Пүрэв гараг бүр 14-18 цаг/;
6. Гэмт хэрэг, зөрчил их үйлдэгдэж байгаа шөнийн цагаар явган эргүүлийг зохион байгуулах, түүнд шаардлагатай хүч хэрэгслийг бүрдүүлэх ажлыг олон нийтийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж тогтмолжуулах;

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр:

Хорооны Засаг даргаар уламжлуулан Дүүргийн ИТХ-д танилцуулах замаар Монелын гэр хороололын 27, 28 дугаар гудамжны үзүүрийн задгай хэсэгт Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 5 өрөө бүхий “Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх олон нийтийн төв”-ийг шинээр байгуулж, дараах дэд хэсгүүдийг байрлуулан ажиллуулах;

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйлчилгээ

- Эхний өрөө нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой иргэдээс ирүүлэх мэдээ, мэдээллийг хүлээн авч, цахим бүртгэлд бүртгэн дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх зориулалттай байна.
- Тус хорооны хэсгийн 22 ахлагч ээлжлэн сард 1-ээс доошгүй удаа дуудлага мэдээлэл хүлээн авч ажиллана.
- Хоёр дахь өрөө нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон иргэнийг хүлээн авч, эмнэлгийн анхан шатны болон сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэн холбогдох байгууллага, албан тушаалтанд хүлээлгэн өгөх хүртэл байрлуулах зориулалттай өрөө байна.

Камерын хяналтын систем

- Энэ өрөө нь тус хорооны камергүй гудамж, талбай, олон нийтийн газар болон гэмт хэрэг, зөрчил гарч болзошгүй цэгүүдэд байршуулсан камеруудад хяналт тавих зорилгоор төхөөрөмжилсөн 20-30 дэлгэц бүхий хяналтын өрөө байна.
- Камерын дэлгэц хянах ажилд тус хороонд оршин сууж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллана.
- Камерын дэлгэц хянаж байгаа иргэн нь бүх сүлжээндээ үнэ төлбөргүй ярих эрхтэй утсаар хангагдсан байна.
- Камерын дэлгэцээр гэмт хэрэг, зөрчлийн шинж тэмдэг бүхий үйлдэл илэрсэн тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэнэ.

Эрх зүйн сургалт, сурталчилгааны дэд хэсэг

- Энэ өрөө нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн иргэд 7 хоногт нэг удаа 6-аас доошгүй цаг хууль тогтоомжтой танилцдаг, эрх зүйн болон ёс зүйн сургалтанд хамрагддаг зориулт бүхий өрөө байна.
- Эрх зүйн сургалтын өрөөг олон нийтийн цагдаагийн ажилтан болон хэсгийн ахлагч нар ээлжлэн хариуцаж ажиллуулна.
- Энэ өрөө нь хэсгийн байцаагч, цагдаа, олон нийтийн цагдаагийн ажилтан болон хэсгийн ахлагч, хорооны зохион байгуулагч нар хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг явуулах зорилгоор тохижуулсан өрөө байна.


Гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх цагдаагийн дэд хэсэг

- Хэсгийн байцаагч, цагдаа болон явган, хөдөлгөөнт эргүүлийн алба хаагч нар тухайн хороонд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг түр саатуулан шалгаж, тодруулах ажиллагаа явуулдаг өрөө болно.
- Гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйлийг түр хураан авч хадгалах буланг энэ өрөөнд байрлуулна.
- “Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх олон нийтийн төв”-ийг шинээр барихтай холбоотой барилгын санхүүгийн эх үүсвэрийг ИХТ, ЗД шийдвэрлэж өгөх;
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж зөрчил гаргасан ажилгүй иргэдийг хорооны хэсгийн ахлагч нарын тусламжтайгаар Хорооны Засаг дарга, Иргэдийн нийтийн хурлын дарга, хөдөлмөр, нийгэм халамжийн хэлтэс, хэсгийн байцаагч нар хамтран 1 сард ажилд зуучлах өдөрлөгийг зохион байгуулж, хэвшүүлэх;
- Тус хорооны 22 хэсгийн ахлагч нар сар бүр гурав гурваараа хуваагдаж, сар бүр 3 хэсэг ажилгүй иргэдийг ажилд зуучлах үйл ажиллагааг сар бүр зохион байгуулах. Тухайлбал, 1-р сард 1, 2, 3-р хэсгийн ахлагч нар өөрсдийн харьяалах гудамж, орон сууцанд амьдран суух ажилгүй, хүчирхийлэл үйлдэж хариуцлага хүлээсэн иргэдийг цуглуулж, ажилд зуучлан оруулж ажилтай болгох. Үүнд хэсгийн байцаагч, цагдаа нар дэмжлэг үзүүлж ажиллах;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд Сууц өмчлөгчдийн холбоодыг татан оролцуулах;
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хариуцлага хүлээсэн иргэдийн талаарх мэдээллийг ажиллаж буй байгууллагын удирдлагад танилцуулж, хамтарсан сургалтыг явуулах.

БҮЛЭГ 5. “БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 7 ДУГААР ХОРООНЫ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ” КРИМИНОЛОГИ СУДАЛГААНЫ ДЭД ТАЙЛАН

Судалгааны дэд баг: Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, цагдаагийн хурандаа А.Амарсайхан, багш, цагдаагийн хошууч Д.Бямбахүү, магистрант нар хийж гүйцэтгэв.

5.1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Монгол Улс 1992 онд Шинэ Үндсэн хуулиа баталж үүнтэй уялдан Монгол Улсын засаг захиргааны нутаг дэвсгэрийн нэгжид өөрчлөлт орж Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль батлагдан гарснаар 1992 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 18 дугаар тогтоолоор Найрамдлын район нь Баянзүрх дүүрэг болсон ба 7 дугаар хороо нь 1986 онд ОСГ-ны 7 дугаар хороо нэртэй байгуулагдаж байжээ.

Хорооны онцлог: Тус хороо нь Нийслэлийн А зэрэглэлийн бүсэд оршдог, 16.68 га талбай бүхий газар нутагтай. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг 182 аж ахуйн нэгжтэй. Архи согтууруулах ундаа, худалдаа үйлчилгээний цэг нийт 42 байдаг. Мөн бүх арилжааны банкуудын салбар, үүрэн телефоны оператор байгууллагуудын салбарууд байрлан үйл ажиллагаа явуулдаг. Үүнийг дагаад хүний урсгал хөдөлгөөн ихтэй. Өдөрт 1 аж ахуйн нэгж, байгууллагаар дунджаар 50 орчим иргэн үйлчлүүлдэг. Хүн олноор дамжин өнгөрдөг тул явуулын гар дээрх жижиглэнгийн худалдаа ихтэй.

- ❖ Нийт өрх –1716
- ❖ Нийт хүн ам – 7179
- ❖ 0-5 насны хүүхэд -875
- ❖ Сургуулийн насны – 1224
- ❖ Өрх толгойлсон эмэгтэй – 670
- ❖ Өрхийн тэргүүн эрэгтэй – 1046
- ❖ Хагас өнчин – 97
- ❖ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд – 13
- ❖ Хөгжлийн бэрхшээлтэй иргэн – 157

Хот төлөвлөлт, барилгажилтын одоогийн байдал: Тус хороо нь хотын А зэрэглэлийн бүсэд 100 хувь орон сууцны хороолол бөгөөд нийт 7 СӨХ-ийн 16 байр, СӨХ байгуулаагүй 9 байр, аж ахуй нэгжийн 24 барилга, нийтийн байр 3 байна. Орон сууцны барилгууд ихэвчлэн 1968-1980 онд баригдсан хуучирч элэгдсэн, хороолол дундах явган болон авто зам эвдэрч муудсан ба хорооны хойд хэсэгт байрлах 37а, 37б, 38а, 38б, 40, 41 дүгээр байрууд орчмын гаднах тохижилт тааруу байна.

Байшин барилга, бүтээн байгуулалтын шийдэл нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ач тусаа байнга өгдөг. Худалдааны болоод орон сууцны зориулалтыг хослуулах нь байнга хөл хөдөлгөөн ихтэй байснаар ажиглагдахуйц байдлыг нэмэгдүүлнэ. Гэхдээ барилгын орц, зогсоол талбайн хуваарилалтыг оновчтой шийдэх хэрэгтэй бөгөөд хуваарилалт нь бүхий л барилгын аюулгүй байдалд нөлөөлөхгүй байх шаардлагатай.

Сууц өмчлөгчдийн холбоо:

- ❖ Л.Цогтбаатар захиралтай “Мичид” СӨХ
- ❖ Г.Энхтуяа захиралтай “Хантайшир” СӨХ
- ❖ П.Алзахгүйбаатар захиралтай “Мандах-Нар” СӨХ
- ❖ Ж.Ганзориг захиралтай “Алтан-Овоо” СӨХ
- ❖ Д. Наранцэцэг захиралтай “Хос зам” өргөө СӨХ
- ❖ С. Батсүх захиралтай “Сүлд-115” СӨХ
- ❖ Н.Адьяа захиралтай “САНСАР СУҮБ” СӨХ –үүд иргэдийн эрүүл ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Дэд бүтцийн талаар: Тус хорооны барилгууд ихэнх нь хуучирсан, хороолол дундах явган болон авто зам эвдэрч муудсаны улмаас тоосжилт ихэссэн. Хорооны хойд хэсэгт байрлах 37а, 37б, 38а, 38б, 40, 41 дүгээр байрууд орчмын энэ хэсэгт гэмт хэрэг үйлдэгдэх нөхцөл бүрдэж байгаа тул хэсгийн байцаагчаас урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулах шаардлагатай.

Тус хорооны нутаг дэвсгэрт ерөнхий боловсролын сургууль байдаггүй, 200 хүүхдийн багтаамжтай 1 цэцэрлэгтэй. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байдаггүй.

Хүснэгт 5.1. Газар доорх инженерийн шугам сүлжээний аюулгүй байдлын судалгаа

Шугам сүлжээн дээр байрлах худгийн төрөл	МД	Хорооны нутаг дэвсгэрт байгаа худгийн тоо	Үүнээс таггүй худгийн тоо
А	Б	1	2
Дулааны худаг	1	35	0
Цэвэр усны худаг	2	28	0
Бохир усны худаг	3	68	0
Холбооны худаг	4	105	0
Борооны ус зайлуулах худаг, шүүр	5	0	0
Бусад	6	0	0
Нийт дүн, мөр 7= мөр\1:6\		236	0

Хүснэгт 5.2. Баянзүрх дүүргийн 7-р хорооны гэрэлтүүлгийн судалгаа

№	Гэрэлтүүлгийн хаяг байршил	Одоо байгаа	Асахгүй байгаа	Нийтийн эзэмшлийн газар	Үүнээс байршлаар			
					Авто болон явган хүний зам дагуу	Аж ахуйн нэгж, байгууллагын орчим	Орон сууцны орчим	Бусад
1	Голомт банкны үзүүрээс Шунхлай ШТС хүртэл	15		15	15			
2	Шунхлай шатахуун түгээх станцаас Буудай зочид буудал хүртэл	13		8	8	5		
3	Буудай зочид буудлаас ЭМ-ийн 10-р төв хүртэл	10		10	10			
4	Тэргэл зочид буудлаас 40-р байрны урд булан хүртэл	5		5	5			
5	Яруу хүнсний дэлгүүрийн үзүүрээс 204-р цэцэрлэгийн урд булан хүртэл	4		4	4			
6	1 дүгээр байрны орчин	0		0	0			
7	2 дугаар байрны орчин	3		3	3			
8	2-р байрны хүүхдийн тоглоомын талбай	6		6				
9	23 дугаар байрны орчин	5		5			5	6

10	115 дугаар байрны орчин	3	2	3			3	
11	116 дугаар байрны орчин	3		3			3	
12	24 дүгээр байрны орчин	5		5			5	
13	29 дүгээр байрны орчин	4	4	4			4	
14	58 дугаар байрны орчин	3		3			3	
15	30 дугаар байрны орчин	5	1	5			5	
16	31 дүгээр байрны орчин	5	1	5			5	
17	37а байрны ард, урд	4		4			4	
18	37б байрны орчин	4	4	4			4	
19	41 дүгээр байрны орчин	4		4			4	
20	38а байрны орчин	5	2	5			5	
21	38б байрны орчин	4		4			4	
22	40 дүгээр байрны орчин	2		2			2	
23	41а байр	1		1			1	
24	36г байрны орчин	0		0			0	
25	33-р байрны орчин	4		4			4	
26	59-р байр	1		1			1	
27	57-р байр	5		5			5	
	Бүгд дүн	123	14	118	45	0	67	6

Хорооны байруудын ойр орчимд гэрэлтүүлэг хангалтгүй зарим газруудад иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд хог хаягдлаа замбараагүй асгах дутагдал зөрчлүүд гарах магадлал өндөр. Дээрх 27 цэгт гэрэлтүүлэг болон эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэх талаар холбогдох байгууллагууд хамтран ажиллах шаардлагатай байна.

Хүснэгт 5.3. Баянзүрх дүүргийн 7-р хорооны авто замын судалгаа

№	Зам, гудамжны нэр	байршил	Замын хучилтын төрөл (кодыг бичих)	Замын урт, км	Замын өргөн, метр
1	Их тойруу, Доржийн гудамж	Голомт банкны үзүүрээс Тэргэл зочид буудал хүртэл	1	1100	6
2	Их тойруу, Доржийн гудамж	Голомт банкны үзүүрээс Шунхлай ШТС-хүртэл	1	0,900	6
3	Шунхлай ШТС-аас Тэргэл Зочид буудал хүртэл	Шунхлай ШТС-аас Тэргэл Зочид буудал хүртэл	1	0,209	6
4	Тэргэл төвөөс Эрүүл мэндийн 10-р төв	Тэргэл төвөөс Эрүүл мэндийн 10-р төв	1	0,400	4,5
5	30 дугаар байр	30 дугаар байр	1	0,200	4
6	31 дүгээр байр	31 дүгээр байр	1	0,200	4
7	116 дугаар байрны 1-р орцны үзүүрээс Панда авто угаалгын урд махны дэлгүүр хүртэл	116 дугаар байрны 1-р орцны үзүүрээс Панда авто угаалгын урд махны дэлгүүр хүртэл	1	0,120	3,8
8	33 дугаар байрны орчин	33 дугаар байрны орчин	1	0,199	5
9	40 дүгээр байр	40 дүгээр байр	1	0,107	4
10	41 дүгээр байр	41 дүгээр байр	1	0,130	4
11	1 дүгээр байр	1 дүгээр байр	1	0,253	5
12	2 дугаар байр	2 дугаар байр	1	0,210	5
13	115 дугаар байр	115 дугаар байр	1	0,106	3
14	23 дугаар байрны урд	23 дугаар байрны урд	1	0.150	3,5
15	24 дүгээр байрны урд	24 дүгээр байрны урд	1	0.171	3,5

16	29 дүгээр байр	29 дүгээр байр	1	0.099	3.7
17	Панда авто угаалгаас 204 дүгээр цэцэрлэгийн баруун үзүүр	Панда авто угаалгаас 204 дүгээр цэцэрлэгийн баруун үзүүр		0,095	3
18	38а байр	38а байр	1	0,095	3.0
19	38б байр	38б байр	1	0,073	3.0
20	37а байр	37а байр	1	0,098	3.5
21	37б байр	37б байр	1	0,076	3.5
22	41а байр	41а байр	1	0,017	4
23	36г байр	36г байр	1	0,048	3
Дүн				5,056	

Хорооны нутаг дэвсгэрийн авто зам нь нийт 5,056 км урттай. 1968-1980 оны үед хорооны тавигдсан ба замын эвдрэл гэмтэл их байгаа нь зам тээврийн осол, зөрчил гарах нэг хүчин зүйл болно. Иймд холбогдох газарт албан мэдэгдэл хүргүүлж ажиллах шаардлагатай.

5.2. ХҮН АМЫН СУДАЛГАА


Хүснэгт 5.4. Баянзүрх дүүргийн 7-р хорооны хүн амын судалгаа

д/д	Нийт хүн ам	Эр	Эм	Түр оршин суугч	Хаягандаа амьдардаггүй иргэд	Гадаад оршин суугаа иргэд
1	7179	3363	3816	5	218	745

Баянзүрх дүүргийн 7-р хороо нь нийт 7179 иргэнтэй ба үүнээс эрэгтэй 3363, эмэгтэй 3816, бусад аймаг дүүрэгт бүртгэлтэй боловч түр оршин сууж байгаа 51 иргэн байна. Тус хороонд бүртгэлтэй боловч хаягандаа оршин сууж амьдардаггүй 218 иргэн, гадаад улсад ажиллаж амьдарч байгаа 745 иргэн бүртгэгдсэн байна.

Засгийн газрын 2011 оны А/153 дугаар тогтоол “Цагдаагийн байгууллагын зарим ажил үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-т зааснаар 4000 хүн амд 1 хэсгийн байцаагч ногддог байна. Харин 7-р хорооны нутаг дэвсгэрт 7179 иргэн оршин суудаг ба 182 аж ахуйн нэгжээр өдөрт дунджаар 50 иргэн үйлчлүүлдэг гэж үзэхэд 9100 орчим иргэн үйлчлүүлдэг буюу дамжин өнгөрдөг байна. Үүнээс үзэхэд тухайн хороонд **4 хэсгийн байцаагч** ажиллах шаардлагатай.

График 5.1. Оршин суудаг иргэн, дамжин өнгөрөгчийн харьцаа.




Хүснэгт 5.5. Хүн ам үндэстэн ястнаар

Хүн ам үндэстэн ястнаар								
Баяд	Буриад	Дархад	Дарьганга	Дөрвөд	Захчин	Казах	Монголын харьяаг бусад	Монголын харьяаг гадаад
Эр 31	38	1	25	55	22	31	10	2

Эм 43	49	8	32	61	21	39	4	3
74	7	9	57	116	43	70	14	5
Мягд	Өөлд	Саргуул	Торгууд	Урианхай	Халх	Хотогойд	Хогон	Нийт
Эр 2	8	8	9	4	3 113	2	2	Эр 3 363
Эм 4	13	6	24	5	3 503	1		Эм 3 816
6	21	14	33	9	6 616	3	2	7 179

Тус хороо нь 7179 хүн амтайгаас үндэстэн ястны бүтцээр нь харвал 6616 буюу дийлэнх хувийг халх үндэстэн, дөрвөд 116, Буриад 87, Баяд 74, Казах 70, Дарьганга 57, Өөлд 21, Торгууд 33, гэхчлэн 17 яснаас бүрдсэн байна.

График 5.2. Хүн амын сургуулийн өмнөх боловсрол, сургуульд хамрагдалтын байдал, хүйсээр



Хүн амын 39 нас хүртлэх насны сургуульд хамрагдалтыг авч үзвэл 1224 ерөнхий боловсролын сургуульд, 13 буюу техник болон мэргэжлийн сургалтын байгууллагад, 794 буюу их дээд сургуульд, 505 сургуулийн өмнөх боловсролын байгууллагад, 1738 буюу сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдаагүй байна.

Хүснэгт 5.6. БЗД-ийн 7-р хорооны 2-39 насны хүн амын сөб, сургуульд хамрагдалтын байдал

Хүйс	Байршил	ЕБС	ТМБСБ	Их, дээд сургууль	СӨБ	Хамрагдаагүй
Эр	7-р хороо	641	6	369	264	809
	Нийт	641	6	369	264	809
Эм	7-р хороо	583	7	380	241	929
	Нийт	583	7	380	241	929
Бүгд		1 224	13	749	505	1 738

График 5.3. 18-с дээш насны иргэдийн боловсролын түвшин





График 5.4 Ажиллагчдын тоо боловсролын түвшин




Тус хорооны ажил эрхлэгчдийг боловсролын түвшингээр авч үзвэл нийт 2352 иргэн ажил хөдөлмөр эрхэлж байгаагаас бакалаврын дээд 1502 буюу 61%, дипломын дээд 98 буюу 4%, боловсролгүй -1, бага -1, суурь - 11, бүрэн дунд - 485 буюу 21%, техникийн болон мэргэжлийн 15 буюу 1%, тусгай мэргэжлийн дунд 148 буюу 6%, доктор - 8, магистр - 83 буюу 4%-ийг эзэлж байна. Иймд хорооны нутаг дэвсгэрт иргэдийн ухамсарт байдлыг сэдэлжүүлэх 1 жилд 1 удаа олон нийтийн сайн дурын эргүүл ажиллуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг анхаарал татсан цэгт тодорхой цагаар ажиллуулж үр дүнг тооцон ажиллаж хэвших хэрэгтэй.

График 5.5. Хөдөлмөр эрхлэлтийн байдал




Хөдөлмөр эрхлэлтийн байдлыг харахад хөдөлмөрийн насны нийт иргэдийн 2352 буюу 45% нь ажил эрхэлдэг 2860 буюу 55% нь ажил хөдөлмөр эрхэлдэггүй байна.

График 5.6. Ажил эрхлэлтийн байдал




Тус хорооны хөдөлмөр эрхлэлтийн байдлаас авч үзвэл нийт 2353 ажил хөдөлмөр эрхэлж байгаагаас түр ажлын байртай 1265 буюу 54%, байнгын ажилтай 573 буюу 24%, өрхийн аж ахуй эрхлэгч 472 буюу 20%, ААНБ-ын эрхлэгч 19 буюу 1%, тохиолдлын ажил хөдөлмөр эрхэлдэг 12 буюу 1%-ийг эзэлдэг байна.

График 5.7. Ажил идэвхтэй хайгаагүй иргэдийн судалгаа



Хөдөлмөр эрхлэх насны иргэдээс ажил хайгаагүй байдлыг судлахад 2760 иргэнээс 1066 буюу 39% нь сургуульд суралцдаг, 694 буюу 25% нь өндөр насны тэтгэвэрт, хөдөлмөр эрхлэх чадваргүй 79 буюу 3%, 286 буюу гэрийн ажилтай 10%, тохирох ажил олдохгүй 260 буюу 9%, 3 иргэн ажиллах сонирхолгүй гэсэн байна.

График 5.8. Хүн амын дунд ажил хайж буй иргэдийн судалгаа




БЗД-ийн 7-р хорооны ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдээс судалгаа авахад Хөдөлмөр халамж үйлчилгээний төвд ажил идэвхтэй хайж бүртгүүлсэн 22, бүртгэлгүй боловч ажил хайж байгаа 30 иргэн байгаа нь 2760 ажил хөдөлмөр эрхлээгүй хүмүүсийн хувьд хангалтгүй байна. Энэ чиглэлээр тодорхой ажил орлоготой байлгах талаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь анхааралдаа авах шаардлагатай бөгөөд криминологийн гэмт явдал үйлдэгдэх шалтгааны нэг нь ажилгүйдэл байдаг болно.

5.3. БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 7-Р ХОРООНЫ ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК

5.3.1. Баянзүрх дүүрэгт бүртгэгдсэн гэмт хэргийн судалгаа

Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн газарт 2018-2019 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоон судалгаанаас харахад 2018 онд 7157 гэмт хэрэг бүртгэгдсэний 2930 буюу 40.9% нь цагдаагийн I хэлтэст, 2771 буюу 38.7% нь цагдаагийн II хэлтэст, 1456 буюу 20.3% нь цагдаагийн III хэлтэст бүртгэгдсэн байна. Харин 2019 онд нийт 5162 гэмт хэрэг бүртгэгдсэний 2076 буюу 40.2% нь цагдаагийн I-р хэлтэст, 1888 буюу 36.5% нь цагдаагийн II хэлтэст, 1198 буюу 23.2% нь цагдаагийн III хэлтэст бүртгэгдсэн байна.

График 5.9. Гэмт хэргийн гаралт




Тус дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийг Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт 2018, 2019 оны эхний 11 сард бүртгэгдсэн гэмт хэргийн эзлэх хувийг авч үзвэл 2018 онд дүүргийн хэмжээнд нийт -7157 гэмт хэрэг бүртгэгдсэн бол Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт -2771 буюу 38,7%, 2019 онд дүүрэгт – 5162, Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн хэмжээнд -1888 буюу 36,5%-ийг тус тус эзэлж байна. Энэхүү үзүүлэлтийг харьцуулан үзэхэд 2,2%-иар өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлт харагдаж байна.

Тус дүүргийн хэмжээнд 2019 оны эхний 11 сарын байдлаар 5162 гэмт хэрэг бүртгэгдсэнийг 2018 оны мөн үед бүртгэгдсэн 7157 гэмт хэрэгтэй харьцуулан авч үзэхэд бүртгэгдсэн гэмт хэрэг 1995 нэгжээр буюу 38.6%-иар буурсан үзүүлэлттэй байна.


Мөн бүртгэгдсэн гэмт хэргийг ангиллаар авч үзвэл 2018 онд хөнгөн гэмт хэрэг -5676, хүнд гэмт хэрэг -1481, 2019 онд хөнгөн гэмт хэрэг -4103, хүнд гэмт хэрэг -1059 байгаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг -1573, хүнд гэмт хэрэг -422 нэгжээр буурсан үзүүлэлт харагдаж байна.

График 5.10. БЗД-ийн 7-р хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн ангилал




БЗД-т бүртгэгдсэн гэмт хэргээс хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 2018 онд 94 бүртгэгдсэн бол 2019 онд 95 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 нэгжээр өссөн байна. Хүнийг алах гэмт хэрэг 2018 онд 20 бүртгэгдсэн бол 2019 онд 25 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 нэгжээр өссөн байна. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 2018 онд 67 бүртгэгдсэн бол 2019 онд 62 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 нэгжээр буурсан байна. Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох гэмт хэрэг 2018 онд 3 бүртгэгдсэн бол 2019 онд 7 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 нэгжээр өссөн байна.

График 5.11. БЗД-ийн 7-р хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн төрөл



БЗД-ийн Цагдаагийн I хэлтэст бүртгэгдсэн гэмт хэргээс хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 2018 онд 34 бүртгэгдсэн бол 2019 онд 27 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 нэгжээр буурсан байна. Хүнийг алах гэмт хэрэг 2018 онд 8 бүртгэгдсэн бол 2019 онд 9 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 нэгжээр өссөн байна. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 2018 онд 23 бүртгэгдсэн бол 2019 онд 16 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 нэгжээр буурсан байна. Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох гэмт хэрэг 2018 онд 2 бүртгэгдсэн бол 2019 онд 2 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.


График 5.12. БЗД-ийн 7-р хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн төрөл



БЗД-ийн Цагдаагийн II хэлтэст бүртгэгдсэн гэмт хэргээс хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 2018 онд 23 бүртгэгдсэн бол 2019 онд 34 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11 нэгжээр өссөн байна. Хүнийг алах гэмт хэрэг 2018 онд 4 бүртгэгдсэн бол 2019 онд 9 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 нэгжээр өссөн байна. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 2018 онд 18 бүртгэгдсэн бол 2019 онд 23 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 нэгжээр өссөн байна. Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох гэмт хэрэг 2018 онд бүртгэгдээгүй бол 2019 онд 1 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 нэгжээр өссөн байна.

БЗД-ийн Цагдаагийн III хэлтэст бүртгэгдсэн гэмт хэргээс хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 2018 онд 37 бүртгэгдсэн бол 2019 онд 34 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 нэгжээр буурсан байна. Хүнийг алах гэмт хэрэг 2018 онд 8 бүртгэгдсэн бол 2019 онд 7 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 нэгжээр өссөн байна. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 2018 онд 28 бүртгэгдсэн бол 2019 онд 23 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 нэгжээр буурсан байна. Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох гэмт хэрэг 2018 онд 1 бүртгэгдсэн бол 2019 онд 4 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 нэгжээр өссөн байна.


График 5.13 БЗД-ийн 7-р хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн төрөл



БЗД-т бүртгэгдсэн гэмт хэргийн хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2018 онд 1505, 2019 онд 1394 бүртгэгдсэн байна. Үүнээс Цагдаагийн I хэлтэст 2018 онд 609 гэмт хэрэг, 2019 онд 547 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 62 нэгжээр буурсан байна. Цагдаагийн II хэлтэст 2018 онд 482 гэмт хэрэг, 2019 онд 430 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн


үетэй харьцуулахад 52 нэгжээр буурсан байна. Цагдаагийн III хэлтэст 2018 онд 414 гэмт хэрэг, 2019 онд 417 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 нэгжээр буурсан байна.

График 5.14. БЗД-ийн 7-р хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын гэмт хэргийн харьцуулалт




БЗД-т бүртгэгдсэн гэмт хэргээс хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2018 онд 80, 2019 онд 64 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16 нэгжээр буурсан байна.

График 5.15. БЗД-ийн 7-р хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн харьцуулалт




БЗД-т бүртгэгдсэн нийт гэмт хэргээс өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 2018 онд 5184, 2019 онд 3207 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1977 нэгжээр буурсан байна.

График 5.16. БЗД-ийн 7-р хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн харьцуулалт




БЗД-т бүртгэгдсэн гэмт хэргээс хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2018 онд 98, 2019 онд 118 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20 нэгжээр өссөн байна.

График 5.17. БЗД-ийн 7-р хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн харьцуулалт




БЗД-т 2018 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргээс 74% нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 22% нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 1% нь хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, 1% нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 1% нь олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг, 1% нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргүүд эзэлж байна.

График 5.18. БЗД-ийн 7-р хорооны нутаг дэвсгэрт 2018 онд үйлдэгдсэн гэмт хэргийн төрөл



БЗД-т 2018 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргээс 65% нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 28% нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 3% нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 1% нь хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, 1% нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 1% нь олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргүүд эзэлж байна.

График 5.19. БЗД-ийн 7-р хорооны нутаг дэвсгэрт 2018 онд үйлдэгдсэн гэмт хэргийн төрөл



Дүүргийн хэмжээнд 2019 оны эхний 11 сард бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь авч үзэж гэмт хэргийн өсөлт бууралтыг судалсан байдал. Үүнд:

Хүснэгт 5.7. Гэмт хэргийг төрлөөр

№	Хэргийн төрөл	2018 он	2019 он	Өсөлт бууралт
1.	ЭХ-ийн 10-р бүлгийн гэмт хэрэг	94	95	1
2.	ЭХ-ийн 11-р бүлгийн гэмт хэрэг	1505	1394	-111
3.	ЭХ-ийн 12-р бүлгийн гэмт хэрэг	80	64	-16
4.	ЭХ-ийн 13-р бүлгийн гэмт хэрэг	19	24	5
5.	ЭХ-ийн 14-р бүлгийн гэмт хэрэг	0	2	2
6.	ЭХ-ийн 15-р бүлгийн гэмт хэрэг	8	6	-2
7.	ЭХ-ийн 16-р бүлгийн гэмт хэрэг	5	10	-5
8.	ЭХ-ийн 17-р бүлгийн гэмт хэрэг	5184	3207	-1977
9.	ЭХ-ийн 18-р бүлгийн гэмт хэрэг	39	19	-20
10.	ЭХ-ийн 19-р бүлгийн гэмт хэрэг	-	-	
11.	ЭХ-ийн 20-р бүлгийн гэмт хэрэг	50	51	1
12.	ЭХ-ийн 21-р бүлгийн гэмт хэрэг	16	14	-2
13.	ЭХ-ийн 22-р бүлгийн гэмт хэрэг	23	12	-11
14.	ЭХ-ийн 23-р бүлгийн гэмт хэрэг	22	28	6
15.	ЭХ-ийн 24-р бүлгийн гэмт хэрэг	-	-	
16.	ЭХ-ийн 25-р бүлгийн гэмт хэрэг	-	-	
17.	ЭХ-ийн 26-р бүлгийн гэмт хэрэг	10	10	0
18.	ЭХ-ийн 27-р бүлгийн гэмт хэрэг	98	118	20
19.	ЭХ-ийн 28-р бүлгийн гэмт хэрэг	3	1	-2
20.	ЭХ-ийн 29-р бүлгийн гэмт хэрэг	-	-	
21.	Нийт	7156	5055	-2101

БЗД-ийн хэмжээнд 2019 оны эхний 11 сард бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2101 гэмт хэргээр буурсан үзүүлэлт харагдаж байгаа боловч хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 20 нэгжээр өссөнийг саармагжуулах шаардлагатай байна.

5.3.2. Баянзүрх дүүргийн 7-р хороонд бүртгэгдсэн гэмт хэрэг.


БЗД-ийн 7-р хороонд 2015 онд 182, 2016 онд 176, 2017 онд 265, 2018 онд 392, 2019 оны эхний 11 сард 245 гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн байна. Үүнд:

Хүснэгт 5.8. Гэмт хэргийг төрлөөр

№	Гэмт хэргийн өнгө	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он /Эхний 11 сар/
1.	Хүнийг алах	1	1	-	-	-
2.	ХЭМХБЭГХ	45	51	58	91	72
3.	Хүчиндэх	-	-	-	2	3
4.	Хулгайлах	31	36	85	152	55
5.	Дээрэмдэх	13	7	31	37	15
6.	Залилах	24	24	43	73	72
7.	ОНАТБАГХ	34	39	24	-	-
8.	ХАБАТАМЭГХ	3	4	4	4	6
9.	Амиа хорлох	1	1	1	1	-
10.	Бусад	30	13	19	32	22
11.	НИЙТ	182	176	265	392	245
12.	ИЛРҮҮЛЭЛТ	57%	61%	20%	13%	37.3%
13.	Гэмт хэргийн өсөлт бууралт /өмнөх оны мөн/	-	6 буюу 3,3 хувь буурсан	109 буюу 48 хувь өссөн	67 буюу 25,3 хувь өссөн	147 буурсан

2015-2019 онд бүртгэгдсэн гэмт хэргийг гэмт хэргийн төрлөөр нь харьцуулалтыг авч үзвэл 2018 онд хулгайлах гэмт хэрэг болон хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг өндөр үзүүлэлттэй байна. Мөн залилах гэмт хэрэг 2015, 2016 онуудад тус тус 24, 2017 онд 43, 2018 онд 72, 2019 оны эхний 11 сард 73 гэмт хэрэг бүртгэгдсэн нь залилах гэмт хэрэг 2015-2019 онуудад 19-30 нэгжээр буюу нэг жилд дунджаар 11 нэгжээр өсөх магадлалтай байна. Залилах гэмт хэрэгтэй тэмцэх буюу урьдчилан сэргийлэх ажил зохион явуулахдаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дээр дурьдсан 4 зорилтыг үе шаттайгаар зохион байгуулж үр дүнг тооцон ажиллах шаардлагатай байна.

График 5.20. БЗД-ийн 7-р хорооны нутаг дэвсгэрт 2015-2019 оны хооронд үйлдэгдсэн гэмт хэргийн гэмт хэргийн харьцуулалт



БЗД-ийн 7-р хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд 2014-2018 онд бүртгэгдсэн гэмт хэргийн дундаж 254 гэмт хэрэг байна.

Гэмт хэргийн үзүүлэлт 2014 оноос 2015 он хүртэл 3,3%-иар буурч, харин 2015 оноос 2019 он хүртэл 44,9%-иар өссөн байна. Сүүлийн 4 жилийн дунджаас харахад гэмт хэргийн үзүүлэлт жилд 53 нэгжээр нэмэгдсэн. /прогноз 1 жилд 53 нэгжээр өсөх магадлал ажиглагдсан ба 2019 онд бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтийг дээрх тоон үзүүлэлтэд оруулан үзэж гэмт хэргийн прогнозыг төлөв харагдана/.

Мөн 2014-2015 онд бүртгэгдсэн гэмт хэргийн хөдөлгөөнийг судлан үзэхэд 6 гэмт хэрэг буюу 3,3%-иар буурсан, 2015-2016 оны гэмт хэргийн хөдөлгөөнийг судлан үзэхэд 109 гэмт хэрэг буюу 48 хувиар өссөн, 2016-2017 оны гэмт хэргийн хөдөлгөөнийг судлан үзэхэд 67 гэмт хэрэг буюу 25,3%-иар өссөн үзүүлэлттэй байна.

2018-2019 онд БЗД-ийн 7-р хороонд бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлт: 2019 онд БЗД-ийн 7-р хороонд нийт бүртгэгдсэн гэмт хэрэг 316 ба үүнээс хүнд гэмт хэрэг 15 буюу 4,7%, хөнгөн гэмт хэрэг 301 буюу 62,4%-тай байна. 2018 онд БЗД-ийн 7-р хороонд бүртгэгдсэн гэмт хэрэг 482 ба үүнээс хүнд гэмт хэрэг 50 буюу 10,3%, хөнгөн гэмт хэрэг 432 буюу 89,7%-тай байна.

Гэмт хэргийн үйлдэгдсэн газрын хувьд авч үзвэл 2019 онд 203 буюу 64%, 2018 онд 347 буюу 72% нь олон нийтийн газар буюу баар, караоке, зогсоолын газар, 2019 онд 42 буюу 13.2%, 2018 онд 53 буюу 11% нь гэр, орон сууцанд, 2019 онд 45 буюу 14.2%, 2018 онд 67 буюу 14% нь аж ахуйн нэгжид, 2019 онд 26 буюу 8.2%, 2018 онд 9 буюу 2.2% нь бусад газруудад үйлдэгдсэн байна. Үүнээс харахад олон нийтийн газарт гэмт хэрэг илүү үйлдэгддэг байна. Тиймээс гудамж талбай, үзвэр үйлчилгээний газруудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдэгдэхгүй байх арга хэмжээ авч ажиллах шаардлагатай.

Тус хороонд үйлдэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтээс харахад олон нийтийн газар үйлдэгдсэн гэмт хэрэг, аж ахуйн нэгж байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг дийлэнхийг эзэлж байгаа нь баар, цэнгээний болон үйлчилгээний газрууд нэг дор төвлөрсөнтэй холбоотой байна. Иймд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга, албан мэдэгдлийг тухай бүр бичих хариуцлага тооцох ажлыг эрчимжүүлэх ЗДТГ-ын нэгжүүдтэй хамтран ажиллах тодорхой эрхийг цуцлан гэмт хэргийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах шаардлагатайг харуулж байна.

График 5.21. Гэмт хэрэг үйлдэгдсэн газар




График 5.22. Гэмт хэрэг үйлдэгдсэн газар тоогоор



2019 онд гэмт хэрэг үйлдэгдсэн аргын хувьд 2019 онд 35% буюу 107, 2018 онд 108 буюу 23.4% нь залилах буюу хүний итгэл алдсан, 2019 онд 33% буюу 101, 2018 онд 153 буюу 33.2% нь хүний бие махбодид гэмтэл учруулахаар үйлдсэн, 2019 онд 20% буюу 61, 2018 онд 93 буюу 20.2% нь бусдын эд зүйлийг хулгайлсан, орон байранд нэвтэрсэн, 2019 онд 11.8% буюу 36, 2018 онд 106 буюу 23% нь бусад аргаар гэмт хэрэг үйлдсэн байна. Үүнээс харахад бие махбодид гэмтэл учруулахаар болон залилангын гэмт хэргийн гаралт өндөр хувьтай байна. Тиймээс эдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт явдлын гаралтыг бууруулах үйл ажиллагаа явуулах шаардлагатай.

График 5.23. Гэмт хэрэг үйлдсэн арга





График 5.24. Гэмт хэргийн үйлдсэн арга




2019 оны хувьд гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан багаж, хэрэгслийн хувьд 2019 онд 9 буюу 2.8% нь компьютер, мэдээллийн болон интернет ашигласан, 2019 онд 5 буюу 1.5%, 2018 онд 5 буюу 1.03% нь тээврийн хэрэгслээр, 2019 онд 4 буюу 1.2%, 2018 онд 4 буюу 0,9% нь архины шил болон хутгаар, 2019 онд 298 буюу 94.3%, 2018 онд 472 буюу 98% нь бусад багаж хэрэгслээр гэмт хэрэг үйлдсэн байна. Эндээс харахад гэмт этгээд гэмт хэрэг үйлдэхдээ төрөл бүрийн эд зүйлийг тодорхой гэмт хэрэг дээр өөр өөр зэвсэг хэрэгслийг ашигласан ба тохиолдлын шинжтэй гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан нөхцөл ажиглагдаж байна.

График 5.25. Гэмт хэрэг үйлдэхэд ашигласан багаж хэрэгсэл



График 5.26. Гэмт хэрэг үйлдэхэд ашигласан багаж хэрэгсэл



2019 онд гэмт хэргийн 10 буюу 3.1% нь бүлэглэн, 1 буюу 0.3% нь зохион байгуулалттай бүлэг, 305 буюу 96.5% нь бусад хэлбэрээр үйлдсэн байна. 2018 онд гэмт хэргийг 18 буюу 3.9% нь бүлэглэн, 464 буюу 96.4% нь бусад хэлбэрээр үйлдсэн байна. Мөн гэмт хэрэг тохиолдлын байдлаар бүртгэгдсэн гэсэн дүгнэлтэд хүрч байгаа үндэслэл нь гэмт хэрэгт хамтран оролцсон хэлбэрийн тоон болон чанарын үзүүлэлтээр тодорхойлогдож байна.

График 5.27. Гэмт хэрэг үйлдэхэд оролцсон хэлбэр



График 5.28. Гэмт хэрэг үйлдэхэд оролцсон хэлбэр



Гэмт хэрэг үйлдсэн цаг хугацааны хувьд 00:00-06:00 буюу шөнийн цагаар 2019 онд 136 хэрэг буюу 43%, 2018 онд 201 буюу 41%, 06:00-12:00 цагийн хооронд 2019 онд 37 хэрэг буюу 11.7%, 2018 онд 48 буюу 9,1%, 12:00-18:00 цагийн хооронд 2019 онд 92 хэрэг буюу 29.1%, 2018 онд 126 буюу 26%, 18:00-00:00 цагийн хооронд 2019 онд 51 хэрэг буюу 16.1%, 2018 онд 107 буюу 23,5%-тай байна. Доорх графикаас харахад 00:00-06:00 цагийн хооронд буюу шөнийн цагаар, баар цэнгээний газрын ажилладаг үеэр гэмт хэрэг илүү үйлдэгддэг байна. Иймд согтууруулах ундаагаар үйлчилж буй тусгай зөвшөөрлийг цуцлах, эрхийг хязгаарлах арга хэмжээг ГХУСАЗЗ-с шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад шуурхай уламжлан шийдвэрлүүлэх шаардлагатай. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн зорилтын нэг болох таслан зогсоох аргыг хэрэглэн давхар гэмт явдлыг тогтворжуулах, дараа нь гэмт явдлын гаралтыг бууруулах гэсэн үе шаттайгаар арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай.

График 5.29. Гэмт хэрэг үйлдсэн цаг хугацаа





График 5.30 Гэмт хэрэг үйлдсэн цаг хугацаа




Гэмт хэрэг үйлдсэн хэлбэрийн хувьд 2019 онд 57 буюу 18%, 2018 онд 62 буюу 13% нь согтуугаар, 2019 онд 24 буюу 7.5%, 2018 онд 17 буюу 3,7% нь эмэгтэй хүн оролцсон, 2019 онд 6 буюу 1.8%, 2018 онд 6 буюу 1.4% нь хүүхэд оролцсон, 2019 онд 3 буюу 0.9%, 2018 онд 2 буюу 0.4% нь согтуугаар эмэгтэй хүн оролцсон, 2019 онд 1 буюу 0.3% нь согтуугаар хүүхэд оролцсон, 2018 онд 1 буюу 0,2% нь гадаадын иргэн оролцсон, 2019 онд 225 буюу 71.2%, 2018 онд 391 буюу 81,3% нь бусад хэлбэрээр үйлдсэн байна. Үүнээс харахад согтуугаар гэмт хэрэг үйлддэг нь харагдаж байна. Энэхүү үзүүлэлтэд дүн шинжилгээ хийхэд мөн гэмт хэрэг үйлдсэн цаг хугацаатай уялдаа холбоо бүхий байдал нь согтууруулах ундаа хэрэглэсэн байдал буюу гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан нөхцөлийг бүрдүүлэхэд нөлөөлж байна. Иймд мөн адил гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн зорилтын нэг болох таслан зогсоох аргыг хэрэглэн давхар гэмт явдлыг тогтворжуулах, дараа нь гэмт явдлын гаралтыг бууруулах гэсэн үе шаттайгаар арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай.

График 5.31. Гэмт хэрэг үйлдсэн хэлбэр



График 5.32. Гэмт хэрэг үйлдсэн хэлбэр



Гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгааны хувьд 2019 онд 143 буюу 45.5%, 2018 онд 285 буюу 59,1% нь ашиг олох, шунахайн сэдэлтээр, 2019 онд 31 буюу 10.5%, 2018 онд 14 буюу 2,9% нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 2019 онд 31 буюу 10.3%, 2018 онд 32 буюу 6,6% нь хүний итгэл алдсаны улмаас, 2019 онд 39 буюу 12.6%, 2018 онд нь 44 буюу 9,1% архидан согтууран танхайран, 2019 онд 7 буюу 2.2% нь гэр бүлийн хэрүүл маргааны улмаас, 2019 онд 60 буюу 18.9%, 2018 онд 107 буюу 22,3% нь бусад шалтгааны улмаас гэмт хэрэг үйлдсэн байна. Үүнээс үзэхэд залилангын гэмт хэрэг үйлдэхээр хүний итгэлийг олж залилах, шунахайн сэдэлтийн улмаас үйлдэгдэж байгаа нь өндөр хувьтай байна.

График 5.33. Гэмт хэрэг үйлдсэн шалтгаан



2019 онд БЗД-ийн 7-р хороонд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 221 буюу 69% нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 90 буюу 28% нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 4 буюу 1.2% нь хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэсэн, үлдсэн 6 буюу 1.8% нь хувь хүний нууцад халдсан, хуурамч бичиг баримт үйлдсэн зэрэг гэмт хэргүүд эзэлж байна.

2018 онд БЗД-ийн 7-р хороонд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 338 буюу 71% нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 125 буюу 25,9% нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 10 буюу 2,07% нь хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэсэн, 6 буюу 1.2% нь мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах, бусад 3 буюу 0,6% нь хүчиндэх, хууль сахиулах ажиллагааг эсэргүүцсэн зэрэг гэмт хэргүүд эзэлж байна. Үүнээс харахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүд болох хулгайлах, залилах, дээрэмдэх гэмт хэрэг ихэнх хувийг эзэлж байна.

Хүснэгт 5.8. Баянзүрх дүүргийн 7-р хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн өсөлт бууралтын үзүүлэлт

Гэмт хэргийн төрөл	2019 он хувиар	Тоогоор	2018 он хувиар	Тоогоор
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	1.2%	4	2.1%	10
Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	28.0%	90	25.9%	125
Хүчиндэх	0.6%	2	0.4%	2
Хувь хүний нууцад халдах гэмт хэрэг	0.3%	1	-	-
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	69.0%	221	71.0%	338
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг	0.3%	1	-	-
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх гэмт хэрэг	0.3%	1	-	-
Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах гэмт хэрэг	0.3%	1	-	-
Мөнгөн тэмдэгт бэлтгэх, ашиглах гэмт хэрэг	-	-	1.2%	6
Хууль сахиулах үйл ажиллагааг эсэргүүцсэн	-	-	0.2%	1
Нийт		318		482


7-р хороонд 2019 оны эхний 11 сарын байдлаар өмчлөх эрхийн эсрэг 215 гэмт хэрэг бүртгэгдсэнээс залилах гэмт хэрэг 92, хулгайлах гэмт хэрэг 88 бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 83.7 хувийг эзэлж байна. Мөн хулгайлах гэмт хэргээс залилах гэмт хэрэг 4 нэгжээр бага бүртгэгдэж байгаа нь залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6.3-р зүйлд заасан тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээг дүүргийн цаашлаад нийслэлийн хэмжээнд зохион байгуулж үр дүнг тооцох ажлыг үе шаттай зохион байгуулах шаардлагатай байна.

График 5.34. Баянзүрх дүүргийн 7-р хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн өсөлт бууралтын үзүүлэлт



2018-2019 оны бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь харьцуулан харвал: 2018 оны 1 сард өмчлөх эрхийн эсрэг 34 гэмт хэрэг, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах 8 гэмт хэрэг, хүнийг амиа хорлоход хүргэсэн 2 гэмт хэрэг үйлдэгдсэн бол 2019 онд өмчлөх эрхийн эсрэг 9 гэмт хэрэг, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах 9 гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийллийн 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

График 5.35 Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлийн харьцуулалт



2019 оны 2 сард бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.7 дахин өссөн, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг болон хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэргүүд буурсан байгаа бол хүнийг амиа хорлоход хүргэсэн гэмт хэрэг 2018 онд 2 бүртгэгдсэн байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрэг 2018 онд 1 бүртгэгдсэн бол 2019 онд бүртгэгдээгүй байна.

График 5.36. Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлийн харьцуулалт




2018 оны 3 сард өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 36 бүртгэгдсэн бол 2019 оны 3 сард 21 болж буурсан байна. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан гэмт хэрэг 2019 оны 3 сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна.

График 5.37. Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлийн харьцуулалт



2019 оны 4 сард өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6 нэгжээр буурсан, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан гэмт хэрэг 9 нэгжээр буурсан байна. Харин авто тээвэр ашиглалтын эсрэг гэмт хэрэг 2018 оны 4 сард бүртгэгдээгүй бол 2019 онд 2 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Мөнгөн тэмдэгт хуурамчаар ашигласан гэмт хэрэг 2018 оны 4 сард 2 бүртгэгдсэн бол 2019 оны мөн үед бүртгэгдээгүй байна.

График 5.38. Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлийн харьцуулалт



2018 оны 5 сард өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 37, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан гэмт хэрэг 9 гарсан бол 2019 оны мөн үед өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 28, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан гэмт хэрэг 9 гарсан байна.

График 5.39 Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлийн харьцуулалт




2018 оны 6 сард өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 26, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан гэмт хэрэг 9 гарсан бол 2019 оны мөн үед өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 25, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан гэмт хэрэг 10, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас зайлсхийсэн 1 хэрэг гарсан байна.

График 5.40. Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлийн харьцуулалт




2018 оны 7 сард өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 22, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан гэмт хэрэг 7 гарсан бол 2019 оны мөн үед гэмт хэргийн гаралт буурсан байна.

График 5.41. Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлийн харьцуулалт



2018 оны 8 сард өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 20, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан гэмт хэрэг 9 гарсан, хүнийг амиа хорлоход хүргэсэн гэмт хэрэг 2 гарсан бол 2019 оны мөн үед өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 15, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан гэмт хэрэг 13 гарсан байна.

График 5.42. Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлийн харьцуулалт




2018 оны 9 сард өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 21, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан гэмт хэрэг 9 гарсан бол 2019 оны мөн үед гэмт хэргийн гаралт буурсан үзүүлэлттэй байгаа ба гэр бүлийн хүчирхийллийн хэрэг 1, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас зайлсхийсэн 1 хэрэг гарсан байна.

График 5.43. Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлийн харьцуулалт




2018 оны 10 сард өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 42, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан гэмт хэрэг 13, хүнийг амиа хорлоход хүргэсэн гэмт хэрэг 2 гарсан бол 2019 оны мөн үед гэмт хэргийн гаралт буурсан үзүүлэлттэй байгаа ба хувь хүний нууцад халдсан 1 хэрэг үйлдэгдсэн байна.

График 5.44. Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлийн харьцуулалт сараар



2018 оны 11 сард өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 34, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан гэмт хэрэг 11, хүнийг амиа хорлоход хүргэсэн гэмт хэрэг 2 гарсан бол 2019 оны мөн үед гэмт хэргийн гаралт буурсан үзүүлэлттэй байгаа ба авто тээвэр ашиглалтын эсрэг гэмт хэрэг 1 үйлдэгдсэн байна.

График 5.45. Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлийн харьцуулалт сараар



Гэмт хэрэг үйлдэгчид: 2019 онд 7-р хороонд бүртгэгдсэн гэмт хэрэгт нийт 102 сэжигтэн татагдсан байна. Үүнээс 12-20 насны 23% буюу 20 сэжигтэн, 21-30 насны 58% буюу 60 сэжигтэн, 31-40 насны 13% буюу 13 сэжигтэн, 41-50 насны 6% буюу 6 сэжигтэн байна.

2018 онд нийт 82 сэжигтэн татагдсан байна. Үүнээс 12-20 насны 23% буюу 19 сэжигтэн, 21-30 насны 48% буюу 39 сэжигтэн, 31-40 насны 17% буюу 14 сэжигтэн, 41-50 насны 9% буюу 7 сэжигтэн, 51-с дээш насны 3% буюу 2 сэжигтэн байна.

12-20 нас, 20-30 насны гэмт хэргийн сэжигтэн өмнөх мөн үеэс 5 нэгж, 21 нэгжээр тус тус өссөн үзүүлэлт өсвөр болон идэр насны бие хүмүүст чиглэсэн нэгбүрчилсэн урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах шаардлага байгааг илтгэж байна. Мөн Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн даргатай судалгааны явцад ярилцлага хийхэд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад гадуур шалгагдаж буй сэжигтэн, яллагдагчдыг хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтыг явуулж буй эрх бүхий албан тушаалтнаас дахин гэмт хэрэг зөрчилд үйлдсэн талаарх судалгаа хийж ЦЕГ-ын тэргүүн дэд даргад судалгааны ажлын үр дүнг танилцуулж улсын түвшинд хэрэгжилтийг хангаж ажиллан гэмт хэрэгт холбогдон шалгагдаж буй хүмүүст тавих хяналтыг сайжруулснаар гэмт хэргийн гаралт буурах үзүүлэлт байгааг алба хаагч нарт мэдээлэл хүргүүлэхийг онцгой анхааралдаа авах шаардлагатай гэж үзлээ.

График 5.46. гэмт хэрэг үйлдэгсдийн насны ангилал




График 5.47. Насны төрөл






График 5.48. Насны төрөл





2019 онд нийт сэжигтнийг хүйсийн хувьд авч үзвэл 11 буюу 11% нь эмэгтэйчүүд, 91 буюу 89% нь эрэгтэйчүүд байна. 2018 онд 9 буюу 11% нь эмэгтэй, 73 буюу 89% нь эрэгтэй байна.

График 5.49. Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлийн харьцуулалт



Тус хороонд бүртгэгдсэн гэмт хэргийн холбогдогчийн хүйсийн байдлаар 2018 оны мөн үетэй харьцуулан үзэхэд 2019 онд 18 нэгжээр эрэгтэй, 2 нэгжээр эмэгтэй хүн холбогдон шалгагдсан өссөн үзүүлэлт байна.

График 5.50. Гэмт хэрэг үйлдэгчдийн хүйсийн харьцаа



2019 онд бүртгэгдсэн нийт сэжигтнийг боловсролын хувьд харвал 1 буюу 1% нь боловсролгүй, 4% буюу 8 нь бага боловсролтой, 4% буюу 5 нь бүрэн бус дунд, 58% буюу 58 нь бүрэн дунд, 27% буюу 25 нь дээд, 6% буюу 5 нь тусгай дунд боловсролтой байна. 2018 бүртгэгдсэн нийт сэжигтнийг боловсролын хувьд харвал 1 буюу 1% нь боловсролгүй, 8% буюу 3 нь бага боловсролтой, 5% буюу 3 нь бүрэн бус дунд, 57% буюу 47 нь бүрэн дунд, 24% буюу 22 нь дээд, 5% буюу 5 нь тусгай дунд боловсролтой байна.

График 5.51. Гэмт хэрэг үйлдэгчдийн боловсролын байдал



Сэжигтний нийгмийн байдлын хувьд 2019 онд нийт сэжигтний 55 буюу 54% нь ажилгүй, 17 буюу 16% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 14 буюу 14% нь хувийн хэвшилд ажиллагч, 8 буюу 8% нь оюутан, 3 буюу 3% нь ТББ-д ажилтан, 3 буюу 4% нь төрийн албан хаагч, 2 буюу 2% нь тэнэмэл, хоригдол байна.

Харин 2018 оны хувьд 40 буюу 48% нь ажилгүй, 16 буюу 19% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 11 буюу 13% нь хувийн хэвшилд ажиллагч, 7 буюу 8% нь оюутан, 3 буюу 4% нь ТББ-д ажилтан, 3 буюу 4% нь төрийн албан хаагч, 1 буюу 2% нь тэнэмэл, хоригдол, 2 буюу 2% нь сурагч байна.

График 5.52. Гэмт хэрэг үйлдэгчдийн нийгмийн байдал



График 5.53. Гэмт хэрэг үйлдэгчдийн ажил эрхлэлтийн байдал





График 5.54. Гэмт хэрэг үйлдэгчдийн ажил эрхлэлтийн байдал



Гэмт хэрэгт холбогдогчдын нийгмийн байдлыг судлан үзэхэд эрхэлсэн тодорхой ажилгүй хүмүүсээс гэмт хэрэгт холбогдон шалгагдсан үзүүлэлт 2018 оны мөн үетэй харьцуулахад 15 нэгж буюу 6 хувиар өссөн нь тогтмол тодорхой орлогогүй шалтгаанаас үүдэлтэй тул хорооны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн хурлаар энэ шалтгаан нөхцөлийг бууруулах талаар тодорхой ажил зохион байгуулах шаардлагатай байна. Мөн хорих болон хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн хүмүүст тавих хяналтын үр нөлөөг дээшлүүлэх талаар анхаарах шаардлагатай байна.

Гэмт хэрэг үйлдэхэд оролцсон хэлбэрийн хувьд 2019 онд 17 буюу 16.5% нь бүлэглэн, 85 буюу 83.5 % нь бусад хэлбэрээр оролцсон байна. 2018 оны хувьд 4 буюу 5% нь бүлэглэн, 78 буюу 95% нь бусад хэлбэрээр оролцсон байна.

График 5.55. Гэмт хэрэг үйлдсэн хэлбэр



Тус хорооны нутаг дэвсгэрт бүртгэгдсэн гэмт хэрэгт хамтран оролцогчдын хэлбэрийг 2018 оны мөн үетэй харьцуулахад 13 нэгжээр буюу 12%-иар өссөн үзүүлэлттэй байгаа нь цаашид гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэр буюу тэр дундаа бүлэглэн гэмт хэрэг үйлдэх хэлбэр өсөх хандлага ажиглагдаж байгаа тул гэмт бүлэг, бөөгнөрөл, зохион байгуулалттай гэмт бүлгийн судалгааг нарийвчлан гаргаж тэдгээрийг хяналтад авах шаардлагатай байна.

Гэмт хэрэг үйлдсэн хэлбэрийн хувьд 2019 онд нийт сэжигтний 24 буюу 23% нь согтуугаар, 1 буюу 1% нь согтуугаар, хүүхэд оролцож, 1 буюу 1% нь эмэгтэй хүн оролцож, 10 буюу 10% нь хүүхэд оролцсон, 9 буюу 9% нь эмэгтэй хүн оролцсон, 1 буюу 1% нь эмэгтэй хүн, согтуугаар, 56 буюу 55% нь бусад хэлбэрээр үйлдсэн байна.

2018 оны хувьд 27 буюу 33% нь согтуугаар, 1 буюу 1% нь согтуугаар хүүхэд оролцож, 4 буюу 5% нь хүүхэд оролцсон, 7 буюу 9% нь эмэгтэй хүн оролцсон, 42 буюу 52% нь бусад хэлбэрээр гэмт хэрэг үйлдсэн байна. Үүнд:

Хүснэгт 5.9. Гэмт хэрэг үйлдсэн хэлбэр

Гэмт хэрэг үйлдсэн хэлбэр	2018 он Тоогоор	Хувиар	2019 он Тоогоор	Хувиар
согтуугаар	27	33%	24	23%
согтуугаар, хүүхэд оролцож	1	1%	1	1%
согтуугаар эмэгтэй хүн оролцож			1	1%
хүүхэд оролцсон	4	5%	10	10%

эмэгтэй хүн оролцсон	7	9%	9	9%
эмэгтэй, согтуугаар			1	1%
бусад	42	52%	56	55%

2019 онд сэжигтний үйлдсэн гэмт хэргийн 55 буюу 53.9% нь хүний биед хөнгөн хохирол учруулсан, 17 буюу 16.6% нь хулгайлах гэмт хэрэг, 9 буюу 8.8% нь дээрэмдэх гэмт хэрэг, 22 буюу 21.5% нь залилах гэмт хэрэг үйлдсэн байна.

2018 онд 3 буюу 3.6% нь хүний биед хөнгөн хохирол учруулсан, 7 буюу 8.5% нь хулгайлах гэмт хэрэг, 2 буюу 2.4% нь дээрэмдэх гэмт хэрэг, 12 буюу 14.6% нь залилах гэмт хэрэг, 1 буюу 1.2% нь хөрөнгө завших, 1 буюу 1.2% нь алдаатай гүйлгээ завших, 1 буюу 1.2% нь эд хөрөнгө устгах, гэмтээх, 2 буюу 2.4% нь хууль сахиулагчийг эсэргүүцсэн байна. Үүнд:

Хүснэгт 5.10. Гэмт хэргийн төрөл


Гэмт хэрэг / зүйл, заалтаар/	2018 он Тоогоор	Хувиар	2019 он Тоогоор	Хувиар
хүний биед хөнгөн хохирол учруулсан	3	3.6%	55	53.9%
хулгайлах	7	8.5%	17	16.6%
дээрэмдэх	2	2.4%	9	1%
залилах	12	14.6%	22	10%
хөрөнгө завших	1	1.2%		
алдаатай гүйлгээ завших	1	1.2%		
эд хөрөнгө устгах, гэмтээх	1	1.2%		
хууль сахиулагчийг эсэргүүцсэн	1	1.2%		

5.4. БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 7-Р ХОРООНД БҮРТГЭГДСЭН ЗӨРЧЛИЙН СУДАЛГАА

5.4.1. 2019 оны Баянзүрх дүүргийн цагдаагийн 2-р хэлтэст бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

2019 онд БЗД-ийн 7-р хороонд ирсэн нийт гэмт хэрэг, зөрчлийн талаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээлэл 3853 ба үүнээс гомдол, мэдээллийн төрлөөр нь авч үзвэл 3340 буюу 86.6% нь зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл, 294 буюу 7.6% нь хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн талаарх гомдол, мэдээлэл, 133 буюу 3.4% нь гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, 86 буюу 2.2% нь зарлан мэдээлэх шинжтэй гомдол, мэдээллүүд эзэлж байна. Үүнээс харахад зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл ихэнх буюу 87%-ийг эзэлж байна.

График 5.56. Гомдол мэдээллийн төрөл



Нийт гомдол, мэдээллийн 1043 буюу 27%-ийг материалжуулан шалгасан, 460 буюу 12%-ийг хэлтэс тасгийн хяналтад авч шийдвэрлэсэн, 410 буюу 12% нь давхардсан мэдээлэл, 373 буюу 11% нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй, 105 буюу 10%-ийг нь харьяаллын дагуу шилжүүлсэн, 372 буюу 10%-


ийг нь зөрчлийн тухай хуулиар торгосон, 343 буюу 9% нь мэдээлэл батлагдаагүй, 287 буюу 7% нь мэдээлэл буцаагдсан, 242 буюу 6%-ийг нь ар гэрт нь хүлээлгэж өгсөн, үлдсэн хувиудад бусад төрлийн арга хэмжээ авсан байна. Үүнээс харахад материалжуулан шалгах аргаар гомдол, мэдээлэл илүүтэй ирдэг бөгөөд хуурамч мэдээлэл, давхардсан мэдээлэл мөн их ирдэг байна.

График 5.57. Гомдол мэдээллийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ



2019 онд БЗД-т нийт 6168 зөрчил бүртгэгдсэн бөгөөд үүнээс 7-р хороонд 847 зөрчил бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн зөрчлийн 353 буюу 41.6% нь олон нийтийн газар зүй бусаар биеэ авч явах, 106 буюу 12.5% нь хүний биед халдах зөрчил, 79 буюу 9.3% нь хуурамч дуудлага мэдээлэл өгөх, 74 буюу 8.7% нь танхайрах зөрчил, 76 буюу 8.9% нь нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах, 50 буюу 5.9% нь худалдаа үйлчилгээний журам зөрчих зөрчил, 43 буюу 5.07% нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил, 27 буюу 3.1% нь хулгайлах зөрчил, 14 буюу 1.6% нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль зөрчих зөрчил, бусад зөрчил нь 22 буюу 0.2%-ийг эзэлж байна. Үүнд:


График 5.58. 2018 онд бүртгэгдсэн зөрчлийн төрөл



2018 онд БЗД-т нийт 3668 зөрчил бүртгэгдсэн бөгөөд үүнээс 7-р хороонд 389 зөрчил бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн зөрчлийн 75 буюу 19.2% нь худалдаа үйлчилгээний журам зөрчих


зөрчил, 58 буюу 14.9% нь танхайрах зөрчил, 51 буюу 13.1% нь хулгайлах зөрчил, 57 буюу 14.6% нь нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах, 49 буюу 12.5% нь олон нийтийн газар зүй бусаар биеэ авч явах, 42 буюу 10.7% нь хүний биед халдах зөрчил, 15 буюу 3.8% нь тамхины хяналтын тухай хууль зөрчих зөрчил, 4 буюу 1.02% нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил болон бусад зөрчлүүд эзэлж байна.

График 5.59. 2019 онд бүртгэгдсэн зөрчлийн төрөл




2017 онд БЗД-г нийт 12052 зөрчил бүртгэгдсэн бөгөөд үүнээс 7-р хороонд 2517 зөрчил бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн зөрчлийн 1547 буюу 61.4% нь худалдаа үйлчилгээний журам зөрчих зөрчил, 693 буюу 27.5% нь танхайрах зөрчил, 162 буюу 6.4% нь нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах, 162 буюу 6.4% нь олон нийтийн газар зүй бусаар биеэ авч явах, 40 буюу 1.5% нь цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх зөрчил, 27 буюу 1.07% нь хулгайлах зөрчил, 10 буюу 0.3% нь хүний биед халдах зөрчил, 2 буюу 0.07% нь хуурамч дуудлага мэдээлэл өгөх, 9 буюу 0.3% нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил, бусад зөрчил нь 22 буюу 0.8%-ийг эзэлж байна.

График 5.60. 2017 онд бүртгэгдсэн зөрчлийн төрөл




Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах зөрчил 2018 онд 49, 2019 онд 353 бүртгэгдсэн нь 7,2 дахин өссөн ба олон нийтийн амгалан тайвныг алдагдуулах гэмт хэрэг тус хороонд 2018, 2019 онуудад бүртгэгдээгүй тоон үзүүлэлт харагдаж байгаагаас үзэхэд тухайн гэмт хэргийг зөрчлийн шатанд нь илрүүлсэнтэй холбоотой гэж үзэж болно.

График 5.61. Олон нийтийн газар зүй бусаар биеэ авч явах зөрчил



Хулгайлах зөрчил 2018 онд 51 бүртгэгдсэн бол 2019 онд 27 бүртгэгдсэн нь 1,8 дахин буурсан байна. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих зөрчил 2018 онд 75 бүртгэгдсэн бол 2019 онд 50 зөрчил бүртгэгдсэн нь 25%-иар буурсан үзүүлэлттэй байна. Иймээс энэ төрлийн зөрчлийг тогтворжуулан барих шаардлагатай.


График 5.62. Зарим төрлийн зөрчлийн тоон харьцуулалт



Танхайрах зөрчил 2018 онд 58 бүртгэгдсэн бол 2019 онд 74 бүртгэгдсэн нь 32%-иар өссөн ба олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах гэмт хэрэг хорооны хэмжээнд 2019 онд Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн хэмжээнд 2018 онд 1 гэмт хэрэг, 2019 онд бүртгэгдээгүй буюу 100%, дүүргийн хэмжээнд 2018 онд 4 гэмт хэрэг, 2019 онд бүртгэгдээгүй байгаа нөхцөлд дүгнэлт хийхэд тухайн гэмт хэргийг зөрчлийн шатанд нь илрүүлсэнтэй холбоотой гэж үзэж байна.


Хүний биед халдах зөрчил 2018 онд 42, 2019 онд хүний биед халдах зөрчил 106 бүртгэгдсэн нь 3 дахин их өссөн байна. Иймээс энэ өсөлтийг саармагжуулах шаардлагатай байна.

График 5.63. Олон нийтийн газар зүй бусаар биеэ авч явах зөрчил



2019 онд нийт үйлдэгдсэн зөрчлийн 409 буюу 86% нь олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явсан, 66 буюу 14% нь нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулсан зөрчил эзэлж байна. Үүнээс үзэхэд олон нийтийн газарт үйлдэгдэж буй зөрчил нь ахуйн хүрээнд үйлдэгдэж буй зөрчлөөс 5 дахин их үйлдэгддэг байна.

График 5.64. 2019 онд үйлдэгдсэн олон нийтийн газар зүй бусаар биеэ авч явах зөрчил




2018 онд зөрчил гаргагчийн 28% нь ажилгүй, 1% нь оюутан, 7% нь төрийн бус байгууллагын ажилтан, 64% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч байна. 2019 онд зөрчил гаргагчийн 35% нь ажилгүй, 1%

нь оюутан, 10% нь төрийн бус байгууллагын ажилтан, 52% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1% нь хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч байна. Дээрхээс харахад зөрчил үйлдэж буй хүмүүс нь ихэнх нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон ажилгүй иргэд байна.

Зөрчлийг үйлдэгдсэн цагаар нь авч үзвэл 2018 онд 00:00-09:00 цагийн хооронд нийт зөрчлийн 48%, 09:00-18:00 цагийн хооронд нийт зөрчлийн 22%, 18:00-00:00 цагийн хооронд зөрчлийн 30% бүртгэгдсэн бол 2019 онд 00:00-09:00 цагийн хооронд нийт зөрчлийн 53%, 09:00-18:00 цагийн хооронд 26%, 18:00-00:00 цагийн хооронд 21% нь үйлдэгдсэн байна. Үүнээс үзэхэд зөрчил нь шөнийн цагаар илүүтэй үйлдэгдэж байгаа нь согтууруулах ундаагаар үйлчилдэг газар ажилладаг байх цагаар үйлдэгддэг нь харагдаж байна. Тиймээс эдгээр газруудад хяналтыг сайжруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах шаардлагатай.

График 65.5 Зөрчил үйлдэгдсэн цаг хугацаа



2015 оны 07 сарын 09 А/609 дүгээр “Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний газруудын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг түр тогтоох тухай” гэх захирамжийг хүчингүй болгож Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 2015 оны 06 сарын 11-нд хүчингүй болгосон 7.8 Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй худалдаа үйлчилгээний газар 00-06 цагт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно гэх заалтыг сэргээхэд тухайн хороонд үйлдэгдсэн зөрчил 48-53%-иар буурах магадлалтай байна.


Баянзүрх дүүргийн 1, 3, 7 дугаар хорооны иргэд, оршин суугчдын дунд 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Баянзүрх дүүргийн Ерөнхий боловсролын 33 дугаар сургуулийн хурлын зааланд зохион байгуулсан “Эрүүл, аюулгүй, амар тайван орчин” сэдэвт уулзалт хэлэлцүүлэгт нийт 98 хүн оролцсоноос 90% нь одоо мөрдөгдөж байгаа цагийн хуваарьт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзсэн бол 84% нь баар цэнгээний газрууд 04:00 цаг хүртэл ажиллаж байгаа нь ая тух алдагдуулж, дуу чимээ ихтэйгээс амарч чадахгүй байна гэсэн байна. Мөн 95% нь нийтийн орон сууцанд үйл ажиллагаа явуулж байгаа баар цэнгээний газрыг 00:00 цагаас хэтрүүлэхгүйгээр хаах санал өгч, 84% нь зориулалтын тусдаа байртай байсан ч 00:00 цагт хаах хэрэгтэй гэж үзсэн, харин 14% нь зориулалтын байртай газрууд 04:00 цаг хүртэл ажиллаж болох юм гэж үзсэн байна.

Мөн цагийн хуваарьт өөрчлөлт оруулахтай холбогдуулан Улаанбаатар хотын захирагчийн албанаас 2018 оны 05 дугаар сард 9 дүүрэг тус бүр дээр иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, албаны сайтаар санал асуулга авсан бөгөөд хэлэлцүүлэгт оролцсон 2706 аж ахуйн нэгж, иргэний 72.4 хувь нь буюу 1912 хүн одоогийн цагийн хуваарийг дэмжсэн, 27,3% буюу 740 хүн дэмжээгүй. Харин сайтаар авсан санал асуулгад 637 хүн оролцсоноос 11.6% нь одоогийн цагийн хуваарийг дэмжсэн, 88.4% нь дэмжээгүй буюу согтууруулах ундаагаар үйлчилдэг газруудыг шөнийн 00:00 цагаас хэтрүүлэхгүйгээр хаах санал өгсөн.

5.5. БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 7-Р ХОРООНЫ КАМЕРЫН СУДАЛГАА


Судалгаанд оролцсон нийт аж ахуй нэгж байгууллага 150, тухайн байгууллагын аюулгүй байдал нууцлалын улмаас камерын хяналтын судалгааг өгөхөөс татгалзсан 7 ААНБ байна. Тухайлбал, Капетрон банк, Худалдаа хөгжлийн банк зэрэг. Камерын хяналтгүй 10 ААНБ, үйл ажиллагаа нь зогсож хаагдсан 12 ААНБ байна.

График 5.66. Аж ахуйн нэгж байгууллагын тоон харьцуулалт



Судалгаанд хамрагдсан аж ахуй нэгж байгууллагуудын 112 камерын бичигч төхөөрөмжид, 673 нь дотор камертай, 190 нь гадна камертай ажиллаж байгаагаас нийт 16 камер ажиллахгүй байна.

График 5.67. Аж ахуйн нэгж байгууллагын камерын харьцуулалт




Аж ахуй нэгжүүдийн гадна орчны хяналтын камерын хувьд 183 нь үйл ажиллагаа нь хэвийн ажилладаг, 143 нь шөнө өдрийн турш ажиллагаатай, 40 нь өдрийн ажиллагаатай, 7 нь ажилладаггүй байна.

График 5.68. Аж ахуйн нэгж байгууллагын камерын ажиллагаа



Судалгаанд хамрагдсан аж ахуй нэгжүүдийн дотор камерын хувьд 664 нь үйл ажиллагаа хэвийн ажилладаг, 523 нь шөнө өдрийн ажиллагаатай, 141 нь зөвхөн өдрийн ажиллагаатай, 9 нь ажилладаггүй байна.

График 5.69. Аж ахуйн нэгж байгууллагын дотор камерын ажиллагаа



Нийт аж ахуй нэгж байгууллагууд нь камерын хяналтын үйл ажиллагааг 94 буюу 72% нь интернетэд холбогдон давхар эрх бүхий албан тушаалтан нь хянаж шалгаж байгаа бол 37 буюу 28% нь интернетэд холбогдоогүй өөрийн байран дээрээс хянаж байна. Интернетэд холбогдож үйл ажиллагаагаа хянаж байгаа эрх бүхий албан тушаалтнуудтай ярилцахад гэмт хэрэг, зөрчил, аж ахуй нэгжийн хэвийн үйл ажиллагааг давхар хянаж байгаа нь ажлыг их хөнгөвчилж байгааг өгүүлж байна.

График 5.70. Аж ахуйн нэгж байгууллагын камерын холболт



Судалгаанаас харахад аж ахуй нэгж байгууллагуудын барилга, байгууламж тэдгээрийн гадна орчинд гадна камер нэмэх шаардлагатай 65, дотор камер нэмэх шаардлагатай 52 аж ахуй нэгж байгууллага байна.

Цаашид шаардлагатай камерын байршил: Тус хорооны гадагш болон дотогшоо чиглэсэн замуудад 9 цэгт өндөр үзүүлэлттэй сайн чанарын камерын хяналтыг суурилуулбал тухайн бүс нутаг үйл ажиллагааг бүрэн хяналтанд авч гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд өндөр ач холбогдолтой.

5.6. АЖ АХУЙ, НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ИРГЭДЭД ХҮРГҮҮЛСЭН АЛБАН МЭДЭГДЭЛД ХИЙСЭН СУДАЛГАА

2015-2019 онуудад ААНБ, иргэдэд хүргүүлсэн албан мэдэгдэл болон хариу авалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5.11. Иргэдэд хүргүүлсэн албан мэдэгдэл болон хариу авалт

№		2015 он		2016 он		2017 он		2018 он		2019 он	
		Мэдэгдэл	Хариу авалт	Мэдэгдэл	Хариу авалт	Мэдэгдэл	Хариу авалт	Мэдэгдэл	Хариу авалт	Мэдэгдэл	Хариу авалт
1.											
2.	Хэрэг бүртгэл	17	14	12	10	5	5	24	18	33	29
3.	Нийтийн хэв журам хамгаалах	212	199	121	113	1746	1011	2216	2122	2042	1948
4.	Мөрдөн байцаалт	606	375	467	303	426	298	466	335	458	316
	Нийт	835	588	600	423	2177	1314	2686	2475	2530	2293

2015-2019 онуудад ААНБ, иргэдэд хүргүүлсэн албан мэдэгдэл болон хариу авалтыг графикаар харуулбал:

График 5.71. Аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлсэн мэдэгдэл хариу ирүүлсэн тоон үзүүлэлт.





График 5.72. Аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлсэн мэдэгдэл хариу ирүүлсэн тоон үзүүлэлт.



2019 онд ААНБ, иргэдэд ирүүлсэн мэдэгдэл 2530, хариу авалт 1948 буюу 76.9%-тай байна.

5.6.1. 7-р хорооны хэсгийн байцаагчийн албан мэдэгдлийн судалгаа

Тус хорооны сүүлийн гурван жилд хэсгийн байцаагчаас нийт 359 албан мэдэгдэл аж ахуй нэгж байгууллагуудад хүргүүлэн ажилласан байна. Үүнээс албан мэдэгдлийн хариуг хугацаанд 159, хугацаа хэтэрч өгсөн 61 албан мэдэгдэлд хариу өгөөгүй 28 аж ахуй нэгж байгууллага байна. 2018-2019 онд албан мэдэгдэлд хариу өгөөгүй аж ахуй нэгж байгууллагуудад “Зөрчлийн тухай” хуулиар арга хэмжээг бүрэн авч туршлага нэвтрүүлсэн байна.

Хүснэгт 5.12. Албан мэдэгдлийн судалгаа

	Албан мэдэгдэл явуулсан	Хугацаандаа Хариу өгсөн	Хугацаа хэтэрсэн	Хариу өгөөгүй	Утга	ААНБ-Д давхардаж өгсөн мэдэгдлийн тоо
2017	53	28	6	19	Г.Х.У.С	Оргилуун 2, Irish pub 2, Venus 2
2018	170	159	3	8	Г.Х.У.С Дэлхийн хөл бөмбөг аварга шалгаруулах нэвтрүүлэг Хэлтсийн шаардлага Хэлтсийн мэдэгдэл Албан мэдэгдлийн хариу Шинэ жил арга хэмжээний хүрээнд зөвшөөрөгдөөгүй ажиллах тухай	Баясах өргөө 2, Баянцээл 2, В lounge 4, Тармаг 3, Тчх 24 ломбард 2, Бишрэлт гүн 4, Моника 3, Цэ паб 2, Цагаан шөнө 5, Venus 4, Гүрэн кафе 2, Алтан овоо 2, Батхаан 2, Гүрэн 2, Андууд 3
2019	136	136	52	1	Г.Х.У.С Архи согтууруулах ундаагаар үйлчилдэг ААН албан мэдэгдэл Нийтийн байр Г.Х.У.С Барьцаалдуулан зээлдүүлэх үйлчилгээний байгууллага	Элст хошуу 2, Аравт 2, Атар шим 4, Аура 2, Алтан овоо 2, Бишрэлт гүн 2, Цэ паб 2, Андууд 4, Ач 2

Тус хорооны “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөл”-ийн 2015-2018 оны хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийхэд нийт жил бүр давтагдсан 11 ажлыг зохион байгуулж байсан ба 2018 он шинээр 13 ажил нэмж төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Жил бүрийн тайланд дээрх төлөвлөсөн ажлуудаас гадна Баянзүрх дүүрэг болон цагдаагийн хэлтсээс зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээг тус нутаг дэвсгэртээ зохион байгуулсныг тайлагнасан байна.

Харин гэмт хэрэг зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн албан мэдэгдлийн мөрөөр зохион байгуулах ажлын төлөвлөлт болон хийж гүйцэтгэсэн ажлын талаар тусгагдаагүй байна.

Хүснэгт 5.12. Албан мэдэгдлийн мөрөөр төлөвлөсөн ажил

Он	Төлөвлөсөн ажил	Жил бүр төлөвлөгддөг ажил	Шинээр төлөвлөсөн ажил	Төлөвлөсөн ажил тайланд тусгагдаг эсэх	Албан мэдэгдлийн дагуу хий гүйцэтгэсэн ажлийн тоо
2015	11	11	0	11	0
2016	11	11	0	11	0
2017	11	11	0	11	0
2018	24	11	13	24	0

Тус хорооны нийгмийн ажилтантай фокус ярилцлага хийхэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах дэд зөвлөлд жилд дунджаар 15 орчим албан мэдэгдлийн дагуу ажил зохион байгуулдаг. Энэ үйл ажиллагаа нь нилээдгүй цаг завьг зарцуулдаг боловч төдийлөн үр дүнтэй ажил болдоггүй дэд зөвлөлийн үйл ажиллагааны зардалд төсөвлөсөн мөнгө байхгүй байна.

Нийтийн хэв журам хамгаалах, Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах тасгаас гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгахаар бичиж байгаа мэдэгдэл нь хорооны засаг дарга, аж ахуй нэгжийн байгууллагын удирдлагад чиглэсэн байдаг боловч тэдгээрээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулсан нь төдийлөн үр дүнд бүрэн хүрсэн гэдэг нь эргэлзээтэй байна. Энэ бүхнийг харгалзан үзэж мэдэгдлийн хариу авалт хэрэгжилтийн мөрөөр эргэн шалгаж биелүүлээгүй бол “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль” зөрчвөл зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх нь зүйтэй

5.6.2. Орон сууцны хороолол доторх орчныг хог хаягдал үүсдэг, гэрэлтүүлэг нэмж тавих шаардлагатай газрын судалгаа

Нийт 13 байрны орчим хог хаягдал үүдэг гэрэлтүүлэг дутмаг байгаа нь судалгаагаар харагдаж байна. Тухайлбал тус хорооны 23, 24-р байрны арк, түүний орчим газар гэрэлтүүлэггүй бөгөөд ойролцоох үйлчлээний газруудаас хог хаягдал үүсдэг, үйлчлүүлэгчдээс тамхи татдаг гэх мэтээр орчны бохирдол, гэмт хэрэг зөрчил үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдал үүсдэг байна.

Хүснэгт 5.13. Орон сууцны хороолол доторх орчныг хог хаягдал үүсдэг гэрэлтүүлэг нэмж тавих шаардлагатай газрын байршил

№	Гэрэлтүүлгийн хаяг байршил	Одоо байгаа	Нэмж тавих	Тайлбар
1	1 дүгээр байр	1	4-6	1-р байрны урд талд гэрэлтүүлэггүй тул гэрэлтүүлэг шинээр хийх
2	2 дугаар байр	3	1-2	2 дугаар байрны орчин
3	115 дугаар байрны орчин	2	1	1-р орчны хойд харалдаа 58-р байрны урд 1 гэрлийн шон
4	116 дугаар байрны орчин	1	1	1, 4-р орчны харалдаа 2 гэрлийн шон
5	37а, б байрнаас 1-р байр руу гарах хэсэгт	0	2	граж талын 4 гэрэл асахгүй байгаа
6	38а, 38б байрны 40,41, 30, 31 –р байр	2	4	Б.Доржийн гудамжны төв замаас 38а, 38б байр руу ордог хэсэг 40, 41, 30, 31–р байрны дундах нүхэн гражны хэсэг
7	23, 24-р байр	0	4	23, 24-р байрны арк, байрны зүүн болон хойд тал, түүний орчим газар
	Бүгд дүн	25	20	

5.6.3. ОХУ, Канадад согтууруулах ундаагаар үйлчлэх цагийн хязгаарлалтын талаар

1995 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 171 тоот “ОХУ-ын Этилийн спирт, согтууруулах ундаа болон спиртын агууламжтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг улсаас зохицуулах тухай Холбооны хууль⁴”-ийн 3.1 дүгээр зүйлд зааснаар согтууруулах ундааны жижиглэнгийн борлуултанд цагийн хязгаарлалт тогтоож болно. ОХУ-ын хувьд субъектүүдийн дор бүрнээ хуульчлан зохицуулдаг бөгөөд ОХУ-ын зарим субъектүүдийн харьяалах нутаг дэвсгэртээ тогтоосон цагийн хязгаарлалтыг хүснэгтлэн үзүүлэв⁵.

⁴ Федеральный Закон РФ О государственном регулировании производства и оборота этилового спирта, алкогольной и спиртосодержащей продукции 1995.11.15 /с изменениями от 2010.12.28/

⁵ Ограничение времени розничной продажи алкогольной продукции /по субъектам РФ/ /http://www.fsrar.ru/industry/analytics/ogranichenie-vremeni-rozничной-alkogolno/ сүүлд үзсэн 2011.03.23

Үүнд:

Хүснэгт 5.14. Согтууруулах ундаагаар үйлчлэх цагийн хязгаарлалт

Д/д	Бүсийн нэр	Борлуулахыг хориглосон цаг	Тайлбар
1	Москва хот	22 ⁰⁰ -10 ⁰⁰	
2	Татар улс	20 ⁰⁰ -8 ⁰⁰	5 дугаар сарын 1-нд 6 дугаар сарын 12-нд Болон 9 дүгээр сарын 1-ний өдөр 8 ⁰⁰ -аас эрт, 13 ⁰⁰ -аас хойш борлуулахыг хориглоно.
3	Ульяановын бүс	20 ⁰⁰ -8 ⁰⁰	
4	Ненецийн автономит тойрог	20 ⁰⁰ -11 ⁰⁰	
5	Ивановын бүс	21 ⁰⁰ -9 ⁰⁰	
6	Эрхүү хот	22 ⁰⁰ -8 ⁰⁰	Бага, дунд сургуулийн ойролцоо бүсийн хувьд 8 ⁰⁰ -19 ⁰⁰
7	Нижегородын бүсэд	22 ⁰⁰ -8 ⁰⁰	Татваргүй барааны дэлгүүрт хамааралгүй

Тус хүснэгтээс харахад согтууруулах ундааны цагийн хязгаарлалтыг дараах байдлаар тогтоодог байна. Үүнд:

1. Тогтмол цагийн хязгаарлалт тогтоох
2. Тодорхой бүсэд /бага, дунд сургуулийн ойролцоо, орон сууц нягтрал ихтэй бүс г.м/ согтууруулах ундааны борлуулалтын цагийн хязгаарлалтыг ялгаатай тогтоох
3. Тогтоосон цагийн хязгаарлалт нь татваргүй барааны дэлгүүрт хамааралгүй байх
4. Согтууруулах ундааны хэрэглээ ихсэж болох зарим баяр ёслолын үеэр борлуулалтын цагийг илүү хязгаарлах зэрэг зохицуулалтууд хийгддэг байна.
5. Тус хязгаарлалт нь нийтийн хоолны газар хамаарахгүй.

Мөн согтууруулах ундааны борлуулалтад цагийн хязгаарлалт тогтооход ОХУ-ын субъект тус бүр өөрийн хуулиараа согтууруулах ундааны спиртийн хэмжээг мөн тогтоодог байна. Тухайлбал, Кемерова мужийн хувьд 2010 оны 10-р сарын 27-ны өдөр батлагдсан №108 “Кемерова” мужид согтууруулах ундаа борлуулах цагийг хязгаарлах тухай хуулийн 1-р зүйлд “15 хувиас дээш спиртийн агууламжтай согтууруулах ундааны жижиглэнгийн борлуулалтыг орон нутгийн цагаар 22⁰⁰-9⁰⁰ цагийн хооронд хориглоно⁶ хэмээн зохицуулжээ. Москва хотын хувьд 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар 15 хувиас дээш хувийн спиртийн агууламжтай согтууруулах ундааны жижиглэнгийн борлуулалтын 23⁰⁰-аас 08⁰⁰ цагийн хооронд хориглодог байсан бол 2010 оны 9 дүгээр сараас эхлэн энэ хугацааг 3 цагаар уртасгаж 22⁰⁰-10⁰⁰ болгон зохицуулсан байна⁷

Мовска хотын дарга ноён Сергей Собяниний нийслэлд хэрэгжүүлсэн тус хязгаарлалт нь шөнийн цагт үйлдэгдэж буй гэмт хэргийн тоог бууруулсан байна⁸.

Канад улсын “Согтууруулах ундаанд хяналт тавих хууль”-д дараах байдлаар зохицуулжээ.

Хориглосон цаг:

41.16 Олон нийтийн арга хэмжээг дараах тохиолдолд зохион байгуулбал зөвшөөрөл олгохгүй.

- а) Улаан өндөгний баярын өмнөх өдөр
- б) 18 дугаар зүйлээс гадна, орон нутгийн засаг захиргаа байрладаг газар

Худалдаалах цагууд:

Дараах өдрүүдэд согтууруулах ундааны борлуулалтын эсхүл согтууруулах ундааны худалдааны газраас өөр газарт согтууруулах ундааны худалдаа, хүргэлт хийхгүй.

- а) Ням гаригт

⁶ Закон Кемеровской области “Об установлении ограничения времени розничной продажи алкогольной продукции” 27 октября 2010 года № 108-03

⁷ Запрет на ночную торговлю алкоголем в России <http://www.rian.ru/infografika/20100901/271022218.html/> сүүлд үзсэн 2011.03.23/

⁸ Польза от запрета на торговлю алкоголем ночью очевидна, заявил Собянин <http://rian.ru/moscow/20101112/295423170.html/> сүүлд үзсэн 2011.03.23/

- Шөнийн 00 цагаас өдрийн 12 цаг хүртэл,
 - Оройн 18 цагаас хойш.
 - b) Улаан өндөгний баярын өдрийн өмнөх Баасан гариг, Улаан өндөгний баярын өдөр, Ням гариг эсхүл Зул сарын баярын өдөр
 - c) Дурсгалт өдрийн 13 цагаас өмнө
 - d) Бусад хугацаа, иймэрхүү бусад өдрийг комисс зааж өгч болно.
- Тусгай дарсны дэлгүүрт дээрх дүгээр заалт хамаарахгүй.

5.6.4. БЗД-ийн 7-р хорооны давуу болон сул тал

Давуу тал:

- Тус хороо нь хотын төвийн А зэрэглэлийн бүсэд оршдог.
- 100 хувь орон сууцны хороолол
- Оршин суугч иргэдийн боловсролын түвшин бүрэн дунд түүнээс дээш, харьцангуй сайн
- Хөдөлмөр эрхлэлт сайн, Ажилгүй иргэдийн тоо багатай
- Амьжиргааны түвшин дундаж ба түүнээс дээш, амьжиргааны түвшин доогуур өрхийн тоо багатай.

Сул тал:

- Хотын төвд байрладаг учир Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй банкнуудын салбарууд, Үүрэн телефоны операторын бүх салбарууд байрлаж үйл ажиллагаа явуулдаг, хүний урсгал хөдөлгөөн их;
- Газар нутгийн хэмжээ бага, хэт олон аж ахуйн нэгжүүд төвлөрсөн байдаг.
- Архи согтууруулах ундаа худалдаа үйлчилгээний цэг нэг дор төвлөрсөн олон байдаг ба үүнийг дагаад гэмт хэрэг, зөрчлийн гаралт нөлөөлдөг.
- Орон сууцны барилга байгууламжууд нь ихэвчлэн 1968-1980-д онд баригдахад хороолол дундах явган болон авто зам тавигдаж он жилийн явцад засвар үйлчилгээ хийгээгүйн улмаас эвдэрч муудсан нь гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх нөхцөл бүрдсэн.
- Орон сууцны нийт 29 байртай СӨХ-д подвалийн өрөө түрээслүүлдэг нь хөдөө орон нутгаас шилжин суурьшиж байгаа болон орон гэргүй иргэд ихээр ирж амьдардаг. Эдгээр өрхүүд нь амьжиргааны түвшин доогуур, өрхийн орлого багатай ядуу өрх иргэд их байдаг.

5.7. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ, АЛДАА, ДУТАГДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

БЗД-ийн 7-р хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд 2014-2018 онд, болон 2018, 2019 оны эхний 12 сард бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтүүдээр өргөн хүрээтэй судалгааг явуулж дүгнэлт хийлээ. Энэхүү дүн шинжилгээг хийхэд тулгамдаж байсан асуудал нь гэмт хэргийн тоон мэдээг дээрх онуудад бүртгэгдсэн гэмт хэргийн үзүүлэлтүүд Эрүүгийн шинэчлэн найруулагдсан 2015 оны хууль болон хүчингүй болсон 2002 оны эрүүгийн хуулийн зүйл хэсэгт дурдагдсан гэмт хэргийн тоон үзүүлэлтийн зөрүү, статистик тоон мэдээ болон шаардлагатай тоон мэдээг мэдээллийн сангаас гаргуулан авахад хэрэгцээт тоон мэдээллийг хугацаа хоцорч авах, шаардлагатай мэдээллийг төлөвлөсөн хугацаанд гарган ирүүлээгүйгээс судалгааны ажлын явц удааширсан хэдий ч БЗД-ийн 7 дугаар хорооны хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, гэмт хэргийн хөдөлгөөн, түвшин, гэмт хэргийн гаралтын прогнозын байдал, анхаарал татаж буй тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зөрчлийн шатанд нь таслан зогсоох цаашлаад гэмт явдлыг өмнөх онуудаас бууруулахад чиглэсэн арга хэмжээ, хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт мөн хорооны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөлийн алба анхаарал хандуулах асуудлыг тус тус судлан үзлээ.

Ингээд тус хорооны нутаг дэвсгэр, хүн ам зүй, нийгмийн байдлыг талаас судлан үзэхэд хотын А зэрэглэлийн бүсэд 100 хувь орон сууцны хороолол нийт 7 СӨХ-ийн 16 байр, СӨХ байгуулаагүй 9 байр, аж ахуй нэгжийн 24 барилга, нийтийн байр 3 байна. 100 хувь байр хороолол боловч орон сууцны

барилгууд ихэвчлэн 1968-1980-д онд баригдсан хуучирч элэгдсэн, хороолол дундах явган болон авто зам эвдэрч муудсан ба хорооны хойд хэсэгт байрлах 37а, 37б, 38а, 38б, 40, 41 дүгээр байрууд орчмоор тохижилт муу байна.

Байшин барилга, бүтээн байгуулалтын зохистой хэрэглээний оновчтой шийдэл нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ач тусаа байнга өгдөг. Худалдааны болоод орон сууцны зориулалтыг хослуулах нь байнга хөл хөдөлгөөн ихтэй байснаар гэмт хэрэг, зөрчил гарах шалтгааны нэг нөхцөл байдлыг нэмэгдүүлнэ. Гэвч барилгын орц, зогсоол талбайн хуваарилалтыг оновчтой шийдэх хэрэгтэй бөгөөд хуваарилалт нь бүхий л барилгын аюулгүй байдалд нөлөөлөхгүй байх шаардлагатай байна.

Гэмт хэргийн тоон үзүүлэлтэд 2014 оноос 2015 он хүртэл 3,3%-иар буурч, харин 2015 оноос 2019 он хүртэл 44,9%-иар өссөн байна. Сүүлийн 4 жилийн дунджаас харахад гэмт хэргийн үзүүлэлт жилд 53 нэгжээр нэмэгдсэн.

2015-2019 онуудад залилах гэмт хэрэг 19-30 нэгжээр буюу нэг жилд дунджаар 11 нэгжээр өсөх магадлалтай байна.

Танхайрах зөрчил 2018 онд 58 бүртгэгдсэн бол 2019 онд 74 буюу 32%-иар өссөн ба олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах гэмт хэрэг хорооны хэмжээнд 2019 онд Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн хэмжээнд 2018 онд 1 гэмт хэрэг, 2019 онд бүртгэгдээгүй буюу 100%, харин дүүргийн хэмжээнд 2018 онд 4 гэмт хэрэг, 2019 онд бүртгэгдээгүй байгаа нөхцөлд дүгнэлт хийхэд тухайн гэмт хэргийг зөрчлийн шатанд нь илрүүлсэнтэй холбоотой гэж үзэж байна.

Мөн 7 дугаар хорооны хэмжээнд сүүлийн 2 жил өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг тэр дундаа залилах гэмт хэргийн 2017 онд бүртгэгдсэн гэмт хэрэгтэй 2019 оны эхний 11 сард бүртгэгдсэн гэмт хэрэг 58,9%-иар өссөн байна. Энэхүү гэмт хэрэгт статистикаас хэргийн товч утгад түүвэр судалгаа хийх болон гэмт хэрэг үйлдэгдсэн арга, гэмт хэрэгт хамтран оролцсон хэлбэрт дүн шинжилгээг хийхэд хамтран оролцох хэлбэр 2019 онд 17 буюу 16.5% нь бүлэглэн, 85 буюу 83.5% нь бусад хэлбэрээр оролцсон байгаа нь тохиолдлын шинжтэй гэмт хэрэг үйлдэгдсэн гэж үзэж байна.

Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах зөрчил 2018 онд 49, 2019 онд 353 бүртгэгдсэн нь 7,2 дахин өссөн ба олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах гэмт хэрэг тус хороонд 2018, 2019 онуудад бүртгэгдээгүй тоон үзүүлэлт харагдаж байгаагаас үзэхэд тухайн гэмт хэргийг зөрчлийн шатанд нь илрүүлсэнтэй холбоотой гэж үзэж болно.

Зөрчлийг үйлдэгдсэн цагаар нь авч үзвэл 2018 онд 00:00-09:00 цагийн хооронд нийт зөрчлийн 48%, 09:00-18:00 цагийн хооронд нийт зөрчлийн 22%, 18:00-00:00 цагийн хооронд 30% нь бүртгэгдсэн бол 2019 онд 00:00-09:00 цагийн хооронд нийт зөрчлийн 53%, 09:00-18:00 цагийн хооронд 26%, 18:00-00:00 цагийн хооронд 21% нь үйлдэгдсэн байна. Үүнээс үзэхэд зөрчил нь шөнийн цагаар илүүтэй үйлдэгдэж байгаа нь согтууруулах ундаагаар үйлчилдэг газрууд ажилладаг байх цагаар үйлдэгддэг нь харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан аж ахуй нэгж байгууллагуудын 112 нь камерын бичигч төхөөрөмжинд, 673 нь дотор камертай, 190 нь гадна камертай ажиллаж байгаагаас нийт 16 камер ажиллахгүй байна. Аж ахуй нэгж байгууллагуудын барилга, байгууламж тэдгээрийн гадна орчинд гадна камер нэмэх шаардлагатай 65, дотор камер нэмэх шаардлагатай 52 аж ахуй нэгж байгууллага байна. Нийт аж ахуй нэгж байгууллагууд нь камерын хяналтын үйл ажиллагааг 94 буюу 72% нь интернетэд холбогдон давхар эрх бүхий албан тушаалтан нь хянаж шалгаж байгаа бол 37 буюу 28% нь интернетэд холбогдоогүй өөрийн байран дээрээс хянадаг байна. Тус хорооны гадагш болон дотогшоо чиглэсэн замуудад 9 өндөр үзүүлэлттэй сайн чанарын камерын хяналтыг суурилуулбал тухайн бүс нутаг үйл ажиллагааг хяналтад авч гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд өндөр ач холбогдолтой.

5.7.1 Санал зөвлөмж

Улсын их хуралд санал оруулж шийдвэрлүүлэх асуудал

Дүүргийн нэр дэвшин гарсан улсын их хурлын гишүүдээр дамжуулан 2015 оны 07 сарын 09 А/609 дүгээр “Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний газруудын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг түр тогтоох тухай” гэх захирамжийг хүчингүй болгож Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 2015 оны 06 сарын 11-нд хүчингүй болгосон 7.8 Согтууруулах

ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй худалдаа үйлчилгээний газар 00-06 цагт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно гэх заалтыг сэргээхэд тухайн хороонд үйлдэгдсэн зөрчил 48-53%-иар буурах магадлалтай байна.

Судалгаанаас хархад аж ахуй нэгж байгууллагууд нь бие биенээ хянах асуудал төдийлөн байхгүй байна. Мөн тухайн хороонд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагаас 24 нь өөрийн объекттой байх ба бусад нь түрээслэгчид байна. Түрээслэгч иргэн, байгууллагуудыг хариуцлагатай болгох болон аж ахуй нэгжүүдийн хяналтыг сайжруулахын тулд 3 удаа зөрчил гарган арга хэмжээ авагдсан тохиолдолд тэр объектод дахин тухайн чиглэлээр тусгай зөвшөөрөл олгохгүй байх талаар хууль тогтоомжинд тусган эрх зүйн орчныг бүрдүүлж өгөх.

Тус хорооны гадагш болон дотогшоо чиглэсэн замуудад 9 цэг буюу нэг цэгт 360 градус эргэдэг ажиглалтын камер, хяналтын 2 камераас бүрдсэн бүрдэлтэй байх ба уг систем нь дүр төрх таних, ухаалаг хайлт хийх програм хангамжтай байна. Тухайн нутаг бүслэн хаах, гэмт хэрэгтнийг илрүүлэх, мөшгөхөд техник технологийг ашиглах нь зүйтэй байна.

Цагдаагийн төв байгууллагаар шийдвэрлүүлэх асуудал

Засгийн газрын 2011 оны А/153 дугаар тогтоол “Цагдаагийн байгууллагын зарим ажил үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-т зааснаар 4000 хүн амд 1 хэсгийн байцаагч ногддог байна. Харин 7-р хорооны нутаг дэвсгэрт 7179 иргэн оршин суудаг, ба 182 аж ахуйн нэгжээр өдөрт дунджаар 50 иргэн үйлчлүүлдэг гэж үзэхэд 9100 орчим иргэн үйлчлүүлдэг буюу дамжин өнгөрдөг байна. Үүнээс үзэхэд тухайн хороонд 4 хэсгийн байцаагч ажиллах шаардлагатай байгааг шийдвэрлүүлэх.

Эргүүлийн алба хаагчдыг хурууны хээ уншигч төхөөрөмжөөр ханган сан бүрдүүлэх. Гэмт хэрэг зөрчил үйлдсэн этгээдүүдийн хурууны хээг газар дээр нь унших багажаар хээг авч сан бүрдүүлдэг ажлыг Баянзүрх дүүргийн хэмжээнд туршин үзэж улсын хэмжээнд нэвтрүүлэх.

Баянзүрх дүүргийн цагдаагийн газарт хүргүүлэх зөвлөмж

БЗД-ийн цагдаагийн 2-р хэлтсийн хэмжээнд албан мэдэгдлийг тасаг тасагтаа бүртгэлтэй байгааг өөрчлөн нэг бүртгэл, судалгаатай болох албан мэдэгдлийн мөрөөр хийж гүйцэтгэсэн ажлын талаар хяналт шалгалтыг тогтмолжуулан, улсын хэмжээнд тэргүүн туршилгыг нэвтрүүлэх;

Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгахаар бичиж байгаа мэдэгдэл нь хорооны засаг дарга, аж ахуй нэгжийн байгууллагын удирдлагад чиглэсэн байдаг боловч тэдгээрээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулсан нь төдийлөн үр дүнд бүрэн хүрсэн гэдэг нь эргэлзээтэй байна. Энэ бүхнийг харгалзан үзэж мэдэгдлийн хариу авалт хэрэгжилтийн мөрөөр эргэн шалгаж биелүүлээгүй бол “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль” зөрчвөл зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх нь зүйтэй. Түрээслэгч иргэн, байгууллагуудыг хариуцлагатай болгох болон аж ахуй нэгжүүдийн хяналтыг сайжруулахын тулд албан мэдэгдлийг тухайн объектын эзэнд өгч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах;

Дээрх судалгаанд хамрагдсан камерын хяналтыг интернетэд холбоогүй 37 аж ахуй нэгж байгууллагын камерын хяналтын төхөөрөмжийг интернетэд холбуулах арга хэмжээ зохион байгуулах. Мөн интернетэд холбогдсон аж ахуй нэгж байгууллагуудын камерын хяналтын системийг шуурхай удирдлагын төвд холбуулах арга хэмжээг авах;

Баян цээлийн гудамж буюу аж ахуй нэгж төвлөрсөн газарт 2018 онд 347 буюу 72% нь 2019 онд 203 буюу 64% гэмт хэрэг үйлдэгдэж байгаа тухайн гудамжийг гурван хэсэгт хуваан 18-24 цаг 00-06 цаг гэсэн хуваарьтай эргүүлийн чиглэлийг тогтоон ажиллуулах;

9 цэгт дүр төрх таних болон ухаалаг хайлт хийх программ хангамжтай камерын хяналтын систем ажиллуулахад 2 машинтай дайчлан баривчлах бүлгийг байнгын ажиллагаанд оруулах шаардлагатай байна.

Хэсгийн байцаагчийн бүртгэл судалгааг баяжуулах, түүнийг шалгах гэх мэт уламжлалт сэтгэлгээ, ажил дүгнэх үзүүлэлтийг өөрчилж түүнд хэрхэн дүгнэж шинжилгээ хийж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ашигласан, ямар дүнд хүрсэн зэргээр нь дүгнэж байх, өөрөөр хэлбэл бүртгэл, судалгааг шалгалтын үед гаргаж харуулдаг, нэр төдий хөтөлж аргацаадаг байдлыг таслан зогсоох хэрэгтэй.

Наад зах нь цагдаагийн албаны тухай хуульд заасан объектын судалгаа хийх явцдаа тодорхой ажиглалт, туршилт хийх боломжтой аргыг хэрэглэвэл зохино. Сар бүрийн нуугдмал болон бүртгэгдсэн хэрэг дээр хэрэглэний программ ашиглана. Прогноз гаргаж түүнд тохирсон арга хэрэгслийг хэрэглэж сурах, зарим тохиолдолд иргэд олон нийтийн туслалцааг ашиглан анкетын болон ярилцлагын судалгааг явуулж чаддаг байх хэрэгтэй юм.

Шинэ тутам арга хэрэгслээр үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцөл нь онцлог байдлаас шалтгаалан өөр өөр байдаг тул цагдаагийн анхан шатны нэгжид ажиллаж буй албан хаагч криминологийн судалгааны аргачлалуудыг хэрэглэж чаддаг чадвартай байх хэрэгтэй юм. Өнөөдөр хотын эсвэл аймгийн нөгөө захад хэрэглэж байгаа арга таны хариуцсан хороо нутаг дэвсгэрт өөр үр дүн үзүүлж болох тул энэхүү судалгааны аргуудыг эзэмших нь тун чухалб

Баянзүрх дүүргийн засаг дарга, иргэдийн төлөөлөгчийн хурлын хуралд хүргүүлэх зөвлөмж

Хорооны нутаг дэвсгэрт гэрэлтүүлэг хангалтгүй зарим газруудад иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд хог хаягдлаа замбараагүй асгах дутагдал зөрчлүүд гарч байна. Энэ нь гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх нөхцөл бүрдсэн ба дээрх 20 цэгт гэрэлтүүлэг болон камержуулах, эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэх талаар холбогдох байгууллагууд хамтран ажиллах шаардлагатай байна.

Судалгаанаас харахад аж ахуй нэгж байгууллагуудын барилга, байгууламж тэдгээрийн гадна орчинд 65 камер, дотор 52 камерыг тодорхой үе шаттайгаар суурилуулах үйл ажиллагааг тус хорооны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлөөс зохион байгуулах.

Дүүргийн иргэдийн төлөөлөгчийн хурлын дэргэд криминологийн судалгаа хийдэг орон тооны бус нэгжийг байгуулан нутаг дэвсгэрийн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг судалж цаашид хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх.

БҮЛЭГ 6. “БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ” КРИМИНОЛГИ СУДАЛГААНЫ ДЭД ТАЙЛАН

Судалгааны дэд баг: Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан-багш, цагдаагийн хошууч Г.Бямбадорж, Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй криминологийн тэнхимийн багш, цагдаагийн ахмад Б.Батцэрэн, магистрант нар хийж гүйцэтгэв.

6.1. Баянзүрх дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэр, дэд бүтцийн судалгаа



БЗД-ийн 20 дугаар хороо Гачуурт тосгон Нийслэлийн хөдөлмөрчдийг сүү цагаан идээгээр тасралтгүй хангах зорилготойгоор анх 1961 оны БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 181 дүгээр тогтоолоор Гацуурт сангийн аж ахуй нэртэйгээр анхлан байгуулагдаж байсан түүхэн замналтай.

Тус Гацуурт сангийн аж ахуй нь байгуулагдсанаас хойш 12 жилийн дараагаар буюу 1973 онд Төв аймгийн засаг захиргаанаас албан ёсоор салж Улаанбаатар хотын захиргааны харъяанд шилжин ирэхдээ 13000 гаруй малтай /үүнээс саалийн

үнээ 12000/, 800 гаруй ажилчдын бүрэлдэхүүнтэйгээр ирсэн байдаг. Тухайн үед тус Гачууртын сангийн аж ахуй нь сүүний чиглэлийн хар тарлан үүлдрийн үхэр үржүүлдэг, жилдээ 3 сая литр сүү үйлдвэрлэж, улсын төсөвт 8,8 сая төгрөгийн цэвэр орлогыг бүрдүүлэн ажиллаж байсан хамгийн том сүүний фермүүдийн нэг байв.

1992 онд Хотын захиргааны өмч хувьчлалын комиссын 32 дугаар тогтоолоор өмч хувьчлал явагдаж тус аж ахуйн мал сүрэг, эд хөрөнгө хувийн хэвшилд шилжиж тарж бутраасан ч тухайн үеийн удирдлагууд Гацуурт сангийн аж ахуй гэх захиргааны статусаа хэвээр хадгалан үлдэж чадсан нь өнөөдрийн Гачуурт тосгон юм.

Тус хороо нь газар нутгийн хувьд 84000 мянган га газар нутгийг хамрасан тухайн газар нутагт **813** малчин өрхийн **42814** толгой мал идээшилсэн нийслэлийн төдийгүй дүүргийн хамгийн том газар нутагтай, хамгийн их малтай хороонд зүй ёсоор тооцогддог, төрөл бүрийн эмийн ургамал, бут сөөг, шилмүүст мод, жимс жимсгэнэ, нэн ховор ан амьтад бүртгэгдсэн байдаг.

Мөн нийслэл хот оршин буй Туул голын хөндий нь монголчуудын эх түүхийн голомт нутгийн нэгэн хэсэг бөгөөд энэ нь түүхэн сурвалжийн мэдээ төдийгүй археологийн биет дурсгалаар батлагддаг билээ. Тухайлбал, Баянзүрх дүүргийн нутаг Маахуур толгой, Хан-Уул дүүргийн Зайсан толгой, Буянт ухаагийн дундад чулуун зэвсгийн үеийн бууц суурин, Хан-Уул дүүргийн Их тэнгэрийн ам, **Баян зүрх дүүргийн Гачууртын амны хүрлийн үеийн зосон зураг, Монгол булш, Бэлхийн амны Хүннү булшны цогцолбор, Сонгины Баруун хайрхан уулын Хүннү, Түрэг булшнууд, Туул голын эрэгт орших Ван ханы гэгдэх орд /Хар түнэ/-ын туурь зэрэг дурсгалуудыг дурдаж болох юм.**

Газар нутгийн хувьд Улаанбаатар хот бүс нь 470 мянган га нутаг дэвсгэртэй. Засаг захиргааны бүтцийн хувьд алслагдсан Багануур, Багахангай, хаяа /налайх, сонгино-био, туул, өлзийт, гачуурт, хонхор, жаргалант, рашаант, 361-ийн гарам, тэрэлж/ зэрэг дагуул 10 дүүрэг тосгонтой.

Улаанбаатарын бүсийг 2020 онд 1534 мянган хүнтэй байхаар тооцсон ба хүн амын нягтрал 246 хүн/км² байна.

Тус хорооны хүн амын хувьд цөөн боловч газар нутгийн хувьд нилээд өргөн уудам нутаг дэвсгэртэй нэг хүнд 99,8 м кв газар оногддог.

Хот төлөвлөлт, барилгажилтын одоогийн байдал: Түүхэн хөгжлийн явцад Улаанбаатарын иргэдийг сүү, цагаан идээгээр хангах зорилготой байгуулагдсан “Гачуурт”-ын сангийн аж ахуйг түшиглэж суурин бий болж, хүрээгээ тэлэн хөгжин хүн амын суурьшилт, нутаг дэвсгэр зохион байгуулалтын одоогийн тогтолцоог бүрдүүлжээ.

Орон сууцны хангамж:

“Гачуурт” тосгонд одоогийн орон сууцны хангамжийн судалгаагаар нийт өрхийн 2.2% нь инженерийн бүрэн хангамжтай тохилог сууцанд амьдарч байгаа бөгөөд 54.9% нь инженерийн бүрэн хангамжгүй сууцад буюу монгол гэрт, 42.9% ердийн халаалттай сууцанд амьдарч байна.

Газар ашиглалтын одоогийн байдал:

Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын дагуу Гачуурт тосгон дахь газар ашиглалтын одоогийн байдлыг тодорхойлоход төлөвлөлт хийгдэж буй талбайг иргэд, байгууллага хувийн болон нийтийн хэрэгцээнд 3 үндсэн зориулалтаар ашиглаж байна.

Үүнд, нийт талбайн 46% буюу 3181.06 га газрыг хөдөө аж ахуйн буюу нийтийн хэрэгцээнд ашиглаж болох бэлчээрийн зориулалтаар, 36.9% буюу 2549.94 га газрыг хот тосгон, бусад суурины зориулалтаар, 17.1% буюу 1184 га газрыг усан сан бүхий газрын зориулалтаар тус тус ашиглаж байгаа юм. Нийт 90.79 га талбайд 1458 нэгж талбарыг өмчлүүлэх эрхтэйгээр, 849.93 га талбайд 5924 нэгж талбарыг эзэмших эрхтэйгээр, 100.93 га талбайд 25 нэгж талбарыг ашиглуулах эрхтэйгээр иргэд, аж ахуйн нэгжид тус тус олгосон байна.

Байгалийн тогтоц газар нутаг:

“Гачуурт” тосгон нь голын ай сав, уулын эрэг, налуу хосолсон үзэсгэлэнтэй байгальтай бөгөөд энэхүү байгалийн үзэсгэлэн нь “Гачуурт”-ын чиглэлд олон нийтийг татах хүч болдог. Монгол улсын Иргэнд газар өмчлүүлэх тухай хууль 2002 онд батлагдан хуульд иргэнд өмчлүүлэх газрыг Нийслэлд 0.07 га хэмээн заасантай холбогдуулан Улаанбаатарын иргэд “Гачуурт” тосгонд зуслангийн зориулалтаар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дагуу дээрх нутаг дэвсгэрт эрчимтэйгээр суурьшлын бүс бий болгон тэлснээр цаашид тус нутгийг хөгжүүлэх, нийгмийн болон дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах төлөвлөлт хийх шаардлагатай.

Сүүлийн жилүүдэд хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой хот, хөдөө орон нутгаас шилжин ирж буй иргэд тус тосгонд гэр сууцны хороолол бүхий суурьшлыг эрчимтэйгээр үүсгэсэн.

Ерөнхий боловсролын сургууль:

“Гачуурт” тосгон буюу Баянзүрх дүүргийн 20-р хороонд нийт 1416 ерөнхий боловсролын сургуулийн сурагч хамрагдаж байна. Үүнээс 790 нь дээрх 85-р сургуульд суралцаж бусад 626 хүүхэд ойролцоох хороо, дүүргийн сургуулиудад суралцаж байна.

Дээрх 85-р ерөнхий боловсролын сургуулийн барилга зориулалтын бус барилга бөгөөд анх цэргийн казармын зориулалтаар баригдсан. Боловсролын газраас тус барилгын хүчин чадлыг 480 гэж тодорхойлсон одоогоор 790 хүүхэд суралцаж байгаа нь хүчин чадлаа 65%-иар хэтрүүлэн сурагч суралцуулж байна.

Цэцэрлэг:

“Гачуурт” тосгонд төрийн өмчийн 63-р цэцэрлэг, болон хувийн өмчийн 3 цэцэрлэг байдаг бөгөөд барилгын нийт хүчин чадал 285 хүүхэд боловч суралцаж байгаа хүүхдийн тоо 419 буюу хүчин чадлаа 91%-иар хэтрүүлэн үйл ажиллагаа явуулж байна. Цэцэрлэгийн насны огт цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа 294 хүүхэд байна.

Авто зам, нийтийн тээврийн одоогийн байдал

Баянзүрх дүүргийн Улиастай –Гачууртын чиглэлийн авто зам 1985 онд ашиглалтад орсон бөгөөд 2015 онд тус авто замыг өргөтгөл шинэчлэлийн ажлын хүрээнд зорчих хэсгийн өргөнийг 7 м, явган хүний зам, гэрэлтүүлэгтэй, нийт далангийн өргөнийг 12 м болгосон байна. Нийтийн тээврийн автобусны буудал 27 цэгт шинээр хийж, 8 цэгт ус зайлуулах төмөр бетон хоолойг засварлаж, шинээр нэг төмөр бетон хоолойг хийж, замын трассын дагууд байрлах хоёр хуучин гүүрийн ачаалал даах чадварыг нэмэгдүүлсэн бөгөөд нийт замын уртад урд талаараа гэрэлтүүлэгтэй, хойд талаар явган замыг шинээр барьж өргөтгөн сайжруулсан байна. Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо буюу “Гачуурт”

тосгон уруу Ч:36 “Гачуурт – Офицер – Зайсан” чиглэлд ажлын өдөр 14, амралтын өдөр 10 их багтаамжийн автобусаар “Эмсид” ХХК-иас нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлж байна.

Дулаан хангамж:

Улаанбаатар хотын “Гачуурт” тосгоны дулаан хангамжийн бүтэц нь дулаан хангамжийн хэсэгчилсэн систем буюу халаалтын зуухнаас хангах хэрэглэгчийн систем, бие даасан халаалтын зуухны систем болон гэр хорооллын айл өрхийн зуух гэсэн дулаан хангамжтай. “Гачуурт” тосгоны төвийн хэсэгт одоогийн байдлаар байгаа дулааны эх үүсвэр нь 1963 онд ашиглалтад орж 2006 он хүртэл Улсын үйлдвэрийн харьяанд байсан бөгөөд 2006 оны үеэс эхлэн дулаан хангамж нь “Түшигтхангай” ХХК хувийн компанид шилжин өнөөг хүртэл ажиллаж байна. “Түшигтхангай” ХХК нь 2012 оны 10 сард хуучин зуухыг монгол гар хийцийн 1,4мвт хүчин чадалтай 2 зуухаар сольж ашиглалтад оруулсан мөн 2015 онд зуухны барилга байгууламж болон 480 м дулааны шугам сүлжээг шинэчилсэн. Барилга байгууламжууд хэрэглээний халуун усанд холбогдоогүй.

Одоогийн байдлаар 2 халаалтын зуухны 1 нь ашиглалтад 1 нөөцөд байгаа. Усан хангамж: Төлөвлөлт хийгдэж буй хэсэгт Улаанбаатар хотын ундны усны хэрэглээг хангахад ус хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор Япон улсын буцалтгүй тусламжаар хоногт 25000м³ ус олдворлох “Гачуурт эх үүсвэр”-ийг 2012-2015 оны хооронд барьж байнгын ашиглалтад оруулсан. Тус эх үүсвэрийн гүний худаг, цуглуулах, дамжуулах хоолой болон халдваргүйжүүлэх төхөөрөмжийг Япон улсын хөрөнгө оруулалтаар барьсан бол манай тал цахилгаан хангамж, $V=2 \times 3000 \text{ м}^3$ усан сан, хамгаалалтын хашаа, харуулын байр, 2 гүүрний барилга угсралтыг иж бүрнээр хийсэн байна.

Нийгмийн зориулалтын барилга байгууламжууд байрладаг ба сургуулийн ойролцоо байрлах гүний худгаас бусад нийгмийн барилга хангагдаг болно. Нийт 11 гүний худагтай.

Цахилгаан хангамж:

Нийт нутаг дэвсгэрийн цахилгаан ачаалал нь өвлийн оргил ачааллын үед 4846кВа. Зун нь 50% ачаалал авдаг буюу 2423кВА байна. Иймд тус нутаг дэвсгэрт 5154кВА –ийн нөөц ачаалал байна. Мөн нийт станцуудын 35% орчим нь 30-40 жилийн насжилттай байгаа тул шинэчлэх солих шаардлагатай байгаа юм. Дорнод-2 станцаас 35кВ-ын нэг хэлхээт агаарын шугамаар тэжээгдэх 35/10кВ-ын 10000кВА “Гачуурт” дэд станцтай. 35/10 кВ-ын “Гачуурт” дэд станц, тус дэд станцаас 10кВ-ын 3 фидер гарсан байна. 10кВ-ын (160кВА- 630кВА) чадалтай улсын болон хувийн хөрөнгө оруулалт бүхий нийт 25ш АТП-дэд станц, 10кВ-ын 400кВА чадалтай 1ш ХТП буюу хаалттай дэд өртөө, 10кВ-ын (100кВА, 400кВА) чадалтай улсын болон хувийн хөрөнгө оруулалт бүхий нийт 2ш КТПН-дэд станцууд байна.

Холбоо мэдээллийн сүлжээ:

Мэдээлэл Холбооны Сүлжээ ТӨК-с авсан мэдээллээр тус байгууллагын хариуцсан агаарын болон худаг сувагчлал байна. MSAN D300 станцаас салбарлан агаарын 230 ширхэг баганаар 10500 метр холбооны физик кабелиар хэрэглэгчдийг холбож үйлчилгээ явуулж байна. Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн 320 хэрэглэгчийн багтаамжтай MSAN D300 станц ажиллаж байна. MSAN D300 станцаас одоогийн байдлаар 198 хэрэглэгчид суурин телефон, 126 хэрэглэгчид интернет үйлчилгээ үзүүлж байна. Мөн АТС-45 станцаас одоо байгаа холбооны худаг сувагчлал болон газраар MSAN D300 станц хүртэл татсан 1998 онд Тайваны төслөөр хийсэн 4 шөрмөсийн шилэн кабель байна. Монгол Шуудан ХКийн салбар нэгж байдаггүй бөгөөд хамгийн ойрын салбар нь БЗД-ийн 14-р хороо Цагдаагийн академи 1- 48-р байранд байна.

Эдийн засгийн салбар:

“Гачуур” тосгоны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хот төлөвлөлтийн суурь судалгаанд үндэслэн Гачуур тосгонд хөгжүүлэх салбар, тэргүүлэх чиглэлийг 11 үзүүлэлтээр шинжлэн судалсан. Шинжилгээний дүгнэлтээс харвал уг тосгонд дараах чиглэлийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих, тэргүүлэх салбаруудыг хөгжүүлэх боломжтой байгаа байна. Үүнд:

- Эрчимжсэн мал аж ахуй /сүүний чиглэлийн фермер/
- Байгалийн аялал жуулчлал
- Ахмад, хүүхдийн сувилал
- Хүүхдийн зуслан, амралт зугаалга
- Хүлэмжийн аж ахуй /хүнсний ногоо, жимс, жимсгэнэ/
- Байгальд ээлтэй хот байгуулалт

Газар зохион байгуулалтын байдал:

Хот байгуулалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийг үндэслэн дараах үндсэн болон дэд бүсүүдийг бүсчлэн тогтоолоо. Үүнд:

- Гэр хорооллын бүс;
- Эдэлбэр газартай хувийн орон сууцны бүс
- Нам давхар орон сууцны бүс;
- Хорооллын худалдаа үйлчилгээ ажил хэргийн бүс;
- Цэцэрлэг, сургуулийн бүс;
- Хөнгөн үйлдвэрийн бүс;
- Соёл, спорт, цэцэрлэг, амралт зугаалга, ногоон байгууламжийн бүс;
- Эрүүл ахуйн хамгаалалтын ногоон байгууламжийн бүс;
- Тусгай зориулалтын бүс;
- Зуслангийн бүс
- Инженерийн барилга байгууламжийн бүс

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичигт "Гачуурт" тосгоны хүн амын эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг хангасан суурьшил, зуслангийн бүс, байгалийн онцлогт тулгуурласан ногоон байгууламж, амралт, аялал жуулчлалын бүс болон сүүний чиглэлийг эрчимжсэн мал аж ахуй бүхий Нийслэлийн хаяа тосгон болгон хөгжүүлэхээр тусгагджээ.

Хорооны үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалт

Иргэдийн нийтийн хурлын дарга, БЗД-ийн 20 дугаар хорооны Засаг дарга, Гачуурт тосгоны захирагч, зохион байгуулагч, нийгмийн ажилтан, иргэний улсын бүртгэгч, ХХҮХ-ийн мэргэжилтэн, нягтлан бодогч, нярав, жижүүр-3, үйлчлэгч-2, жолооч, 12 хэсгийн ахлагч, БЗД-ийн Цагдаагийн 3-р хэлтсийн Гачуурт тосгоны Цагдаагийн тасгийн бүрэлдэхүүн-3, байгаль хамгаалагч бүгд 40 гаруй ажилтан албан хаагчийн бүтэцтэйгээр төрийн үйлчилгээг тус хорооны иргэдэд хүргэж байна.

Мөн Ерөнхий боловсролын сургууль-1, цэцэрлэг-1 тус тус байна.

Тус хорооны аж ахуйн нэгжийг дурьдвал архи согтууруулах ундаагаар үйлчилдэг хүнсний дэлгүүр-24, зургаан нэрийн хүнсний дэлгүүр-10, цайны газар-4, ресторан-1, амралтын газар-23, сувилал-8, ШТС-4, банк-2 зэрэг нийт хувийн хэвшлийн 91 байгууллага аж ахуйн нэгжтэй.

Үйл ажиллагаа явуулж буй нийт ААНБ-аас улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж цөөнгүй. Тухайлбал: 4-өөс 10 дугаар сарын хооронд буюу улирлын чанартай ажилдаг 34 буюу 37,3% байнгын үйл ажиллагаа явуулдаг 52 буюу 57.1% эзлэж байна. Дэд бүтэц хөгжлийн хувьд төдийлөн хөгжөөгүй үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, худалдаа, үйлчилгээ, санхүү, татвар, аялал жуулчлалын салбарын хөгжил сул байгааг харуулж байна.



Улаанбаатарын бүсийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 206 км хатуу хучилттай, 180 км сайжруулсан хот хоорондын болон орон нутгийн авто зам байдаг. Баруун аймгууд болон Багануур, Багахангай, Гачуурт, Тэрэлж, Налайх, Хонхор, Шувуун фабрик, Био-Сонгино хаяа хот, тосгод хатуу хучилттай замаар холбогдсон. Сүүлийн жилүүдэд алслагдсан болон

хаяа хот, тосгодын хөгжил Улаанбаатар хотын төв рүү чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөний тодорхой хэсгийг хязгаарлах Улаанбаатар хот тойрсон хот тосгодын бүсийн нутагшилт суурьшлын оновчтой тогтолцоо бүрдээгүй байна.

Мөн төвийн дүүрэг, хорооны хүн амын нийгмийн үйлчилгээний ачаалалыг багасгах, төрийн зарим чиг үүргийг бусад бүсийн тулгуур төвд шилжүүлэх дорвитой үндэс суурь тус тосгонд тавигдаагүй байна.

Хот тосгоны эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөлт, хот байгуулалтын бодлогын харилцан уялдаа хангалтгүй хөгжлийн бодлогыг орон зайн хэмжээнд авч үзэж, бүсүүдийн тулгуур төв хотуудын эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, харилцан хамааралд тулгуурлан төлөвлөлт хөрөнгө оруулалтын тогтолцоог бүрдүүлж, нийгмийн ямар үйлчилгээг аль хот, тосгодод шилжүүлж хэрхэн хөгжүүлэх төлөвлөлт, хөрөнгө оруулалтын талаар Нийслэл, дүүргийн засаг дарга, иргэдийн хурал бусад үүрэгтэй нэгжийн оновчтой бодлого үгүйлэгдэж байгааг илтгэж байна.

6.2.БЗД-ийн 20-р хорооны нутаг дэвсгэрын хүн амын бүтцийн судалгаа

Баянзүрх дүүргийн нийт хүн амын 2.5% буюу 3072 өрхийн 8275 хүн 20-р хороо “Гачуурт” тосгоны нутаг дэвсгэрт хамрагдаж байна. Үүнээс байнгын оршин суудаг 2500 өрхийн 6500 хүн байна.

Тус тосгон нь дүүргийн хэмжээнд 28 хорооноос газар нутгаараа нэгдүгээрт, өрхийн тоогоороо 16-рт, хүн амын тоогоороо 22-рт орж байна. Нэг өрхийн ам бүлийн тоо 2.7 ам бүл, 1 га-д 0.1 хүн буюу хамгийн нягтшил багатай хороо болно.

Дийлэнх хүн амын 70 гаруй хувь нь тосгоны төвд суурьшмал амьдардаг бол 20 гаруй хувь нь төвөөс алслагдмал 12 хэсэгт таран амьдардаг малчин өрх байдаг.

Хүснэгт № 6.1. Хүн амын тоо

№	Дүүрэг	Хороо	Хэсэг	2018 оны нийт өрхийн тоо	2018 оны суурин хүн амын тоо
1	Баянзүрх	20	Бүгд	2991	7990
2			1-р хэсэг	123	310

3			2-р хэсэг	122	203
4			3-р хэсэг	321	789
5			4-р хэсэг	170	458
6			5-р хэсэг	157	445
7			6-р хэсэг	131	317
8			7-р хэсэг	183	438
9			8-р хэсэг	336	1031
10			9-р хэсэг	633	1734
11			10-р хэсэг	136	401
12			11-р хэсэг	220	715
13			12-р хэсэг	459	1149
14	Дүн			2991	7990

Хүснэгт №6.2. Хүн амын судалгаа нийгмийн байдлаар


Үзүүлэлт		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
Хүүхэд /0-17/	0-5	Нийт	998	524	474
		Үүнээс цэцэрлэгт	471	251	220
	6-17	Нийт	1396	736	660
		Үүнээс сургуульд	1396	736	660
Хөдөлмөрийн нас /18-59/	Нийт		4844	2504	2340
	Ажилтай		3016	1686	1330
	Ажилгүй		1828	816	1012
	Сурдаг		699	331	368
	Тэтгэвэр, нөхөн олговор		208	75	133
	Өвчтэй, группт		204	98	106
	Бусад		113	67	46
Нийт өрхийн тоо			2991	51.75%	48.25%
Амжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлогтой өрхийн тоо			3146	1006	2140
Хорооны нийт хүн амын тоо			7990	4125	3865

График №6.1. Хүн амын тоо хэсгээр



Тус хорооны хүн амыг хэсгээр нь авч үзвэл 9-р хэсэгт 1834 буюу 22.9 хувь 12-р хэсэгт 1249 буюу 15,6 хувь, 8-р хэсэгт 1031 буюу 12.9 хувь, 3-р хэсэгт 889 буюу 11.1 хувь, 11-р хэсэгт 715 буюу 8.9 хувь нь тус тус оршин сууж байгаа нь тус хэсгүүдэд хүн амын төвлөрөл их байгааг анхаарч хүн ам төвлөрсөн хэсгүүдэд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг түлхүү зохион байгуулах, энэхүү хэсгүүдэд үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчөөс урьдчилан сэргийлэх урамшилтай эргүүл жижүүрийг нэмэгдүүлж ажилуулах арга хэмжээ авах нь зүйтэй.

График №6.2. Өрхийн тоо хэсгээр



Тус хорооны нийт өрхийг хэсгээр нь авч үзвэл 9-р хэсэгт 633 буюу 21.1 12-р хэсэгт 459 буюу 15,3 хувь, 8-р хэсэгт 346 буюу 11.5 хувь, 3-р хэсэгт 321 буюу 10.7 хувь, 11-р хэсэгт 241 буюу 8.1 хувь нь тус тус оршин сууж байгаа нь тус хэсгүүдэд мөн өрхийн тоо болон хүн амын нягтрал төвлөрөл их байгааг харуулж байна. Мөн цаашид ч тус хэсгүүдэд хүн амын тоо шилжин ирэгсэдийн тоо нэмэгдэх хандлагатай байна.

Хүн амын дунд насанд хүрээгүй хүнийг авч үзвэл 0-5 насны 998 буюу 41.6

хувь 6-17 насны 1396 буюу 59.4 хувь эзлэж байгаа нь залуу үеийн төлөөлөл нэмэгдэж байгаа нь ажиглагдаж байгаа бөгөөд цаашид дэд бүтцийг хөгжүүлэх, гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх ажлыг боловсронгуй болгох, гэмт хэрэгтэй тэмцэх ажилд шинжлэх ухааны ололт амжилт, орчин үеийн техник технологийг нэвтрүүлэх нэг алба хаагчид оногдох хүний тоо бууруулах арга хэмжээг авах шаардлага тулгарч байна.

График №6.3. Насанд хүрээгүй хүний тоон үзүүлэлт





График №6.4. Насанд хүрээгүй хүмүүсийн цэцэрлэгт хамрагдсан байдал



График №6.5. Хүйсийн байдал, хөдөлмөр эрхлэлт



Тус хороонд хөдөлмөрийн насны нийт 4844 иргэн оршин суудаг бөгөөд үүнээс ажилтай-3016, ажилгүй-1828, сурдаг-699, тэтгэвэр, нөхөн олговор-208, өвчтэй, группт-204, хувиараараа хөдөлмөр эрхлэгч-113 хүн байна.

Хүснэгт №6.3. Өрхийн гэр орон сууцны судалгаа 2019 оны байдлаар


Баг хороо	Хэсэг	Баг хорооны өрх, хүн амын тоо		Хороолол			
		Нийт өрхийн тоо	Хүн амын тоо бүгд	Сууцны тусдаа байшин	Байшинд амьдардаг	Гэрт амьдардаг	Орон гэргүй
20-р хороо	1.	177	374		45	132	
	2.	122	204		31	91	
	3.	321	889	10	151	160	
	4.	170	458		84	86	
	5.	197	495		132	65	
	6.	139	317		60	76	
	7.	183	138		60	123	
	8.	346	1031		246	100	
	9.	633	1834		520	113	
	10.	159	501		100	59	
	11.	241	715		176	65	
	12.	459	1249		380	79	
Бүгд:		3147	8205	10	1985	1149	

Тус хорооны өрхийн 1985 буюу 66,3 хувь байшинд, 1149 буюу 50,1 хувь гэрт, 10 буюу 0,3 хувь нь сууцны тусдаа байшинд амьдарч байна.

6.2.1.БЗД-ийн 20-р хорооны нутаг дэвсгэрийн субъектын судалгаа

Тус хороонд сэжигтэй этгээдийн бүртгэлд авагдсан нийт 94 субъект байдаг бөгөөд нийт сэжигтэй этгээдийн бүртгэлд авагсан этгээдүүдийн 8 буюу 0.8 хувь нь хорихоос суллагдсан хүн, 21 буюу 22 хувь нь сэтгэцийн өвчтэй хүн, 3 буюу хувь 0.3 хувь нь захиргааны хяналтанд байгаа хүн, 27 буюу 28 хувь нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч, 10 буюу 10.6 хувь нь бүлэг бөөгнөрөл үүсгэгч, 25 буюу 26.5 хувь нь галт зэвсэгтэй иргэд бүртгэгдсэн байгаа бөгөөд эдгээр субъектүүд нь нийт гэмт хэрэг үйлдэж болзошгүй сэжигтэй этгээдийн бүртгэлд авагдсан хүмүүсийн 10 хувийг эзлэж байна.

График №6.6.Субъектын судалгаа



Тус хороонд бүртгэгдсэн сэжигтэй этгээдийн бүртгэлтэй нийт 940 хүн байгаа бөгөөд тус хороонд үүрэг гүйцэтгэж байгаа нэг алба хаагчид 470 хүн оногдож байна.

Судалгаанд авагдсан этгээдүүдийн талаар дараах мэдээллийг судалгаанд авсан байна. Үүнд:

- Овог нэр
- Гэрэл зураг
- Регистерын дугаар
- Төрсөн огноо
- Гэрийн хаяг, байршил
- Гэрийн утас
- Гар утас
- Субъектын төрөл гэсэн мэдээллийг тусгажээ.

6.3.Баянзүрх дүүргийн 20-р хорооны малын тоо, малчин өрхийн статистик


Хүснэгт №6.4. Малын тоо толгой төрлөөр

№	Баг хэсэг	Багийн нэр	Мал бүхий этгээдийн тоо		Үүнээс:						Бүгд толгой
			Өрхийн тоо	ААН-ийн тоо	Адуу	Тэмээ	Үхэр	Сарлаг	Хонь	Ямаа	
1	1-р хэсэг	Улиастай -1	162		440	-	2599		1338	1224	5601
2	2-р хэсэг	Улиастай -2	90		618	-	2017		560	303	3498
3	3-р хэсэг	Хар усан тохой	15		67	-	181		245	36	529

4	4-р хэсэг	Гялалзах, Могойт дэнж	36	250	-	531	798	845	2424
5	5-р хэсэг	Бага шар хоолой	61	510	-	906	408	181	2005
6	6-р хэсэг	Хуандай, Дээндий	97	886	-	1856	247	3757	8958
7	7-р хэсэг	Арцат	124	515	-	1912	1589	2097	6113
8	8-р хэсэг	Төв, 10 айл, Гүнжийн хоолой, цэргийн булаг	57	217	-	835	1052	1231	3335
9	9-р хэсэг	Туул	29	25	-	645	402	485	1557
10	10-р хэсэг	Дээд шар хоолой	96	431	-	1776	1788	1358	5353
11	11-р хэсэг	Туулферм, их ам, бага ам	30	42	-	307	141	206	696
12	12-р хэсэг	Баяндөхөм	16	259	-	160	387	246	1052
ДҮН			813	4260	-	13725	247	12465	10424

Тус хорооны малтай өрх малын тооноос үзэхэд малын тоо, малтай өрхийн тоо өссөн нэмэгдэх хандлагатай байгаа нь харагдаж байна. Мөн сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотод гарсан мал, амьтны гаралтай шүлхий, боом, гахай, шувууны ханиад зэрэг гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөлтөнд тусган хэрэгжүүлэх шаардлага байгааг анхаарч энэ төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал аж ахуйг фермийн хэлбэрээр мал аж ахуй эрхлэх бүс нутаг дэвсгэр болгон тусгайлан тогтоож хөгжүүлэх шаардлагатай.


График №6.7. Малын генетикийн судалгаа




Монгол Улсын Засгийн Газраас нийслэлд мал аж ахуй эрхлэх, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах, худалдах явдлыг эмх цэгцтэй болгох зорилгоор “нийслэлд мал аж ахуй эрхлэх журам”-ыг 2002 оны 133 дугаар тогтоолоор баталсан. Энэхүү журмыг хэрэгжүүлэх зорилгоор нийслэлийн засаг дарга 2002 онд 411 тоот захирамжаар “нийслэлд мал аж ахуй эрхлэх журам”-ыг батлан, мал аж ахуй эрхлэхийг хориглох улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол хийж Нийслэлийн зураг төслийн хүрээлэн 28 бүсийг урд тал нь айдасын даваа, баруун тал нь Морин-уул, хойд тал нь тахилт, гүнтийн даваа, зүүн тал нь улиастай гол, налайх-

тэрэлжийн засмал замын уулзвараар хязгаарлан тогтоосон нь мал аж ахуй эрхлэх нутаг дэвсгэрийг тусгайлан тогтоож хөгжүүлэх шаардлагатай⁹.

График №6.8 Таван хошуу малын тоо толгой



Цаашид мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх ажилд малчидын сайн дурын холбооны үүрэг оролцоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг нь дэмжих, сайжруулах, малчин хорооны иргэдийн идэвхи санаачлагыг дээшлүүлэх тус хорооны малын им тамга тэмдгийг жигдрүүлэх, тамгажуулах аяныг өрнүүлэх, ялангуяа бод малыг хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор бод малд чип “GPS” дохиолол суулгах арга хэмжээг авч хэрэгжүүлж болох юм.




⁹ <http://development.ub.gov.mn/uploads/The-first-volume-of-UB-master-plan.pdf>



6.4. Баянзүрх дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн судалгаа

График №6.14. Төрийн болон төрийн бус байгууллагын харьцаа



Төрийн бус байгууллага 84 буюу 91 хувь нь 7 буюу 8 хувь нь төрийн байгууллага эзлэж байна. Төрийн байгууллагад хорооны засаг даргын тамгын газар, өрхийн эрүүл мэндийн төв, ЕБС, цэцэрлэг, гачуурт тосгоны Цагдаагийн тасаг зэрэг байгууллага багтаж байгаа бөгөөд өдөр тутам иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж байна.

График № 6.15 Архи согтууруулах ундаагаар үйлчилдэг хүнсний дэлгүүлийн эзлэх хувь



Тус хорооны нутаг дэвсгэрт нийт 38 хүнсний дэлгүүр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үүнээс 24 хүнсний дэлгүүр нь архи согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй байгаа нь Үйлдвэр худалдааны сайдын 2008 оны № 05-р тушаалаар батлагдсан 2000 хүн ам тутамд нэг аж ахуйн нэгж, байгууллага байхаар тооцсон нормативаас даруй 3 дахин их байна. Мөн төвийн хэсэгт оршин сууж байгаа 166 иргэнд нэг цэг оногдож байна.

Мөн тус хороонд нийт 91 аж ахуйн нэгж байгууллага бүртгэгдснээс 38 хүнсний дэлгүүр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнээс зургаан нэрийн хүнсний дэлгүүр-10, архи согтууруулах ундаагаар үйлчилдэг хүнсний дэлгүүр-24, амралтын газар-23, сувилал-8, штахцуун түгээх станц-4 үйл ажиллагаа явуулж байна.




График №6.16. Байгууллагын үйл ажиллганы төрөл
Аж ахуйн нэгжийн үйл ажиллганы төрөлөөс үзвэл тус хорооны нутаг дэвсгэрийн онцлогоос хамаарч нийт ААН-ын дотор амралтын газар 23 буюу 25.2 хувь, хүнсний дэлгүүр 48 буюу 52.7 хувь, эмнэлэг сувилал 8 буюу 8,7 хувь, шатахуун түгээх станц 4.3 хувь, банк 2 буюу 2.1 хувийг тус тус эзлэж байгаагаас үзэхэд дэд бүтэц төдийлөн хөгжөөгүй үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, санхүү, татвар, аялал жуулчлалын салбарын хөгжил сул байгааг харуулж байна. Мөн ард иргэдэд үйлчилгээ үзүүлэх хороо тосгоны нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах,

тэднийг хөгжүүлэх өөр шинэ салбар, бодлого үйл ажиллагааг үгүйлэгдэж байгааг илэхийлж байна.




График №6.17. Үйл ажиллагаа явуулж буй цаг хугацаагаар нь

Үйл ажиллагаа явуулж буй нийт 91 аж ахуйн нэгж байгууллагаас улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг.

Тухайлбал: тухайн оны 4 дүгээр сараас 10 дугаар сарын хооронд буюу дулааны улиралд амралт сувлалын газар ажлуулдаг ажилдаг 34 буюу 37.3 хувь, байнгын ажиллагаатай жилийн дөрвөн улиралд үйл ажиллагаа явуулаг 52 буюу 57.1 хувь, үйл ажиллагаа эхлээгүй 1 буюу 0.9 хувь эзлэж байна.

График №6.18. Хэсгүүдэд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн тоо



Тус хорооны хэсгүүдэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийг авч үзвэл 3-р хэсэгт 7 буюу нийт аж ахуйн нэгжийн 7.6 %, 8-р хэсэгт 1 буюу нийт аж ахуйн нэгжийн 0.9%, 5-р хэсэгт 9 буюу нийт аж ахуйн нэгжийн 9.8 %, 10-р хэсэгт 3 буюу нийт аж ахуйн нэгжийн 3.2 %, 11-р хэсэгт 2 нийт аж ахуйн нэгжийн 2.1%, 4-р хэсэгт 2 буюу нийт аж ахуйн нэгжийн 2.1% нь эзлэж байна.

6.5.Баянзүрх дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн статистик

Судалгааны ажлын хүрээнд тус хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн төрөл, ангилал, гариг, цаг хугацаа, тоо давтамж зэргийг судлан эрүүгийн нөхцөл байдлыг судлаж тогтоон, цаашид хэрэгжүүлэх ажил арга хэмжээг тодорхойлохын тулд 2015, 2016, 2017, 2018 онуудад тус хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн тоо судалгаанд дүн шинжилгээ хийлээ.

График №6.19. БЗД-ийн 20-р хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг хороогоор

д/д	Хороо	2015	2016	2017	2018
1	8-р хороо	169	161	204	307
2	9-р хороо	104	80	91	137
3	10-р хороо	70	97	63	140
4	11-р хороо	154	190	159	256
5	12-р хороо	119	124	135	176
6	17-р хороо	100	94	75	124
7	20-р хороо	125	118	113	135
8	23-р хороо	110	110	112	171
9	28-р хороо	73	88	74	94
Дүн		1024	1062	1026	1540

График №6.20 БЗД-ийн 20-р хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн тоон өсөлтийн үзүүлэлт





График №6.22 2015 онд бүртгэгдсэн гэмт хэрэг

График №6.23 2016 онд бүртгэгдсэн гэмт хэрэг




График №6.24 2017 онд бүртгэгдсэн гэмт хэрэг

График №6.25 2018 онд бүртгэгдсэн гэмт хэрэг



График №6.26 2015-2018 онд эрүүгийн хэрэг үүсгэсэн үндэслэл




2015 онд БЗД-ийн 20-р хороо эрүүгийн хэрэг үүсгэсэн үндэслэлээр нь авч үзэхэд гэмт хэргийн тухай гомдол мэдээлэл 89.5%, мөрдөгч илрүүлсэн 0.8%, прокурор илрүүлсэн 8.8-ыг эзэлж байгаа бөгөөд гэмт хэрэг үйлдсэн хэмээн өөрийгөө илчилж ирсэн, гүйцэтгэх ажлын шугамаар баримтжуулагдсан мэдээ, баримт 0.8% байна.

2016 онд БЗД-ийн 20-р хороо эрүүгийн хэрэг үүсгэсэн үндэслэлээр нь авч үзвэл гэмт хэргийн тухай гомдол 77%, гэмт хэрэг үйлдсэн хэмээн өөрийгөө илчэлж ирсэн 0%, хэрэг бүртгэгч илрүүлсэн 0%, мөрдөгч илрүүлсэн 0%, прокурор илрүүлсэн 27%, гүйцэтгэх ажлын шугамаар ажлуулсан мэдээ 0%.

2017 онд БЗД-ийн 20-р хороо эрүүгийн хэрэг үүсгэсэн үндэслэлээр нь авч үзвэл нийт 132 гэмт хэргээс гэмт хэргийн тухай гомдол 81 буюу 61.1%, прокурор илрүүлсэн 50 буюу 37%, мөрдөгч илрүүлсэн 18 буюу 0.7% байна.

2018 онд БЗД-ийн 20-р хороо эрүүгийн хэрэг үүсгэсэн үндэслэлээр нь авч үзвэл нийт 137 гэмт хэргээс гэмт хэргийн тухай гомдол 81 буюу 59.1%, прокурор илрүүлсэн 35 буюу 25.5%, мөрдөгч илрүүлсэн 18 буюу 13.1% байна.

График №6.27. Гэмт хэргийн шалтгаан нөхцөл



2015 онд БЗД-ийн 20-р хороо гэмт хэргийн шалтгаан нөхцөлөөр нь авч үзвэл согтуугаар үйлдэгдсэн-63.63%, мансуурсан үедээ үйлдсэн-0%, галт зэвсгээр үйлдсэн-0%, хүүхэд оролцсон-15.9%, эмэгтэй хүн оролцсон-15.9%, гадаадын иргэн үйлдсэн-0%, харьяалалгүй хүн үйлдсэн-0%, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн-4.5%-ийг тус тус эзэлж байна.

2016 онд БЗД-ийн 20-р хороо гэмт хэргийн шалтгаан нөхцөлөөр нь авч үзвэл согтуугаар үйлдэгдсэн 51%, харъяалалгүй хүн үйлдсэн 0%, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 13%, мансуурсан үедээ үйлдсэн 4%, галт зэвсгээр үйлдсэн 0%, хүүхэд оролцсон 6%, эмэгтэй хүн оролцсон 26%, гадаадын иргэн үйлдсэн 0%

2017 онд БЗД-ийн 20-р хороо гэмт хэргийн шалтгаан нөхцөлөөр нь авч үзвэл согтуугаар үйлдэгдсэн 5 буюу 33%, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 5 буюу 33%, эмэгтэй хүн оролцсон 11 буюу 33%, байна.

2018 онд БЗД-ийн 20-р хороо гэмт хэргийн шалтгаан нөхцөлөөр нь авч үзвэл согтуугаар үйлдэгдсэн 5 буюу 16%, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 5 буюу 16%, мансуурсан үедээ үйлдсэн 2 буюу 6%, галт зэвсгээр үйлдсэн 1 буюу 3%, хүүхэд оролцсон 5 буюу 16%, эмэгтэй хүн оролцсон 11 буюу 36%, гадаадын иргэн үйлдсэн 1 буюу 3% байна.


График №6.28 Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бургуйн хэлбэр



2017 онд БЗД-ийн 20-р хороо гэмт хэрэг үйлдсэн хэлбэрээр нийт 116 хэргээс санаатай 105 буюу 90.5%, болгоомжгүй 65 буюу 4.3%, холимог 3 буюу 2.5%, бүлэглэн 2 буюу 1.7%, зохион байгуулалттай 1 буюу 0.7% байна.

2018 онд БЗД-ийн 20-р хороо гэмт хэрэг үйлдсэн хэлбэрээр нийт 135 хэргээс санаатай 128 буюу 94.8%, болгоомжгүй 6 буюу 4.4%, холимог 1 буюу 0.7% байна.

График №6.29. Гэмт хэргийг олж тогтоосон алба хаагч



2015 онд БЗД-ийн 20-р хороо гэмт этгээдийг олж тогтоосон цагдаагийн алба хаагчаар авч үзвэл эрүүгийн цагдаа-1.07%, мөрдөгч-21.50%, нийтийн хэв журам хамгаалах-2.15%, хэсгийн байцаагч-0%,


эргүүлийн цагдаа-1.07%, хорооны цагдаа-0%, замын цагдаа-0%, замын байцаагч-41.9%, зохицуулагч 33.33%, жижүүрийн шуурхай алба 0%, бусад-0.

2016 онд БЗД-ийн 20-р хороо гэмт этгээдийг олж тогтоосон цагдаагийн албан хаагчаар авч үзвэл эргүүлийн цагдаа 0%, хэсгийн төлөөлөгч 0%, мөрдөгч 75%, хэрэг бүртгэх 22%, нийтийн хэв журам хамгаалах 0%, хэсгийн байцаагч 0%, эргүүлийн цагдаа 0%, сумын цагдаа хорооны цагдаа 0%, замын цагдаа 2%, байцаагч зохицуулагч 0%, жижүүрийн шуурхай алба 0%.

2017 онд БЗД-ийн 20-р хороо гэмт этгээдийг олж тогтоосон цагдаагийн албан хаагчаар авч үзвэл эргүүлийн цагдаа 1 буюу 4%, мөрдөгч 20 буюу 83%, замын цагдаа 1 буюу 4%, хорооны цагдаа 2 буюу 8% байна.

2018 онд БЗД-ийн 20-р хороо гэмт этгээдийг олж тогтоосон цагдаагийн албан хаагчаар авч үзвэл эргүүлийн цагдаа 4 буюу 20%, мөрдөгч 17 буюу 80% байна.

График №6.30. Гэмт хэрэг илрүүлсэн арга




2015 онд БЗД-ийн 20-р хороо гэмт этгээдийг олж тогтоосон аргаар хэрэг бүртгэл-45.3%, мөрдөгч-45.3%, гүйцэтгэх ажил-9.3%, цагдаагийн ажилтан биечлэн-0%, иргэдийн мэдээлэл-0%, шинжилгээний дүгнэлт-0%, эрэлч нохой-0%, гэмт этгээд өөрийн үйлдсэн хэргээ илчилж ирсэн-0%, бусад-0%.

2016 онд БЗД-ийн 20-р хороо гэмт этгээдийг олж тогтоосон аргаар нь хэрэг бүртгэлд 66%, мөрдөн байцаалт 60%, гүйцэтгэх ажил 30%, цагдаагийн биечлэн 0%, иргэдийн мэдээлэл 0% шинжилгээний дүгнэлт 0%, эрэлч нохой 0%, гэмт этгээд өөрийн үйлдсэн хэргээ илчлэж ирсэн 0%, бусад 0%.

2017 онд БЗД-ийн 20-р хороо гэмт этгээдийг олж тогтоосон аргаар нь цагдаагийн албан хаагч эргүүлийн цагдаа 1 буюу 4%, мөрдөгч 20 буюу 83%, замын цагдаа 1 буюу 4%, хорооны цагдаа 2 буюу 8% байна.

2018 онд БЗД-ийн 20-р хороо гэмт этгээдийг олж тогтоосон аргаар нь мөрдөн байцаалт 25 буюу 56%, хэрэг бүртгэлт 19 буюу 44% байна.


График №6.31. Гэмт хэрэг үйлдэхэд ашигласан багаж зэвсэг, хэрэгсэл



2017 онд БЗД-ийн 20-р хорооны гэмт хэрэг үйлдэхэд ашигласан багаж зэвсэг хэрэгслээр нь авч үзвэл галт зэвсэг ашигласан 1 буюу 7%, тээврийн хэрэгсэл ашигласан 6 буюу 43%, хутга мэс ашигласан 4 буюу 29%, архины шил ашигласан 2 буюу 15%, мод чулуу ашигласан 1 буюу 7% байна.

2018 онд БЗД-ийн 20-р хорооны гэмт хэрэг үйлдэхэд ашигласан багаж зэвсэг, хэрэгслээр нь авч үзвэл галт зэвсэг ашигласан 1 буюу 11%, тээврийн хэрэгсэл ашигласан 2 буюу 22%, хутга мэс ашигласан 2 буюу 22%, олс дээс ашигласан 2 буюу 22%, архины шил ашигласан 1 буюу 11%, чулуу ашигласан 1 буюу 11% байна.

График №6.32. Гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөр




2015 онд БЗД-ийн 20-р хороонд үйлдэгдсэн гэмт хэргийг өдрөөр нь авч үзвэл даваа гаригт-14.2%, мягмар гаригт-13.4%, лхагва гаригт-18.4%, пүрэв гаригт-10.08%, баасан гаригт-16.8%, бямба гаригт-17.64%, ням гаригт-9.24% нь үйлдэгджээ.

2016 онд БЗД-ийн 20-р хорооны гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөр нь даваа гаригт-14%, мягмар гаригт- 10%, лхагва гаригт-19%, пүрэв гаригт-8%, баасан гаригт-17%, бямба гаригт- 18%, ням гаригт-14% нь үйлдэгджээ.

2017 онд БЗД-ийн 20-р хорооны гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөр нь даваа гаригт- 25 буюу 22%, мягмар гагритг-15 буюу 13%, лхагва гаригт- 16 буюу 18%, пүрэв гаригт-6 буюу 7%, баасан гаригт-16 буюу 14%, бямба гаригт-23 буюу 21%, ням гагритг-11 буюу 10% нь үйлдэгджээ.

2018 онд БЗД-ийн 20-р хорооны гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөр нь даваа гаригт-25 буюу 18%, мягмар гаригт-13 буюу 10%, лхагва гаригт-18 буюу 13%, пүрэв гаригт-15 буюу 11%, баасан гаригт-26 буюу 19%, бямба гаригт-17 буюу 13%, ням гаригт-21 буюу 16% нь үйлдэгджээ.

График №6.33 Гэмт хэрэг үйлдэгдсэн цагаар



2015 онд БЗД-ийн 20-р хороонд гэмт хэрэг үйлдэгдсэн цагаар нь авч үзвэл 06.00-14:00 цагийн хооронд-14.4%,14:00-19:00 цагийн хооронд-20.8%, 19:00-22:00 цагийн хооронд-15.2%, 22:00-06:00 цагийн хооронд-49.6% нь үйлдэгсэн.

2016 онд БЗД-ийн 20-р хороонд гэмт хэрэг үйлдэгдсэн цагаар нь авч үзвэл 06:00-14:00 цагийн хооронд 36%, 14:00-19:00 цагийн хооронд 31%, 19:00-22:00 цагийн хооронд 20%, 22:00-06:00 цагийн хооронд 13% байгаагаас үзэхэд өглөөний 06 цагаас өдрийн 14 цагийн хооронд гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байна.

2017 онд БЗД-ийн 20-р хороонд гэмт хэрэг үйлдэгдсэн цагаар нь авч үзвэл 06:00-14:00 цагийн хооронд 14 буюу 16%, 14:00-19:00 цагийн хооронд 38 буюу 27%, 19:00-22:00 цагийн хооронд 18 буюу 19%, 22:00-06:00 цагийн хооронд 43 буюу 38% нь үйлдэгдсэн байна.

2018 онд БЗД-ийн 20-р хороонд гэмт хэрэг үйлдэгдсэн цагаар нь авч үзвэл 06:00-14:00 цагийн хооронд 21 буюу 16%, 14:00-19:00 цагийн хооронд 37 буюу 27%, 19:00-22:00 цагийн хооронд 26 буюу 19%, 22:00-06:00 цагийн хооронд 51 буюу 38% нв тус тус үйлдэгдсэн байна.



2015 онд БЗД-ийн 20-р хороонд гэмт хэрэг үйлдэгдсэн газраар нь авч үзвэл гэрт 26%, хувийн байшинд 55%, зуслангийн байшинд 8%, хаусд 2%, амбаарт 2%, бусад газарт 6% үүнээс харахад гэмт хэргийг хувийн байшин болон гэрт ихэвчлэн үйлдэгддэг.

2016 онд БЗД-ийн 20-р хороонд гэмт хэрэг үйлдэгдсэн газраар нь авч үзвэл гэр, орон сууцанд үйлдэгдсэн байдлаар хувийн байшин 41.8%, гэр 34.8%, зуслангийн байшин 18.6%, агуулах 2.3%, бусад 2.3% байгаагаас үзэхэд хувийн байшин болон гэрт гэмт хэрэг их үйлдэгдсэн байна.

2017 онд БЗД-ийн 20-р хороонд гэмт хэрэг үйлдэгдсэн газраар нь авч үзвэл 133 гэр 17 буюу 12.7%, орон сууц 56 буюу 42.1%, хувийн байшин 18 буюу 13.5%, зуслангийн байшин 14 буюу 10.5%, амбаар 1 буюу 0.7%, агуулах 2 буюу 1.5%, ШТС 1 буюу 0.7%, хөдөө хээр 3 буюу 3%, бэлчээр 8 буюу 8%, гол усны ай сав 3 буюу 3%, олон нийтийн газар 12 буюу 9%, амралтын газар 12 буюу 8.2% байна.

2018 онд БЗД-ийн 20-р хороонд гэмт хэрэг үйлдэгдсэн газраар нь авч үзвэл 98 гэр 31 буюу 31.6%, орон сууц 1 буюу 1%, хувийн байшин 12 буюу 12%, зуслангийн байшин 21 буюу 21%, амбаар 1 буюу 1%, агуулах 1 буюу 1%, ШТС 1 буюу 1%, хөдөө хээр 3 буюу 3%, бэлчээр 8 буюу 8%, гол усны ай сав 3 буюу 3%, амралтын газар 15 буюу 15% байна.

График №6.35. Гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан




2017 онд БЗД-ийн 20-р хороо гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаанаар нь авч үзвэл архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ 3 буюу 4%, ашиг олох шунахайн сэдэлтээр буюу 92.9%, харуул манааны хариуцлагагүй шалтгаанаар 2 буюу 2.8% байна.

2018 онд БЗД-ийн 20-р хороо гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаанаар нь авч үзвэл архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ 5 буюу 6%, ашиг олох шунахайн сэдэлтээр 72 буюу 90%, мал хариулаагүй 2 буюу 2.5%, харуул манааны хариуцлагагүй шалтгаанаар 1 буюу 1.3% байна.


6.6. БЗД-ийн 20-р хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн зөрчлийн статистик

График №6.36 20-р хорооны нутаг дэвсгэрт сүүлийн 3 жилд үйлдэгдсэн зөрчлийн тоон үзүүлэлт




БЗД-ийн 20-р хороонд гарсан нийт зөрчлийн харьцаалалтаар 2017 онд 300, 2018 онд 411, 2019 онд 578 байгаа нь жил ирэх бүр өссөн үзүүлэлттэй байна.

График 6.37 БЗД-ийн 20-р хорооны нутаг дэвсгэрт сүүлийн 3 жилд үйлдэгдсэн зөрчлийн өссөн хувь



БЗД-ийн 20-р хороонд гарсан нийт зөрчлийн тоог өссөн дүнг авч үзвэл 2017 онд 23 хувь, 2018 онд 32 хувь, 2019 оны эхний 11-р сарын байдлаар 45 хувиар тус тус өссөн байна.

График №6.38. 20-р хорооны нутаг дэвсгэрт 2017 онд үйлдэгдсэн зөрчлийн төрөл




БЗД-ийн 20-р хороонд 2017 онд нийт 300 зөрчил бүртгэгдсэнээс бусдын биед халдах 25, худалдаа үйлчилгээний журам зөрчих 8, иргэдийн өмчийг хулгайлах 26 хууль бус мод бэлтгэх 1, гүтгэх 2, бусад 2, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 69, олон нийтийн амгалан байдлыг алдагдуулах 136 зөрчил бүртгэгдсэн байна.

График №6.39 БЗД-ийн 20-р хорооны нутаг дэвсгэрт 2018 онд үйлдэгдсэн зөрчлийн төрөл



БЗД-ийн 20-р хороонд 2018 онд нийт 411 зөрчил бүртгэгдсэнээс бусдын биед халдах 40, худалдаа үйлчилгээний журам зөрчих 6, иргэдийн өмчийг хулгайлах 33 хууль бус мод бэлтгэх, гүтгэх 2, бусад 56, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 165, олон нийтийн амгалан байдлыг алдагдуулах 109 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

График №6.40. 20-р хорооны нутаг дэвсгэрт 2019 онд үйлдэгдсэн зөрчлийн төрөл



БЗД-ийн 20-р хороонд 2019 онд гарсан нийт 578 зөрчил бүртгэгдсэнээс бусдын биед халдах 8, худалдаа үйлчилгээний журам зөрчих 5, иргэдийн өмчийг хулгайлах 59 хууль бус мод бэлтгэх, гүтгэх, бусад 166, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 148, олон нийтийн амгалан байдлыг алдагдуулах 110, хууль сахиулагчийн шаардлага эсэргүүцэх 1, малын хулгай 2 зөрчил бүртгэгдсэн өмнөх оноос өссөн үзүүлэлттэй.

График №6.41. 20-р хорооны нутаг дэвсгэрт сүүлийн 3 жилийн хугацаанд үйлдэгдсэн зөрчлийн төрөл





График №6.41 Бусдын биед халдах зөрчлийн тоон үзүүлэлт



БЗД-ийн 20-р хороонд 2017 бусдын биед халдах зөрчил 17 хувь, 2018 онд 26 хувь, 2019 онд 57 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байгаа нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг түлхүү зохион байгуулах, согтууруулах ундаагаар үйлчилдэг цэг газруудад тавих хяналтын сайжруулах шаардлага ажиглагдаж байна.





График №6.42 Худалдаа үйлчилгээний журам зөрчих зөрчлийн тоон үзүүлэлт

БЗД-ийн 20-р хороонд 2017 онд худалдаа үйлчилгээний журам зөрчих зөрчил-8, 2018 онд-6, 2019 онд 5 зөрчил бүртгэгдэж энэ төрлийн зөрчил буурсан үзүүлэлттэй байгаа нь харагдаж байна. Нөгөө талаар энэ төрлийн зөрчил буурсан шалтгаан нь

худалгаа үйлчилгээ эрхлэгчид хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаагаас шалтгаалж буурах боломжтой хэдий ч гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, бусдын биед халдах зэрэг зөрчлийн тоо өсөх хандлагатай байгаа хяналт тавих алба хаагчдын ажлын ачаалалыг нэмэгдүүлж, зөрчлийг илрүүлэх чиглэлээр бага ажил арга хэмжээ зохион байгуулсантай холбон авч үзэж болно.


График №6.43 Бусдын эд хөрөнгийг хулгайлах зөрчил



БЗД-ийн 20-р хороонд 2017 онд бусдын эд хөрөнгийг хулгайлах зөрчил-27, 2018 онд эд хөрөнгийг хулгайлах зөрчил-33, 2019 онд бусдын эд хөрөнгийг хулгайлах зөрчил-59 тус тус бүртгэгдсэн байна. Энэ төрлийн нийт зөрчлийн эзлэх хувийг оноор нь авч үзвэл 2017 онд 22 хувь, 2018 онд 28 хувь, 2019 онд 50 хувийг тус тус эзлэж байгаа нь энэ төрлийн зөрчил буурахгүй цаашид жил бүр 20-ээс дээш хувиар өсөх хандлага

ажиглагдаж байна. Нөгөө талаар энэ төрлийн зөрчил буурахгүй байгаа шалтгаан нь ажилгүйчүүдийн тоо 3016 буюу нийт хүн амын 37,7 хувийг эзэлжээ. Нөгөө талаар энэ төрлийн зөрчил буурахгүй байгаа шалтгаан нь иргэдийн сонор сэрэмж сул, амар хялбар аргаар санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх, мөнгө олох, амь зуух, архидан согтуурах, РС тоглоом тоглох зэрэг явдал газар авсан нь энэ төрийн зөрчил нэмэгдэх шалтгаан болжээ.


График №6.44 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил



БЗД-ийн 20-р хороонд 2017 онд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил-33, 2018 онд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил-56, 2019 онд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил-166 тус тус бүртгэгдсэн байна. Энэ төрлийн зөрчлийн эзлэх хувийг оноор нь авч үзвэл 2017 онд 13 хувь, 2018 онд 22 хувь, 2019 онд 65 хувийг тус тус эзлэж байгаа нь энэ төрлийн зөрчил буурахгүй цаашид жил бүр өсөх хандлага ажилаглаж байна. Нөгөө талаар энэ төрлийн зөрчил


буурахгүй байгаа шалтгаан нь гэр бүлийн харьцаа, жендерийн тэгш бус байдал, гэр бүлийн гишүүдийн эрх үүргийн таларх буруу төсөөлөл хандлага, үл ойлголцол, гэр бүлийн гишүүдийн аль нэг хүйсийн хүн давуу эрх эдлэх гэсэн санаа, зорилго, сэдэл, үйлдэл үг яриа гэх зэрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх шалтгаан болсон байна. Нөгөө талаар хүчирхийлэлтэй тэмцэх байгууллагуудын үйл ажиллагаа идэхижсэн, иргэдийн гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдлэг нэмэгдэж энэ төрлийн зөрчлийг хууль сахиулах болон бусад байгууллагад мэдээлэх хандлага өссөн нэмэгдсэн зэрэг нь энэ төрлийн зөрчлийг бүртгэх тоо харьцангуй олширжээ.

График №6.45. Танхайрах зөрчил



БЗД-ийн 20-р хороонд 2017 онд танхайрах зөрчил-136, 2018 танхайрах зөрчил-109, 2019 онд танхайрах зөрчил-110 тус тус бүртгэгдсэн байна. Энэ төрлийн зөрчлийн эзлэх хувийг оноор нь авч үзвэл 2017 онд 38 хувь, 2018 онд 31 хувь, 2019 онд 31 хувийг тус тус эзлэж байгаа нь энэ төрлийн зөрчил жил бүр буурах хандлагатай байгаа буурсан шалтгаан нь 2017 оны 7-р сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн Зөрчлийн тухай хуульд “Танхайрах” зөрчилд

хамааруулан бүртгэж байсан гэр үлийн хүчирхийллээс үүдэлтэй зөрчлийг шинээр 5.4-р зүйлд “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” зөрчлийг хуурьчлан тогтоосон нь танхайрах зөрчлийн эзлэх хувь буурах үндэс суурь болжээ.



БЗД-ийн 20-р хороонд 2017 онд бусад зөрчил-33, 2018 бусад зөрчил-56, 2019 онд бусад зөрчил-166 тус тус бүртгэгдсэн байна. Энэ төрлийн зөрчлийн эзлэх хувийг олон нийтийн газар зүй бусаар биеэ авч явах, тамхины хяналтын тухай хууль тогтоомж зөрчих, **Нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах зөрчил эзлэж байгаа бөгөөд 2019 оны эхний 11-р сарын байдлаар бусад зөрчил 2017 онд бүртгэгдсэн зөрчлийн зөрчлөөс 5 дахин, 2018 онд бүртгэгдсэн зөрчлөөс даруй 3-аас дахин их байгаа нь энэ төрлийн зөрчлийн хууль тогтоомжийн биелэлтэд сул нөгөө талаас хууль тогтоомжид тавих хяналтын**

үр нөлөөг дээшлүүлэх, ихээр үйлдэгддэг зөрчлүүдэд гол анхаарал хандуулахын зэрэгцээ үйлдэгдэж байгаа бусад зөрчлүүдэд анхаарал хандуулж нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах шаардлага харагдаж байна.

6.7.БЗД-ийн 20-р хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, түүнийг арилгах арга хэмжээ

6.7.1. Үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, түүнийг арилгах арга хэмжээ

Судалгааны ажлын хүрээнд тус хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг тогтоох зорилгоор 2019 онд тус цагдаагийн хэлтсийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн мөрдөгч нарын бичиж хүргүүлсэн нийт 203 албан мэдэгдэл шаардлагыг баримт бичиг судлах арга ашиглан судлаж дүн шинжилгээ хийсэн бөгөөд үүнээс түүвэрийн аргыг ашиглан БЗД-ийн 20-р хороонд үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар бичсэн 30 албан мэдэгдэл, шаардлагыг судлаж тус хороонд үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг тодорхойлов.

Хүснэгт № 6.5 Мэдэгдэл шаардлага гэмт хэргийн төрлөөр нь

№	Гэмт хэргийн төрөл	Мэдэгдлийн тоо
1	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	14
2	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг	4
3	Орон байрны хулгайн гэмт хэрэг	8
4	Мал хулгайлах гэмт хэрэг	2
5	Залилан мэхлэх гэмт хэрэг	2
6	Дүн	30

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн шалтгаан нөхцөл

Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг, ахуйн хүрээнд архи дан согтуурах, хувь хүний ёс суртахууны доголдол, гэр бүлийн таарамжгүй харьцаа, хорооны гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан багаас зохион байгуулах үйл ажиллагаа дутмаг.

Нөгөө талаар энэ төрлийн зөрчил буурахгүй байгаа шалтгаан нь гэр бүлийн харьцаа, жендерийн тэгш бус байдал, гэр бүлийн гишүүдийн эрх үүргийн таларх буруу төсөөлөл хандлага, үл ойлголцол, гэр бүлийн гишүүдийн аль нэг хүйсийн хүн давуу эрх эдлэх гэсэн санаа, зорилго, сэдэл, үйлдэл үг яриа гэх зэрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх шалтгаан болсон байна. Нөгөө талаар хүчирхийлэлтэй тэмцэх байгууллагуудын үйл ажиллагаа идэхижсэн, иргэдийн гэр бүлийн хүчирхийллийн талаарх

мэдлэг нэмэгдэж энэ төрлийн зөрчлийг хууль сахиулах болон бусад байгууллагад мэдээлэх хандлага өссөн нэмэгдсэн зэрэг нь энэ төрлийн зөрчлийг бүртгэх тоо олширсон зэрэг болно.

Нөлөөлж буй хүчин зүйл, хэрэгжүүлэх арга хэмжээ

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг зөрчил буурах байх нэг шалтгаан нь хүчирхийлэлд нөлөөлж буй хүчин зүйлийг бууруулах арга хэмжээг авах талаар ажил арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажил сул байгаатай холбон тайлбарлаж болох бөгөөд дор дурьдсан хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд:

- Хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохиож буй ажил нь төдийлөн бодит судалгаанд тулгуурлалгүй хийгддэг;
- Энэ төрлийн гэмт хэрэг зөрчил тэр дундаа гэр бүлийн хүрээн дэх хүчирхийллийн төлөв байдлыг бодитойгоор тогтоож, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга замыг оновчтой тодорхойлоогүй;
- Гэр бүлийн хүчирхийлэл нь нийгэмд болон хүмүүст ямар хор уршигтайг бүрэн ухамсарладаггүй. Энэ талаар зохиож буй ажил арга хэмээ нь магадгүй нийгэмд эрхийн талаарх хэт нэг талын ойлголтыг бий болгосноос улбаалж гэр бүлийн хүрээн дэх хүчирхийллийг улам дэвэргэх нэг хүчин зүйл болж байгааг үгүйсгэх аргагүй;
- Нийгэмд хулгай, дээрэм, булаалт, хүчиндэх, авилгын гэмт хэрэг аюултай, харин гэр бүлийн хүрээн дэх болон хүүхдийн эсрэг хүчирхийллийг нийгэмд ямар аюултайг үйл оошоох хандлага давамгайлсан, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил ямар ач холбогдолтойг ухамсарладаггүй. Бодит байдал дээр хүчирхийлэл, тэд дундаа гэр бүл дэх хүчирхийлэл нь цаашлаад бусад төрлийн гэмт хэг зөрчил үйлдэгдэх шалтгаан болж байгааг ухамсарладаггүй;
- Хүчирхийлэлд өртсөн хүмүүстэй ажиллах талаар анхаарлаа хандуулах нь зүйтэй, үр дүн нь шууд харагддаг боловч элдэв хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажил нь шууд үр дүн нь харагдахгүй боловч ямар ч талаараа ихээхэн ач холбогдолтой;
- Хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хоорондоо уялдаа холбоо муутай. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүрээн дэх хүчирхийлэл, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагууд хоорондоо хамтарч ажиллах уялдаа холбоо жигд бус;
- Хүмүүс мэдлэг, боловсролтой хүүхэдтэй болоход илүү анхаардаг болж гэр бүлийн хүмүүжлийг орхигдуулсан. Хүүхдийн хүмүүжил тэр дундаа хууль хүндэтгэн сахих, нийгэмшин амьдрах, эрх, үүргийн харилцан хамаарал, бусдыг болон өөрийгөө хүндэтгэх зэрэг зайлшгүй эзэмшвэл зохих сургалт зарим талаараа орхигдсон нь хүмүүст өөрийнхөө эрх ашгийг бусдаас дээр тавих, хүлээн зөвшөөрөхгүй бол хүч хэрэглэн тулгах хандлагыг төлөвшүүлэх гол хүчин зүйл болж байгааг анхаарч хүүхдэд багаас нь эерэг хандлага төлөвшүүлэх, бага насны хүүхдийн цэцэрлэг, ЕБС-ын боловсролын чиглэлд хүмүүжүүлэх үүргийг нэмэгдүүлэх;
- Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүд нь энэ төрлийн гэмт хэрэг ихээр гарч байгаа олон нийтийн газар, бар ресторан, зочид буудлууд зэрэг тухайн гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй газруудад тавих хяналтыг сайжруулах;
- Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүд дүүрэг, хорооны мэргэжилтэн, нийгмийн ажилтан, хэсгийн дарга, хэсгийн ахлагч нартай хамтран “Хөршийн холбоо” “Хөршийн хяналт”-ыг идэвхижүүлэх, архи дан согтуурч, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулдаг хүмүүсийн бүртгэл судалгааг шинэчилж, тэднийг хяналтад авах, хуулийн хариуцлага тооцох, холбогдох хууль тогтоомжийг судлуулж ойлгуулах ажлыг хэвшүүлэх;
- Урьдчилан сэргийлэх хэлтэс судалгааны байгууллагатай хамтран холбогдох газрууд, ард, иргэдээс санал авч, архи согтууруулах ундааны нийгмийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлон, улмаар архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг үйлчилгээ явуулдаг аж ахуйн нэгжүүдийн тоонд хязгаарлалт тогтоологдох, цагийн хязгаарыг шинэчлэх, цэгийн тоог багасгах талаар санал боловсруулж хүргүүлэн, шийдвэрийг хэрэгжүүлэх;

- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хор уршиг, оногдуулах хуулийн хариуцлагын талаар санамж, сэрэмжлүүлгийг ард иргэд, залуучуудад хэвлэл мэдээлэлээр болон зар сурталчилгааны хэрэгслүүдээр тогтмол явуулах.
- Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүд уул уурхай, барилгын ажлын улирал эхлэж байгаатай холбогдуулан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны заавар, журмыг хэрэгжүүлэх, иргэдийн эрүүл мэндэд хохирол учрахаас сэргийлэх чиглэлээр харьяа нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж буй холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдэд тусгайлан анхааруулсан мэдэгдэл хүргүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуула гэх мэт.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн шалтгаан нөхцөл

Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг, ахуйн хүрээнд архидан согтуурах, хувь хүний ёс суртахууны доголдол, хорооны хамтарсан багаас зохион байгуулах үйл ажиллагаа дутмаг.

хэрэгжүүлэх арга хэмжээ

- БЗД-ийн 20-р хорооны нутаг дэвсгэрт архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилдэг цэг газруудад хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавих;
- Архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэдэг иргэдэд чиглэсэн доривтой арга хэмжээг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран хэрэгжүүлэх;
- Хорооны нутаг дэвсгэрт урамшилт болон нийтийн эргүүлүүдийг тогтмол үр дүнтэй ажиллуулах;
- Залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах;
- Хорооны иргэдэд Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулийг сурталчилах ажлыг зохион байгуулах

Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөл

Гэр орон байраа олон хоноогоор харуул хамгаалалтгүй орхиж явах, хорооны нутаг дэвсгэрт урамшилт болон нийтийн эргүүлүүдийг хангалтгүй зохион байгуулсан, гэрүүлэг муу үзэгдэх орчин хязгаарлагдмал байдал зэрэг нь энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан нөхцөл болж байна.

Энэ төрлийн гэмт хэргийн гаралт, тоо, үйлдлийн арга, ашигласан техник хэрэгсэл, халдлагын зүйл зэргийг үндэслэн дараах шалтгаан нөхцөлийн улмаас энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байна хэмээн бид үзэж байна. Үүнд:

- Нийгэм эдийн засгийн тэгш бус байдал;
- Эд материалын хомсдол;
- Эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт тавих нийгэм, эрх зүйн хяналт сул;
- Шухайн сэдэлтэй гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтын хомсдол;
- Хулгайн гэмт хэргийг илрүүлэх бүртгэх, эрүүгийн хариуцлагад татах явцад хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд гарч буй алдаа дутагдал;
- Цалин хөлсний хэмжээ ялгаа;
- Хүн амын ажил эрхлэлтийн байдлыг үе шаттай шийдвэрлэх бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хангалттай биелэгдээгүй;
- Ядуучуудад тусламж үзүүлдэг төрийн болон төрийн бус байгууллагыг урамшуулах төрийн бодлогоор дэмжих ажил хангалтгүй зэрэг шалтгаан нөхцөл оршоор байна.

Түүнчлэн Нийгэм эдийн засгийн тэгш бус байдал нь шунхайн сэдэлтээр үйлдэгдсэн гэмт явдлын гаралтад нөлөөлдөг хэврээ хэрэгцээ ба гуйланчлал нь үүгээгүй ядуучуудыг гэмт хэрэгт түлхдэг бол нийгэм эдийн засгийн тэгш бус байдлаар нөхцөлдсөн баяжих гэсэн шунал нь чинээлэг хэсгийнхнийг гэмт хэрэгт илүүтэй түлхэж байдаг.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- БЗД-ийн 20-р хороо Туул фермийн хэсгийн гудамжийг харуулсан хяналт тавих камер байрлуулах, гэрэлтүүлэг нэмэх;

- Хорооны нутаг дэвсгэрт урамшилт болон нийтийн эргүүлүүдийг тогтмол үр дүнтэй ажиллуулах;
- Хулгайлах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх түүний хор уршигийн талаар ард иргэд ухуулга сурталчилгаа хийх, зах худалдааны төвүүдээр эргүүл шалгалт хийх;
- Тус хорооны нутаг дэвсгэрт оршин сууж байгаа ял тэнссэн, хорихоос суллагдсан хүмүүс, захиргааны хяналтанд байгаа хүн, тэнэмэл, орон гэргүй, өсвөр насны хүүхдүүдэд зэрэг субъектэд хяналт тавьж тэднийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх;
- Иргэд орон байрныхаа цонх, хаалга, тагт гэх мэтийг найдвартай цоожоор цоожлох, хамгаалалтын тор суулгах зэрэг болно.

Шунахайн сэдэлтэй гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр өнөөг дээшлүүлэхийн тулд эрх зүйн бүхий л харилцаанд авч үзэх шаардлагатай байна.

Иргэдэд аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд иргэдэд эн тэнцүү боломж олгосноор эдийн засгийн хувьд идэвхтэй ашиг сонирхлын бүлгүүд болон эд материалын хувьд чинээлэг хүмүүсийн тоог нэмэгдүүлдэг учир төрөөс хэрэгжүүлэх арга хэмжээ нь нийгмийн тэгш бус байдлыг арилгахад чиглэгдэх ёстой.

Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хүн амын нийгмийн хамгааллын арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэх тэднийг ядуурлаас болон эд материалын гачигдлаас гаргах явдал гэдгийг байнга санаж ажил арга хэмжээгээ төлөвлөх шаардлагатай.

Мөн тус хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн хууль бусаар бусдын орон байранд нэвтрэн орж бусдын эд хөрөнгө хулгайлах гэмт хэргийг хасанд хүрээгүй хүмүүс давтан үйлдсэн нь эцэг эх нь архины хамааралтай, хүүхдүүд хүчирхийллийн үл хайрхал хэлбэрийн хүчирхийлэлд удаа дараа өртсөн. Мөн эд материал хоол хүнсний дутагдал гачигдал нь энэ төрлийн гэмт хэрэг үйлдэх шалтгаан болжээ.

Мөн иргэд, аж ахуйн нэгж байгууллагын ажилтнуудын сонор сэрэмжгүй, хайхрамжгүй, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй хариуцлагагүй хандасан байдлууд нь гэмт хэрэг үйдэгдэх нөхцөл боломжийг бүрдүүлж байна.

Эцэг эх нь архичин эсхүл хойт эцэг эхийн хүчирхийллээс хүүхдүүд дайжиж гэмт хэриг үйлдэг хандлага давамгүйал байгааг анхаарч хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагуудтай хамтран ажиллах, үйл ажиллагаа идэвхижүүлэх шаардлагатай.

Нийслэл дүүргийн төр захиргаа, хууль хяналтын байгууллагууд, гадаад дотоодын зарим байгууллага, иргэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэнэмэл хүүхэд, орон гэргүй хүмүүс, хорихоос суллагсадын талаар чамгүй арга хэмжээ авч ихээхэн хөрөнгө зарцуулж байгаа боловч эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрүүдийг иргэд, нэгжийн удирдлагууд зохих ёсоор биелүүлэлдэггүй, тэдэнд хариуцлага тооцдоггүй явдал энэ төрлийн гэмт хэргийг бууруулахад саад болж ажлын үр дүнг бууруулж байна.

Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийг олон нийтийн газарт, иргэдийн орон байр, агуулах саванд, хувь нь байгууллага, аж ахуй нэгжийн байранд тус тус нэвтэрч үйлдэгдсэн байх ба аймаг дүүрэг дамжин үйлдэгдсэн, мал амьтаныг хашаа саравчнаас, бэлчээрээс, бэхэлгээ, цоож хаалгыг эвдэх, цонх, тагт, тооноор дамжин орон байранд нэвтрэх, халаас суйлах, цүнх, тор зүсэх, тээврийн хэрэгсэл ашиглаж, багаж хэрэгсэл ашиглах зэрэг аргуудыг хэрэглэн үйлджээ.

Иймд тус хороонд урьд өмнө нь хулгайлах гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэн, энэ төрлийн гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж байсан, одоо шалгагдаж байгаа этгээдүүдэд тавих хяналтыг сайжруулж үйлдлийн арга, халдлагын зүйл, үйлдэгдсэн цаг хугацаагаар нь адилтган гэмт хэрэг үйлдэж болзошгүй сэжигтэй этгээдүүдийн судалгаанаас түүвэрлэн авч шалгах ажлыг төрөл мэргэжлийн албад хамран зохион байгуулах.

Сүүлийн жилүүдэд үйлдэгдсэн хулгайлах хэргүүдэд судалгаа хийхэд гэмт этгээдүүд урьдчилан судалгаа хийгч, биечлэн гүйцэтгэгч, тээвэрлэгч, борлуулагч гэх мэтээр харьцангуй зохион байгуулалтанд орсон нь нэг биш удаа давтагдаж байгаа бөгөөд тэд харуул хамгалалт султай аж ахуйн нэгж, иргэд, амьжиргааны түвшин дээгүүр хүмүүс амьдардаг, эзэнгүй орон байрыг сонгон халдаж байгааг анхаарч энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж болзошгүй бүлэг этгээдүүд, үйлдэж байсан бүлэг бөөгнөрлийг хяналтандаа авах тэдний гэмт үйлдлийг илрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.

Мөн гэмт этгээдүүд бэлэн мөнгө валют, шашны эд зүйл, алт мөнгө үнэт эдлэл, авто машины сэлбэг хэрэгсэл, шатах тослох материал, барилгын материал, дархан мужааны цахилгаан багаж хэрэгсэл гэх мэтээр, хулгайлдаг эд зүйлээ төрөлжүүлэн дагнах байдалд орж энэ хэмжээгээр нийгмийн хор аюул, учруулах хохирлыг ихэсгэж байгаа ченж болон хувираа энэ төрлийн эд зүйл зарж борлуулдаг хүмүүс олширсон, тэдгээрт хяналт тавих эрх зүйн зохицуулалт сул байгааг анхаарал ажиллах.

Гэмт хэрэг үүнээс хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хор аюул, тоо хэмжээг буруулах, шалтгааныг арилгуулах талаар, эрх үүрэг бүхий байгууллага нэгдсэн бодлоготойгоор хөрөнгө, хүч хэрэгслээ нэгтгэн дараах арга хэмжээг хэрэгжүүлж болох юм.

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд, иргэн байгууллага, аж ахуй нэгжүүд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хүлээх үүргийг дэлгэрэнгүй оновчтой болгох, биелүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг чангатгах талаар нэмэлт оруулах саналыг хууль санаачлагчид хүргүүлэх;
- Цагдаагийн байгууллагын үүрэг бүхий алба, дүүрэг хороодын тухайн ажил хариуцсан ажилтны орон тоо, төсөв, цалин, хүч хэрэгслийг нэмэгдүүлэх;
- Тухайн дүүргийн нутаг дахь байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг өргөнөөр байнга оролцуулах, Ажлын байр, орон сууц бусад объектод гэрэлтүүлэг, дохиолол, камержуулалт хийсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг хөхүүлэн дэмжих;
- Архи, согтууруулах ундааг худалддаг, үйлчилдэг дэлгүүр, цэнгээний газруудыг цөөрүүлэх, зөвшөөрөл олгохдоо тэгээрийн байршил, өөр хооронд зайг зохистой байхаар зохицуулах, дурьдсан төрлийн бүтээгдэхүүнээр үйлчлэх, худалдах хугацааг богиносгож өдрийг цөөрүүлэх асуудлыг судлан ИТХТ-өөс урьд гаргасан шийдвэрээ дахин хянаж зохих шийдвэр гаргах, түүний хэрэгжилтэнд тавих хяналтанд иргэд, төрийн бус болон олон нийтийн байгууллагыг татан оролцуулах;
- Оршин суугч иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэл хаягжуулалтыг тухай бүр байнга хийх;
- Гэмт хэрэг үйлдэж болзошгүй болон ял шийтгүүлэгсэдийн суурьшил хөдөлгөөнийг хяналтанд бүрэн оруулах, хорихоос суллагдсан этгээдийг нийгэмшүүлэхэд төрийн бус болон гадаадын хөрөнгөөр төсөл хэргжүүлэгч байгууллагын хүчийг ашиглах боломжийг судалж зохих арга хэмжээ авах;
- Насанд хүрээгүй хүнийг тэнүүлэл, гуйланчлал, гэмт хэрэгт татан оруулагч эцэг эхэд хариуцлага хүлээлгэх тухай эрүүгийн хуулийн заалтыг хэрэгжүүлдэг болох.
- Гэмт явдал, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх болон бусад шаардлагатай хууль тогтоомжоор иргэн, байгууллага, аж ахуйн нэгж, тэнд ажиллаж байгаа ажилтан ямар эрх үүрэгтэй болохыг хүн бүрт хүргэх тэр нь байнгын шинжээтэй байхаар сургалт суталчилгааг зохион байгуулах, үүнд боловсрол, сургалт эрхэлдэг болон шүүх прокурор, мөрдөн байцаах, өмгөөлөх байгууллагын ажилтан, хуульчдын хүчийг нэгтгэн ашиглах;
- Гэмт хэрэг үйлдэгчдийн эдийн засгийн эргэлтийг хаах арга хэмжээ авах ломбард барьцаалан зээлдүүлэх газруудад тавигдах шаардлага, стандарт шалгуурын өндөрсгөх;
- Прокурор, мөрдөгчийн хэргийн шалтгаан нөхцлийг тогтоож түүнийг арилгуулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахуулах мэдэгдлийг зохих газарт тухай бүр хүргүүлэх, мэдэгдэл авсан байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага түүний мөрөөр тодорхой, үр нөлөөтэй ажил хийж энэ тухай хариуг заавал өгдөг байх, арга хэмжээ аваагүй, хариу өгөөгүй албан тушаалтанд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэдэг болох зэрэг болно.

Мал хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөл

Тус хороонд оршин сууж байгаа малчин иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг, малчин иргэд бүртгэл судалгаанд бүрэн хамрагдаагүй, малын им тамга жигд бус, малаа хариулаггүй олон хоногоор орхих, бэлчээрийн хомсдол, ажилгүй орлогогүй иргэдийн тоо өссөн, мал, махан бүтээгдэхүүний үнэ зах зээлийн ханш өссөн, амар хялбар аргаар санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх, ашиг хонжоо олох гэсэн хүмүүсийн гэмт сэдэл, зорилгод автсан хууль тогтоомжийг үл ойшоох хүмүүсийн сөрөг хандлага зэрэг нь энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан нөхцөл болж байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

Энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл нь эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулж буй ялын бодлого хөнгөдсөн, энэ нь уг гэмт хэргийг үйлдсэн этгээдэд дахин гэмт хэрэг үйлдэх нөхцөл бололцоо олгож байна.

Түүнчлэн орон нутаг, сумдын удирдах байгууллагын зүгээс харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд мал маллан амьдардаг ард иргэдэд холбогдох хууль тогтоомжийг мэдээллэх, сурталчлан таниулах, малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон этгээдүүдийг нийгэмшүүлэх, ажлын байраар хангах ажлыг шаардлагатай хэмжээнд зохион байгуулах ажил хангалтгүй байгаа байдал.

Нөгөө талаас малчид өөрийн өмчлөл, эзэмшлийн малаа бэлчээрт хариулаггүй олон хоног орхих, бэлэнчлэх сэтгэлгээндээ хөтлөгдөн амар хялбар аргаар мөнгө олох гэсэн шунхайн сэдэл давамгайлсан, зах зээлд өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн ялангуяа мал, махны эрэлт хэрэгцээ, үнэ нэмэгдсэн зэрэг нь мал хулгайлах үйлдэгдэх шалтгаан нөхцөл болсоор байна.

Энэ төрлийн гэмт хэргийг үйлдэхдээ бэлчээрт явсан малыг машин, мотоцикль ашиглан хулгайлах, мөн бүлэглэх болон урьдчилан тохиролцож бүлэглэн хулгайлж байгаа бөгөөд хулгайлсан малын дотор гойд ашиг шимтэй мал, хурдан удмын адуу байхаас гадна тухайн айлын амьжиргааг залгуулах гол эх үүсвэр болсон мал сүргийг хотыг нь харлуулан бүгдийг нь хулгайлсан хэрэг олноор үйлдэгдэж байна.

Иймд малын хулгайн гэмт хэрэгт ял шийтгэл оногдуулахдаа ял шийтгэлийн цээрлүүлэх ач холбогдлыг илүү анхаарах шаардлага зүй ёсоор гарч байгааг тэмдэглэж байна.

Хулгайлах гэмт хэрэг гарч байгаа шалтгааны нэг хэсэг нь ажилгүйдэл, ядуурал гэдэг. Үүнийг үгүйсгэх аргагүй. Гэхдээ ажил хийхийг үл хүсэгчид, бусдын бүтээсэн баялагийг завшигчид олширсон нь түлхүү шалтгаан болно.

Зөвхөн архи эсхүл масууруулах бодис худалдаж авахын тулд үгүй бол РС тогтоом тоглохын тулд хулгай хийж байгаа нь нэг бус удаа бүртгэгджээ. Эцэг эх, асран хамгаалагч харгалзан дэмжигч нар насанд хүрээгүй хүүхдийг хараа хяналтгүй орхих, тэднээр хулгай хийлгэх асуудал ч гарчээ.

Малын үнэлгээг тогтоохдоо тухайн орон нутгийн үнэ ханшийг харгалзахаас гадна уг малын удам, үүлдэр угсаа, хээлтэй эсвэл нялх төлтэй байсан зэргийг харгалзан ялгамжтай үнэлж байвал зохино.

Малын хулгайн гэмт хэргийн статистик тоон үзүүлэлт жилээс жилд ийнхүү өсөж байгаа болон энэ төрлийн гэмт хэргийг бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт хамааруулснаар, мал хулгайлсан гэмт хэрэгт шүүхээс оногдуулж байгаа ял шийтгэлийн байдлыг судлаж мал хулгайлсан хэрэгт баримтлах ялын бодлогыг оновчтой зөв тодорхойлох шаардлагатай байгааг анхаарч энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг оновчтой зохион байгуулах шаардлагатай.

Малын хулгайн гэмт хэрэгт шүүхээс оногдуулж байгаа ял шийтгэлийн бодлогыг сулруулахгүйгээр, энэ төрлийн гэмт хэрэгт шийтгүүлэгсдэд оногдуулах ялыг ялгамжтай, зөв тэнцвэртэй оногдуулах, хуулийн үндэслэлгүйгээр хавтгайруулан тэнсэх, ял хойшлуулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хуульд заасан ялын аль хөнгөн төрлийг сонгон хэрэглэх, зарим тохиолдолд олон

үйлдэлтэй их хэмжээний хохирол учруулсан хэрэгт хөнгөн ял шийтгэл оногдуулах, үйлдэл цөөнтэй, хохирлын хэмжээ бага гэмт хэрэгт хөнгөн ял шийтгэгдэх боломжийг таслан зогсоох, малын хулгайн хэрэгт ялын бодлого алдагдуулах хандлага гарч байгааг цаашид анхаарч засах.

Эрүүгийн хуулийн 17.12-т “Наймаас их бод, 24-өөс дээш тоогоор бог мал хулгайлбал хүндрүүлэх нөхцөлд тооцож, хорих ял, бусад тохиолдолд хорихоос өөр төрлийн ял ногдуулна” гэж заасан.

Наймаас бага бод, 24-өөс доош тооны бог хулгайлсан тохиолдолд нийтийн тустай хөдөлмөр эрхлүүлэх, зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял ногдуулахаар тусгажээ.

Үүнийг гэмт этгээдэд ял завших боломж олгосон, хийдэл зөрчилтэй байгаа нь ихэнх тохиолдолд шүүгч нар хохирлын хэмжээ их биш, хүндрүүлэх нөхцөлгүй хэмээн үзэж, нийгэд тустай хөдөлмөр эрхлүүлэх, эсвэл зорчих эрхийг нь хязгаарлах, торгох ял ногдуулахаар заасан тул ялын бодлогыг энэ төрлийн гэмт хэрэгт чангатган хорих ялаар шийтгэхээр тусгах шаардлага харагдаж байна.

Малын хулгайн гэмт хэргийн хохирлын хэмжээг тогтоохдоо тухайн орон нутгийн зах зээлийн үнэ ханш, хохирогч алдсан малаа хайхад зарцуулсан зардал, хулгайд алдсан мал хээлтэй, нялх төлтэй, ашиг шим ихтэй байсан зэрэг онцлог нөхцөл байдлыг харгалзан хохирол төлбөрийг гаргуулж байх.

Мал хулгайлсан гэмт хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүхийн практикийг жил бүр судлан үзэж дүгнэлт гаргаж ажиллах

“Мал хулгайлах буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.12 дугаар зүйлд заасан” гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөлийг тогтоогдсон судалгаанд дүгнэлт хийхэд нэг талаас мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд мэргэжилгүй, дийлэнх нь тодорхой эрхэлсэн ажилгүй, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой иргэд байх ба мөнгө олох, амьжиргаагаа залгуулах зорилгоор бусдын малыг хулгайлах гэмт хэрэг үйлдсэн байх бөгөөд яллагдагч нарын дийлэнх нь урьд нь хулгайлах гэмт хэрэгт 1-5 удаа ял шийтгэгдэж байсан нь мал хулгайлах нь зарим этгээдүүдийн хувьд амьдралын хэвшил, амьдрах арга хэрэгсэл болсон гэж үзэхээр байна.

Мал хулгайлах гэмт хэрэг далд хэлбэрт шилжиж зарим хүмүүсийн амьжиргааны эх үүсвэр болсонтой холбоотой сүүлийн жилүүдэд “махны ченж” гэж нэрлэгдэх хүмүүс малчдын гар дээрээс мал махыг өндөр үнээр авах, түүнчлэн орон нутгийн ажилгүй, малчин, архины хамааралтай залуучуудтай сүлжээ тогтоож, тэднийг шаардлагатай зүйлээр хангаж, улмаар гэмт хэрэгт татан оруулж, хулгайн малыг тэднээс хямд үнээр худалдан авдаг.

Малын хулгай гэмт хэрэг үйлдэж байгаа хүмүүс нь мал зүйн зохих мэдлэгтэй мал нядлах тал дээр мэргэшсэн байхын зэрэгцээ мал махны захиалга өгдөг газар хулгай хийх нөхцөл боломжийг судалдаг, мал хаана байгааг эзэнтэй эзэнгүй явж байгааг мэдээлдэг, малыг туудаг, нядалдаг, ачдаг, тээвэрлэдэг, зарж борлуулдаг гэх зэргээр сүлжээ үүсгэн зохион байгуулалтанд орсон байна.

Мал хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах урьдчилсан сэргийлэх ажил зохион байгуулуулахаар мөрдөгчийн бичсэн “мэдэгдэл” нь малаа хулгайд алдсан иргэний харьяалах нутаг дэвсгэрийн Засаг даргын нэр дээр бичдэг боловч сум, хорооны засаг дарга үүнд ач холбогдол өгдөггүй, алдагдсан мал нь хувь хүний өмч гэсэн байдлаар хайнга хандаж ямар ч ажил зохион байгуулдаггүй, мөрдөгчийн мэдэгдэлд ач холбогдолгүй хандлагаас энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төдийлэн ахиц дэвшил гарахгүй хүндрэл учруулж байна.

Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд, гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлж сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх шаардлагатай.

- Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сан” байгуулах ажлыг тогтмолжуулах түүнийг торгуулын орлого гарал үүслийн гэрчилгээ зэрэг орлогоос төвлөрүүлэн мал сүргийг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд зарцуулах;

- Мал хулгайлах гэмт хэрэг анх удаа болон удаа дараа үйлдсэн хүмүүсийг малчдад зарлан мэдээлж байх, гэмт хэргийн ангиллаас хамаарч мэдээллийг тодорхой жишиг үнэлгээ, урамшуулалтай болгож иргэдийн идэвхи оролцоог сайжруулах;
- Хэсэг бүрт малчдын сайн дурын холбоо байгуулах, малчдад мал бүхий иргэн бүр мал сүргээ өдрийн хариулгатай, шөнийн манаатай болоход хамтран ажиллах хүчээ нэгтгэх;
- Хорооны нутаг дэвсгэрт урамшилт болон нийтийн эргүүлүүдийг тогтмол үр дүнтэй ажиллуулах;
- Мал хулгайлах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх түүний хор уршигийн талаар ард иргэд ухуулга сурталчилгаа хийх;
- Малын хулгайн гэмт хэрэг үйлдэхэд ашигласан байж болзошгүй тээврийн хэрэгсэл бусад сэжигтэй тээврийн хөдөлгөөнд хяналт тавих, гэнэтийн хяналт шалгалт зохион байгуулах;
- Тус хорооны нутаг дэвсгэрт оршин сууж байгаа ял тэнссэн, хорихоос суллагдсан хүмүүст тавих хяналтыг сайжруулах;
- Малчидын хууль эрх зүйн мэдлгийг дээшлүүлэх, малчидыг бүртгэл судалгаанд бүрэн хамруулж, малын их тамгыг төрөлжүүлэн жигдлэх;
- Малын хулгайн гэмт хэрэг ихэвчлэн 10,11,12 саруудад идэвхиждэг тул энэ үер нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж түүнтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх зэрэг болно.

Залилан мэхлэх гэмт хэргийн шалтгаан нөхцөл

Залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэгдсэн гудамж гэрэлтүүлэггүй, иргэдийн хууль тогтоомжийн мэдлэг дутмаг, гэнэн итгэмтгий зан, ажилгүй орлоггүй иргэдийн тоо өссөн, төгрөгийн хаш унасан, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, амар хялбар аргаар санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх, ашиг хонжоо олох гэсэн хүмүүсийн гэмт сэдэл, зорилгод автсан хууль тогтоомжийг үл ойшоох хүмүүсийн сөрөг хандлага эцэг эхийн хараа хяналт сул зэрэг нь энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан болсон.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Хорооны нутаг дэвсгэрт урамшилт болон нийтийн эргүүлүүдийг тогтмол үр дүнтэй ажиллуулах;
- Тус хорооны нутаг дэвсгэрт оршин сууж байгаа ял тэнссэн, хорихоос суллагдсан хүмүүст тавих хяналтыг сайжруулах;
- Аж ахуйн нэгж байгууллагын камер, гэрэлтүүлэгийг сайжруулах;
- Гэмт хэрэг үйлдсэн У, А нарын эцэг эхийн хараа хяналтыг сайжруулах;
- Хорооны хамтарсан багаар авч хэлэлцэн, тэдний зүгээр дахин гэмт хэрэг зөрчилд холбогдуулахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Ажил хөдөлмөр эрхлүүлэх боломж нөхцлөөр хангах зэрэг болно.

Дээр дурьдсан “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх”, “хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”, “бусдын эд хөрөнгийг хулгайлах” /ороны байрны, малын хулгай/, “бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах” зэрэг гэмт хэргийн шалтгаан нөхцлийг тогтоож арилгуулах талаар тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь сайн талтай ч зарим гэмт хэргүүдийн шалтгаан нөхцлийг ерөнхий байдлаар тогтоосон, мэдэгдэл шаардлагын даалгавар хэрэгжүүлвэл зохих ажил арга хэмжээ нь гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгахад чиглээгүй байгааг анхаарч засаж залуурах нь зүйтэй хэмээн дүгнэж байна.

Иймд гэмт хэргийн шалтгаан нөхцлийг нарийн тодорхойлох, үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгахад чиглэгдсэн бодиттой ажил арга хэмжээг мэдэгдэл шаардлагад тусгах, дурьдсан ажил арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн эсэхэд хяналт тавих, хэрэгжүүлээгүй аж ахуйн нэгж байгууллагад шийтгэл оногдуулах арга хэмжээг үе шаттай зохион байгуулж хэвших.

Түүнээс гадна мэдэгдэл шаардлагын хариуг өгсөн байдлаас үзэхэд дийлэнх тохиолдол нь хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага, тухайн хороог харицсан хэсгийн байцаагч, хороон цагдаа нар мэдэгдэл шаардлагын хуриуг хүргүүлсэн байна. Харин хорооны

засаг дарга, иргэдийн хурлын төлөөлөгч, хорооны хамтарсан баг, хорооны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс Цагдаагийн байгууллага, алба хаагчийн хүргүүлсэн (мөрдөгчийн) мэдэгдэлд цөөн тоогоор хариу өгсөн нь энэ чиглэлд анхаарал бага хандуулж байгаа нь ажиглагдаж байна.

Гарал үүслийн гэрчилгээ олгох хуулийн зүйл заалт зөв бүрэн утгаар хэрэгжиж чадахгүй байгаа нь мал хулгайлах гэмт хэргийн шалтгаан болсоор байна. Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10-р зүйлийн 10.1-д "...сум дүүрэг, баг хорооны засаг дарга, мал бүхий иргэн аж ахуй нэгж, байгууллагаас төв суурин газарт борлуулах, худалдах, зорилгоор оруулж буй олон тооны мал маханд мал мах бэлтгэх гарал үүслийн гэрчилгээ олгоно"... гэж заасан. Үүний хүрээнд малын тооллогын "А" данс нь сум орон нутгийн багийн засаг дээр бүртгэгдэг бөгөөд гарал үүслийн гэрчилгээ олгоход "А" дансанд хасалт хийгдэж байх ёстой атал хасалт хийдэггүй, гарал үүслийн гэрчилгээг малын эмчийн гар дээрээс хяналтгүйгээр олгогдож байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх боломжийг нэмэгдүүлж байна.

6.8. БЗД-ийн 20-р хорооны нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр цаашид хэрэгжүүлэх ажил арга хэмжээ

6.8.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар

Тус хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахын тулд гэмт хэргийн тухай мэдээллийг судлах, гэмт хэрэг үйлдэгдэж байгаа шалтгаан нөхцлийг тогтоох, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх авч хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой төлөвлөх шаардлагатай.

Судлаач бид энэхүү судалгааны ажлын хүрээнд тус хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, гэмт хэргийн тоо, төрөл, ангилал зэргийг харгалзан үзэж гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд дараах ажил арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, хорооноос дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах төсвийн саналыг оруулах;

Хорооны онцлогт тохирсон үйл ажиллагааг үндэсний бусад хөтөлбөр, төслүүдтэй уялдуулан төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, иргэдийн идэвхтэй оролцоо, санаачлагад түшиглэн явуулах.

Хүнд нөхцөлд амьдарч байгаа болон нийгмийн эмзэг бүлгийн хүүхдийг /гэр оронгүй, эцэг, эхийн хараа хяналтаас гарсан, сургууль завсардсан, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж байгаа/ халамж, асрамжийн үйлчилгээ, дотоод, гадаадын санхүүжилттэй хөтөлбөр, төсөлд хамруулах ажлыг зохион байгуулах;

Хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгийн аливаа үйлдэл, гэмт халдлагад өртөхөөс сэргийлж тэдний өөрсдийн оролцоог дэмжин ажиллах, хүүхэд хүүхдэдээ туслах хөдөлгөөнийг өрнүүлэх, хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд анхаардаг, хүүхдийн эрхийн зөрчилгүй гэр бүл, сургууль, баг, хороо шалгаруулан сурталчлах, урамшуулан дэмжих;

Хөтөлбөрийн зорилго, явц хэрэгжилтийн талаар орон нутгийн радио, телевиз, сонин болон бусад арга хэлбэрээр сурталчлах, хамтран ажиллах, сургалт, зөвлөгөөн, уулзалт, өдөрлөг, уралдаан тэмцээнийг зохион байгуулах үр дүнг тодорхой хугацаанд тооцон холбогдох байгууллагуудад танилцуулж ажиллана.

Хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдэж буй гэмт хэргийг бууруулах зорилгоор хороо, дүүргийн иргэдийн хурал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд үндэслэл бүхий танилцуулга хүргүүлэн эрх зүйн акт гаргуулах. Үүнд:

- Тус хорооны малтай хэсэг бүрт сайн дурын малчин холбоо байгуулах тухай тогтоол гаргуулах;
- Аж ахуйн нэгж байгууллага, гэр хороолол, нийтийн эзэмшлийн зам талбайг камержуулах” тогтоол захирамж гаргуулах /энэхүү арга хэмжээг үе шат дараатай хэрэгжүүлэх тухай “аюулгүй амгалан гачуурт” гэх мэт төсөл хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх/;
- “school police”-ын үйл ажиллагаанд хяналт тавих комисс ажилуулах тогтоол, захирамж гаргуулах;
- Архи согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуйн нэгжийн цагийн хязгаарлалтыг тогтоох тухай тогтоол, захирамж гарган мөрдүүлж ажиллах;
- Иргэд оршин суугч аж ахуйн нэгж байгууллагын хамтарсан “урамшилт”, “нийтийн”, “сайн дурын эргүүл” арга хэмжээг хэрэгжүүлэх тухай тогтоол захирамж гаргуулж хэрэгжүүлж ажиллах гэх мэт.

6.8.2. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор малчдын сайн дурын бүлэг холбоодыг сумын төр захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах, мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгддэг цаг үеэр иргэд, олон нийтийн цагдаа, цагдаагийн туслах ажилтны хүч дэмжлэгийг авч автомашин, мотоциклтой болон морин эргүүлээр тодорхой зам маршрутын дагуу үзлэг шалгалт хийх ажилд мэргэжлийн туслалцаа үзүүлэн хамтарч ажиллах.

Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр иргэдийн өөрсдийн нь үүсгэл санаачилгыг өрнүүлэн “Малчин холбоо”, “Тавт, аравт”-ын систем гэх мэтээр хэсгийн байгуулан морин болон мотоциклтой эргүүлийг гардан ажилуулах.

Малын хулгай гарч болзошгүй газруудыг тодорхой хяналтанд авч эргүүлийн чиглэлийг зохион байгуулах.

Малын хулгайн гэмт хэргийн мэдээ, мэдээллийг иргэдээс авч шуурхай шийдвэрлэх.

Зэргэлдээх оршин төв аймгийн Эрдэнэ сумын хэсгийн төлөөлөгч, холбогдох албан тушаалтан, малчидтай мэдээлэл солилцох ажлыг зохион байуулах.

Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сайн дурын малчин холбооны үйл ажиллагааг эрчимжүүлэх, идэвхижүүлэх, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Адуучин тэмцээн зохион байгуулах, бод малыг чипжүүлэх, малын им тамгыг жигдрүүлэх гэх мэт арга хэмжээг хэрэгжүүлэх.

Жич энэхүү судалгааны тайлангийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл гэсэн 6.1-р хэсгийн мал хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөл гэсэн хэсгээс үзнэ үү!

6.8.3. Аж ахуйн нэгж байгууллага, гэр хороолол, нийтийн эзэмшлийн зам талбайг камержуулах ажлын талаар

Аж ахуйн нэгж байгууллага, гэр хороолол, нийтийн эзэмшлийн зам талбайг камержуулах ажлыг хэрэгжүүлж нийслэл, дүүргийн иргэдийн төлөөлөгчдын хурал, засаг дарга, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс гаргасан тогтоол захирамжийг биелүүлж тус хорооны гэмт хэрэг зөрчил үйлдэгдэж болзошгүй эмзэг цэг газруудад камерын хяналтын систем, гэрэлтүүлгэ тавих ажлыг үе шаттай зохион байгуулах.

Гэмт хэрэг зөрчил үйлдэгдэж болзошгүй цэг газруудыг камержуулах талаар төсөл хөтөлбөр боловсруулан төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.

Аж ахуйн нэгж байгууллагуудын камерыг нэг стандартад оруулж, ижил хүчин чадал бүхий хяналтын систем бүрдүүлж хяналтын нэг төвтэй байхаар зохион байгуулж, хяналтыг гэрээт харуул хамгаалалт болон цагдаагийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.

6.8.4. “school police” хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар

Нийслэлийн ИТХ-ийн 2015 оны 10-р сарын 16-ны 177 тогтоолоор “school police”-ын ажиллах журмыг баталсан бөгөөд судалгаагаар “school police”-ын ажиллах журмын 2.3-д заасан үүргийн хэрэгжилт сул байгаа нь ажиглагдаж байгаа тул энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавих орон тооны бус комисс томилж ажилуулах тогтоол, захирамжийн дагуу комиссын дарга, гишүүд тогтмол хяналт тавьж ажиллан сургуулийн орчимд үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээ авах.

Төрийн захиргааны байгууллагатай насанд хүрээгүй хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах хөтөлбөр боловсруулан, ерөнхий боловсролын сургуультай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Гурвалсан гэрээ” байгуулан гэрээнд заагдсан ажлын гүйцэтгэлийг гаргаж ажиллах.

Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд насанд хүрээгүй хүмүүс, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдаас үйлдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн байдалд судалгаа дүгнэлт хийж, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажлын санал боловсруулан Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлэх.

Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд багш, эцэг эхчүүд болон хүүхдийн өөрсдийн үүсгэл санаачлагын байгууллагуудын дэмжлэгийг авч ажиллах.

Ерөнхий боловсролын сургуулийн 6-8 дугаар ангийн сурагчдыг оролцуулсан “Өсвөрийн цагдаагийн бүлгэм”-ийг сургууль бүрт үүсгэн байгуулж, мэргэжлийн удирдлагаар ханган, тэдний оролцоотойгоор эргүүл шалгалтыг зохион байгуулах.

Хүүхэд хүүхэддээ туслах хөдөлгөөнийг сургуулийн захиргаатай хамтран зохион байгуулах.

Сурагчдыг гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрх ашиг хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоо нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран тухайн цаг үеийн нөхцөл байдал, нутаг дэвсгэрийн онцлогтой уялдуулан зохион байгуулах.

Гэмт хэргийн шалтгаан нөхцөл, хор холбогдол, урьдчилан сэргийлэх арга замын талаар баг хорооны ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан, арга зүйч багш нартай хамтран яриа таниулга, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах.

Хохирогч хүүхдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр хүүхэд залуучуудын байгууллага, ТББ, сургууль, багш, эцэг эх, асран хамгаалагч нартай хамтран ажиллах.

Орон гэргүй тэнэмэл, гэмт хэрэг зөрчил үйлдэж болзошгүй, сургууль завсардсан насанд хүрээгүй хүмүүсийн судалгаа гаргаж, тэдний асуудлыг шийдвэрлэх талаах орон нутгийн төр захиргаа, олон нийтийн байгууллагатай хамтран шат дараалсан арга хэмжээ авч ажиллах.

Архи согтууруулах ундаа үйлдвэрлэдэг, худалдаалдаг, үйлчилдэг цэг, аж ахуйн нэгжийн судалгаанд тулгуурлан, хүүхэдтэй холбоотой хуулийн заалтын хэрэгжилтэнд нутгийн захиргааны байгууллага, эцэг эх, иргэдтэй хамтарсан хяналтыг тавьж, илэрсэн зөрчил бүрд зохих арга хэмжээг авч ажиллах.

Хорихоос суллагдсан, ХӨТЯШ-тэй насанд хүрээгүй хүмүүсийг захиргааны хяналтанд авч хувийн хэрэг нээн, төр захиргааны байгууллага, сургуулийн нийгмийн ажилтан, багш, эцэг эхчүүдтэй тэднийг хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг хүүхэд нэгбүрийн онцлогт тохируулан төлөвлөж, хэрэгжүүлэх.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран сум багийнхаа хэмжээнд насанд хүрээгүй хүмүүс, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдаас зонхилон үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаар санамж сэрэмжлүүлэг, зөвлөмж боловсруулан тарааж, сурталчилах.

Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар байгууллага, аж ахуйн нэгж, их дээд болон ерөнхий боловсролын сургуулиудад мэдэгдэл шаардлага бичиж, хариуг авах, биелэлтийг шалгах

6.8.5.Архи согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих хэлбэр, урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах талаар

Архи согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуйн нэгжийн цагийн хуваарийг шинэчлэн тогтоох тухай тогтоол, захирамж гарган мөрдүүлж ажиллан согтуургаар үйлдэгдсэн гэмт хэргийг бууруулах, шөнийн цагаар архи согтууруулах ундаа худалдах, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн, 21 насанд хүрээгүй хүнд архи согтууруулах ундааны зүйл худалдах явлыг таслан зогсоох.

Архи согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хэрэгжилт, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх журмын биелэлт, үйл ажиллагаа явуулахад хориглосон газруудад хууль мөрдөгдөж байгаа эсэх зэрэгт хуульд заасны дагуу хяналт тавих.

Тус хорооны засаг захиргаа, төрийн болон төрийн бус байгууллага, их, дээд, ерөнхий боловсролын сургууль, аж ахуйн нэгж, иргэдэд Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг сурталчлан хуулийг мөрдлөг болгох талаар ажил зохиох.

Урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажилд төрийн болон төрийн бус байгууллагуудыг татан оролцуулж, зурагт хуудас, плакат, санамж, сэрэмжлүүлэг тараан, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад архидан согтуурахын эсрэг сургалтыг ойлгомжтой хэлбэрээр зохион явуулах.

Архи согтууруулах ундаагаар үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагыг тогтмол шалгаж, хууль зөрчсөн зөрчил дээр хуулийн дагуу арга хэмжээ тогтмол авч ажиллах.

Архи, согтууруулах ундаа нууцаар худалдан борлуулдаг, архины хамааралтай хүмүүсийн цуглардаг газруудыг эргүүлийн болон Цагдаагийн байгууллагын туслах хүчий хяналтанд байлгаж, гарч байгаа зөрчлийг цаг тухайд нь таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажил явуулж үр дүнг тооцох.

Тухайн аймаг, сумдад архидан согтуурсны улмаас ямар төрлийн гэмт хэрэг зонхилон гарч байгаад дүгнэлт хийж урьдчилан сэргийлэх чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулах.

Үйлдэгдэж байгаа гэмт хэргийг бууруулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран сургалт, сурталчилгааны ажил зохиох.

Аж ахуйн нэгж, байууллагууд, их дээд болон ерөнхий боловсролын сургуулиудад архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгааны ажил явуулах, сурталчилгаандаа архидан согтуурсны улмаас осгосон, хөлдсөн, гар, хөлөө тайруулсан, архидан согтуурахын хор хөнөөлийг харуулсан жигшүүлэх зурагт хуудас гэх мэтийг ашиглаж болно.

Гэмт хэрэг зөрчил үйлдэж болзошгүй, удаа дараа архидан согтуурч эрүүлжүүлэгддэг хүмүүст архинддонтонх өвчний зэргийг тогтоолгон сайн дурын болон албадан эмчилгээнд хамруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

Дүүрэг хорооны эрүүл мэндийн нэгдлийн наркологийн төвтэй хамтран архинд донтонх өвчний зэргийг тогтоолгон сайн дурын болон албадан эмчилгээнд хамруулах.

Эмчилгээнд хамрагдаад гарсаны дараа Засаг даргын Тамгын газартай хамтран ажлын байраар хангуулах ажлыг зохион байгуулах, санал оруулах.

Дээрх чиглэлээр дараах судалгаануудтай байна.

- Орчиндоо түгшүүр төрүүлж, бусдын амгалан тайван байдал алдагдуулдаг хүмүүсийн судалгаа
- Архидан согтуурсны улмаас архинд хордсон, осгосон, амиа хорлосон хүмүүсийн судалгааг нарийвчлан гаргах.
- Удаа дараа архидан согтуурч зөрчил гарган захиргааны журмаар баривчлагдсан хүмүүсийн судалгаа
- Архи хувиараа зардаг, архаг архичид цуглардаг, бөөгнөрдөг айл өрх, хүмүүсийн судалгаа
Тус хорооны иргэд оршин суугч, аж ахуйн нэгж байгууллагын хамтарсан “урамшилт”, “нийтийн”, “сайн дур”-ын гэх эргүүлийн үйл ажиллагааг тогтмолжуулан энэхүү судалгааны ажлын тайлангийн 6.3-д заасан олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

6.8.6.Нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн цагдаагийн ажилтан, урамшилттай эргүүл, жижүүрыг мэргэжлийн удирдлагаар тогтмол хангаж, ажлын үр дүнг тооцох.

- Нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчид нь хэсгийн төлөөлөгчдийн хувьд шадар туслах, хамтран ажиллагч байж өдөр тутам мэргэжлийн удирдлагаар хангагдан, мэдээллээр хангадаг, ялангуяа урамшилт болон нийтийн эргүүл, жижүүрийг зохион байгуулж, хяналт тавин удирдаж ажиллуулах.
- Олон нийтийн цагдаагийн ажилтан нь Монгол Улсын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Зөрчлийн тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Тамхины хяналтын тухай хууль, Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомж, эрх зүйн актыг хэрэгжүүлэх, иргэд оршин суугч, аж ахуйн нэгж, байгууллага хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, биелэлтийг хангуулах, илэрсэн зөрчилд эрх хэмжээнийхээ дагуу арга хэмжээ авч, нийгмийн хэв журам сахиулах ажлыг зохион байгуулах.
- Нийтийн эргүүлийг зохион байгуулахдаа тухайн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бүх байгууллага, аж ахуйн нэгжийг /Өмчийн хэлбэр харгалзахгүй/ эргүүлд гаргах хуваарь, графикайг гарган хорооны ИТХ, Засаг даргаар батлуулан шаардлагатай чиглэлд хуваарилан мэргэжлийн удирдлагаар ханган үр дүнг тооцох.
- Хариуцсан хорооны нутаг дэвсгэрийн онцлог, хүн амын нягтрал, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалдаа тохируулан олон нийтийн байцаагчийн тоог сумын иргэдийн хуралд оруулж тогтоолгох,
- Олон нийтийн цагдаа байцаагч, урамшилт эргүүлийг өдөр тутмын үүрэг чиглэлээр хангах, ажлыг зохион байгуулж үнэн зөв дүгнэх, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам бусад гарын авлага, материалаар хангаж өгөх.

6.8.7.Монгол улсын хууль тогтоомжийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад сурталчлах ажлыг зохион байгуулах

- Монгол улсын хууль тогтоомжийг сурталчлахдаа өдөрлөг, уулзалт, уралдаан тэмцээн, багийн хурал зэрэг иргэдийг олноор цугларсан үед хууль тогтоомжийг самбараар сурталчлах, хэсгийн төлөөлөгч тайлбарлан таниулах, ухуулах, сурталчлах хэлбэрээр явуулж болно. /Чанга яригч, радио узель, хуурцагийг ашиглах/
- Нутаг дэвсгэрийнхээ байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дунд “**Аялах дэвтэр**”-ийг аялуулах, “**Санал хүсэлтийн хайрцаг**”-аар тэдний санал хүсэлтийг авч иргэд цагдаагийн байгууллагаас ямар үйлчилгээ, тусламж, дэмжлэг авах “**Хэрэгцээг**” тодорхойлж түүний мөрөөр тодорхой ажил зохиох, авсан арга хэмжээ, зохион байгун ажлынхаа талаар эргэж хариу мэдэгдэх,
- Сум, багийнхаа хэмжээнд зонхилон үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаар санамж, зөвлөмж боловсруулан тарааж сурталчлах

6.8.8.Эрүү хэв журмын нөхцөл байдлыг үнэлэх талаар

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүн амын төвлөрөл, барилгажилт, хот төлөвлөлт, хотын амьдралын хэв маяг, нийгмийн ёс суртахууны доройтол, хотжилтыг даган эрчимжиж буй гэмт явдлын чиг хандлага, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөл зэргийг харьцуулан судалж цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээ онолын болон практикийн түвшинд тодорхойлж, ажиллах шаардлага зүй ёсоор тулгарсаар байна¹⁰.

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүн амын төвлөрөл, барилгажилт, хот төлөвлөлт, хотын амьдралын хэв маяг, нийгмийн ёс суртахууны доройтол, хотжилтыг даган эрчимжиж буй гэмт явдлын чиг хандлага, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөл зэргийг харьцуулан судалж цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээ онолын болон практикийн түвшинд тодорхойлж, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгааг сайжруулж, түүнд дүн шинжилгээ хийж түүний мөрөөр үр дүнтэй ажиллах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Цагдаагийн байгууллагаас хийх хариуцсан нутаг дэвсгэрийн объектын судалгааны бүрэлдэхүүн хэсэг болох “Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгаа” хийх ажлын эрх зүйн үндэсийг шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хуульд нарийн тодорхой зааж өгөөгүй боловч, энэхүү ажлын эрх зүйн үндэс нь цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үндсэн үүрэгтэй шууд холбоотойгоор хуульчлагдсан байна. Үүнд:

Шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хуулийн **18-р зүйлд** цагдаагийн байгууллагын судалгааны төв доор дурдсан чиглэлээр сан бүрдүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах, санал боловсруулах үүргийг хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх стандарт, дүрэм, журам, зааврыг боловсронгуй болгох, энэ зорилгоор хууль сахиулах үйл ажиллагаатай холбоотой сан бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх;

2. Гэмт хэргийн ул мөр илрүүлэх, буулган авах, бэхжүүлэх, нотлох, мөрдөн шалгах ажиллагааны арга тактикийг боловсронгуй болгох талаар;

3. Зам тээврийн осол, хэрэг болон насанд хүрээгүй хүнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар;

4. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах асуудлаар бодлого боловсруулах чиглэлээр дүн шинжилгээ хийж, цагдаагийн байгууллагыг мэдээллээр хангах;

5. Цагдаагийн төв байгууллагын даргын даалгасан бусад чиглэл судалгаа хийх¹¹ гэсэн заалт нь цагдаагийн байгууллага алба хаагч хариуцсан нутаг дэвсгэрийн хүн объектыг судалхаас гадна үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг судлах, нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг судлаж нөхцөл байдлаа үнэлэн үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлэх эрх зүйн үндэс бий болсон.

Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгаа гэдгийг бид дараах байдлаар тодорхойлж авч үзсэн.

Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгаа гэдэг нь:

Хариуцсан нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчлийн ангилал, төрөл, өсөлт, бууралт, үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн давтамж, үйлдэгдсэн өдөр гариг, цаг хугацаа, гэмт хэрэг зөрчлийн нягтаршил, гэмт халдлагын зүйл, хөндөгдөж буй нийгмийн харилцаа зэрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж байгаа шалтгаан нөхцлийг нарийн тодорхойлж хийсэн дүн шинжилгээ гэж бид тодорхойлж болохоор байна¹².

¹⁰ Цагдаа судлал сэтгүүл 2013 №3. 47 дахь тал

¹¹ Цагдаагийн албаны тухай хууль

¹² Г.Бямбадорж. Архидан согтуурах явдалтай тэмцэх үйл ажиллагаа, УБ хот 2013 он. 76 дахь тал

Мөн түүнчлэн хариуцсан нутаг дэвсэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгааг хийх нь дараах ач холбогдолтой байна. Үүнд:

- Үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн гаралтийг тодорхойлох
- Үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн ангилал, төрлийг тодорхойлох
- Үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нягтрал байршил тодорхойлох
- Үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн циклийг тодорхойлох
- Гэмт явдлын прогноз гаргах
- Гэмт явдлын шалгаан нөхцлийг тогтоох
- Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх
- Цагдаагийн байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой болгох
- Гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх ажлын алдаа дутагдлыг ирүүлж, арилгуулах
- Эргүүлийн нэгдсэн байшил, чиглэлийг оновчтой тодорхойлох
- Цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийх
- Цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа үнэлэлт өгөх гэх мэт ач холбогдолтой байна.

Цагдаагийн хэв журмын эргүүлийн төлөвлөлтийг судлан үзэхэд жилд хоёр удаа эргүүлийн чиглэл (эргүүлийн нэгдсэн байршил)-ыг шинэчлэн батлаж байгаа нь учир дутагдалтай оновчтой бус байгаа бөгөөд эргүүлийн чиглэл бүрийг тухайн чиглэлд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн байдал өөрөөр хэлбэл эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд тулгуурлах ёстойг орхигдуулснаас гудамж тайлбайд үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчил буурахгүй байх шалтгаан болсоор байна.

Тиймээс хэсгийн байцаагч, хороо сум хариуцсан цагдаа нар нь хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгааг сайжруулж, цагдаагийн хэв журмын эргүүл харуулын нэгдсэн байшилтыг батлуулах эргүүлийн чиглэлийг шинээр нэмэгдүүлэх, гэмт хэрэг зөрчлийн гаралт багатай эргүүлийн чиглэлийг цуцлах, уг чиглэлд ажиллах алба хаагчийн тоог цөөрүүлэх, гэмт хэрэг зөрчил байнга үйлдэгддэг, гэмт хэрэг зөрчлийн тоо өсөж байгаа нутаг дэвсгэрт эргүүлийн чиглэлийг нэмэгдүүлж эргүүлийн чиглэлд ажиллах алба хаагч нарын тоог нэмэгдүүлэх шаардлагатай.

Цагдаагийн байгууллагын мэдээлэл судалгааны алба үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн гаралт, гэмт хэрэг, зөрчлийн төрөл, өсөлт бууралт, хэрэг, зөрчлийн ангилал, халдаж буй нийгмийн харилцаагаар нь, гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаагаар сар бүр дүн шинжилгээ хийж байгаа ч энэхүү статистик мэдээг гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд төдийлөн ашиглахгүй байгааг өнөөгийн үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн тоо шинж байдлаас харж болно.

Бидний үзэж байгаагаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн байдалд дүн шинжилгээ хийж аль дүүрэг хороонд ямар төрлийн гэмт хэрэг өсөж байна тэр дүүрэг хороонд эргүүлийн чиглэл, хүн хүчийг түлхүү ажиллуулах, олон нийтийн цагдаагийн ажилтан болон сайн дурын цагдаагийн ажилтан ажлуулах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

Түүнээс гадна гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх арга хэлбэрийг сайжруулах үүднээс байгууллагын объектив шинжтэй дараах онол загваруудтай холбон авч үзье. Үүнд:

Хүрээлэн буй орчны онолыг АНУ-ын судлаач Бурнс болон Сталкер нар уг онолыг санаачилсан юм. Тэдний хувьд байгууллагуудын удирдагчид аливаа нөхцөл байдлыг сайтар судалж, “хүрээлэн буй орчныг нь сайтар унших буюу судлан” байж тухайн байгууллагад “тохирсон” бүтцийн загвар болон үйл ажиллагааг тодорхойлон сонгох ёстой гэж үздэг юм¹³

Иймээс энэхүү онолд үндэслэн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг судлахдаа орчныг сайтар судлаж түүнд тохирсон арга тактик, үйл ажиллагааг тодорхойлох боломжтой юм.

¹³ Larry K. Gaines, John L. Worrall, Police Administration, 2011. 124-139 дэхь тал

Нөөцийн хамаарлын онолыг үндэслэлтэй тайлбарлаж чадсан судлаачид бол Преффер болон Сланцик нар юм. Тухайн онолын үндсэн санаа нь аливаа агентлаг үйл ажиллагаа явуулахын тулд заавал хүрээлэн буй орчноос нөөц хэрэгслийг авах ёстой байдаг гэсэн үзэл юм. Энэ нь нөөц хэрэгслээс хэт хамааралтай байх нөхцөл байдлыг бий болгодог.

Нөөц хэрэгслийн хувиарлалтанд анхаарч хүрээлэн буй орчинг судлан хянаснаар агентлагуудыг захирч, улмаар тэднийг хүрээлэн буй орчноос хамааралтай болгодог гэж үзсэн¹⁴.

Өөрөөр хэлбэр эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг хянаж чадахгүй бол цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлаас хамааралтай болж зөвхөн түүнд тохирсон үйл ажиллагаа явуулж түүнийг хянаж чаддаггүй ба эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг хяналтандаа авсны дараа түүнээс хамааралгүй болж байгууллага амжилтанд хүрнэ хэмээн үзсэн байна.

Нөгөө талаар цагдаагийн байгууллага хүн хүч, чадавхаа нэмэгдүүлэх, нөөц хэрэгслийг хангах нь амжилтанд хүрэх чухал хэрэгсэл гэдгийг нотолжээ.

Хүн амын экологийн онолыг Герман Улсын эрдэмтэн Ханнан болон Фриман нар үндэслэсэн бөгөөд 1970-аад оны сүүл үеэс эхлэн газар авч эхэлсэн ба уг онолоор нэг чиг үүрэгтэй олон байгууллагууд өрсөлдөн хүн амын нягтаршил, газар нутгийн байрлал, түүний онцлог зэрэгт илүү анхаарал хандуулснаар байгууллагууд илүү их амжилтад хүрнэ гэдгийг тодорхойлох оролдлого хийжээ.¹⁵

Өөрөөр хэлбэл: Гэмт хэрэгтэй тэмцэх нэг чиг үүрэг бүхий нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага хариуцсан нутаг дэвсгэрийн хүн амын тоо, оршин суух иргэдийн нягтаршил газар нутгийн хэмжээ, байрлал онцлог зэргийг судлаж, дүн шинжилгээ хийх гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Мөн зэргэлдээ орших аймаг, дүүрэг, сум, баг, хорооны хүн амын нягтаршил, газар нутгийн байрлал, түүний онцлог зэргийг судлан мэдэж байх нь үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, гэмт этгээдийг эрэн сурвалжлах ажил явуулах зэрэг цагдаагийн байгууллагын чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэх үндэс болно хэмээн тайлбарлаж болох юм.

Иймд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгааг хийхдээ энэхүү онолыг иш үндэс болгон өөрийн хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг судлаад зогсохгүй зэргэлдээ орших аймаг, дүүрэг, сум, баг, хорооны хүн амын нягтаршил судалгааг хийх шаардлагатай.

Судлаач бид хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг судлахдаа дээр дурьдсан онолыг үндэслэл болгон нөхцөл байдлыг судлах дараах загвар байж болно гэж үзэж байна. Үүнд: Хүснэгтээр харуулав.

Хүснэгт №6.6. Нөхцөл байдлыг үнэлэх онолын загвар

д/д	Чиглэл	Хүрээлэн буй орчны хүчин зүйлс
1	Дотоод орчин	Цагдаагийн алба хаагчийн орон тоо, хүний нөөцийн бүрдүүлэлт Тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн судалгаа, тэдний үйл хөдлөл, үйлдэж буй гэмт хэрэг, зөрчил Гэмт хэрэг үйлдээд суллагдсан болон гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүдийн үйл хөдлөл, тэдний байдал Туслах хүч, сайн дурын ба олон нийтийн цагдаагийн ажлтны тоо, тэдний үйл ажиллагаа Үйл ажиллагаа, ажил арга хэмжээний үр дүн Сүүлийн үед үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчил тэдгээрийн шинж байдал

¹⁴ Larry K. Gaines, John L. Worrall, Police Administration, 2011. 124-136 дахь тал

¹⁵ Larry K. Gaines, John L. Worrall, Police Administration, 2011. 124-129 дэхь тал

		Эргүүлийн нэгдсэн байршил
2	Эдийн засгийн орчин	Эдийн засгийн өнөөгийн байдал Эдийн засгийн төлөв Эдийн засгийн уналт Эдийн засгийн өсөлт Үнийн хөөрөгдөл
3	Улс төрийн орчин	Улс төрийн төлөв байдал Улс төрийн тогтоортой байдал ЗГ-ын бодлого үйл ажиллагаа Эрх мэдэлтнүүдийн нөлөөлөл
4	Улс орны нийгмийн байдал	Ажилгүйдлийн тоо Ядууралын түвшин Архидалт Мансуурах явдал Биеэ үнэлэлт Үйлдвэр, аж ахуй эрхлэлт Нийгмийн халамжийн үйлчилгээ, тэтгэвэр тэтгэмж
5	Боловсрол мэргэжлийн байдал	Боловсролын тогтолцоо Иргэдийн боловсролын түвшин Гэмт хэрэг үйлдэгчидийн боловсролын түвшин Иргэдийн мэргэжил эзэмшсэн байдал Гэмт хэрэг үйлдэгчидийн мэргэжил
6	Үйл явдал	Байгалийн гамшиг, жагсаал цуглаан бослого тэмцэл, томоохон үйлдвэрлэлийн осол, олныг айдаст автуулсан хүнд, онц хүнд гэмт хэрэг аллага, мансууруулах боистой холбоотой гэмт хэрэг, хүний наймаа, зэрэг улс төр, нийгэм, эдийн засагт хор хохирол учруулсан гэмт хэргийн ертөнцтэй холбоотой үйлдэл, нэмэлт төсөв хөрөнгө шаардлагатай ажил арга хэмжээнүүд
7	Эрх зүйн орчин	Үндсэн хууль бусад хууль тогтоомж Үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж Тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам Эрх зүйн хамгаалалт бий болсон орчин
8	Хуулийн байгууллагуудын үйл ажиллагаа	Хуулийн хэрэглээ Урьдчилан сэргийлэх ажил ба нөлөөллийн арга хэмжээ Хуулийн байгууллагуудын үйл ажиллагаа ба шүүхийн мэтгэлцээн Торгох, хорих, эд хөрөнгө хураах, нийтэд тустай ажил хийлгэх зэрэг Эрүүгийн ял оногдуулалтын байдал Захиргааны шийтгэл ногдуулалт Ялтныг нийгэмшүүлэх ажил, түүний үр дүн Ялтныг хүмүүжүүлэх ажил, түүний үр дүн Өмгөөлөлийн үйл ажиллагаа Цагдаагийн байгууллага, алба хаагч нарын үйл ажиллагаа
9	Технологи	Үйл ажиллагаагааны ил тод байдал, цахим үйлчилгээний төрөл, хэлбэр шинжлэх ухааны ололт амжилт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээний ашиглалт шинэ арга, технологи
10	Бусад байгууллага нэгжийн үйл ажиллагаа	Үндсэн чиг үүрэг гүйцэтгэдэггүй алба нэгжийн үйл ажиллагаа, тэдгээрийн нөөц боломж Бусад агентлагууд байгууллагуудын үйл ажиллагаа Төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо

Эдгээр онолыг удирдлага болгохын зэрэгцээ эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг судлахдаа шинжлэх ухааны судалгааны аргуудыг өргөнөөр ашиглаж болно.

Цагдаагийн эргүүл нь зөвхөн хариуцсан нутаг дэвсгэрт эргүүлийн үүрэг гүйцэтгэх бус тухай нутаг дэвсгэрт оршин сууж байгаа гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүмүүс, гэмт хэрэг үйлдээд батлан даалтанд байгаа хүмүүс, хорих ял эдлээд суллагдсан, хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн зэрэг хүмүүст хяналт тавих зэргээр тэднийг дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэх, үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой болох тул эргүүлийн үүрэг гүйцэтгэж буй алба хаагч нарын үүргийг энэ чиглэлэд хандуулж ажилуулснаар эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг хянах боломжтой болно.

Мөн нутаг дэвсгэрийн хүн амын нягтаршил үйлдэгдэж буй гэмт хэргийн гаралтын тоо, хэргийн ангилал, үйлдлийн арга зэрэгт дүн шинжилгээ хийж шаардлагатай бол нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн хэсэг бий болгож ажилуулж болно.

Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг илааршуулахын тулд **street police** буюу Гудамж талбайд цагдаагийн алба хаагч нарыг оновчтой байрлуулж ажлуулах ёстой.

Нөгөө талаар гудамжид үүрэг гүйцэтгэж буй цагдаагийн алба хаагч нь цагдаагийн байгууллагын нүүр царай болж байдаг. Тухайлбал: Тэд олон нийттэй харилцаж, цагдаагийн байгууллагын бодлого, зорилтыг хэрэгжүүдэг.

Ингэхдээ тэд хоёр янзаар ажил үүргээ гүйцэтгэдэг. Үүнд:

(1) “Төрийн ажилтны эрх үүрэг гүйцэтгэх” буюу хууль дүрмийг сахиулах бодлогыг хэрэгжүүлж байгууллага, иргэдийг дагаж мөрдүүлэх.

(2) “Иргэний цагдаагийн үүрэг гүйцэтгэх” буюу хууль дүрмийг сурталчилж цагдаагийн үйл ажиллагаанд иргэд олон нийтийн татан оролцуулж, иргэдэд түшиглэх зарчмыг хэрэгжүүлэх гэсэн хоёр хэлбэртэй байдаг.

Хэдийгээр зарим нэг цагдаагийн алба хаагч нар дээрх хоёр хэлбэрийн нэг талыг илүү баримтлах нь элбэг байдаг ч, олонх нь аль алийг нь баримтлан ажил үүргээ гүйцэтгэдэг учир энэхүү хоёр хэлбэрийг ашигласан нь тодорхой үр дүнг үзүүлсэн байна.¹⁶

Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгааны статистик үзүүлэлтийн хэмжээнд хийгдсэн уламжлалт загварыг өөрчилж, шинжлэх ухааны онол, аргуудыг ашиглан эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгааг гарган хэсгийн байцаагч, төлөөлөгчийн объектын судалгааны төрөл болох эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгаанд түшиглэн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа төлөвлөх, үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчлийн гаралт, ангилал төрөл, гэмт хэрэг зөрчлийн нягтрал, гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй эмзэг цэгийг тодорхойлох, гэмт явдлын прогноз гаргах, гэмт явдлын шалгаан нөхцлийг тогтоох, гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх ажлын алдаа дутагдлыг ирүүлж, арилгуулах, эргүүлийн нэгдсэн байшил, эргүүлийн чиглэлийг оновчтой тодорхойлох, үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийх, гэмт хэргийн илрүүлэлтийн хувь хэмжээг нэмэгдүүлэх, цагдаагийн байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой тодорхойлох нөхцлийг бүрдүүлсэн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгааг хийж ашиглах шаардлагатай.

6.8.9.Орчин үеийн техник технологи ашиглах бодлогыг хэрэгжүүлэх талаар

Монгол Улс хууль сахиулах болон аюулгүй байдлыг сахин хамгаалах байгууллагуудынхаа тогтолцоо үйл ажиллагааг шинэчлэх талаар цөөнгүй ажил арга хэмжээ зохион байгуулж хууль сахиулах үйл ажиллагаанд инноваци нэвтрүүлэх усаг оролдлого хийсээр байна.

Монгол Улс хууль зүйн салбартаа инноваци нэвтрүүлж, эрх салбарын шинэтгэлийг эхлүүлж хэд хэдэн хуулийг шинээр батлан гаргасан ба үүний нэг нь 2017 онд шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хууль юм.

Уг хуулийн 62-р зүйлийн 62.6.2.цагдаагийн алба хаагчийн сургалт болон гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх бодлогын хэрэгжилтэд иргэний хяналтын зөвлөл хяналт тавихаар тусгасан бөгөөд цагдаагийн төв байгууллага, түүний харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас энэхүү заалтыг хэрэгжүүлж ажиллах шаардлага тулгасан.

Ийм учраас цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт явдлын шалтгаан, нөхцлийг тогтоох ажлыг тэргүүлэх чиглэл болгон тодорхойлж, гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй

¹⁶ Larry K. Gaines, John L. Worrall, Police Administration , 2011. 154 дэх тал

байдлыг хангах, нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагаанд “Secure alert” буюу цахим хянагч “Электрон гав”, Полиграф, GPS, Comp.stat, Crime mapping, CCTY зэрэг орчин үеийн smart системүүдийг нэвтрүүлж ашиглах зэргээр хууль сахиулах үйл ажиллагаанд иноваци хийх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

Монгол улсын хүн амд ноогдох цагдаагийн алба хаагчийн тооноос шалтгаалж гудамж тайлбай болон гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүдийг хянаж чадахгүй байгаа учир иргэдийн аюулгүй байдлыг хангахад нийт гудамж тайлбайг гэрэлтүүлэх, хянах, тогтолцоог сайжруулж, бүх гудамж талбай болон гэр хорооллыг цахилгааны шон дагуу камержуулах ажлыг зохион байгуулах.

Тус дүүргийн цагдаагийн хэлтэст байрлах хяналтын төвийг өргөжүүлж камеруудыг хянаж, эргүүлийн үүрэг гүйцэтгэх үүрэг бүхий цагдаа нарыг гэмт хэргийн талаар тогтмол мэдээллээр хангаж, гэмт хэрэг үйлдэгдэх магадлалтай харанхуй булан тохой, зэрэг гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй газрыг хяналтандаа авч гэмт хэргээс урьдчилан сэргийлж ажиллах.

Хяналтын систем нэвтрүүлснээр хаана гэмт хэрэг үйлдэгдэх бол гэсэн байдлаар гудамжаар үр ашиггүй холхих биш гэмт хэрэг гарсан болон сэжигтэй үйлдэл илэрсэн тохиолдолд газар дээр нь шуурхай очиж илрүүлэх боломжтой болно.

Нөгөө талаар гэмт хэрэг үйлдэгдсний дараа гэмт хэрэгтэнээ хайдаг биш, гэмт хэргийг газар дээр нь илрүүлдэг, гэмт хэрэгтэнтэй хөөцөлддөг биш гэмт хэргийг урьдчилан сэргийлж, таслан зогсоож чаддаг хууль сахиулагчид бий болно.

CCTV системийг нэвтрүүлснээр дараах ач холбогдолтой байна.

1. Гэмт хэрэгтэнээ хайхад үрэгддэг үр ашиггүй цаг хугацаа зардал хэмнэгдэнэ.
2. Иргэний амьд явах эрх болон аюулгүй орчинд амьдрах эрх баталгаажина.
3. Гэмт хэргийн гаралт багасаж, олон нийтийн газар гудамж талбайд үйлдэгддэг танхай, дээрэм бусад гэмт хэрэг эрс багасна.
4. Цагдаагийн алба хаагч нарын амрах цаг бага ч болов нэмэгдэнэ.
5. Цагдаагийн байгууллагын нэр хүнд өсөж бодит хяналтыг бий болгож чадна.
6. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь нэмэгдэх зэрэг олон ач холбогдолтой болно.

Мөн гэмт хэргийн тоо үзүүлэлтэнд дүн шинжилгээ хийдэг европын орнуудын цагдаагийн байгууллагад хэрэглэдэг “Comp.stat” системийг нэвтрүүлж ашиглах шаардлагатай байна. Анх 1994 онд АНУ-ын Нью-Йорк хотод цагдаагийн комиссар Уильям Браттон цагдаагийн хэлтсийн мэдээлэлд суурилсан удирдлагын загварыг танилцуулсан бөгөөд энэхүү загвар нь АНУ даяар маш хурдан тархаж энэ нь гэмт хэрэг бууруулахад чиглэсэн орчин үеийн менежментийн загвар болж чадсан байна¹⁷.

Comp.Stat загвар нь гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөл, стратегийн ач холбогдолтой асуудлыг шийдвэрлэх, тодорхой үйл ажиллагаанд анализ хийх, гэмт хэргийн гаралт, төрөл, гэмт хэрэг гарсан цэг бусад нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлоход ашиглагдаж байгаа мэдээ мэдээлэл, түүний үнэн зөв эсэхийг цаг хугацаанд нь дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлж байна.

Энэхүү нөхцөл байдлын үнэлгээн дээр тулгуурлан, тохирсон хариу арга хэмжээ авах, алба хаагч ажилтан болон нөөц хүчийг зохих газар хурдацтай байршуулах, байдлаар хэрэгжүүлж байна.

Comp.Stat загварын хүрээнд нь асуудлыг шийдвэрлэх, шинжилгээ хийх, хариуцлагын тухай олон давхаргат загварыг ашиглаж байна. Олон давхаргат загвар нь гэмт хэрэг бууруулах “стратегийн”-аас урт хугацааны асуудлуудыг хэрэгжүүлэх загвар юм¹⁸.

Иймд Comp.stat системийг тус дүүргийн цагдаагийн хэлтсийн үйл ажиллагаанд нэвтрүүлж ашигласнаар тухайн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдалд долоо хоног бүр дүн шинжилгээ хийж тухайн долоо хоногт үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэргийн төрөл, гэмт явдлын

¹⁷ <http://www.compstat.umd.edu>

¹⁸ <http://www.compstat.umd.edu>

шалтгаан нөхцөл, тохироо, гэмт хэрэг үйлдэгч, хохирогч, халдлагын зүйл зэрэгт дүн шинжилгээ хийж цаашид авах арга хэмжээг төлөвлөж ямар ямар гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байна түүнийг бууруулах урьчилан сэргийлэх үйл ажиллагаагаа оновчтой тодорхойлох, гэмт явдалд прогноз хийх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Өнөөгийн байдлаар тус дүүргийн цагдаагийн хэлтсийн мэдээлэл судалгаа хариуцсан алба хаагч нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт, гэмт хэргийн төрөл, өсөлт бууралт, хэргийн ангилал, халдаж буй нийгмийн харилцаагаар нь, гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаагаар сар бүр дүн шинжилгээ хийж байгаа ч энэхүү статистик мэдээг гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд ашиглахад төдийлөн үр дүнд хүрдэггүй байна.

Түүнчлэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаад “Crime mapping” буюу гэмт хэргийн зураглал үйлдэх системийг бүрэн ашиглаж болно.

“Crime mapping” буюу гэмт хэргийн зураглал нь: Гэмт хэрэг явдлын гаралт, төрөл, ангилалтыг зурагт төсөөлөн харах болон гэмт явдлыг шинжлэхийн тулд хууль сахиулах байгууллага ашигладаг систем юм.

Энэ нь гэмт хэрэгт дүн шинжилгээ хийх, цагдаагийн стратегийн Comp.Stat загварын нэг гол бүрэлдэхүүн хэсэг юм. “Crime mapping” буюу гэмт хэргийн зураглал үйлдэх системийг газар зүйн мэдээллийн систем (GIS) ашиглан бусад чиг хандлага, гэмт явдлын төлөв байдлыг шинжээчийн тусламжтайгаар тодорхойлж гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй цэгүүдийг тодорхойлох боломжийг олгодог систем юм¹⁹.

Энэхүү системийг ашигласнаар тухайн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийг зураглал дээр тусгай тэмдэглэлээр тэмдэглэж ямар гэмт хэрэг өссөн, аль дүүрэг хороонд хэд хэчнээн гэмт хэрэг үйлдэгдсэн, ямар төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байгааг аль ч үед (шаардлагатай үед) харж болох боломжтой бөгөөд энэхүү зураглалыг “Comp.stat системтэй хослуулан ашиглавал илүү үр дүнд хүрч болно.

Тэрчлэн 20-р хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн байдалд дүн шинжилгээ хийж аль хэсэгт ямар төрлийн гэмт хэрэг өсөж байна тэр дүүрэг хороонд эргүүлийн чиглэлийг түлхүү ажиллуулах, хяналтын системийг түлхүү ашиглах зэрэг үйл ажиллагаагаа сайжруулах ач холбогдолтой юм.

Түүнээс гадна цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагаанд “Secure alert” буюу цахим хянагч “электрон гав”, полиграф, GPS зэрэг орчин үеийн smart системүүдийг нэвтрүүлж түлхүү ашиглах шаардлагатай байна.

“Secure-alert” буюу цахим хянагч төхөөрөмжийг нэвтрүүлж ашигласнаар шүүгч, хамгаалалтанд байгаа гэрч хохирогч болон ял тэнссэн, гэрийн хорионд байгаа ялтан, батлан даалтан байгаа сэжигтэн, гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл үйлдэгчид зэрэг өндөр эрсдэлтэй гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй бусад хүмүүст зориулсан тусгай техникийн тусгай шийдэлтэй хүч хэрэглэдэггүй байрлал тогтоох GPS системийн тусламжтайгаар үр дүнтэй хяналт тавих төхөөрөмж юм.

GPS (Global positioning system) буюу дэлхийн хэмжээнд байрлал тогтоох системийг АНУ болон дэлхийн бусад улс орнууд өргөнөөр ашиглаж байгаа билээ. Уг системийг 2006 онд анхлан сэжигтний гаранд электрон бугуйвч зүүж, хэрэв байх ёстой газраас хэтэрвэл хиймэл дагуулаар дамжин удирдлагын компьютерт мэдээлэл өгөх байдлаар хэрэглэх болжээ.

Тус мужийн шүүхээс хэрэгтэнд уг бугуйвчийг зүүлгэх асуудлыг хуулиар зөвшөөрдөг бөгөөд одоо АНУ-ын хэд хэдэн мужид уг хууль үйлчилж эхэлсэн байна.

¹⁹ http://en.wikipedia.org/wiki/Crime_mapping.

Оклахомад GPS-ээр гэмт хэрэгтнийг хянах асуудлыг 100%-ийн саналаар баталсан бөгөөд. Энэхүү системийн бас нэгэн давуу тал нь хөрөнгө мөнгийг хэмнэдэг. Тухайлбал: Масачусетс мужийн цагдаагийн хэлтсийн дарга Паул Лүччигийн ярьснаар “Гэмт этгээдийг шоронд хориход жилд 30-40 мянган ам.доллар шаардлагатай. Харин GPS-ийг ашиглахад жилд 3400 ам.доллар л шаардлагатай гэсэн тооцоо гаргасан байдаг.

GPS системийг дээр дурьдснаас гадна гэмт хэрэгтэй тэмцэх ажилд дараах байдлаар ашиглаж болно. Үүнд:

- Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн захиргааны хяналтанд байгаа этгээдийг хянах;
- Бага насны хүүхдийг гэмт халдлагад өртүүлэхгүй байх. Нэн ялангуяа хүний наймаа, эд эрхтэний наймааны золиос болгохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор ашиглах;
- Тээврийн хэрэгсэл, үнэт эдлэлд суулгах;
- Бурхан, үзмэр, хосгүй үнэт зүйлс гэх мэт түүх соёлын дурсгалт болон бусад эд зүйл хулгайлагдахаас урьдчилан сэргийлэх, ийм төрийн гэмт хэргийг илрүүлэх;
- Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх зэрэгт ашиглаж болно.²⁰

Үүнээс гадна цагдаагийн байгууллагын гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагаанд ашиглаж байгаа гарын мөрний папилон сангийн системийг гэмт хэргийг түргэн шуурхай халуун мөрөөр нь илрүүлэх ажиллагаанд ашиглахад учир дутагдалтай байна.

Учир нь гарын мөрний адилтгалын шинжилгээ хийлгэхээр мөрдөгч тогтоол үйлдэж криминалистик шинжээч томилж олон шат дамжлага дамжиж шинжээчийн дүгнэлт гардаг. Шинжээчийн дүгнэлт нь шүүх хурал дээр тухайн гэмт этгээдийн хууль бус үйлдлийг нотлох баримт болон үнэлэгдэж байгаа ч гэмт хэргийг халуун мөрөөр нь илрүүлэх арга хэрэгсэл болгон ашиглаж чадахгүй байна.

Криминалистикийн шинжээч хэргийн газарт үзлэг хийх явцад тухайн газраас илрүүлж бэхжүүлсэн гарын дардасыг папилон санд байгаа хүмүүсийн гарын дардастай харьцуулах, гарын дардасаар хэн болохыг нь түргэн хугацаанд газар дээр нь тогтоодог зөөврийн адилтгалын системтэй болгох шаардлагатай байна.

Түүнчлэн хууль сахиулагч нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх нь иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх зэрэг хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

6.8.10. Иргэд олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагаа явуулах талаар

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаандаа шинэчлэл хийхгүйгээр өнөөгийн шаардлагын түвшинд хүрэхгүй нь ойлгомжтой байна.

Ийм учраас гэмт явдлын шалтгаан, нөхцлийг тогтоох ажлыг тэргүүлэх чиглэл болгон тодорхойлж, гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагаанд олон нийтийг өргөнөөр татан оролцуулж, “Secure alert” буюу цахим хянагч “Электрон гав”, Полиграф, JPS, Comp.stat, Crime mapping, CCTV зэрэг орчин үеийн smart системүүдийг нэвтрүүлж ашиглах зэргээр хууль сахиулах салбарт иноваци хийх шаардлагатай байна²¹.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 32-р зүйлд иргэд байгууллагыг татан оролцуулах хэлбэрийг заасан байна. Үүнд:

²⁰ Цагдаа судлал сэтгүүлийн 2013№3 47 дахь тал

²¹ Нийслэл хотын аюулгүй байдлыг хангахад төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа сэдэвт зөвөлгөөний эмхтгэл, УБ 2014. 6 дахь тал

32.1.1.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, байгууллагыг урамшуулах;

32.1.2.гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авах;

32.1.3.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн санал, санаачлагыг дэмжих;

32.1.4.төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд олон нийтийн хөндлөнгийн хяналтын тогтмол тогтолцоог бий болгох;

32.1.5.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах;

32.1.6.иргэдээс гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд оролцох баталгааг хангахаар заасан.

Мөн шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хуулийн 14.3.2-д “Цагдаагийн төв байгууллага нь олон нийтэд түшиглэсэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны бодлого, арга зүйг нэгтгэн зохион байгуулах” үүрэг хүлээсэн.

Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа буюу “Community oriented policing” анх удаа цагдаагийн албаны тухай хуульд хуульчилж олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагааг бэхлүүлэн тогтмолжуулах, хөгжүүлэх талаар заасан нь цагдаагийн байгууллагын “Олон нийтийн итгэл хүлээж иргэний дэмжлэгийг авах”, “төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэдтэй харилцан ажиллах” гэсэн зарчмыг хэрэгжүүлж ажиллах чухал заалт болжээ.

Гадаад орнуудын цагдаагийн байгууллага гэмт хэрэг, эрх зүйн зөрчилтэй тэмцэхдээ ард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ямар туслалцаа дэмжлэг авдаг талаар товчхон авч үзвэл.

Олон нийтийн цагдаа нь: АНУ-д 1994 онд Хууль сахиулах тухай хуульд олон нийтийн оролцоог бодлогоор дэмжих зорилгоор олон нийтийн цагдаагийн албыг бий болгож олон нийтийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, нийгмийн эмх замбараагүй байдал, олон нийтийн аюулгүй байдалтай холбоотой асуудал үүсгэж байгаа нөхцөл байдлыг нэн даруй шийдвэрлэх, олон нийтрүү чиглэсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хэв журам сахиулах үүрэгтэй орон нутгийн гишүүдтэй нягт хамтран ажиллахад гол анхаарлаа хандуулж байгаа цагдаагийн нэг стратеги юм²².

Сингапур улсын цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор цагдаагийн гэрээт ажилтан олноор ажиллуулж цалин олгодог. Мөн “Цагдаагийн фонд” байгуулан цагдаагийн ажилтан илүү цаг ажиллах, тэтгэвэрт гаргах, гачигдалтай үед нь туслах зэргээр зарцуулдаг.

Герман улсад тэнгисийн цагдаа, Оросын холбооны улс татварын цагдаатай бөгөөд тэд цагдаагийн бүрэлдхүүнд ордоггүй бөгөөд тусгай хуулиар үйл ажиллагааг нь зохицуулдаг.

Япон улсад цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг дэмжихтэй холбогдсон “Гэмт хэргээс сэргийлэх иргэний нийгэмлэг”, “Өсвөр үеийн өв тэгш хүмүүжлийн байгууллага”, “Галын аюулаас сэргийлэх сайн дурын байгууллага”, “Нутаг дэвсгэрийн иргэдийн холбоо”, “Хөршийн холбоо” болон эмэгтэйчүүдийн нийгэмлэг, ахмадын нийгэмлэг, худалдааны гудамжны эвлэл зэрэг олон байгууллагууд “бүх салбарт гэмт хэрэг, осол, зөрчлөөс сэргийлэх” үйл ажиллагаа явуулдаг байна.

Умард ирландын хэмжээнд цагдаагийн байгууллагатай 110 хүндэтгэх хороо хамтарч ажилладаг бөгөөд эдгээр нь сайн дурын үндсэн дээр байгуулагдсан байдаг.

Хорооны гишүүд 2 сард 1 удаа цугларч цагдаагийн дарга, хариуцлагатныг урьж гомдол, санал, мэдээллээ солилцдог бөгөөд цагдаагийнхан ихэнхи мэдээллээ тэднээс авдаг байна. Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын үр нөлөө цагдаагийн ажилд иргэн, байгууллага, аж ахуйн нэгжээс үзүүлэх туслалцаа,

²² n.wikipedia.org/wiki/Community_policing

тэдгээрийн хамтын ажиллагаанаас ихээхэн хэмжээгээр хамаардаг болохын дээрх улс орнуудын туршлага харуулж байна.

Шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хуульд олон нийтийн цагдаагийн ажилтны тоог хязгаарлаагүй нь сайшаалтай уг хуулийн 63.2-д “Аймаг, нийслэлийн Засаг даргаас Иргэний зөвлөл, цагдаагийн байгууллагатай зөвшилцөн гаргасан саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал олон нийтийн цагдаагийн тоог жил бүр тогтооно” гэж заасан нь аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд олон нийтийн цагдаагийн ажилтны тоог тогтоох эрх олгосон нь тухайн нутаг дэвсгэрээс сонсогдсон иргэдийн төлөөлөгчид оршин суугч иргэдийнхээ аюулгүй байдлыг хангах үүргээ хэрэгжүүлэх нэг баталгаа болжээ.

Нөгөө талаар аймаг, дүүргийнхээ иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хангахад олон нийтийн оролцоог хэрхэн яаж хангах нь аймаг нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас шалтгаалж байна.

Иймд дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хангаж олон нийтийн цагдаагийн ажилтны тоог урьд өмнө ажиллаж байсан хэв журам сахиулах олон нийтийн байцаагчаас илүү орон тоогоор буюу нэг хороонд-хоёр буюу түүнээс дээш олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллуулах боломжтой байна.

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаандаа байнгын мэдээлэлтэй байхын тулд олон нийтийн цагдаагийн ажилтан нь иргэд оршин суугчидтайгаа холбоотой байж иргэдэд үйлчилснийхээ хэрээр ард иргэдээсээ дэмжлэг туслалцаа авч хамтран ажиллах ажил хэрэгч холбоо тогтоох нөхцлийг бүрдүүлж ажиллах нь чухал юм.

Олон нийтийн цагдаагийн ажилтан иргэдээс мэдээлэл авч ажиллах нь нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг судлаж мэдэх цагдаагийн байгууллагын хэсгийн байцаагчийн ажилд туслаж хариуцсан нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчил, түүний шалтгаан нөхцөл үйлдэгдээд гэмт этгээд нь тогтоогдоогүй хэргийн төрөл, ангилал, тоо зэргийг нарийвчлан судлаж, гэмт явдлын хөдөлгөөн гаралт, гэмт хэрэг үйлдэгчид, гэмт хэргийн хохирогч, гэмт хэргийн шалтгаан нөхцөл зэргийг судлаж нутаг дэвсгэрийн нөхцөл байдлыг үнэлэж, гэмт явдлын прогноз гаргаснаар цаашид гэмт хэрэгтэй тэмцэх ямар үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай байгааг тодорхойлж, түүнийг цаг алдалгүй таслан зогсоох, илрүүлэх үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдэх юм.

Үүссэн нөхцөл байдлыг дагаж урьдчилан сэргийлэх ажлыг объектруугаа хандуулж хийнэ гэвэл амжилтанд хүрэхгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

Харин олон нийтийн цагдаагийн ажилтан, иргэдээс мэдээлэл цуглуулж бусад алба хаагч нарын хамт түүндээ дүн шинжилгээ хийж үүсэх нөхцөл байдлыг урьдчилан мэдэж түүний эсрэг арга хэмжээ авах нь бидний үйл ажиллагаа амжилтанд хүрнэ.

Гэмт хэрэг үйлдэгсдийн дотор орон нутгаас шилжин ирсэн тодорхой оршин суух хаяггүй, ажил сургуульгүй хүмүүсийн эзлэх хувийн жин өсч орон нутгаас нийслэлрүү шилжсэн хүн амын шилжилт хөдөлгөөний улмаас засаг захиргаа завсардагсад орлогын их үүсвэргүй иргэд бүлэг зохион байгуулалттай хэлбэрт шилжин хот хөдөөг дамжин гэмт хэрэг үйлдэх болсноор хүнд онц хүнд гэмт хэргийн илрүүлэлт эрүүгийн ба хэв журмын нөхцөл байдалд сөргөөр нөлөөлөх боллоо.

Иймд нутаг дэвсгэр хариуцсан алба хаагч, олон нийтийн цагдаагийн ажилтан нь тухайн нутаг дэвсгэрийн онцлог объект, гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээд, тэдний хань харилцаа, түр оршин суугч явуулын хүмүүсийн үйл хөдөлгөөнд нь анхаарлаа төвлөрүүлж тэднийг хяналтандаа авч онцгой анхаарч ажилвал гэмт хэрэгтэй тэмцэх, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил болон гарсан гэмт хэргийг илрүүлэхэд ихээхэн тустай.

олон нийтийн цагдааг ажлуулж байгаа бусад улс орны туршлагаас хархад олон нийтийн цагдаа нь сонирголоороо ажиллах бөгөөд олон нийтийн цагдаа, сайн дурын ажилтан гэсэн хоёр хэлбэртэй байдаг ба тэд урамшуулал авч ажилладаг байна. Иймд Цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа

олон нийтийн цагдаагийн ажилтан ажлуулахаас гадна сайн дурын цагдаагийн ажилтан болон иргэдийг ажлуулж болно.

Сайн дурын цагдаагийн ажилтнаар иргэд болон урьд өмнө нь цагдаагийн байгууллагад ажиллаж байсан эсвэл, ажиллаж байгаа амралттай, чөлөөнд гарсан цагдаагийн алба хаагчийг өөрийн хүсэлтээр нь сайн дурын цагдаагийн ажилтнаар ажилуулж болно.

Энэ тохиолдолд сайн дурын цагдаа нар албан үүрэг гүйцэтгэхдээ цагдаагийн эрхийг эдлэж дүрэмт хувцас, хамгаалах болон нэг бүрийн тусгай хэрэгсэлтэйгээр үүрэг гүйцэтгүүлж болно гэж үзэж байна.

Мөн эдгээр сайн дурын цагдаа болон иргэдийг эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал хүндэрсэн үед тухайлбал: Баасан, бямба, ням гаригуудад нэмэлтээр ажилуулж болно.

Шинэчлэн найруулсан цагдаагийн албаны тухай хуулийн 64-р зүйлд иргэдтэй хамтран ажиллах гэсэн зүйлийн 64.1-д “Цагдаагийн байгууллага нь нутгийн захиргааны болон төрийн бус байгууллага, иргэдээс зохион байгуулж байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажиллана”, 64.2-д “Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдийн туслалцаа, тэдний хамтын ажиллагаанд түшиглэн зохион байгуулна” гэж заасан нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа олон нийтэд түшиглэх, иргэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд оролцох эрх зүйн үндсийг тогтоожээ.

Ийм учраас иргэдийг тус цагдаагийн хэлтсийн үйл ажиллагаанд дор дурьдсан байдлаар оролцуулж болно гэж үзэж байна. Үүнд:

1.Гэмт хэргийн талаар мэдээлэл өгөх

- Гэмт хэрэгт хохирсон хүний талаар;
- Зөрчил гаргасан этгээдийн талаар;
- Эрэн сурвалжлагдаж байгаа хүний талаар;
- Тээврийн хэрэгсэл эзэмшигчийн талаар;
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналтад байгаа хүний талаар;
- Төрийн тусгай хамгаалалтад байгаа хүний талаар;
- Галт зэвсэг эзэмшигчийн талаар;
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн талаар;
- Орчиндоо байнга тааламжгүй байдал гаргадаг хүмүүсийн талаар;
- Бүлэг бөөгнөрөл үүсгэж байгаа хүмүүсийн талаарх мэдээлэх г.м.

2.Гэмт хэрэг, зөрчил гарах нөхцөл бүрдүүлэхгүй байх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах

- Иргэн өөрийн амьдарч буй орчин тойрондоо гэмт хэрэг үйлдэгдэх нөхцөл; бүрдүүлэхгүй байх талаар шаардлага тавих;
- Гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй газрын талаар мэдээлэл өгөх;
- Ийм нөхцөл бүрдсэн үед үйлдэгдэж болзошгүй газарт тусгай тэмдэглэл хийх; тусгаарлах зурвас татах г.м.

3.Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах талаар цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд оролцох

- Цагдаагийн байгууллагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон бусад зорилгоор зохион байгуулж байгаа төрөл бүрийн нэгдсэн, хэсэгчилсэн арга хэмжээнд оролцох;
- Жагсаал цугаан олон нийтийг хамарсан арга хэмжээний үед иргэд олон нийтийг мэдээллээр хангах, хууль бус үйлдэл хийхгүй байхыг ухуулан сурталчилах;
- Цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын болон техникийн арга хэмжээнд оролцох;
- Байгалын гамшиг, хүн малын гоц халдварт өвчин, үйлвэрлэлийн осол зэрэг гэнэтийн бусад аюул тохиолдсон үед хорио цээрийн дэглэм сахиулах;
- Иргэдийг нүүлгэн шилжүүлэх, иргэд байгууллагын эд хөрөнгө, улсын онц чухал объект хамгаалах үүрэг гүйцэтгэхэд оролцох г.м.

4.Олон нийтийн оролцоог хангах

- Иргэдэд цагдаагийн байгууллагатай хамтарч ажиллахын ач холбогдлыг ойлгуулах, хамтарч ажиллаж байгаа иргэдэд тохирсон урамшуулалыг тогтмол олгох;
 - Урамшуулалын хэмжээг нэмэгдүүлэх;
 - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг олон нийтэд таниулах, ухуулга сурталчилгааг сайтар явуулах;
 - Баяр ёслолын үеэр гэмт хэрэг, зөрчил ихэсдэг өдөрүүдэд иргэдийг сайн дураар нь ажиллуулах;
 - Ахлах ангийн хүүхдүүд болон оюутан залуучуудыг энэ ажилд татан оролцуулах;
 - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар төрөл бүрийн уралдаан тэмцээн зохион байгуулах;
- Иргэдээс гэмт хэргийн талаар мэдээ мэдээлэл төлбөртэй авах нь гэмт хэрэг илрүүлэх болон нуугдмал гэмт явдлыг илрүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх ажил иргэдийг татан оролцуулах чухал ажлын нэг юм.

Цагдаагийн байгууллага иргэдээс гэмт хэргийн талаарх мэдээлэлийг төлбөртэй авах ажил төв орон нутгийн цагдаагийн байгууллагын хэмжээнд харилцан адилгүй жигд бус байгаа нь гэмт хэргийн илрүүлэлт, нуугдал гэмт явдлыг илрүүлэх ажилд сөрөгөөр нөлөөлж байна.

Мөн тухайн жилийн цагдаагийн байгууллагын төсөвт “Гэмт хэргийн талаарх мэдээлэлийг төлбөртэй авахад зориулсан төсвийн хөрөнгө”- ийг тусгайлан төсөвт суулгаагүйгээс шалтгаалж энэхүү ажлын үр нөлөө дээшлэхгүй байх срөг тал ажиглагдаж бана.

Эцэст нь дүгнэхэд олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааг сайжруулахад шат шатны байгууллагууд нэгдсэн нэг зорилго чиглэлтэй ажиллах, иргэдийг цагдаагийн байгууллагатай хамтарч ажиллах хүсэл сонирхолыг нь нэмэгдүүлэх, гэмт хэрэгт зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд оролцож байгаа иргэдийг урамшуулах, урамшуулалын хэмжээг нэмэгдүүлэх, сайн дурын ажилтан бэлтгэх тал дээр анхаарах, энэ асуудалд бусад төрийн болон төрийн бус байгууллагуудыг татан оролцуулах нь зүйтэй гэж үзэж байна.

6.8.11.Дэд тайлангийн зөвлөмж

Энэхүү судалгааны ажлын хүрээнд Баянзүрх дүүргийн 20-р хорооны дэд бүтэц, гэмт хэрэг, зөрчлийн криминологи судалгаа, судалгааны ажлын дэд тайланд дурьдсан үр дүнг үндэслэн Баянзүрх дүүргийн 20-р хороо, дүүргийн, нийслэлийн засаг дарга, иргэдийн төлөөлөгчдийн хурал, дүүргийн цагдаагийн хэлтэст дараах зөвлөмж өгч байна. Үүнд:

Баянзүрх дүүргийн 20-р хорооны засаг дарга, иргэдийн төлөөлөгчдийн хуралд өгөх зөвлөмж

1. БЗД-ийн 20-р хорооны иргэдийн хууль эрх зүйн мэдлгийг дээшлүүлэх нь бүх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэс суурь болох учир хувь ялангуяа хүний хөгжил, ёс суртахуун, гэр бүлийн харьцаа, жендерийн тэгш бус байдал, гэр бүлийн гишүүдийн эрх үүргийн таларх буруу төсөөлөл хандлага, үл ойлголцол, гэр бүлийн гишүүдийн аль нэг хүйсийн хүний давуу эрх эдлэх гэсэн санаа, зорилго, сэдэл, үйлдэл үг яриа гэх зэрэг нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх шалтгаан болсоор байгааг FM, радио, facebook, цахим хуудас зэргийг ашиглан подкаст, яриа, таниулга, шторк хэлбэрээр эрх зүйн суртал ухуулга нэвтрүүлэг явуулж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх;
2. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж БЗД-ийн нутаг дэвсгэрт нэг цэгийн үйлчилгээний төв шинээр байгуулах;
3. Тус хорооны малтай хэсэг бүрт сайн дурын “Малчин холбоо” байгуулах тухай тогтоол гаргуулах саналаа дүүргийн иргэдийн хуралд танилцуулж тоглоол гаргуулж, малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр иргэдийн үүсгэл санаачлагыг өрнүүлэн малтай иргэдээс бага хэмжээний татаас авч уг хөрөнгөөр малчин холбооны гишүүдийг урамшуулах, морин эргүүл хийх, мал хариулах, тэдэнд дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагааны зардалд зарцуулах;

4. Цагдаагийн байгууллага, алба хаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулах талаар бичсэн мэдэгдэл, шаардлагын дагуу тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгах, бууруулах чиглэлээр ажил арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж үр дүнг тооцож ажиллах;
5. Нийслэл, дүүргийн засаг дарга, иргэдийн төлөөлөгчдын хурал, төрийн болон төрийн бус бусад байгууллагад нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон аялал жуулчлал, мал аж ахуйн, дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг чиглэлээр төрөл бүрийн төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэн иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авах.

Баянзүрх дүүргийн Цагдаагийн 3-р хэлтэст өгөх зөвлөмж

1. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлын тэргүүлэх чиглэлийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил болгон тодорхойлж шинэчлэн найруулсан Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нийцүүлэн тус хорооны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үүний тулд гэмт хэрэг, зөрчлийн талаарх нөхцөл байдлын судалгаанд түшиглэн хэрэгжүүлэх ажил арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, гүйцэтгэлийг үе үе болон гүйцэтгэлийн явцад, төгсгөл үе шатанд хянан шалгаж, алдаа дутагдлыг арилгуулах;
2. Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр иргэдийн өөрсдийн нь үүсгэл санаачилгыг өрнүүлэн, хөхүүлэн дэмжиж Малчин холбооны үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, тэднээс мэдээ мэдээлэл авах, солилцох, шалгах ажлыг түргэн шуурхай явуулах, энэ төрлийн гэмт хэргийг бууруулах чиглэлээр Төв аймгийн Цагдаагийн газар Эрдэнэ сум, Налайх дүүргийн засаг захиргааны нэгжтэй хамтран ажиллах;
3. Хорооны нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй эмзэг цэгүүдэд олон нийтийн цагдаа, урамшилт эргүүл, нийтийн эргүүл, сайн дурын эргүүлийн үүрэг гүйцэтгүүлэх, тэднийг байнга мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллан, цагдаагийн байгууллагаас зохион байгуулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж буй ажил, арга хэмжээнд оролцуулах;
4. Тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдэж тус хорооны нутаг дэвсгэрт оршин сууж байгаа ял тэнссэн, хорихоос суллагдсан, хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн хүмүүст тавих хяналтыг сайжруулж, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй эмзэг цэг газруудад хяналт тавих;
5. Аж ахуйн нэгж байгууллагуудын камерыг нэг стандартад оруулж, ижил хүчин чадал бүхий хяналтын систем бүрдүүлж хяналтын нэг төвтэй байхаар зохион байгуулж, хяналтыг ШУТ-тэй хамтран хэрэгжүүлэх.

Хүснэгт № 6.7 Камер шинээр байрлуулах цэг газрын санал

д/д	Байршил төрөл			Холболтын төрөл
	Газрын нэр	Уртраг	Өргөрөг	
1.	Туул-4-1а тоот	47°55'31.48"N	107°09'57.49"E	Агаарын шилэн кабель
2.	Туул-7-1-1 тоот	47°55'46.99"N	107°09'55.94"E	Агаарын шилэн кабель
3.	Хуандай Нүүрстийн доод адаг голын гарам	47°58'40.27"N	107°16'15.49"E	Агаарын шилэн кабель
4.	Хаундай-1-22 тоот	47°59'56.26"N	107°18'0.95"E	Агаарын шилэн кабель
5.	Арцат -1-88 тоот	47°57'9.87"N	107°14'23.98"E	Агаарын шилэн кабель
6.	Арцатбулаг	47°58'15.30"N	107°14'24.65"E	Агаарын шилэн кабель
7.	Арцат Цэмбэл	47°54'54.58"N	107°12'28.76"E	Агаарын шилэн кабель
8.	Арцат могойт Аварлын зар сүмийн зүүн жалга	47°54'0.05"N	107°12'19.88"E	Агаарын шилэн кабель

9.	Улаан эрэг Туул голын хамгаалалтын бүс	47°54'34.98"N	107°10'34.36"E	Агаарын шилэн кабель
10.	Хар хошуу Могойт дэнж	47°54'17.58"N	107°10'56.67"E	Агаарын шилэн кабель
11.	Гялалзах 2 дах гүүр	47°54'58.80"N	107°10'37.83"E	Агаарын шилэн кабель
12.	Гялалзах 1-р хэсэг-14-р гудамж	47°55'11.51"N	107°10'48.80"E	Агаарын шилэн кабель
13.	Улаан эрэг 1-р хэсэг 1-19 тоот	47°55'16.87"N	107°10'12.09"E	Агаарын шилэн кабель
14.	Баяндөхөм	47°55'45.54"N	107°8'57.41"E	Агаарын шилэн кабель
15.	10 айл-1-27 тоот	47°55'50.89"N	107°9'25.56"E	Агаарын шилэн кабель
16.	10 айл-2-39 тоот	47°56'16.63"N	107°9'36.89"E	Агаарын шилэн кабель
17.	Баядөхөм	47°55'48.36"N	107°8'33.90"E	Агаарын шилэн кабель

6. Шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хуулийн 62-р зүйлийн 62.6.2.Цагдаагийн алба хаагчийн сургалт болон гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх бодлого хэрэгжүүлэх талаар тусгасан бөгөөд үүний хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажилд цахим хянагч, GPS, Comp.stat, Crime mapping, ССТУ зэрэг орчин үеийн smart системүүдийг нэвтрүүлж ашиглах талаар санал хүргүүлж, хэрэгжүүлж ажиллах;
7. Шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хуулийн 14.3.2-д “Цагдаагийн төв байгууллага нь олон нийтэд түшиглэсэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны бодлого, арга зүйг нэгтгэн зохион байгуулах” үүрэг хүлээсэн бөгөөд үүний хүрээнд Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа буюу “Community oriented policing” үйл ажиллагааг хэрэгжүүлж, хөгжүүлэх, тогтмолжуулах ажлыг зохион байгуулах;

Баянзүрх дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд өгөх зөвлөмж

1. Дүүргийн Цагдаагийн хэлтэс, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, хорооноос дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах төсвийг батлах, шаардлагатай төсөвийн төсөөлөл холбогдох материалыг дээд шатны байгууллагад хүргүүлж, тэдний үйл ажиллагааг дэмжих төсөв, эд материалын асуудлыг шийдвэрлүүлэх;
2. Хүнд нөхцөлд амьдарч байгаа болон нийгмийн эмзэг бүлгийн хүүхдийг /гэр оронгүй, эцэг, эхийн хараа хяналтаас гарсан, сургууль завсардсан, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж байгаа/ халамж, асрамжийн үйлчилгээ, дотоод, гадаадын санхүүжилттэй хөтөлбөр, төсөлд хамруулах ажлыг зохион байгуулах;
3. Аж ахуйн нэгж байгууллага, гэр хороолол, нийтийн эзэмшлийн зам талбайг камержуулах, гэрэлтүүлэх талаар иргэдийн төлөөлөгчдын хурал, засаг дарга, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс шийдвэр гаргаж, тус хороог аюулгүйн баян бүрд бий болгох ажлыг төсөл хөтөлбөр боловсруулан төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;
4. НИТХ-ийн 2015 оны 12-р сарын 11-ны өдрийн тогтоолоор батлагдсан Нийслэлийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журмын 1.5-д Архи согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг дүүргийн үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэс олгох эрх шилжүүлэн авах санал хүргүүлэх;
5. Гэмт хэрэг ихээр үйлдэгдсэн өдөр тухайлбал Баасан, Бямба гаригт “Архигүй өдөр” болгох тогтоол гаргаж, биелэлтэд хяналт тавих ажлыг дүүргийн цагдаагийн газар, мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран зохион байгуулах.

6. Шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хуульд олон нийтийн цагдаагийн ажилтны тоог хязгаарлаагүй бөгөөд уг хуулийн 63.2-д “Аймаг, нийслэлийн Засаг даргаас Иргэний зөвлөл, цагдаагийн байгууллагатай зөвшилцөн гаргасан саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал олон нийтийн цагдаагийн тоог жил бүр тогтооно” гэж заасан нь учир оршин суугч иргэдийнхээ аюулгүй байдлыг хангах үүргээ хэрэгжүүлэхийн тулд олон нийтийн цагдаагийн тоог үе шаттай нэмэгдүүлэх;

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, засаг даргад өгөх зөвлөмж

1. Нийслэлийн цагдаагийн удирдах газар, Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтэс, дүүрэг, хороодын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аливаа арга хэмжээг хамтран зохион байгуулах, нэн тэргүүнд бусдын эд хөрөнгийг хулгайлах, залилан мэхлэж авах, булаах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зэрэг гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих гэмт хэрэг, зөрчлийг саармагжуулах, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэх мэт ажил арга хэмжээг хэрэгжүүлж, шаардлагатай эд материал, санхүүгийн эх үүсвэрийг бий болгох, зарим арга хэмжээний төсвийг тухай жилийн төсөвт суулгах гэх мэт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж ажиллах;
2. Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Монгол Улсын Их Хурлын 2013 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 23-р тогтоолоор баталсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд, хөгжүүлэх үндсэн чиглэл Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн баталсан 2017 оны 05-р сарын 12-ны өдрийн 2017-А/226-05 дугаартай албан даалгавар зэрэг эрх зүйн актыг үндэслэн тус хорооны дэд бүтэцийг хөгжүүлэх арга хэмжээг авч гачууртын ерөнхий ба хэсэгчилсэн төлөвлөлтийг хэрэгжүүлэх;
3. Тус хорооны мал аж ахуйг хөгжүүлэх хувийн хэвшил, мэргэжлийн холбоодын явуулж байгаа үйл ажиллагаа, санал санаачилгыг дэмжих, мал аж ахуйг хөгжүүлэх төсөл хөтбөр хэрэгжүүлэх, мал, мах, зарим түүхий эд, бүтээгдэхүүний улирлын хамаарлыг багасгах, мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүний валютын гадагш урсгалыг дотоодын үйлдвэрлэл рүү чиглүүлэх, мал мах бэлтгэлийн жижиг дунд үйлдвэрлэл бий болгох, мал аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлж, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрийг тус хороонд нэг бүс болгон хэрэгжүүлэх замаар ажлын байр бий болгох, малчин иргэдийн өрхийн оллогыг нэмэгдүүлэх;
4. БЗД-ийн 20-р хороо гарчууртыг амралт сувилал, аялал жуулчлал хөгжсөн бүс болгох төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, тус хорооны уугуул иргэдийн амралт сувилал, аялал жуулчлалын салбарт өрсөлдөх боломжийг нээж өгөх, тус хорооны иргэдэд энэ салбарт үйл ажиллагаа явуулах хөнгөлттэй зээл тусламж олгох, төсөл хөтөлбөрт хамруулах;
7. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 2015 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр уг хуулийн 7.8-д заасан Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газарт 00-06 цагт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно” гэсэн заалтыг хүчингүй тооцсон тул согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдлыг танилцуулж, хүчинтэйд тооцуулах санал гаргаж хүргүүлэх;
8. Нийслэлийн Засаг Даргын 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн А/609 дүгээр захирамжаар “Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний газруудын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг шөнийн 4 цаг хүртэл байхаар тогтоосон заалтыг хүчингүй болгож, шөнийн 00 цаг хүртэл хязгаарлалт тогтоох;
9. НИТХ-ийн 2015 оны 12-р сарын 11-ны өдрийн тогтоолоор батлагдсан Нийслэлийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих

журмын 1.5-д “Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг нийслэлийн Засаг дарга олгох бөгөөд нийслэлийн Засаг даргын эрх шилжүүлсэнээр дүүргийн үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэс, дагуул хотын Захирагч тусгай зөвшөөрлийг олгоно” гэж нэмэлт өөрчлөлт оруулж тусгай зөвшөөрөл олгох эрхийг дүүргийн үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэст шилжүүлэх;

10. Шинэчлэн найруулсан онцгой албан татварын тухай хуульд Согтууруулах ундааны үйлдвэрт худалдсан 1 литр спирт-1740 төгрөг, бүх төрлийн цагаан архи, ликёр, кордиал ба спиртлэг бусад ундаа 25 хүртэл хатуулагтай-3335 төгрөг, 40 хүртэл хатуулагтай-6670, 40 ба түүнээс дээш хатуулагтай-15000, бүх төрлийн пиво-350 төгрөгний албан татвар ногдуулахаар татварын хэмжээг бага тогтоосон заалтыг өөрчилж, тухайн үеийн ам долларын ханштай дүйцүүлж татвар ногдуулах нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргаж хүргүүлэх;

**БҮЛЭГ 7. “БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 8-Р ХОРООНЫ ЗАМ
ТЭЭВРИЙН ОСОЛ, ШАЛТГААН НӨХЦӨЛ”
СУДАЛГААНЫ ДЭД ТАЙЛАН**

Судалгааны дэд баг: Цагдаагийн сургуулийн Замын цагдаагийн
тэнхимийн эрхлэгч, цагдаагийн хурандаа Р.Мөнхбаяр,
магистрант нар хийж гүйцэтгэв.

7.1. Зам тээврийн ослын шалтгаан нөхцөл

Дэлхий нийтийн нас баралтын үндсэн шалтгаанд зам тээврийн осол, гэмтэл наймдугаар байр эзлэж, 15-29 хүртлэх насны залуучуудын амиа алдах үндсэн шалтгаан нь болж байна. Нэг жилд дэлхий нийтэд зам дээр 1,38 сая хүн амиа алдаж, зам тээврийн ослоос шалтгаалсан хохирол 500 тэрбум ам долларт хүрчээ.

Хэрэв яаралтай арга хэмжээ авахгүй бол 2020 он хүртэл зам тээврийн осол гэмтэл дэлхий дээр нас баралтын үндсэн шалтгааны тавдугаар байр хүртэл дээшлэх магадлал байгааг судалгаа харуулж байна.

Зам тээврийн ослыг бууруулах стратеги нэлээд улс оронд хэрэгжиж зам тээврийн нас баралтыг бууруулж чаджээ. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ), Дэлхийн банк (ДБ) 2009 онд “Дэлхий нийтийн зам тээврийн ослоос сэргийлэх тухай илтгэл” нийтэлсэн. Илтгэлд зам тээврийн ослын эрсдлийн үндсэн шалтгаан, урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ, зам тээврийн аюулгүй байдлыг сайжруулах зөвлөмж, мэдээлэл зэргийг багтаасан.

2010 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2011-2020 онуудад явуулах замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арван жилийн үйл ажиллагааны болон үндэсний, нийт түвшинд арван жилийн үйл ажиллагааг хянах зорилготой дэлхий нийтийн замын хөдөлгөөний байдлын тухай дараагийн илтгэлийг бэлтгэхэд уриалсан тогтоолыг нэгэн дугаар баталсан. Энэхүү илтгэл нь 2009 оны илтгэлд тулгуурласан, өөртөө нэлээд чухал чиглэлүүдийн нэмэлт мэдээллийг агуулсан. Түүнд дурьдсан мэдээллүүд нь арван жилийн хүрэн дэх арга хэмжээнүүдийн явцын хяналтын тайлангийн тулгуур нь болно. Илтгэлд дэлхий нийтэд зам тээврийн ослоос үүдэн амиа алдсан хүмүүсийн тоо буурахгүй, жил бүр ойролцоогоор 1,38 сая хүн амь эрсэдсэн тохиолдол бүртгэгдэж байна. Харин энэ тогтонгишихтой зэрэгцэн дэлхийд бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн тооны өсөлтийн 15%-тай нэг эхтэй болгон авч үзвэл зохилтой гэсэн байна.


Зам тээврийн осолтой холбоотой сөрөг үр дагаврыг бууруулах зорилгоор зам тээврийн осолд өртөгсдөд ослын дараах тусламжийг түргэн шуурхай үзүүлэх, эмнэлгүүдийн гэмтлийн тасгийн мэргэжилтнүүдийг зохих ёсоор мэргэшүүлэх талаар төлөвлөх нь чухал болохыг онцолсон. “Дэлхий нийтийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай” анхны илтгэлд зам тээврийн ослын үндсэн эрсдэлт хүчин зүйлүүд (хурд, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох, хамгаалах малгайн ашиглалт, хамгаалах бүс, хүүхдэд зориулсан аюулгүй суудал буюу хүүхдийг унагахгүй байх төхөөрөмж)-эд хамаарах бүгдийг багтаасан цогц хууль тогтоомж байхгүй тухай онцлон дурьдсан байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 163-р тогтоолоор “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийг баталсан байна. Уг хөтөлбөрт зам тээврийн ослын тоо болон ослоос үүдэлтэй нийгмийн эрсдлийг 50% бууруулах, суурин газрын болон хот хоорондын замын 50%-ийг камержуулах зорилт дэвшүүлсэн байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах явдал нь замын хөдөлгөөнийг зохицуулагч, жолоочийн үүрэг мэт алдаатай ойлголт байсан бөгөөд өнөө үед замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах гэдэг нь “Хүн-Тээврийн хэрэгсэл-Зам-Орчин” гэсэн харилцан уялдаа бүхий асуудлыг цогцоор нь шийдвэрлэх, шалтгаан нөхцөлийг бодитой, зөв тодорхойлох асуудал болоод байна.

Зам тээврийн ослын шалтгааны хүчин зүйлийн хамаарал:

График 7.1. **Европийн холбооны улсад**²³



Дээрх диаграммаас харахад АНУ-д замын нөхцөлөөс шалтгаалсан осол 35%, автомашинаас шалтгаалсан осол 12%, Европийн холбооны улсад замын нөхцөлөөс шалтгаалсан осол 28%, автомашинаас шалтгаалсан осол 8% байхад Монгол Улсад замын нөхцөлөөс шалтгаалсан осол 0,1%, автомашинаас шалтгаалсан осол бүртгэгдээгүй байна. Энэ нь Зам тээврийн ослын шалтгаан нөхцөлийг зөв тодорхойлж чадахгүй байгааг харуулж байгаа ба асуудлыг тодорхойлох мэдлэг, мэргэшил, хандлага дутмагаас болж байна. Зам тээврийн ослын шалтгаан, нөхцөлийн зөв тодорхойлоогүйгээс, урьдчилан сэргийлэх арга хэмжээг оновчтой зохион байгуулах боломжгүй юм. Иймээс “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-т заасны дагуу судалгаа, шинжилгээнд суурилсан замын хөдөлгөөн зохион байгуулалтын оновчтой зохицуулалтыг нэвтрүүлж, замын хөдөлгөөний зохицуулалтыг боловсронгуй болгох зорилго дэвшүүлэн энэхүү судалгааг гүйцэтгэлээ.

7.2. Тээврийн хэрэгслийн тоон үзүүлэлт

Монгол Улсын тээврийн хэрэгслийн бүртгэлийн санд бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн тоо 2018 онд нийт 970 818 болж өмнөх оныхоос 70 693 тээврийн хэрэгсэл буюу 7,8%-иар өссөн байна. Үүнээс 871 329 буюу 89,7%-ийг автомашин, 5,8%-ийг мотоцикл, 3,2%-ийг чиргүүл, 1,3%-ийг механизм тус тус эзэлж байна.


Нийт тээврийн хэрэгслийн 789 204 буюу 81,3% нь 10-аас дээш жил, 154 996 буюу 16% нь 4-9 жил, 26 618 буюу 2,7% нь 0-3 жилийн насжилттай байна.

4-6 жилийн насжилттай тээврийн хэрэгсэл өмнөх оныхоос 5 128 буюу 12%- иар буурч, 0-3 жилийн насжилттай тээврийн хэрэгсэл 7 778 буюу 41,3%, 7-9 жилийн насжилттай тээврийн хэрэгсэл 23 898 буюу 25,6%, 10 болон түүнээс дээш жилийн насжилттай тээврийн хэрэгсэл 3 944 буюу 0,5%- иар тус тус өссөн байна.

²³ <https://www.tii.ie/tii-library/road-safety/Road%20Safety%20Research/Collision-Contributory-Factors.pdf>

2018 онд нийт 871 329 автомашин бүртгэлтэй байгаагаас 407 391 буюу 46,8% нь зүүн талдаа жолооны хүрдтэй, 463 938 буюу 53,2% нь баруун талдаа жолооны хүрдтэй байна.

График 7.2. Шинээр бүртгэгдсэн автомашины жолооны хүрдний байрлал:



Баруун талдаа жолооны хүрдтэй автомашины тоо өмнөх оныхоос 13,1%-иар, зүүн талдаа жолооны хүрдтэй автомашины тоо 0,7%-иар тус тус өссөн байна.

Улаанбаатар хотод бүртгэлтэй автомашины тоо 501925 буюу нийт автомашины 57,6%-ийг эзэлж байна. 2018 онд Улаанбаатар хотод бүртгэлтэй автомашины тоо өмнөх оныхоос 1,4%-иар буурсан үзүүлэлттэй байна.

2018 онд Монгол Улсад бүртгэлтэй нийт 970 818 тээврийн хэрэгслээс техникийн хяналтын үзлэгт 634 669 буюу нийт тээврийн хэрэгслийн 65,3 хувь нь хамрагдсан байна. Олон жилээр техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй, татвар төлөөгүй болон хаяг тодорхойгүй автомашинуудыг бүртгэлээс хассан байна. Монгол Улсын хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар 970,8 мянган тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн байна. Эдгээр тээврийн хэрэгслээс техникийн хяналтын үзлэгт 634,7 мянга буюу 65,3% нь хамрагдсан байна. Үүнээс үзэхэд нийт хүн амын 5 хүн тутамд 1 тээврийн хэрэгсэл ногдож байна. Импортоор 64039 суудлын автомашин оруулж ирсэн нь сүүлийн жилүүдийнхээс хамгийн өндөр үзүүлэлт болж байгаа бөгөөд энэ нь тээврийн хэрэгслийн тоог хурдацтайгаар өсөхөд нөлөөлж байна.

6.3. Зам тээврийн ослын талаарх мэдээлэл

Улсын хэмжээнд болон нийслэл, дүүргийн хэмжээнд хүн ам²⁴ болон автомашины²⁵ өсөлтийг 3-н жилээр харуулбал:

Хүснэгт 7.1

№	Нийслэл дүүрэг	Хүн ам /мян/			Автомашин /мян/		
		2016	2017	2018	2016	2017	2018
1	Улаанбаатар	1380,8	1417,4	1444,7	459032	471994	501934
2	Баянзүрх	327,1	336,9	343,6	91023	109369	106676
3	Баянгол	214,3	221,4	226,9	67658	85959	81336
4	Сүхбаатар	136,6	138,0	145,3	46906	67859	55490
5	Сонгинохайрхан	315,8	322,5	321,2	56851	87147	65283
6	Хан-Уул	159,5	169,7	178,9	34444	52487	44757
7	Чингэлтэй	158,0	159,0	157,3	36324	54617	40538

Улаанбаатар хотод нэг автомашинд 2,9 хүн ногдож байна. Автомашины тоогоор Баянзүрх дүүрэг тэргүүлж Баянгол, Сонгинохайрхан дүүргүүд удаалж байгаа боловч нэг автомашинд ногдох тоогоор өөр дүн харагдаж байна. Энэ тоог гаргасанаар үйлдвэр, үйлчилгээ болон орон сууцны зогсоолын талбайг төлөвлөхдөө харгалзан үзэх үзүүлэлт болдог. Нэг автомашинд ногдох хүн ОХУ-д 2,7, БНСУ-д 1,98, Япон улсад 1,6, БНХАУ-д 4,8 байдаг байна.

²⁴ Нийслэлийн статистикийн газрын сайт

²⁵ Монгол Улс дахь Зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт

Хүснэгт 7.2

№	Нийслэл дүүрэг	Хүн/авто	байр
1	Улаанбаатар	2,9	
2	Баянзүрх	3,2	III
3	Баянгол	2,8	II
4	Сүхбаатар	2,6	I
5	Сонгинохайрхан	4,9	VI
6	Хан-Уул	4	V
7	Чингэлтэй	3,9	VI

Улсын хэмжээнд 2018 онд зам, тээврийн ослын шинжтэй 81211 дуудлага хүлээн авч, 29 474 зам, тээврийн осол бүртгэн шалгасан байна. Харин 2017 онд 92261 дуудлага хүлээн авч байсан бол 2018 онд өмнөх оныхоос 11 050 буюу 12%-иар буурсан үзүүлэлттэй байна. Улсын хэмжээнд ирүүлсэн дуудлагын 95,2% нь нийслэл Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.

Хүснэгт 7.3

№	Дүүргүүд	Дуудлага, бүртгэгдсэн ЗТО						
		2016	ЗТО	2017	ЗТО	2018	ЗТО	дундаж
1	ХУД	9367	5509	10306	5373	9551	3680	
2	БГД	17556	8126	17183	6241	15382	5516	
3	БЗД	22670	9453	22554	7285	20082	5863	
4	СБД	15707	6985	15214	4487	12324	3339	
5	СХД	14043	6593	13578	5189	12345	4567	
6	ЧД	9761	4424	9155	3797	7442	2489	
7	Багануур	204	197	147	147	71	71	
8	Багахангай	10	10	13	12	12	9	
9	Налайх	78	78	90	131	132	132	

Баянзүрх дүүрэгт сүүлийн 3 жилийн байдлаар дуудлага ихэссэн боловч бүртгэгдсэн зам тээврийн осол байнга буурсан байна. Бусад дүүргүүдтэй харьцуулахад дуудлагын тоо их боловч бүртгэгдсэн ЗТО ойролцоо байна.

Дуудлага, бүртгэгдсэн ослын байдлыг графикаар харуулбал:

График 7.3. Зам тээврийн ослын дуудлага 3 жилээр






График 7.4. Бүртгэгдсэн зам тээврийн осол 3 жилээр



Нийслэлд бүртгэгдсэн зам тээврийн ослын 22,8 хувь нь Баянзүрх дүүрэгт, 21,5 хувь нь Баянгол, 17,8 хувь нь Сонгинохайрхан, 14,3 хувь нь Хан-Уул, 13,0 хувь нь Сүхбаатар, 9,7 хувь нь Чингэлтэй дүүрэгт, 0,8 хувь нь бусад алслагдсан 3 дүүрэгт бүртгэгджээ.

График 7.5. Зам тээврийн ослын дуудлагын эзлэх хувь



2018 онд Монгол Улсын хэмжээнд 36 220 гэмт хэргийн улмаас 934 хүн амиа алдсаны 34,7 хувь нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас амь насаа алджээ²⁶.

Зам тээврийн ослын улмаас 2018 онд амь насаа алдсан хүний тоог өнгөрсөн оныхтой харьцуулахад улсын хэмжээнд 10,8 хувиар өсч, нийслэлийн хэмжээнд 25,0, орон нутагт 6,8 хувийн өсөлттэй байна.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн 29 474 замтээврийн ослын 28 794 буюу 97,7 хувь нь жолоочийн буруугаас, 632 буюу 2,1 хувь нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, 48 буюу 0,2 хувь нь замын нөхцлөөс шалтгаалсан байна.

²⁶ “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Цагаан ном 2018” эмхтгэлийн мэдээлэл

№	Аймгийн тасаг, алба	Нийт ЗТО /гэмт хэрэг/			ЗТО-оор гэмтсэн хүн			ЗТО-оор амиа алдсан			3-н жилийн дунджаар		
		2016он	2017он	2018он	2016он	2017он	2018он	2016он	2017он	2018он	гэмт хэрэг	гэмтсэн хүн	амиа алдсан
1	Улсын хэмжээнд	1782	1525	1231	1247	1135	998	479	507	562	1512	1127	516
2	Улаанбаатар	912	652	517	681	556	464	127	112	140	694	567	126
3	Баянзүрх	183	137	108	148	138	96	29	16	23	143	127	23
4	Баянгол	131	96	77	98	78	75	12	11	9	101	84	11
5	Сүхбаатар	119	70	64	107	57	67	10	9	9	84	77	9
6	Сонгинохайрхан	212	167	101	146	144	84	30	39	41	160	125	37
7	Хан-Уул	90	88	79	60	64	70	15	19	29	86	65	21
8	Чингэлтэй	108	62	51	80	51	43	17	11	12	74	58	13

Замын хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, түүний улмаас гэмтсэн болон амиа алдсан хүнийг сүүлийн 3 жилийн дундажаар авч үзэн графикаар харуулбал:

График 7.6. Зам тээврийн ослын улмаас гэмтсэн, нас барсан хүний тоон үзүүлэлт






График 7.7. Зам тээврийн ослын улмаас нас барсан хүний тоон үзүүлэлт




Зам тээврийн ослын дуудлага, бүртгэгдсэн осол нэмэгдээд байгаа боловч Замын хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг Баянзүрх дүүрэгт сүүлийн 3-н жил дараалан буурч байна. 2019 оны эхний 6-н сарын байдлаар гэмт хэрэг өсөх хандлага ажиглагдаж байна.

График 7.8. Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүний тоон үзүүлэлт



Замын хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн сүүлийн 3-н жил дараалан буурсан боловч 2019 оны эхний 6-н сарын байдлаар өссөн дүнтэй байна.

График 7.9. Зам тээврийн ослын улмаас хүнд, хүндэвтэр гэмтсэн хүний тоон үзүүлэлт



Хэдийгээр ЗТО-ын дуудлага, бүртгэгдсэн гэмт хэрэг, гэмтсэн хүний тоо Баянзүрх дүүрэгт


буурч байгаа боловч зам тээврийн ослын улмаас амиа алдсан хүний тоо өсөх хандлагатай байна. 2019 оны эхний 6-н сарын байдлаар авч үзвэл:

График 7.10. Нийслэлд зам тээврийн ослын улмаас нас барсан хүний тоон үзүүлэлт



Баянзүрх дүүргийн хэмжээнд сүүлийн 3 жилд үйлдэгдсэн ЗХАБАЖЭ гэмт хэрэг, гэмтсэн болон амиа алдсан хүний тоог графикаар харуулбал:

График 7.11. Баянзүрх дүүргийн хэмжээнд сүүлийн 3 жилийн хугацаанд зам тээврийн ослын улмаас нас барсан, гэмтсэн хүний тоон үзүүлэлт



Зуун мянган хүн ам тутамд ногдох нас баралт, тээврийн хэрэгслийн тоонд харьцуулан харуулбал:

Хүснэгт 5

№	Дүүрэг	100 мян хүнд ногдох амь эрсдэл	Хүн/автомашин
1	Баянзүрх	6,8	3,2
2	Баянгол	4,8	2,8
3	Сүхбаатар	6,2	2,6
4	Сонгинохайрхан	11,5	4,9
5	Хан-Уул	11,7	4
6	Чингэлтэй	8,26	3,9
7	Улаанбаатар	8,7	2,9
8	Улсын хэмжээнд	15,9	

Хүснэгтээс харахад нэг автомашинд олон хүн ногдож байгаа дүүрэгт 100-н мян хүнд ногдох амь эрсдэл өндөр гарч байна. Энэ нь явган зорчигчийн аюулгүй байдал төдийлөн хангалтгүй байгааг харуулсан үзүүлэлт гэж үзэж байна. Улсын хэмжээнд явган зорчигч мөргөх хэлбэрээр бүртгэгдсэн ослын 2519 буюу 91,2 хувь нь нийслэлд бүртгэгдсэн байна. Иймээс явган зорчигчийн хөдөлгөөнийг автомашины хөдөлгөөнөөс тусгаарлах бодлого барих шаардлагатай.

100000 хүнд ногдох амиа алдалтын байдлыг дүүргээр авч үзвэл Сонгинохайрхан, Хан-Уул,

Чингэлтэй дүүргүүд эрсдэл өндөртэй, Баянгол дүүрэг аюул багатай байхаар харагдаж байна. 100 мян хүнд ногдох нас баралт ОХУ-д 18, БНСУ-д 9,8, Япон улсад 4,1, БНХАУ-д 18,2 байдаг байна²⁷.

7.4.Зам тээврийн ослын шалтгаан

Бүртгэгдсэн зам, тээврийн ослын 97.7 хувь нь жолоочийн буруутай үйлдэл буюу хууль, дүрэм зөрчсөн, сахилга хариуцлагагүй үйл ажиллагаатай холбоотой байна. Зам тээврийн ослын шалтгааныг харуулбал:

Хүснэгт 7.6.

Үзүүлэлт Он	Жолоочийн буруу		Явган зорчигчийн буруу		Замын нөхцөл	
	Улсын хэмжээнд	Нийслэлд	Улсын хэмжээнд	Нийслэлд	Улсын хэмжээнд	Нийслэлд
2018	28794	25093	632	549	48	24
Нийт осолд эзлэх хувь	97.7	97.8	2.1	2.1	0.2	0.1

Өнгөрсөн онд бүртгэгдсэн зам, тээврийн ослын шалтгаан, нөхцлийн өөрчлөлтийг авч үзвэл жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан осол 4,4 хувийн өсөлттэй, явган зорчигчийн буруутай үйлдлээс гарсан осол 24,4 хувиар, замын нөхцлөөс шалтгаалсан осол 22,4 хувиар тус тус буурсан байна.

Улсын хэмжээнд 2018 онд зам тээврийн осол 19,5 хувиар буурчээ. Зам, тээврийн ослын шалтгаан, нөхцлийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулан судлаж үзэхэд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос шалтгаалсан осол 0,8 хувиар, хурд хэтрүүлснээс шалтгаалсан осол 49,8 хувиар, гадны гэрлийн нөлөөллөөс шалтгаалан 5 дахин, явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцсоноос осолд өртсөн тохиолдол 8.8 хувиар өссөн байна.

7.5. Замын хөдөлгөөний хяналт

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас дэвшүүлсэн эрсдэлт 5-н хүчин зүйл /согтуугаар автомашин жолоодох, хурд, хамгаалах бүс, хамгаалах малгай, хүүхдийн суудал/-ийн хяналтыг сайжруулж хэвшүүлж чадсан тохиолдолд зам тээврийн ослоор амиа алдах болон хүнд гэмтэх явдлыг 50% бууруулах боломжтой гэжээ.

Хурд хэтрүүлсэн буюу согтуугаар автомашин жолоодож зам тээврийн осол гаргасан болон согтуугаар автомашин жолоодсон зөрчлийг дүүргээр харуулбал²⁸:

Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, осол гэмтэл түүний үр дагаврыг бууруулах тодорхой үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж үр нөлөөг тооцох нь чухал байдаг. Энэ үйл ажиллагаанд хурд хэтрүүлэх болон согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохыг бууруулах, мотоциклын хамгаалалтын малгай, суудлын даруулга, хүүхдийн хамгаалах хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх арга хэмжээг тогтмол авч ажиллах шаардлагатай болохыг статистик мэдээллийн дүн харуулж байна.


Хүснэгт 7

№	Дүүрэг	зам тээврийн осол						Илрүүлсэн зөрчил согтуугаар а/м жолоодсон		
		Хурд			Согтуу			2016	2017	2018
		2016	2017	2018	2016	2017	2018			
1	Баянзүрх	221	100	302	119	100	112	3296	3204	2867
2	Баянгол		47	35	95	47	32	2670	2267	2256
3	Сүхбаатар		76	140	80	76	72	3359	2310	3061
4	Сонгинохайрхан		117	179	94	117	102	3407	2187	2703
5	Хан-Уул		58	75	43	58	69	2220	1764	1972
6	Чингэлтэй		42	172	51	42	97	2388	2778	2985

²⁷ Global Status Report On road Safety 2018

²⁸ Монгол Улс дахь Зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт

График 14. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зам тээврийн осол гаргасан, тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлийн харьцаа



Судалгааны явцад бүсийн байцаагч нарын ажлын ачааллын судалгааг 2019-11-05-наас 2019-11-10-ны хооронд магистрантууд гүйцэтгэсэн. Ачааллын судалгааг хийхээр боловсруулсан хүснэгтийг хавсралтаар оруулсан. Энэ хугацаанд цаг агаар тогтуун, замын хөдөлгөөний ачаалал ердийн хэмжээнд байсан.

Баянзүрх дүүргийн замын цагдаагийн хэлтэс нь нутаг дэвсгэрээ 3-н бүсэд хувааж алба хаагчид ажиллаж байна. Бүсийн байцаагч нарыг материалыг хүлээн авч шийдвэрлэдэг тусдаа байцаагч гарган ажилласан нь иргэдэд үйлчлэх үйлчилгээг шуурхай болгожээ. Мөн тусдаа байцаагч ажилласнаар зам тээврийн ослыг бүртгэх бүртгэл бусад дүүргээс сайжирч тооны хувьд өссөн байна. Үүнээс

1 дүгээр бүс буюу Ганга 111 нь албаны 06-52УНУ автомашин.

2 дугаар бүс буюу Ганга 112 нь албаны 02-67УБУ автомашин

3 дугаар бүс буюу Ганга 113 нь албаны 80-24УНУ автомашин

Нэгдүгээр ээлж өглөөний 07:00 минутаас 15:00 цаг хүртэл, 2 дугаар ээлж нь 15:00 минутаас 22:00 цаг хүртэл ээлжлэн ажиллаж байна.

Судалгааны хугацаанд нэгдүгээр ээлжийн ажлын ачаалал харьцангуй бага 85-н дуудлагатай, нийтдээ 130,7 км, хоёрдугаар ээлж 119-н дуудлагатай, нийтдээ 287 км явсан байна. Шатахууны норм өдөрт 6 л байгаа нь дуудлагад явахад хүрэхээргүй байна.

Нэг дуудлагад дунджаар 23,1 минут зарцуулж байгаагаас 11,2 минутыг хэмжилт хийхэд зарцуулж байна. Мэргэшсэн алба хаагчийг бүсийн байцаагчаар ажиллуулах шаардлагатай байна. Шинэ ажиллаж байгаа байцаагч автомашин жолоодох үедээ богино долгионы станцаар ярих, дуудлага мэдээлэл авах зэрэг хүндрэлтэй нөхцөлд ажиллахаар тэвдэх, стресст орох үүний улмаас ажлаас халшрах шинж илэрч байна. Мөн хэргийн газарт хэмжилт хийх, автомашинд үзлэг хийх, эд мөрийн баримтыг хамгаалах, замын хөдөлгөөн зохицуулахад 2 алба хаагч үүрэг гүйцэтгэх шаардлагатай. Бүсэд нэг байцаагч ажилласнаар цагдаагийн алба хаагч өөрөө замын хөдөлгөөний дүрэм зөрчих байдал ажиглагдаж байгаа бөгөөд ХЗДХЭргийн сайдын 2019 онд А/101 тоот тушаалаар баталсан “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам”-ыг зөрчиж үүрэг гүйцэтгэж байна.

Судалгааны явцад бүсийн автомашин техникийн хувьд замын хөдөлгөөнд оролцох шаардлага хангахгүй байсан боловч Баянзүрх дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс автомашины засварын зардлыг гарган засварлуулж 2019-11-22-ны өдөр бэлэн болгосон байлаа.

Дүгнэлт

Энэ судалгааг дахин хийх шаардлагатай гэж үзэж байна. Учир нь цаг агаарын хүндэрсэн нөхцөл, замын гэнэтийн ачаалал, цаг үеийн ачаалал зэргийг харгалзан бүсийн байцаагчийн үйлдэл бүрийн хугацааг бүртгэх, мэдлэг, чадвар зэргийг тооцох байдлаар хийх нь зүйтэй байна. Мөн замын хөдөлгөөний хяналтыг хөдөлгөөн эргүүлийн хэлбэрээр гүйцэтгэх шаардлага гарч байна.

7.5. ЗТО-ООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГАЧЛАЛ

Дэлхийн банкнаас зохион байгуулсан “Авто замын дэд бүтцийн аюулгүй байдлыг сайжруулах” сургалтад /Замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөвлөх Филлип Жордан/ зам тээврийн ослын улмаас амиа алдахад 263900 ам.доллар, хүнд гэмтэл авахад 65,975 ам.долларын эдийн засгийн хохирол учруулдаг²⁹ гэж заасан байна.

Баянзүрх дүүргийн хэмжээнд 2018 онд зам тээврийн ослын улмаас 23 хүн амиа алдаж, 96 хүн хүнд гэмтсэн байна. Дээрх аргачлалаар хохирлын хэмжээг тооцвол 12403300 ам доллар буюу 33,5 тэрбум төгрөгийн хохирол учирсан дүн мэдээ гарч байна. Энэ хохирлын хэмжээг бууруулахын тулд урьдчилан сэргийлэх ажилд зориулсан зардлыг зоригтойгоор нэмэгдүүлэх нь зүйтэй юм.

“Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-т зам тээврийн ослын тоог бууруулах зорилт дэвшүүлсэн.

Замын аюулгүй байдлын инженерчлэл нь дараах зүйлд суурилна³⁰:

- Ослын тоог багасгах үндэс болгон байгаа автозам дээр зардлын хувьд үр ашигтай арга хэрэгжүүлэх (**reactive-мөрөөр нь авах арга хэмжээний арга**)
- Шинэ болон одоо байгаа зам дээр автозамын аюулгүй байдлын аудит, хяналт шинжилгээг хийх замаар ослоос сэргийлэх аюулгүй байдлын зарчмуудыг хэрэгжүүлэх (**proactive –урьдчилан сэргийлэх арга**)

Авто замын сүлжээний аюулгүй байдлыг зэрэглэх (эсвэл менежмент) нь **reactive арга юм**. Энд асуудлыг тодорхойлох эсвэл урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахаас өмнө осол гарсан хэсэг болон сайжруулах арга хэмжээ авах байршлыг тодорхойлох, эрэмблэхэд хэрэглэж байгаа ослын байршил орно.

осол (шийдэх асуудал) → асуудлыг тодорхойлох → асуудлыг шийдвэрлэх

3 буюу түүнээс олон жилийн ослын тоон мэдээлэл бүхий замыг зэрэглэдэг.

Цар хүрээний хувьд аюулгүй байдлыг нь ханган сайжруулах өндөр боломжтой байршлыг тодорхойлох.

Өндөр нөөц боломжтой → зардлын хувьд өндөр үр ашигтай

Иймээс зам тээврийн ослыг бууруулахын тулд автозамын сүлжээний аюулгүй байдлыг сайжруулах чиглэлийг сонгосон болно.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зөвлөсөн эрсдэлт 5-н хүчин зүйл:

- Хурд
- Согтуугаар автомашин жолоодох
- Суудлын бүс хэрэглэх
- Хамгаалах малгай хэрэглэх
- Хүүхдийн суудал хэрэглэх

Автозамын сүлжээний аюулгүй байдлыг сайжруулсанаар мөргөлдөх, мөргөх, шүргэлцэх тоог бууруулах, осол болсон ч учирах хохирлыг багасгах үр дүнтэй болно. Зам тээврийн ослын хор, хохирлыг бууруулах, замын ачааллыг багасгахын тулд хүнд даацын машинуудыг хязгаарлах, хурдыг удаашруулах аргыг ашигладаг. Эдгээрээс аль нь илүү үр дүнтэйг тооцож үзвэл:

- Хурд нэмэгдсэнээр тээврийн хэрэгслийн бүрэн зогсолтын замын урт нэмэгдэж ослын тоо өсдөг.
- Хурд нэмэгдсэнээр мөргөх хүч нэмэгдэж хүнд гэмтэл, үхлийн тоо нэмэгддэг.
- Их хурдтай үед кинетик энерги их хэмжээгээр нэмэгдэж (кинетик энерги нь хурдны квадратаас шууд хамаарч өсдөг), улмаар кинетик энерги осолд нөлөөлж хүнд гэмтэл, амиа алдах нөхцөл бүрдэнэ.

- **100 кг масстай бие 10 м/с хурдтай явах үеийн кинетик энерги**

²⁹ McMahon, K. and Dahdah, S. (2008 он) Зам тээврийн ослын бодит хохирол: Хүний амь болон хүнд гэмтлийг үнэлэх нь. <http://irap.org/library.aspx>; Олон улсын валютын сан, 2013 он.

³⁰ ADB “Автозамын аюулгүй байдлын аудит ба хар цэгийг арилгах нь” сургалтын материал https://drive.google.com/open?id=1tKMSJw8_1Tt7Q257fjXBxfeWq09tKVeP

$$E = \frac{m \cdot v^2}{2} = \frac{100\text{кг} \cdot (10\text{м/с})^2}{2} = 5000\text{Ж}$$

- Хурдыг хоёр дахин өсгөхөд


$$E = \frac{m \cdot v^2}{2} = \frac{100\text{кг} \cdot (20\text{м/с})^2}{2} = 20000\text{Ж}$$

- Массыг хоёр дахин өсгөхөд

$$E = \frac{m \cdot v^2}{2} = \frac{200\text{кг} \cdot (10\text{м/с})^2}{2} = 10000\text{Ж}$$

Дээрх томъёоноос харахад хурдыг багасгаснаар илүү үр дүнтэйгээр бууруулах боломжтой байна.

Дэлхий нийтэд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэхийн тулд урд урдаасаа мөргөлдөх, эгц хажуугаас мөргөх ослыг багасгах нь илүү үр дүнтэй аргад тооцогдож байна. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эрсдэлийн түвшинг тогтоохын тулд хэдэн огтлолцсон уулзварын хөдөлгөөнийг тойрог хэлбэрээр зохион байгуулсан гэдгийг харгалзан үздэг болжээ.



Гэрлэн дохионы зохицуулгатай уулзвар автомашин мөргөлдөж болзошгүй 32 цэг байдаг бол тойрог хөдөлгөөн 8-н цэгтэй байна. Тойрог хөдөлгөөн хурдыг тодорхой интервалд зохицуулж байдаг. Гэрлэн дохионы зохицуулгатай уулзвар автомашины хурдыг “0” болгодог ч гэсэн зарим тохиолдолд өсгөж байдагаараа эрсдэлтэй байдаг байна. Мөн замын дагуу олон огтлолцлыг үгүй болгосноор ослын тоо буурна, тойрог хөдөлгөөн дээр бага зэрэг нэмэгдэх боловч хохирол багасна.

7.6. ШИЙДЭЛ САНАЛ

Баянзүрх дүүргийн 8-р хорооны нутаг дэвсгэрт орших Чулуун овооноос Хилчний гудамж хүртэл буюу ДХИС-ийн уулзвар хүртэлх зам дээр зам тээврийн ослыг бууруулах шийдэл гаргасан.

Чулуун овооноос ДХИС-ын уулзвар хүртэлх замд гарсан зам тээврийн осол

Хүснэгт 8


№	Он	ЗТО-ын тоо
1	2016	457
2	2017	281
3	2018	287
	Нийт	1025

Цагдаагийн академийн гудамжны энэ хэсэгт зам тээврийн осол гарч болзошгүй буюу гарах магадлал өндөртэй 7-н цэг байгааг бичлэг хийн тогтоосон. Эдгээр цэгүүдэд байнга цагдаагийн хяналт тавих боломжгүй байдгаас жолооч нар ЗХД зөрчин гарцаас зүүн гар тийш эргэх буюу гол замаас зүүн

гар тийш гарц руу эргэж байна. Сонгон авсан эдгээр гарцнууд нь хөдөлгөөний эрчим харьцангуй ихтэй байдаг. Аж ахуйн нэгж, байгууллагын зогсоол, гарцыг тооцож оруулаагүй, эдгээр зогсоол талбайгаас замын тэмдэглэл зөрчин зүүн гар тийш эргэдэг боловч харьцангуй цөөн гэж үзсэн. Тодорхойлсон цэгийн автозамын байгууламжийн асуудлыг шийдвэрлэснээр дээрх асуудлыг цэгцэлнэ. Мөн цагдаагийн хяналт шаардлагагүй болно.


Энэ асуудлыг шийдвэрлэснээр 90⁰-аар болон өөдөөсөө мөргөлдөх осол гарахгүй хурц өнцөгөөр мөргөлдөх магадлал үлдэнэ.

Энэ замын хэсгийг харуулбал:



1-р цэгт 90⁰-аар мөргөлдөх магадлалтай 6-н цэг, хурц өнцөгөөр мөргөлдөх магадлалтай 2 цэг, эгц өөдөөсөө мөргөлдөх 1 цэг, нийт 9-н цэг байна.

Зургаар үзүүлбэл:




Эдгээр цэгүүдэд нийтдээ 63-н цэг байна. Иймээс замын голоор хашлагаар тусгаарлах зурвас хийсэн тохиолдолд хурц өгцөгөөр мөргөлдөх цэг л үлдэнэ.

Автомашинууд зүүн гар тийш эргэх боломжгүй болсноор ДХИС-ийн баруун урд уулзварын

ачаалал нэмэгдэх тул тойрог хөдөлгөөнтэй уулзвар болгох санал гаргаж байна.


7 цэгийн байдлыг зургаар үзүүлбэл:



Энэ зураг дээрх замын тэмдэглэл асуудалтай болох нь харагдаж байна. Монгол Улс баруун гарын дүрэмтэй байхад гарцыг зүүн талаар зөрж нэвтрэх байдлаар хийсэн байна. Ингэснээр өөд өөдөөсөө мөргөлдөх магадлалыг ихэсгэж аюултай нөхцөл үүсгэж байна.



ДХИС-ийн баруун урд уулзварыг тойрог хөдөлгөөнтэй болгох боломжтой бөгөөд хойноос буюу Хилчний гудамж талын замыг тойрог хөдөлгөөнтэй огтлолцох уулзварт нэг эгнээ нэмэх саналтай байна.



Замын голоор хашлага хийж уулзварыг тойрог болгосноор

Давуу тал:

- Зам тээврийн осол багадаа 30% буурна
- Замын хөдөлгөөний дүрэм зөрчигдөх явдал багасна
- Зам тээврийн ослын хохирол багасна
- Уулзварын нэвтрүүлэх чадвар нэмэгдэнэ
- Автомашины хурд багасна.

- Хилчний гудамжны нэвтрүүлэх чадвар нэмэгдэнэ.

Сөрөг тал:

- Чулуун овооны тойргийн ачаалал нэмэгдэнэ
- Явган хүний гарцаар нэвтрэх автомашины тоо нэмэгдэнэ. Энэ нь явган зорчигчийн аюулгүй байдлын зэрэг буурах тул явган хүний гарам хийх шаардлага гарна.
- Энэ замын орчимд явдаг автомашины явалт ихэснэ.
- Тойрог хөдөлгөөний замын тэмдэглэлийг байнга тодруулах зардал нэмэгдэнэ

Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гэмтэл түүний үр дагаврыг бууруулах тодорхой үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж үр нөлөөг тооцоход судалгаа шинжилгээ чухал байдаг.

“Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-т Зам, тээврийн ослоос үүдэлтэй нийгмийн эрсдэлийг 50 хувь бууруулах зорилтын хүрээнд:

- олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлэх замаар жолоочийн сахилга, хариуцлагаас шалтгаалсан зам, тээврийн ослыг бууруулах;

- бүх шатны боловсрол, сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөрт замын хөдөлгөөнд оролцогчдын мэдлэг, дадал, хандлагыг дээшлүүлэх сургалтыг тусгах замаар замын хөдөлгөөнд оролцогчдын хандлага, соёл, дадал, хариуцлагыг дээшлүүлэх;

- явганаар болон унадаг дугуйгаар зорчих, хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настан, бага насны хүүхдийг замын хөдөлгөөнд аюулгүй оролцох нөхцөлийг бүрдүүлэх;

гэж заасан учраас жолооч нарыг замын хөдөлгөөний дүрэм зөрчих боломжгүй байх замын нөхцөл бүрдүүлэх, явган зорчигчийн хөдөлгөөнийг автомашины хөдөлгөөнтэй огтлолцохгүй байхаар зохион байгуулах зөвлөмж гаргаж байна.

Хатуу хучилттай гол замын дэргэд шинээр сургууль, цэцэрлэгийн барилга баригдах бол явган зорчигчийн хөдөлгөөнийг автомашины хөдөлгөөнтэй огтлолцохгүй байх нөхцөлийг бүрдүүлж байх тогтолцоо бий болгох.

Хатуу хучилттай гол зам сургууль, цэцэрлэгийн хажуугаар тавигдах бол мөн явган зорчигчийн хөдөлгөөнийг автомашины хөдөлгөөнтэй огтлолцохгүй байхаар төсөллөж байх. Шинээр баригдах зам, сургууль, цэцэрлэгийн барилгын төслийг хийхдээ явган зорчигчид зориулсан нүхэн болон гүүрэн гарам хийх төсөв хийж байх тогтолцоог бий болгох.

Төв замын дэргэд үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын 14-р сургууль, МИУ дээд сургуулийн дэргэд гүүрэн гарц байгуулах зэрэг болно.

БҮЛЭГ 8. “БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХЭМЖЭЭНД ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ” СУДАЛГААНЫ ДЭД ТАЙЛАН

Судалгааны дэд баг: Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч, доктор (Ph.D),
хурандаа, дэд профессор Б.Алтангэрэл,
магистрант нар хийж гүйцэтгэв.

8.1. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны хэрэгжилтийн судалгаа”

Эрүүгийн хариуцлага нь Эрүүгийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, нийгэмшүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой төрийн албадлагын арга хэмжээний хамгийн хатуу төрөл болохын хувьд эрх зүйн бусад албадлагаас ялгагдана.

Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг шийтгэж цээрлүүлэхээс гадна нийгэмшүүлэх зорилгыг давхар агуулдаг. 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Эрүүгийн хуульд заахдаа гэмт хэрэг үйлдсэн хүнд доор дурдсан ял оногдуулна:

- 1.торгох ял;
- 2.нийтэд тустай ажил хийлгэх ял;
- 3.зорчих эрхийг хязгаарлах ял;
- 4.хорих ял;
- 5.эрх хасах ял.

2015 оны Эрүүгийн хуульд ялын эрүүгийн хариуцлагын зорилгод нийцүүлэн гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хорих ял тэнссэн, эсхүл хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүнд шүүх үндсэн ялаас гадна тодорхой үүрэг хүлээлгэх, эрхийн хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэхээр заасан. Тухайлбал, гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авах, зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах, тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх, оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа хяналт тавьж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх, тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах, галт зэвсэг өмчлөх, эзэмшихийг хориглох, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох, тодорхой үйл ажиллагаа явуулахыг хориглох зэрэг болно.

2015 оны Эрүүгийн хуульд уламжлалт хорих, торгох ялаас гадна нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, эрх хасах ялын төрөл шинээр нэмж хуульчилсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа нь Шүүхээс гаргасан эрүү, иргэн, захиргааны хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн эрх бүхий байгууллагаас албадан гүйцэтгэж буй төрийн албадлагын арга хэмжээ байдаг.Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг шүүхийн шийдвэрийн төрөл, онцлогоос нь шалтгаалан:

1.Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа /хорих болон хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа/;

- 2.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа;
- 3.Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа;
- 4.Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гэж ангилж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд сум, дүүргийн засаг дарга, түүний ажлын албатай хамтран ажиллах талаар дараах эрх зүйн зохицуулалт байна. Үүнд: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн:

14.6.Мэдэгдэх хуудсыг гардуулан өгвөл зохих хүн оршин суугаа газар, эсхүл ажлын байрандаа байхгүй бол мэдэгдэх хуудсыг түүний хамт амьдардаг арван найман насанд хүрсэн хүн, эсхүл сум, баг, хорооны Засаг дарга, түүний ажлын албанд, эсхүл ажлын газрын захиргаанд хүлээлгэн өгч, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулна.

128.1.Бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газар нь доод шатны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийн биелэлтэд хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээнд хяналт тавина.

128.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр уламжлан энэ хуульд заасан хугацаанд захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, Засгийн газраас томилогдож, чөлөөлөгддөг бусад албан тушаалтны асуудлыг

Засгийн газарт, Улсын Их Хурлаас томилогдож, чөлөөлөгддөг албан тушаалтны асуудлыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцуулна.

187.1.3. тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийг хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэх үүрэг хүлээсэн этгээд болон сум, дүүргийн Засаг даргаас хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх харилцан мэдээлэл солилцоход дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

189.5. Сум, дүүргийн Засаг дарга үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд шүүхээс даалгасан үүрэг, хязгаарлалтыг биелүүлэх талаар зохих туслалцаа үзүүлнэ.

197.2. Хорих ангийн үйлдвэрлэлийн чиглэлийг аймаг, нийслэлийн Засаг дарга болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын даргын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

239.1. Нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа хоригдлын энэ хуулийн 213.1-д заасан төрөл, садангийн хүн хүндээр өвчилсөн, эсхүл нас барсан, гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсоны улмаас ар гэрт нь үлэмж хор хөнөөл учирсан бол тухайн хоригдлын зан байдал, засрал хүмүүжлийг харгалзан хорих ангийн дарга зам хоногийг оролцуулан 7 хүртэл хоногийн чөлөө олгоно.

239.2. Чөлөө хүсэгч хоригдол, түүнийг батлан даагч энэ хуулийн 239.1-д заасан нөхцөл байдал бий болсныг нотолсон сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, эмнэлгийн байгууллагын магадлагааг бүрдүүлэн хорих ангийн даргад чөлөө хүссэн өргөдлийн хамт өгч шийдвэрлүүлнэ зэргээр хуульчилжээ.

8.2. Хорих ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр:

Хорих ял нь иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, ялтанд эрхийн хязгаарлалтаар дамжсан хатуу цээрлэл амсуулах, ялтнаас дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг гаргуулахгүй байх, нийгмийн дотор байгаа зарим тогтворгүй хүмүүст урьдчилан сэргийлэх нөлөө үзүүлдэг хамгийн өргөн хэрэглэгддэг төрийн албадлагын онцгой төрөл юм.

Хүн төрөлхтөн гэмтнийг гэсгээн цээрлүүлэх, хашраах, гэмшүүлэхийн тулд түүнийг шоронд хорихоос өөр илүү дэвшилттэй аргыг өнөө хэр нь олоогүй байгаагийн нэг тод илрэл бол дэлхийн бүх оронд хорих ялыг өргөн хэрэглэсээр ирсэн явдал юм.


Хорих ялыг бусад төрлийн ялтай харьцуулан авч үзвэл:

- 1/ хоригдол нь чөлөөтэй зорчин явах эрхээ хязгаарлуулдаг;
- 2/ олон нийтээс тодорхой хугацаагаар тусгаарлагддаг;
- 3/ харьцангуй удаан хугацаатай;
- 4/ тусгай байгууллага болох хорих анги, гянданд хоригддог;
- 5/ хорих ял эдлэх хугацаандаа нийгэм, хамт олон дотор байж эрх чөлөөт иргэдийн нэгэн адил өөрийн эрх дураар ажиллаж, хөдөлмөрлөх, амьдрах эрхгүй байдаг;
- 6/ нийгэм, төрийн үйл ажиллагаанд Үндсэн хуульд заасан улс төрийн эрхээ эдэлж, оролцох боломжоо алддаг;
- 7/ гэр бүл, үр хүүхэд, төрөл төрөгсөд, найз нөхдөөсөө хагас тусгаарлагддаг;
- 8/ хорих байгууллагын дэглэм, дотоод журамд захирагдах, тэдгээрийг дагаж мөрдөх шаардлагатай болдог;
- 9/ иргэн гэхийн оронд хоригдол гэж дуудуулан нэр төрийн хувьд ичгэвтэр байдалд орох зэмлэл хүлээдэг;
- 10/ ял шийтгүүлэхийн өмнө ажиллаж, сурч байсан хамт олноосоо тусгаарлагддаг;
- 11/ эзэмшсэн мэргэжлийн ажлаа болон дур сонирхолтой, хийхийг хүссэн ажил хөдөлмөр эрхлэх эрхгүй;
- 12/ өөрийн мэргэжил, ур чадвар, оюун ухаанаа нийгэмд ашигтай үйл ажиллагаанд зориулах боломжгүй болдог;
- 13/ удаан хугацаатай хорих ял шийтгүүлсэн хоригдлын эхнэр, нөхөр гэрлэлтээ цуцлуулах нэхэмжлэл шүүхэд гаргахад маргах эрхгүй болдог;
- 14/ хорих ангид ял эдэлж байхдаа хийсэн ажлын хөлсөө өөрөө гардан авах, шууд зарцуулах болон өмч хөрөнгө, эд зүйлээ зориулалтаар зарцуулах, чөлөөтэй ашиглах эрхээ тодорхой хэлбэрээр хязгаарлуулдаг;

Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь ялын бодлого, зорилгыг хангахад чиглэх ба ялын бодлого нь тухайн улс орны хөгжлийн шат дахь нийгэм, эдийн засаг, улс төр, эрх зүйн хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн дэг журмыг хангах, хүний эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалах чиг үүрэг хэрэгжүүлэхэд төрөөс баримталж буй чиглэл бөгөөд төр эрүүгийн ялын бодлогоо хариуцлагын оновчтой төрөл, тогтолцоог бий болгох, оногдуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох, түүгээр дамжуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зэрэг арга хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлж байдаг.


2003-2018 оны жилийн эцсийн байдлаар ШШГЕГ-ын харьяа хорих ангиудад хорих ял эдэлсэн хоригдлын тоог авч үзвэл 2003 онд-5769, 2004 онд-6341, 2005 онд-6782, 2006 онд-5101, 2007 онд-6109, 2008 онд-5601, 2009 онд-4986, 2010 онд-5694, 2011 онд-6410, 2012 онд-6786, 2013 онд-6974, 2014 онд-6402, 2015 онд-4480, 2016 онд-4464, 2017 онд-2942, 2018 онд-3525 хоригдол ял эдэлсэн байна.

График 8.1.2003-2018 оны хооронд улсын хэмжээнд хорих ял эдэлсэн хоригдлын үзүүлэлт:




1.1.ШШГЕГ-ын харьяа хорих ангиудад 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 3227 хоригдол ял эдэлсэнээс Баянзүрх дүүргийн харьяат 298 нь хоригдол ял эдэлсэн нь 8 хувийг эзэлж байна.

График 8.2. 2018 онд тус дүүргийн иргэдээс ял эдэлсэн иргэдийн тоон үзүүлэлт




1.2.ШШГЕГ-ын харьяа хорих ангиудад 2019 оны 10 дугаар сарын 01-ний байдлаар 3689 ял эдэлж байгаагаас Баянзүрх дүүргийн харьяат 258 хоригдол ял эдэлж байгаа нь нийт хоригдлын 7 хувийг эзэлж байна.

График 8.3. 2019 онд тус дүүргийн иргэдээс ял эдэлсэн иргэдийн тоон үзүүлэлт



1.3.ШШГЕГ-ын харьяа хорих ангиудад 2019 оны 10 дугаар сарын 01-ний байдлаар Баянзүрх дүүргийн харьяат 45 хоригдол суллагдсан нь 2019 онд нийт суллагдсан хоригдлын 2 хувийг эзэлж байна.

График 8.4. 2019 онд тус дүүгийн иргэдээс ял эдлээд суллагдсан хүмүүсийн тоон үзүүлэлт



1.4.ШШГЕГ-ын харьяа хорих ангиудад 2019 оны 10 дугаар сарын 01-ний байдлаар Баянзүрх дүүргийн харьяат 69 хоригдол суллагдахаас 6 сарын хугацаа үлдэж байна.

Монгол Улсын Их хурлаас 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр батлагдан 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх гэж буй “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн шинэчилсэн найруулгийн 6 дугаар зүйлд “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэл”-ийг дараах байдлаар зохион байгуулж, хэрэгжүүлнэ. Үүнд:

1.Ерөнхий чиглэл /хуулийн 7.2.3-т гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох/;

2.Тусгай чиглэл /хуулийн 8.2.7-т тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг, эсхүл үйлдэгдэж болзошгүй газар нутаг, үйл ажиллагаа, харилцаанд чиглэсэн цогц арга хэмжээг авах/;

3.Нэг бүрчилсэн чиглэл /хуулийн 9.2.2-т гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгүүлж суллагдсан хүнд хяналт тавих, 9.2.3-т гэмт хэрэг үйлдэж болзошгүй нөхцөлд байгаа болон хорих ял шийтгүүлж, суллагдсан этгээдэд нийгэмд дасан зохицох, нийгмийн амьдралд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх, 9.2.5-т гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийн зан байдалд нөлөөлөх, хуулийг чандлан сахих дадал төлөвшүүлэх, хорих байгууллагад байх хугацаанд боловсрол, ажил хөдөлмөр эрхлэх дадал, туршлага олгох, суллагдсаны дараа нийгэмд дасан зохицох шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох/;

4.Соён гэгээрүүлэх чиглэл /хуулийн 10.2.1-т өөрийн үйл ажиллагааны онцлог, зан үйл, дадлаас хамааран гэмт хэрэг, зөрчилд өртөх, түүний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөж болзошгүй хүн, хуулийн этгээдийн хүрээг тодорхойлох, 10.2.2-т тухайн этгээдийн үйл ажиллагаа, зан үйл, дадал гэмт хэрэг, зөрчлийг өдөөж болзошгүй шалтгаан, нөхцөлийг тогтоож, тэдгээрийг саармагжуулах, арилгах арга хэмжээг авах зэргээр заажээ.

Түүнчлэн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд Нутгийн захиргааны бүх шатны байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллага, иргэдийн үйл ажиллагаа, санал, санаачилгыг дэмжин туслах, нутаг дэвсгэртээ бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн байдалд дүгнэлт хийж, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах талаар мэргэжлийн байгууллага, эрдэмтэн, судлаач, шинжээчтэй хамтран ажиллах, гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байсан хүнийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байр бий болгох, хөдөлмөрлөх дадал, туршлага олоход нь дэмжлэг үзүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгосон билээ.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хяналт тавих үндэслэлийг заахдаа:

1.Эрүүгийн хуулийн 10.1 /хүнийг санаатай алах/, 11.2 /санаа сэтгэл нь хүчтэй цорон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах/, 12.1 /хүчиндэх/, 12.3 /бэлгийн мөлжлөг/, 15.1 /эмнэлэгийн тусламж үзүүлэхгүй байх/, 15.5 /хууль бусаар үр хөндөх/, 15.6 /бусдын амь насанд аюул учруулж

болзошгүй халдварт өвчин, дархлал хомсдолын вирус тараах/, 16.2 /хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах/, 17.1 /хулгайлах/, 18.6 /мөнгө угаах/, 19.2 /төрийн эрх мэдлийг хууль бусаар авах/, 19.5 /зэвсэгт үймээн дэгдээх/, 19.6 /хорлон сүйтгэх/, 19.8 /экстремист үйл ажиллагаа явуулах/, 20.3 /зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулах, түүнд элсэх/, 20.7 /мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/, 20.8 /мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэх орон байраар хангах/, 26.1 /цахим мэдээлэлд хууль бусаар халдах/, 26.2 /цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах/, 26.3 /хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах/, 29.8 /террорист үйлдэл хийх/, 29.10 /терроризмыг санхүүжүүлэх/ зэрэг 22 төрлийн гэмт хэрэг үйлдэж, хоёроос дээш жилийн хугацаагаар хорих ял эдэлж суллагдсан.

2.Хоёроос дээш жилийн хугацаагаар хорих ял эдэлж, хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон, хорих, зорчих эрхийг хязгаарлах ялаас өвчний учир чөлөөлөгдсөн, өршөөл, уучлал үзүүлж ялаас чөлөөлөгдсөн.

3.Шүүхээс хорих ялаас хугацаанаас нь өмнө суллахдаа эдлээгүй үлдсэн ялын хугацаатай тэнцүү хяналтын хугацаа тогтоох ба хяналтын хугацаа нь дууссан хүнд гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт тогтооно.


Түүнчлэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д Аймаг, дүүргийн Засаг дарга, орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралтай зөвшилцөн хүүхдийн эрхийн хууль зүйн хороог байгуулах бөгөөд хороо нь дараа үйл ажиллагааг явуулна.

15.1.1.гэмт хэрэг үйлдэж шүүхээс ял шийтгүүлсэн хүмүүжлийн чанартай арга хэмжээ авагдсан хүүхдийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хүлээн авах, шүүхээс хүүхдэд даалгасан үүргийг биелүүлэхэд зөвлөгөө өгөх, дэмжлэг туслалцаа үзүүлэх;

15.1.2.сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаад суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь дэмжлэг туслалцаа үзүүлэх заалтыг хэрэгжүүлэх нь дахин гэмт хэргээс урьдчилан сэргийлэх явдалд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж заажээ.

Шүүхээс зөвхөн 2018 онд 3245 хүнд хорих ял оногдуулснаас 2995 хүнд биечлэн эдлүүлж, 132 хүнийг тэнсэн, 111 хүнийг тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, 1813 хоригдол суллагдсанаас хугацаа дуусч-702, хугацаанаас өмнө-1068, хуулийн тэгшитгэлд-20, ерөнхийлөгчийн зарлиг, ялын өөрчлөлт, өвчний учир суллагдсан-23 хүн суллагдсан судалгаа байна³¹.Энэ нь жилд 2000 гаруй хүн шүүхийн журмаар суллагдан тодорхой хяналтад ордог байна.

График 8.5.2018 онд гэмт хэрэг үйлдэн шүүх, хорих байгууллагаас улсын хэмжээнд суллагдсан хүмүүсийн судалгаа



Хяналтыг оногдуулсан хорих ялын хугацаатай уялдуулан нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр нэгээс гурван жил хүртэл хугацаагаар тогтооно.

Монгол Улсын өнөөгийн практикт хугацаанаас өмнө суллах, тэнсэх, ял хойшлогдсон хүнд тавих хяналт, нийгэмшүүлэх ажлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, хорих ялын хугацаа

³¹ Б.Алтангэрэл.Монгол Улсын хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ 2003-2018.Уб., 2019 он. 59 дэх тал

дуусч суллагдсан хүнд тавих хяналт, нийгэмшүүлэх асуудлыг Цагдаагийн байгууллага хариуцан гүйцэтгэж байна.

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн А/247, А/167/303 дугаар хамтарсан тушаалаар хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэр гүйцэтгэгч нийслэлд 160, орон нутагт 120 ялтан, этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудсанд хяналт тавиж ажиллахаар жишиг нормативийг батлан тогтоосон. 2019 оны байдлаар 1 эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч орон нутагт 250, нийслэлд 360 этгээдэд хяналт тавин ажиллаж байна.

Монгол Улс дахь ял эдлүүлэх ажиллагааны өнөөгийн байдлаас харахад гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдлэгсдийн тоо жилд дунджаар 8.3-15.2 хувиар өссөн үзүүлэлттэй³², хорих ял эдлээд суллагдсан иргэдийн зүгээс давтан гэмт хэрэг үйлдэх явдал буурахгүй³³, байна. Энэхүү статистик үзүүлэлтээс гадна ял эдэлж буй хоригдлыг хорих байгууллагаас суллагдсаны дараа үзүүлэх нийгэмшүүлэх ажлын тогтолцоо хангалтгүй, нутгийн захиргааны болон хууль сахиулах байгууллагуудын хэмжээнд эрх зүйн зохицуулалтын хувьд хүлээсэн чиг үүрэг бүрэн тодорхойлогдоогүй байгаа нь эрх зүйн зохицуулалтын болон зохион байгуулалтын шинэлэг арга хэлбэр шаардлагатайг илэрхийлж байгаа юм.

Суллагдсан хүнийг нийгэмшүүлэх нь зөвхөн дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй гэсэн үндэслэлээр дуудаж уулзах, хянах байдлаар явагдаж байна. Өөрөөр хэлбэл “ХЯНАЛТ-НИЙГЭМШҮҮЛЭХ АЖИЛ”-ын харьцаа алдагдсанаар суллагдсан этгээдийг эргэн нийгэмшүүлэх ажил үр дүнтэй явагдахгүй байна.

Түүнчлэн суллагдсан этгээдийг нийгэмшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагаа, оролцоог хуульчилсан эрх зүйн зохицуулалт хангалтгүй, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэхтэй холбоотой Цагдаагийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага тус тусдаа өөр өөрсдийн хууль, журам, зааврын хүрээнд гүйцэтгэгдэгээс болж байна.

Улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарууд, тэр дундаа хууль зүйн салбарт хийгдэж буй тогтолцооны болон эрх зүйн шинэчлэл, өөрчлөлтүүд нь хүний хөгжлийг, улмаар нийгмийн зөв тогтолцоог дэмжин хөгжүүлэхэд чиглэгдсэн байх ёстойг бүх нийтээр хүлээн зөвшөөрч байна.

Хоригдлыг хорих байгууллагаас суллагдсаны дараа үзүүлэх нийгэмшүүлэх ажлын тогтолцоо байхгүй, нутгийн захиргааны болон хууль сахиулах байгууллагуудын хэмжээнд эрх зүйн зохицуулалтын хувьд хүлээсэн чиг үүрэг бүрэн тодорхойлогдоогүй, хэрэгжүүлэх нэгдсэн тогтолцоогүй байгаа нь бие даасан эрх зүйн зохицуулалтын болон бүтцийн шинэлэг арга хэлбэр шаардлагатайг илэрхийлж байгаа юм.

Өөрөөр хэлбэл, ял эдлүүлэх ажиллагааны тогтолцоо, хэлбэр, эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын өсөлт, гэмт хэргийн гаралт, нөхцөл байдалтай холбон өөрчлөх, гадаадын бусад орны ижил чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааны туршлагад суурилан, олон улсын чиг хандлага, загварт нийцүүлэн хөгжүүлэх нь зүйтэй юм.


8.3. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр:

Нийслэлийн Шийдвэр гүйцэтгэх газрын Баянзүрх дүүргийн хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар Баянзүрх дүүргийн харьяат 1196 этгээд хорихоос өөр төрлийн ял эдэлсэн байна.

³²ШШГЕГ-ын Хорих ял эдлүүлэх албаны 2009-2017 оны тайлангаас үзэхэд жилийн эцсийн байдлаар нийт 5069-7083 ялтан ял эдэлж байжээ.

³³2018 оны жилийн эцсийн дүнгээр нийт ял эдэлж буй хоригдогсдын 32 хувь нь 2-3 удаа гэмт хэрэг үйлдсэн, 16 хувь 4-ээс дээш удаа давтан гэмт хэрэг үйлдсэн байна.

График 8.6. 2018 онд тус дүүгийн иргэдээс хорихоос өөр төрлийн ял эдэлсэн иргэдийн тоон үзүүлэлт



Нийслэлийн Баянзүрх дүүргийн хэмжээнд 2019 оны 10 дугаар сарын 01-ны байдлаар Баянзүрх дүүргийн харьяат 1250 этгээд ял эдэлж байна. Үүнээс:

1. Торгох ял:

Торгох³⁴ ял нь үндсэн ялын чанартай манай улсад өргөн хэрэглэгдэж ирсэн нэн эртний түүхэн уламжлал бүхий ялын бие даасан төрөл юм. 2002 оны Эрүүгийн хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд шүүхээс мөнгөн төлөөс оногдуулахыг торгох ял гэнэ” гэж тодорхойлсон бол 2015 оны Эрүүгийн хуульд “Гэмт хэрэг үйлдсэн хүнд энэ хуулийн тусгай ангид заасан торгуулийн нэгжтэй тэнцүү хэмжээгээр мөнгөн төлбөр оногдуулахыг торгох ял гэнэ”³⁵ гэж хуульчилсан.

Торгох ялын үндсэн агуулга нь нэг талаас, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хорих мэтийн ял хэрэглэхгүйгээр эрүүгийн хариуцлагын гарцаагүй байх зарчмыг хэрэгжүүлэх, нөгөө талаас, гэмт этгээдэд материалын хохирол учруулж цээрлүүлж хашраахад оршино”³⁶ гэж тус тус торгох ялын талаар үзэл бодлоо илэрхийлжээ.

2002 оны Эрүүгийн хууль батлагдахаас өмнө торгох ялын хэмжээг тодорхой хэмжээний мөнгөөр тогтоож байсан нь зах зээлийн эдийн засгийн харилцааны нөхцөлд туйлын оновчгүй зохицуулалт байсныг харгалзан торгуулийн ялын хэмжээг гэмт хэрэг үйлдэгдэх үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид тодорхойлсон нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тогтоосон нь оновчтой зохицуулалт бөгөөд торгох ялын хэмжээ нийгэм-эдийн засгийн болон мөнгөний ханшны өөрчлөлт (өсөлт)-ийг дагаж өөрчлөгдөж байх уян хатан механизм болсон юм.

Торгох ял нь а) түүнийг нэг удаа оногдуулах; б) шүүгдэгчийн эдийн засгийн болон эд хөрөнгийн эрх, ашиг сонирхлыг хөнддөг харин бусад эрх, эрх чөлөөнд ямар нэг хязгаарлалт тогтоодоггүй; в) тэнсэж болдоггүй зэрэг онцлог шинжүүдтэй.

Торгох ялын цээрлэл нь ялтны эд хөрөнгийн эрхийг хязгаарлах замаар түүнд эдийн засгийн дарамт, таагүй үр дагавраар нөлөөлж, эргэж төлөгдөх нөхцөлгүйгээр мөнгөн төлбөрийг шүүхийн шийдвэрээр албадан гаргуулж төрийн өмчлөлд шилжүүлж байгаагаар илэрнэ.

Эндээс үзвэл торгох ял нь Монгол Улсын тухайд эрүүгийн хариуцлагын нэг үндсэн ял болгон хүлээн зөвшөөрсөн түгээмэл хэрэглэгддэг ял бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эдийн засгийн эрхийн байдалд тодорхой хэмжээний хохирол учруулдаг тул түүний цээрлүүлэх гол агуулга нь материаллаг шинжтэй цээрлүүлэлт болох нь тодорхой байна. Түүнээс гадна торгуулсан этгээд нийгмээс тусгаарлагддаггүй тул бие махбодын болон сэтгэл санааны хувьд нийгэм хамт олны дотор

³⁴Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь зохиогчид “Торгууль-ял болгож авах мөнгө юм. Торгох - гэм буруутай үйлдэл хийсэн хүнд шийтгэл болгож мөнгө төгрөг, эд зүйл авах” гэж тайлбарлажээ. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. УБ., 2008. 2017 дахь тал. Я.Цэвэл “Торгууль нь гэм буруутай явдал /гэмт хэрэг. С.Ж/ үйлдсэн хүнд ял болгож и мөнгө авах, мөнгөөр торгох гэсэнтэй дүйтэй байна” гэж тодорхойлолт өгчээ. Я.Цэвэл:-Монгол хэлний товч тайлбар толь УБ., 1967. 213 дахь тал

³⁵ Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл, Улаанбаатар хот, 2016 он, №7

³⁶С.Нарангэрэл.Монгол Улсын эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. УБ., 1999. 277-278 дахь тал; Ж.Болдбаатар. Дурдсан зохиол. УБ., 2008; Г.Эрдэнэбат, Ж.Эрдэнэбулган. Дурдсан зохиол. УБ., 2004; Б.Ганболд. Дурдсан зохиол. УБ., 2003

байж хүмүүждэг онцлогтой байна.

Шүүгдэгчид оногдуулах торгох ялын хэмжээг түүний үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал, хувийн байдал, түүний өмчлөлд байгаа эд хөрөнгийн байдал, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх ба хүндрүүлэх нөхцөл байдлуудыг тал бүрээс нь харгалзан Эрүүгийн хуулийн шударга ёсны зарчимд нийцүүлэн тогтооно.

Торгох ялын хэмжээг тогтооход 2002 оны Эрүүгийн хуулиар нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дүйцүүлэн тооцдог аргачлалыг өөрчилж, 2015 оны Эрүүгийн хуульд “торгуулийн нэгж” гэх хоёр мянган төгрөгтэй тэнцэх илтгэлцүүрийг хуульчилсан. Учир нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хууль тогтоогч биш, харин Засгийн газар, ажил олгогч, үйлдвэрчний эвлэлийн гурвалсан хэлэлцээрээр тогтоож, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай адил гэмт хэргийн хохирол, хэргийн зүйлчлэл, төрийн ялын бодлогод шууд нөлөөлж байгаа нь хууль ёсны зарчимд нийцэхгүй гэж үзсэн.

Төрийн эрүүгийн бодлогын нэг салшгүй хэсэг бол ялын бодлого бөгөөд торгох ялын хэмжээг нэмэгдүүлэх, бууруулах нь төрийн ялын бодлогод хамаарах асуудал тул зөвхөн хууль тогтоох дээд байгууллага Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталж, торгуулийн нэгжийг өөрчилнө.


Үндэсний статистикийн хорооноос хийсэн судалгаагаар сүүлийн 4 жилд манай улсын өрхийн орлого 50 хувиар буурсан болох нь тогтоогдсон байна. Иймд хорих ялын хэрэгжилтийг хангах нөхцөлийг бүрдүүлэх, бодитой байх үүднээс 2017 онд УИХ-аас баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд торгуулийн нэгжийг 2 дахин багасгаж, нэг мянган төгрөг хуульчилсан.

2017 онд УИХ-аас баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд зааснаар торгох ялын хэмжээ 100-40.000 нэгжтэй тэнцүү буюу 100.000-40.000.000 төгрөг байхаар, шүүхээс ялтны хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзан торгох ялыг гурван жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож болохыг заасан. 2002 оны Эрүүгийн хуульд “Торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар сольж болно” гэж заасан бол 2015 оны Эрүүгийн хуульд “Ялтан торгох ялыг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шүүх биелэгдээгүй торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг нэг хоногоор тооцож хорих ялаар солино” гэж хуульчилсан. Ингэснээр торгох ялын биелэлт нэмэгдэх, хууль ёсны зарчим хэрэгжинэ.

Баянзүрх дүүргийн хэмжээнд 2019 оны 09 дүгээр сарын байдлаар торгох ялын нийт 1056 ялтны 1.114.348.000 (нэг тэрбум нэг зуун арван дөрвөн сая гурван зуун дөчин найман мянга)-н төгрөгний гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулснаас 83 хувь буюу 879 ялтны 59 хувь буюу 652.029.000 төгрөгийг бүрэн төлүүлж, 462.319.000 мянган төгрөгний 177 ялтны үлдэгдэлтэй байна.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1д зааснаар тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ гэсний дагуу 2019 оны 12 дугаар сарын 01-ны байдлаар тус дүүргийн харьяалалтай торгох ял эдэлж буй ялтны төлсөн мөнгөний 40 хувь болох 276.674.800 төгрөгийг Баянзүрх дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн нэмэлт санхүүжилтэд тогтмол төлөгдсөн байна.

График 8.7. 2019 онд оногдуулсан торгох ялын биелэлт



2. Нийтэд тустай ажил хийлгэх ял:

Нийтэд тустай ажил хийлгэх ялын зорилго бол ялтанг гэмт хэрэг үйлдсэний улмаас эрх чөлөөгөө хязгаарлуулсан байдал, бие махбод, сэтгэл санааны дарамт, цээрлэлийг ойлгуулж мэдүүлэх, бусдыг хүндэтгэж, хууль ёс, дэг журмыг сахин биелүүлдэг болгон хүмүүжүүлэх, амьдралд нь хэрэгтэй ажил хөдөлмөрийн дадлага, туршлага эзэмшүүлэх, ялтныг хөдөлмөрөөр хүмүүжүүлэх замаар дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршдог.

Нийтэд тустай ажил хийлгэх ял нь ялтныг олон нийтээс тусгаарлахгүйгээр, гэр орондоо байх боломж олгодог бөгөөд нийтэд тустай ажил хийж, гэм буруугаа цайруулах, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөх боломж олгодог.

Дэлхий нийтээр хорих ялын нийгэм болон хувь хүнд үлдээх сөрөг үр дагаврыг улам бүр ойлгох болж, гэмт хэрэг үйлдсэн хүнийг хорих байгууллагад хорихоос өөр байдлаар цээрлүүлэх, засаж хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх арга хэлбэрийг эрэлхийлэх болсны үр дүнд хорихоос өөр төрлийн ялын нэг төрөл болох нийгэмд тустай хөдөлмөр хийлгэх ял буюу албадан ажил хийлгэх ял нь ял шийтгэлийн тогтолцоонд шинээр бий болж эрүүгийн хариуцлагын хамгийн үр нөлөөтэй арга хэрэгсэлд тооцогдон, дийлэнх улс орны эрүүгийн хууль тогтоомжид тусгалаа олж шүүн таслах ажиллагааны практикт өргөн хэрэглэгдэх болсон байна.

“Нийтэд тустай ажил хийлгэх ял” нь Монгол Улсын хувьд 2002 онд шинээр батлагдсан Эрүүгийн хуульд хуульчлагдсан ялын өвөрмөц төрөл юм. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд эрүүгийн хуулийг шинэчлэн найруулж, ялын тогтолцоонд нийтэд тустай ажил хийлгэх ялыг олон улсын жишиг хандлагаас үндэс болгон ялын тогтолцоонд шинээр оруулсан явдал нь эрүүгийн бодлогод зарчмын томоохон өөрчлөлт гарсны нэг илэрхийлэл юм.

Нөгөө талаар НҮБ-ээс баримталж буй хорихоос өөр төрлийн ялыг бий болгож, хэрэглэх зарчмын дагуу ялын бодлогод гарч ирсэн нэгэн дэвшил гэж үзэж болохоор байна.

Гэхдээ ялын тогтолцоонд ялын шинэ төрлийг нэмэхдээ бус уг ялын мөн чанар, агуулгыг хууль хэрэглэгчид хэрхэн ойлгож, практикт яаж хэрэгжүүлж, төлөвшүүлж байна вэ гэдгээс уг ялын үр нөлөө шууд хамаарч, ялын зорилго бүрэн хангагдаж байх ёстой.

Нийтэд ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагаанд баримталж буй хууль тогтоомжийн хэм хэмжээнүүдийн уялдаа холбооноос гадна албадан ажил хийлгэх ялын гүйцэтгэлд хэн хяналт тавих, хяналтыг хэрхэн үр ашигтай зохион байгуулах, хяналтыг ямар байгууллага яаж хэрэгжүүлэх, ял эдлүүлэх ажиллагааг хэрхэн хянах гэсэн олон асуудал албадан ажил хийлгэх ялыг үр дүнтэй хэрэгжүүлэх асуудал чухал юм.

Нийтэд тустай ажил хийлгэх ял нь ялтанг нийгмээс тусгаарлахгүйгээр, гэр орондоо байх боломж олгодог бөгөөд ялтанг шүүхийн шийтгэх тогтоолоор үйлдсэн гэмт хэргийн төлөө хорих байгууллагад хоригдохын оронд нийгэмд тустай ажил хийж гэм буруугаа цайруулах, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо арилгах боломжийг бүрдүүлдэг. Түүнчлэн **нийгэмд тустай ажил гэдэг нь** нийт иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэхэд чиглэгдсэн, тухайлбал хот суурины ногоон бүс, цэцэрлэгт хүрээлэнг тохижуулах, гал түймэр унтраах, зам гүүр, үер уснаас хамгаалах далан хамгаалалт тавих зэрэг үйл ажиллагаа байж болно.

Нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавихад Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон журмыг мөрдлөг болгодог.

Шүүх ялын зорилгод нийцүүлэн нийтэд тустай ямар ажлыг, хэрхэн хийхийг тогтоож, өдөрт дөрвөөс дээшгүй цагаар, нийт 240-720 цаг нийтийн ашиг сонирхолд тустай ажил хийлгэх ял шийтгэх эрх зүйн зохицуулалттай байна.

Нийтийн ашиг сонирхолд тустай ажил гэдгийг зөвхөн хог цэвэрлүүлэх, цас арилгуулах хүрээнд ойлгож болохгүй. Гэмт хэрэг үйлдсэн хүний боловсролын түвшин, мэргэжил, эрхэлж буй ажил, авьяас, чадварыг харгалзан өсвөр насныханд яриа, таниулга хийлгэх, лекц уншуулах, олон нийтийг соён гэгээрүүлэх ном бичүүлэх, уран бүтээл туурвиулах, ахмад настан, асаргаа, сувилгаа шаардлагатай хүнийг асруулах зэрэг хэлбэртэй байж болно.

Ялтан ялыг биелүүлээгүй бол нийтэд тустай ажил хийлгэх ялын найман цагийг нэг хоногоор тооцож, хорих ялаар солино.

Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүнд, биеийн эрүүл мэндэд шууд нөлөөлөхүйц нийтэд тустай ажил хийлгэх ялыг жирэмсэн эмэгтэй, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй хүнд оногдуулахгүй.

Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилтийг ял шийтгэл гарцаагүй байх зарчмын хүрээнд бүрэн биелүүлэх шаардлага шийдвэр гүйцэтгэгч төдийгүй ял эдлүүлж байгаа байгууллагад өндрөөр тавигдах болсныг эрх зүйн зохицуулалтаас бүрэн харж болохоор байна.

Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд:

➤ Шүүхийн шийдвэрт тусгайлан заагаагүй тохиолдолд нийтэд тустай ажлыг нутгийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагаас баталсан жагсаалтад заасан байгууллагад гүйцэтгэнэ.

➤ Ялтныг ажиллуулахаар гэрээ байгуулсан байгууллага шийдвэр гүйцэтгэгчид бүх талын дэмжлэг үзүүлнэ.

➤ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа нэгжгүй нутаг дэвсгэрт оршин суух ялтны ял эдлүүлэх ажиллагаанд харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага хяналт тавих бөгөөд ял эдлүүлэх ажиллагааны талаар 30 хоног тутам Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад бичгээр мэдэгдэнэ.

➤ Ялтны ажлын цагийн бүртгэлийг нийтэд тустай ажил хийлгэхээр гэрээ байгуулсан байгууллага бүртгэж, шийдвэр гүйцэтгэгч ажлын цагийн бүртгэл, ажлын гүйцэтгэлийг үндэслэн ялын тооцоо хийнэ. Шийдвэр гүйцэтгэгч ялтны ажилласан цагийн бүртгэлийг үндэслэн ялын тооцоог үнэн зөв хийх, ял эдлэхээс зайлсхийсэн нөхцөл байдлыг шалган тогтоох, ялтны хувийн хэргийг хөтлөх үүрэгтэй.

➤ Шийдвэр гүйцэтгэгч 7 хоног тутам ялтны ажлыг биечлэн шалгаж, ажлын байрыг шалгасан тэмдэглэлд ялтан болон нийтэд тустай ажлыг хийлгэж байгаа байгууллагын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, баталгаажуулна.

➤ Нийтэд тустай ажлыг хийлгэж байгаа байгууллага нь ялтны хөдөлмөр эрхлэлт, ажлын цаг, ял эдлэлтийн талаар шийдвэр гүйцэтгэгчид 7 хоног тутам тогтмол мэдээлэх үүрэгтэй гэж Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилтийг хэрхэн хангах талаар журамлаж өгсөн байна.

Дээрх эрх зүйн зохицуулалтын хүрээнд нийтэд тустай ажил хийлгэх ялтай этгээдийг ажлын байраар хангах асуудлыг шийдвэрлэж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас дараах байгууллагуудад ажиллуулах жагсаалтыг баталсан. Үүнд:

1. Аймаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд:

- 1) Авто замын хөгжлийн газар;
- 2) Агаарын бохирдлыг бууруулах газар;
- 3) Архивын газар;
- 4) Аялал жуулчлалын газар;
- 5) Байгаль орчны газар;
- 6) Нийтийн биеийн тамир, спортын хороо;
- 7) Боловсролын газар;
- 8) Нийслэлийн Газрын алба;
- 9) Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар;

- 10) Гэр хорооллын дэд бүтцийн газар,
- 11) Дотоод аудитын алба;
- 12) Залуучуудын хөгжлийн газар;
- 13) Мал эмнэлгийн газар;
- 14) Мэдээллийн технологийн газар;
- 15) Мэргэжлийн хяналтын газар,
- 16) Нийгмийн даатгалын газар;
- 17) Нийгмийн халамжийн газар;
- 18) Нийтлэг үйлчилгээний газар;
- 19) Нийслэлийн бүртгэлийн газар;
- 20) Онцгой байдлын газар (Нөөцийн албатай);
- 21) Өмчийн харилцааны газар;
- 22) Статистикийн газар;
- 23) Соёл, урлагийн газар;
- 24) Татварын газар;
- 25) Тээврийн газар;
- 26) Хөдөлмөр эрхлэлтийн газар;
- 27) Хүнс, хөдөө аж ахуйн газар;
- 28) Худалдан авах ажиллагааны газар;
- 29) Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар;
- 30) Улаанбаатар хотын цагдаагийн газар;
- 31) Үйлдвэрлэл, инновацийн газар;
- 32) Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба;
- 33) Эрүүл мэндийн газар.

2. Сум, дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд:

- 1) Боловсролын хэлтэс;
- 2) Биеийн тамир, спортын хороо;
- 3) Газрын алба;
- 4) Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс;
- 5) Дотоодын аудитын алба;
- 6) Замын цагдаагийн хэлтэс;
- 7) Мэргэжлийн хяналтын хэлтэс;
- 8) Онцгой байдлын хэлтэс;
- 9) Статистикийн хэлтэс;
- 10) Соёлын ордон;
- 11) Татварын хэлтэс;
- 12) Улсын бүртгэлийн хэлтэс;
- 13) Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс;
- 14) Худалдан авах ажиллагааны алба;
- 15) Цагдаагийн хэлтэс;
- 16) Эрүүл мэндийн даатгалын хэлтэс;
- 17) Эрүүл мэндийн нэгдэл.


3. Аймаг, нийслэл, сум дүүргийн төрийн өмчит үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудад тус тус эдлүүлнэ.

Эдгээр байгууллагууд нийтэд тустай ажлыг хийлгэж байгаа ялтны ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, цагийг үнэн зөв бүртгэх, ялтны хөдөлмөр эрхлэлт, ажлын цаг, ял эдлэлтийн талаар шийдвэр гүйцэтгэгчид тогтоосон хугацаанд мэдээлэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажлын хувцсаар хангах үүргийг тус тус хүлээнэ.

Баянзүрх дүүргийн хэмжээнд нийтэд тустай ажил хийлгэх ялын нийт 251 ялтны 77099 цагийн гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулснаас 70 хувь буюу 176 ялтны 78 хувь буюу 60221 цагийн ялыг бүрэн эдлүүлж, 16878 цагийн 75 ялтны үлдэгдэлтэй байна.

Нийтэд тустай ажил хийлгэх ялын тухайд тус дүүргээс ял эдлэх боломжтой байгууллагын судалгааг авахад-БЗД НҮГ-1-ээс 4 хүртлэх ӨНӨААТҮГ, Гэр бүл, хүүхэд залуучуудын хэлтэс гэж хариу ирүүлсэн. Бусад ажлын байранд заасан байгууллагуудад ажиллуулах талаар хамтраагүй.

График 8.8. Дүүргийн хэмжээний нийтэд тустай ажил хийлгэх ялын биелэлт



3. Эрх хязгаарлах ял:

2002 оны Эрүүгийн хуульд энэ төрлийн ялыг Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нэгээс таван жил хүртэл хугацаагаар үндсэн ба нэмэгдэл ялын чанартайгаар оногдуулахаар заасан бол 2015 оны Эрүүгийн хуульд шүүх оногдуулсан үндсэн ял дээр нэмж эрх хасах ялыг оногдуулж болохоор, энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрх хасах ялыг заавал оногдуулахаар заасан. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн тусгай ангид заагаагүй ч шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан оногдуулсан үндсэн ял дээр нэмж эрх хасах ял оногдуулж болно. Мөн 2015 оны Эрүүгийн хуульд эрх хасах ялын хугацааг уртасгаж, нэг жилээс найман жил хүртэл хугацаагаар оногдуулахаар заажээ.

Шүүх эрх хасах ялыг хорих ял дээр нэмж оногдуулсан бол уг ялыг эдэлж дууссаны дараа, эсхүл торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял дээр нэмж оногдуулсан бол ял оногдуулсан үеэс, эсхүл хорих ял оногдуулахгүйгээр үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан бол албадлагын арга хэмжээ авсан үеэс хугацааг тоолно.


Хууль тогтоогч 2002 оны Эрүүгийн хуулийн “төрийн албан тушаал эрхлэх” гэснийг “нийтийн албанд ажиллах” гэж өөрчилсөн. Нийтийн алба гэдэгт төрийн албыг бүхэлд нь хамруулан ойлгож болно. Иймээс нийтийн алба нь иргэдийн эрх ашигт нийцсэн төрөөс хэрэгжүүлж буй ажил, үйлчилгээ, бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм. Төрийн албаны тухай хуульд “Төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн алба гэнэ” хэмээн тодорхойлжээ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд нийтийн албан тушаалтан буюу хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийг заасан.

Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан шүүх энэ хуулийн 12 дугаар бүлэгт заасан гэмт хэргийг хүүхдийн эсрэг, эсхүл 16 дугаар бүлэгт заасан гэмт хэргийг үйлдсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид оногдуулсан үндсэн ял дээр нэмж эрх хасах ял оногдуулж болно.

Баянзүрх дүүргийн хэмжээнд эрх хасах ялын нийт 165 ялтны 98516 цагийн гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулснаас 28 хувь буюу 47 ялтны 37 хувь буюу 36759 хоногийн ялыг бүрэн эдлүүлж, 61757 хоногийн 118 ялтны үлдэгдэлтэй байна.

График 8.9. Дүүргийн хэмжээний эрх хасах шийтгэл оногдуусан ялын биелэлт



8.4. Албадлагын арга хэмжээний чиглэлээр:

Албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журмыг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/240, А/369 дүгээр хамтарсан тушаалаар “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга нарын 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/170, А/0138 дугаар хамтарсан тушаалаар “Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх журам”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/169 дүгээр тушаалаар “Зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан хүний зан үйлд нөлөөлөх сургалт явуулах журам”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/137 дугаар тушаалаар “Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан болон хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан, хорих ялаас хугацааны өмнө суллаж, хяналт тогтоосон шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажиллагаанд ашиглагдах маягт”, мөн өдрийн А/138 дугаар тушаалаар “Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажиллагаанд ашиглагдах маягт”-ыг тус тус батлуулан ажиллаж байна.

Эрүүгийн хариуцлага нь ял, албадлагын арга хэмжээнээс бүрдэх ба зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино.

Албадлагын арга хэмжээ тус бүрийг гүйцэтгэх нөхцөл, журмыг авч үзвэл:

Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох

Ялтан гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлж зан байдлаараа нийтэд аюулгүй болсноо нотлон харуулж ял эдлэх хугацаандаа ноцтой зөрчил гаргаагүй, оногдуулсан ялын дараах хувийг эдэлсэн бол прокурорын саналыг харгалзан шүүх хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохоор шийдвэрлэж болно:

1. таван жил хүртэл хугацаагаар оногдуулсан хорих ялын хоёрны нэгээс доошгүй хувийг;
2. таван жилээс дээш арван хоёр жил хүртэл хугацаагаар оногдуулсан хорих ялын гуравны хоёроос доошгүй хувийг;
3. арван хоёр жилээс дээш хорин жил хүртэл хугацаагаар оногдуулсан хорих ялын дөрөвний гурваас доошгүй хувийг эдэлсэн бол.

Хорих ялаас хугацаанаас нь өмнө суллахдаа эдлээгүй үлдсэн ялын хугацаатай тэнцүү хяналтын хугацаа тогтооно. Хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан хүн хяналтын хугацаанд түүнд хүлээлгэсэн үүргийг зөрчсөн бол прокурорын саналыг харгалзан шүүх хяналт тогтоосон шийдвэрийг хүчингүй болгож эдлээгүй үлдсэн ялыг эдлүүлэхээр шийдвэрлэнэ.

Хорих, зорчих эрхийг хязгаарлах ялаас өвчний учир чөлөөлөх

Гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэний дараа сэтгэцийн эмгэгтэй болж өөрийн үйлдлийн бодит шинж чанар, хор уршгийг ухамсарлах, үйлдлээ удирдан жолоодох чадваргүй болсон хүнийг ял эдлэхээс чөлөөлж, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэнэ. Шүүх гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэний дараа ял эдлүүлэхэд саад болохуйц өвчнөөр өвчилсөн тохиолдолд ялтныг ял эдлэхээс чөлөөлж болно. Хорих, зорчих эрхийг хязгаарлах ял эдэлж байх үедээ өөрийн эрүүл мэндэд санаатай хохирол учруулсан хүнийг ялаас чөлөөлөхгүй.

Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах

Шүүх анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Энэ хугацаанд ялтанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавина. Ялтан хүүхдээ асарч хүмүүжүүлэхээс зайлсхийсэн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шүүгч захирамж гаргана.

Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө.

Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх

Хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүн гэм буруугаа хүлээн зөвшөөрч гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж хор уршгийг арилгасан, эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан тухайн зүйл, хэсэг, заалтад заасан хорих ялыг оногдуулахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар тэнсэж болно. Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан хэд хэдэн үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоож болно.

Тэнссэн хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, хязгаарлалтыг зөрчсөн бол шүүх тэнссэн шийдвэрийг хүчингүй болгож ял оногдуулна.

Тэнссэн хугацаанд гэмт хэргийн хохирлыг бүрэн төлж шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлж эрхийн хязгаарлалтыг зөрчөөгүй ба цаашид үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлагагүй гэж үзвэл прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан хугацааг дуусахаас өмнө ялаас чөлөөлж болно. Тэнсэх хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ял оногдуулахгүй.

Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан болон хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон ялтны бүртгэлийг түүний оршин сууж байгаа нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, нэгдсэн тоо бүртгэлийг хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба хариуцан хөтөлнө.

Шийдвэр гүйцэтгэгч тогтоолын биелэлтийг хойшлуулсан шийдвэрийг хүлээн авч дараах ажиллагааг гүйцэтгэнэ:

1. тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдэд хяналт тавих нөхцөл, журам, эрх, үүргийг нь тайлбарлаж, гарын үсэг зуруулах;

2. тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн хувийн бичиг баримт, онцлог содон тэмдэг, ялтны хувийн байдлын талаарх бусад мэдээллийг хувийн хэрэгт тэмдэглэж, ял эдлэлтийн байдалтай холбоотой бусад баримт бичгийг хавсаргах;

3. тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, түүнчлэн ялтныг хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэнийг дуудан ирүүлж, тэдгээрийн эрх, үүрэг, тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдэд хууль, шүүхийн шийдвэрээр тогтоосон хязгаарлалт, даалгасан үүргийг танилцуулах;

4. тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэн үүргээ биелүүлэх талаар шаардлага тавьж, биелэлтийг хангуулах;

5. тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн сахилга, засрал хүмүүжил, шүүхээс даалгасан үүргийн биелэлтийн талаар хяналтын хувийн хэрэгт 30 хоног тутам тэмдэглэл хийх;

6. шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаа дуусмагц энэ тухай прокурор, цагдаагийн байгууллага болон ял шийтгүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэх.

Шийдвэр гүйцэтгэгч тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн засрал хүмүүжлийн байдалд дараахь журмаар хяналт тавина:

1. гадаадад зорчих, цагаачлахыг хориглож, оршин суугаа засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийг 7 хоногоос дээш хугацаагаар орхин явах тохиолдолд зөвшөөрөл авах, 30 хоног тутам нэг удаа биечлэн ирж, бүртгүүлэхийг даалгах;

2. оршин суух газар болон эрхлэх ажил, албан тушаал өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр мэдэгдэж байх тухай баталгаа гаргуулах;

3. тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийг хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэх үүрэг хүлээсэн этгээд болон сум, дүүргийн Засаг даргаас хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх харилцан мэдээлэл солилцоход дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

4. тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн эцэх, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хараа хяналтдаа байлгах хүсэлт гаргасан буюу хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэний хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулах;

5. тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээд шүүхээс тогтоосон хязгаарлалт, үүргийг биелүүлээгүй, эсхүл хяналтаас зайлсхийсэн тохиолдолд албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулах;

6. тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч хянан шийдвэрлэх, эсхүл холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлах;

7. гэмт хэрэг, зөрчил гаргахгүй байх талаар тогтоолын биелэлтийг нь хойшлуулсан этгээдэд санамж, зөвлөгөө өгөх, ярилцлага зохион байгуулах;

8. хяналтад нь байгаа тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн зан байдал, үйл ажиллагааны талаар байгууллага, албан тушаалтнаас тодорхойлолт, лавлагаа авах;

9. тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээд хүндэтгэх шалтгаанаар оршин суух газраа өөрчлөх бол түүний хяналтын хугацааг тооцож, хяналтын хувийн хэргийг шинээр оршин суух газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, шийдвэр гүйцэтгэгчид шилжүүлэх.

Тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээд дараахь үүрэгтэй:

1. байнга оршин суух газраа очсоноос хойш ажлын 3 өдрийн дотор нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд мэдэгдэх;

2. сар тутамд шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд, оршин суугаа нутаг дэвсгэрт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгжгүй бол харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад бүртгүүлэх, шүүхээс хүлээлгэсэн үүргийн биелэлтийн талаар тайлбар гаргах;

3. байнга оршин суух хаягаа өөрчлөх тохиолдолд хяналт тавьж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд, оршин суугаа нутаг дэвсгэрт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгжгүй бол харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад мэдэгдэх, шинээр суурьших нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд, эсхүл цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

4. байнга оршин суугаа газраасаа 7 хоногоос илүү хугацаагаар явах, гадаадад зорчих бол хяналт тавьж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд, оршин суугаа нутаг дэвсгэрт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгжгүй бол харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

5. хяналт тавьж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, цагдаагийн байгууллагын алба хаагч, шийдвэр гүйцэтгэгчийн шаардлагыг биелүүлэх.

Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан, тэнссэн хугацаанд ялтан засарч хүмүүжсэнээ үлгэр жишээ зан төлөв, сурлага, хөдөлмөрт үнэнч, шударга хандлагаараа харуулсан, шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлсэн, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан ялтны хянан харгалзахаар тогтоосон хугацааны 50 хувиас багагүй хугацаа өнгөрсөн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч ялтныг ялаас чөлөөлүүлэх саналыг прокурорт гаргаж болно.

Прокурор хяналтын хувийн хэрэгтэй танилцаж, шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсныг хүчингүй болгох, ялаас чөлөөлөх тухай дүгнэлтээ шүүхэд хүргүүлнэ.

Шийдвэр гүйцэтгэгч санал гаргаагүй, эсхүл прокурор гаргасан саналыг үндэслэлгүй гэж үзсэн бөгөөд шүүхийн тогтоолд заасан хянан харгалзах хугацаа дууссан боловч дараагийн шийдвэр гараагүй тохиолдолд уг хугацаа дуусмагц шийдвэр гүйцэтгэгч цаашид авах арга хэмжээний тухай саналаа хяналтын хувийн хэргийн хамт прокурорт хүргүүлнэ.

Ялтан тэнссэн, тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, эсхүл шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг 6 сарын хугацаанд хоёр, түүнээс дээш удаа зөрчсөн, эсхүл хориглолт, хязгаарлалтыг зөрчсөний улмаас хүн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхолд хохирол учирсан, эсхүл үүргээ биелүүлээгүй бол шийдвэр гүйцэтгэгч 5 хоногийн дотор тэнссэн, тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгуулж, ял оногдуулах саналаа прокурорт хүргүүлнэ.

Прокурор шийдвэр гүйцэтгэгчийн саналыг хүлээн авч үндэслэлийг хянаж тэнссэн, тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгуулах, ял оногдуулах эсэхийг шүүхэд шилжүүлэн шийдвэрлүүлнэ.

Албадлагын арга хэмжээ:

Шүүх ялын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахгүйгээр тэнсэж, эсхүл оногдуулсан ял дээр нэмж дараах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно:

1. үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ;
2. эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ;
3. хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ.

Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ:

Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан хэд хэдэн үүрэг хүлээлгэж, эрхийн хязгаарлалтыг тогтоож болно.

Шүүх дараах үүргийг хүлээлгэнэ:

1. гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авах;
2. зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах;
3. тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх;

5. оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа хяналт тавьж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх.

Шүүх дараах хязгаарлалтыг тогтооно:

1. тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах;
2. галт зэвсэг өмчлөх, эзэмшихийг хориглох;
3. согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох;
4. тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглох.

Шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх уг шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулна. Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан хугацаанд санаатай гэмт хэрэг үйлдсэн бол шүүх уг албадлагын арга хэмжээ авагдсан шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулна.

Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан хүн гэмт хэргийн хохирлыг бүрэн төлж шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлж эрхийн хязгаарлалтыг зөрчөөгүй ба цаашид үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлагагүй гэж үзвэл прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх уг хугацааг дуусахаас өмнө ялаас чөлөөлж болно.

Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан хугацаа дууссаны дараа тухайн хүнд ял оногдуулах эсэхийг прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

Шийдвэр гүйцэтгэгч үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, хязгаарлалтыг биелүүлэх хугацаа, хуваарийг нарийвчлан тогтоож, биелэлтэд нь хяналт тавина.

Зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан хүнд шийдвэр гүйцэтгэгч зан үйлд нөлөөлөх сургалтын агуулга, хөтөлбөрийг танилцуулна.

Шийдвэр гүйцэтгэгч үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн хувийн байдал, албадлагын арга хэмжээ авагдсан хугацаанд хүлээлгэсэн үүргээ биелүүлсэн байдлын талаар шүүх, прокурорын байгууллагад тодорхойлолт гаргана.

Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан этгээд дуудсан цагт хүрэлцэн ирэх, шийдвэр гүйцэтгэгчээс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх, оршин суух газар, ажил, албан тушаал өөрчлөгдсөн тухай болон шаардлагатай бусад мэдээллийг тухай бүр танилцуулах үүрэг хүлээнэ.

Сум, дүүргийн Засаг дарга үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд шүүхээс даалгасан үүрэг, хязгаарлалтыг биелүүлэх талаар зохих туслалцаа үзүүлнэ. Цагдаагийн байгууллага үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан хүний сахилга, шүүхээс даалгасан үүрэг, хязгаарлалтын биелэлт, засрал хүмүүжлийн байдалд хяналт тавих ажилд туслалцаа үзүүлж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албатай харилцан мэдээлэл солилцож хамтран ажиллана.

Шийдвэр гүйцэтгэгч албадлагын арга хэмжээ авагдсан этгээд гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо бүрэн төлсөн, шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлсэн, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй тохиолдолд шүүхээс тогтоосон хугацааны 50 хувиас багагүй хугацаа өнгөрсний дараа хугацаанаас нь өмнө хүчингүй болгох саналыг прокурорт гаргаж болно.

Шийдвэр гүйцэтгэгч үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан этгээд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн талаар хуульд заасан аргаар мэдээлэл авч болно.

Шийдвэр гүйцэтгэгч хугацаа, хуваарь, шүүхээс хүлээлгэсэн үүргийг зөрчсөн этгээдэд албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг хүчингүй болгуулж, ял оногдуулах тухай саналыг прокурорт гаргана. Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд техникийн болон биечилсэн хяналт тавьж болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан хүний зан үйлд нөлөөлөх сургалт явуулах мэргэжлийн нэгж, сургалтын хөтөлбөртэй байна.

Албадлагын арга хэмжээ авагдсан хүний зан үйлд нөлөөлөх сургалтыг тусгай зөвшөөрөл бүхий магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ:

Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан, гэмт хэрэг үйлдсэний дараа хэрэг хариуцах чадваргүй болсон нөхцөлд шүүхээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргана. Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсны улмаас эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан бол шүүхээс уг албадлагын арга хэмжээг зогсоох тухай шийдвэр гаргана.

Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүний сэтгэцийн байдал нь өөртөө, бусдад аюул учруулахааргүй бол шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхгүйгээр сэтгэцийн эрүүл мэндийн холбогдох байгууллагад эмчлүүлэх, асран хамгаалагчид халамжлуулахаар шилжүүлж болно.

Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадвартай байсан боловч хэрэг шалган шийдвэрлэх үед хэрэг хариуцах чадваргүй болсны улмаас эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан бол шүүхээс уг албадлагын арга хэмжээг зогсоож ял оногдуулна. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүн хөөн хэлэлцэх хугацаанд эмчлэгдсэн, хэрэг хариуцах чадваргүй байдал нь арилсан бол шүүхээс түүнд оногдуулсан ялаас эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан нэг хоногийг хорих ялын нэг хоногоор тооцон хасаж үлдсэн ялыг эдлүүлнэ.

Хэрэг хариуцах чадвартай байхдаа ял шийтгүүлсэн ялтны сэтгэцийн эмгэгийг эмчлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд шүүх амбулаторийн албадан хяналтад, эсхүл сэтгэцийн эмгэг

судлаачаар эмчлүүлэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэж болно. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэм, хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг сунгах, өөрчлөх, зогсоох эсэхийг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх шийдвэрлэнэ.

Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан сэтгэл заслын, донтох зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулах ба этгээдийн эмчилгээний зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн бол шүүх албадлагын арга хэмжээг ямар төрлийн эмнэлэгт хэрэгжүүлэхийг тогтоолдоо заана.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэр гармагц уг этгээдийг албадан эмчлэх байгууллагад хүргэх үүргийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хүлээх бөгөөд шүүхийн шийдвэр, сэтгэцийн эмгэг судлалын шинжилгээний дүгнэлт, холбогдох бусад баримт бичгийг хамтад нь хүргүүлнэ.

Албадан эмчлүүлж байгаа этгээдийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, эмнэлэг, цагдаагийн байгууллага хамтран хэрэгжүүлнэ. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх байгууллага дараах үүрэг хүлээнэ:

1. албадан эмчлүүлж байгаа этгээдэд зайлшгүй шаардлагатай шинжилгээ, эмчилгээг цаг тухайд нь хийх;

2. эмчилгээний явц, үр дүнг үнэн зөв, тодорхой тусгах;

3. эмчилгээний үр дүн, өвчний шинж байдлыг харгалзан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг сунгах, өөрчлөх, зогсоох эсэх талаар шинжээчийн дүгнэлт гаргуулах;

4. эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг цаашид хэрэгжүүлэх шаардлагагүй, эсхүл хугацааг сунгах шаардлагатай тохиолдолд энэ тухай прокурорт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад даруй мэдэгдэх.

Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадвартай байсан боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэг хариуцах чадваргүй болсны улмаас эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан бол албадлагын арга хэмжээг цаашид хэрэглэх шаардлагагүй тухай дүгнэлтийг шийдвэр гүйцэтгэгчид, шийдвэр гүйцэтгэгч санал гарган 10 хоногийн дотор прокурорт хүргүүлнэ.

Прокурор дүгнэлт, холбогдох баримт бичгийг үндэслэн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хүчингүй болгож урьд оногдуулсан ялыг үргэлжлүүлэн эдлүүлэх, эсхүл эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хүчингүй болгож, ял оногдуулах тухай дүгнэлт үйлдэж, шүүхэд хүргүүлнэ.

Прокурор саналыг хянан үзэж эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн тохиолдолд уг албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагад шийдвэрийг хүргүүлнэ.

Албадан эмчлүүлж байгаа этгээдийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлт, прокурорын саналаар албадан эмчлэх хугацаа дуусахаас өмнө дүгнэлтийг гаргуулж болно.

Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ:

Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна.

“Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж Монгол Улсад бол энэ хуулийн тусгай ангид заасан, гадаад улсад бол тухайн улсын хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж шууд, шууд бусаар олсон эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгслийг ойлгоно.

Хураан авсан хөрөнгө, орлогыг бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх, хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны зардалд зарцуулна. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын хэмжээ нь

хохирлоос илүү гарсан тохиолдолд улсын төсөвт шилжүүлнэ. Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл нь тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд түүнийг хураан авч хадгалах, устгах, гэмт хэргийн хохирол нөхөн төлөхөд зарцуулна.

Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого хууль ёсны дагуу хийгдсэн хэлцлийн үндсэн дээр бусдын өмчлөлд шилжсэн бол шүүх тухайн эд зүйлийг үнэлж гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох, хураан авахыг хуулиар хориглоогүй хөрөнгө, орлогоос албадан гаргуулж хохирлыг төлүүлнэ. Тухайн хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдэж олсон болохыг мэдсээр байж авсан болох нь тогтоогдвол шүүх уг эд зүйл, хөрөнгө, орлогыг бусдын өмчлөлд шилжүүлсэн хэлцлийг хүчингүйд тооцож, хөрөнгө, орлогыг хураан авч хохирлыг нөхөн төлүүлнэ.

Шүүх хөрөнгө, орлого хураан авахдаа хураан авах хөрөнгө, орлогыг шийдвэртээ нэг бүрчлэн заана.

Хөрөнгө, орлогыг хураах шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа нь шүүхийн шийдвэрт заасан эд зүйл, хөрөнгийг хариу төлбөргүйгээр албадан хураан авах, улсын орлого болгох зорилгоор төрийн холбогдох байгууллагад шилжүүлэх, худалдан борлуулж олсон орлогыг улсын төсөвт оруулах арга хэмжээнээс бүрдэнэ.

Өсвөр насны хүнд оногдуулсан албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх

Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах:

Шүүх анх удаа энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоож болно.

Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүн шүүхээс тогтоосон хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана. Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд санаатай гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд ял оногдуулна.

Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ:

Хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг тэнсэж нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хянан хүмүүжүүлэхээр шийдвэрлэж болно.

Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор үүргийг хүлээлгэнэ.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ. Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хянан хүмүүжүүлэх хугацаанд хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэх үүргийг тодорхой хамт олон, төрийн бус байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садангийн хүн, тодорхой иргэний хүсэлтээр нь, эсхүл зөвшөөрснөөр нь даалгаж болно.

Өсвөр насны хүнд оногдуулсан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг Эрүүгийн хуульд заасны дагуу хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гүйцэтгэх ба прокурор хяналт тавьж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

Хуулийн этгээдэд оногдуулсан албадлагын арга хэмжээ:

Шүүх шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд оногдуулсан ял дээр нэмж дараах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно:

1. эрх хасах албадлагын арга хэмжээ;
2. татан буулгах албадлагын арга хэмжээ;
3. хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ.

Эрх хасах албадлагын арга хэмжээ:

Нэг жилээс найман жил хүртэл хугацаагаар хуулийн этгээдэд нэг, эсхүл хэд хэдэн төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлах, эсхүл эрх хасах албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

Татан буулгах албадлагын арга хэмжээ:

Хуулийн этгээдийг татан буулгах албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ хөрөнгө, орлогыг хураан авч гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөхөд зарцуулж, үлдсэн хөрөнгийг улсын төсөвт шилжүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар нь гэмт хэрэг үйлдсэн бол салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгаж болно.

Хуулийн этгээдийг татан буулгах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг тухайн хуулийн этгээдийг албадан татан буулгаж, улсын бүртгэлээс хассанаар биелэгдсэнд тооцно.

Татан буулгах ажлыг Иргэний хуулийн 32.2-т заасны дагуу татан буулгах комисс гүйцэтгэх бөгөөд татан буулгах комисс /цаашид “Комисс” гэх/-т татан буулгах албадлагын арга хэмжээ авагдсан хуулийн этгээдийн төлөөлөл, ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч, бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөллөөс бүрдсэн дөрвөөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байна.

Комисс нь татан буулгах албадлагын арга хэмжээ авагдсан хуулийн этгээдийг татан буулгах ажлыг Иргэний хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу татан буулгах ажлыг зохион байгуулж, хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасуулах мэдэгдлийг улсын бүртгэлийн асуудал хариуцсан байгууллагад, аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох мэдэгдлийг уг зөвшөөрлийг олгосон этгээдэд хүргүүлнэ.

Улсын бүртгэлийн байгууллага хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасах шийдвэрийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль тогтоомжид заасны дагуу гаргаж, нийтэд мэдээлнэ.

Татан буугдаж байгаа хуулийн этгээдээс шаардах эрхтэй этгээдийн өргөдлийг хүлээн авах хугацаа нь хуулийн этгээдийг татан буугдсан тухай нийтэд мэдээлснээс хойш 2 сараас багагүй, 6 сараас ихгүй байна.

Комисс татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох шаардлагыг дараахь дарааллаар хангана:

1. гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;
2. шүүхийн шийдвэрийн дагуу гаргуулах төлбөр;
3. хөдөлмөрийн гэрээний дагуу ажилтанд төлөх хөдөлмөрийн хөлс;
4. хууль тогтоомжид заасны дагуу бусад этгээдтэй хийх тооцоо.

Хуулийн этгээдэд байгаа мөнгөн хөрөнгө нь шаардлагыг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд Комисс түүний бусад эд хөрөнгийг энэ хуульд заасан журмын дагуу худалдан борлуулж, төлбөрийг барагдуулна.

Харилцагчдын шаардлагыг хангасны дараа үлдсэн эд хөрөнгийг шүүхийн шийдвэрт заасны дагуу шийдвэрлэнэ.

Хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ:

Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хуулийн этгээдийн ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна.

Ахлах шийдвэр гүйцэтгэгч албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн хамт хүлээн авна. Ахлах шийдвэр гүйцэтгэгч шийдвэрийг тоо

бүртгэлд оруулан албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд хяналтын хувийн хэрэг нээж, ажлын 3 өдрийн дотор тойрог хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид хуваарилан, энэ тухай прокурорт мэдэгдэнэ.

Шийдвэр гүйцэтгэгч дараах үндэслэлээр албадлагын арга хэмжээг дуусгавар болсонд тооцож, хяналтын хувийн хэргийг хаана:

- албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг хүчингүй болсонд тооцсон;
- албадлагын арга хэмжээ авагдсан хугацаа дууссан;
- өршөөл, уучлал үзүүлсэн;
- албадлагын арга хэмжээ авагдсан этгээд нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсоноос хойш 2 жилийн хугацаа өнгөрсөн;
- албадлагын арга хэмжээ авагдсан этгээд гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн;
- албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийг хүчингүй болсонд тооцож, ял шийтгэсэн.

Шийдвэр гүйцэтгэгч албадлагын арга хэмжээг дуусгавар болгосон тухай шийдвэрийг ажлын 3 өдрийн дотор прокурор, цагдаагийн байгууллагад хүргүүлнэ.

2018 оны жилийн эцсийн байдлаар Баянзүрх дүүргийн харьяат 292 этгээд тэнссэн, хорих ялаас хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоосон, хорих ял эдлүүлэхийг хойшлуулсан, хөрөнгө орлогыг хураах, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан байна.

2019 оны 10 дугаар сарын 01-ны байдлаар Баянзүрх дүүргийн харьяат 391 этгээд албадлагын арга хэмжээ авагдсан байна. Үүнээс:

1. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан нийт 29 этгээдийн гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулснаас 9 этгээдийг дуусгавар болгож, 20 этгээдийн үлдэгдэлтэй байна.

2. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан нийт 54 этгээдийг хүлээн авч хяналт тависнаас Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 18 этгээдийн албадан эмчилгээг цуцлаж, үлдэгдэл 36 этгээд байна.

3. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан 1 этгээдийн 1.625.000 төгрөгийг хүлээн авч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулан бүрэн төлүүлж дуусгавар болгосон байна.

Баянзүрх дүүргийн засаг даргад үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд шүүхээс даалгасан үүрэг, хязгаарлалтыг биелүүлэх талаар зохих туслалцаа үзүүлнэ гэсэн заалтыг үндэслэн 2019 оны 06 сард ШШГБ-аас албан тоотой хандахад татгалзах зүйлгүй гэж хариу өгсөн ба Баянзүрх дүүргийн 28 хороонд тус заалтыг үндэслэн засаг дарга нарт албан тоотой хандахад:

-12 хорооноос тус хорооны засаг даргын чиг үүрэг биш тул хамтран ажиллах боломжгүй тухай хариу өгсөн.

-16-р хороо нь тус дүүрэгт бүртгэлтэй этгээдүүдийн гэрийн хаяг холбогдох судалгааг гарган өгсөн.

-20-р хороо нь этгээдүүдтэй сургалт хийсэн талаар 3 сарын тайланг хүргүүлсэн ба бусад хороо албан тоотын хариуг ирүүлээгүй байна.

Судалгаа 8.10. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нарын ажлын ачаалал


Д/д	Үзүүлэлт	Хяналтын хувийн хэргийн тоо			
		2017 он /6 шийдвэр гүйцэтгэгч/		2018 оны байдлаар /8 шийдвэр гүйцэтгэгч/	
		Хувийн хэргийн тоо	1 шийдвэр гүйцэтгэгчид	Хувийн хэргийн тоо	1 шийдвэр гүйцэтгэгчид
1	Баянзүрх	273	195	1560	713
	Сонгинохайрхан	299		1377	
	Баянгол	161		835	
	Чингэлтэй	162		738	
	Хан-Уул	154		628	
	Сүхбаатар	120		565	
	Нийслэл дүн	1169		5703	
1	Орхон	212	113	582	390
2	Дархан-Уул	156		501	

3	Дорнод	95		428	
4	Баянхонгор	123		397	
5	Хэнтий	94		383	
6	Хөвсгөл	126		352	
7	Архангай	94		338	
8	Сүхбаатар	77		309	
9	Өмнөговь	86		304	
10	Увс	101		303	
Орон нутаг дун		1164		3897	

8.5. Иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа:


2019 онд шүүхээс шинээр иргэний шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр нийт 51.748.135.400 төгрөгний дүн бүхий 1257 гүйцэтгэх хуудас шинээр ирсэн ба урьд оны үлдэгдэлтэй хамт нийт 177.268.004.200 төгрөгний дүн бүхий 3452 гүйцэтгэх хуудаснаас 12 хувь буюу 20.731.505.400 төгрөгний дүн бүхий 35 хувь буюу 1193 гүйцэтгэх хуудсыг биелүүлж, 156.536.498.800 төгрөгний дүн бүхий 2259 гүйцэтгэх хуудас биелэгдээгүй байна.

График 8.11. Дүүргийн хэмжээнд 2019 онд оногдуулсан торгох шийтгэлийн биелэлт



2019 онд шүүхээс шинээр зөрчлийн хэргийн шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр нийт 245.554.900 төгрөгний дүн бүхий 254 гүйцэтгэх хуудас шинээр ирсэн ба урьд оны үлдэгдэлтэй хамт нийт 250.404.900 төгрөгний дүн бүхий 261 гүйцэтгэх хуудаснаас 55 хувь буюу 137.234.900 төгрөгний дүн бүхий 94 хувь буюу 246 гүйцэтгэх хуудсыг биелүүлж, 113.170.000 төгрөгний дүн бүхий 15 гүйцэтгэх хуудас биелэгдээгүй байна.

График 8.12. Дүүргийн хэмжээнд 2019 онд зөрчилд ногдуулсан шийтгэлийг биелүүлэхээр хүргүүлсэн гүйцэтгэх хуудасны биелэлт



8.6. ДҮГНЭЛТ ЗӨВЛӨМЖ

Нэг. Хорих ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа нээлттэй, хаалттай хорих ангиудад жилд дунджаар Баянзүрх дүүргийн харьяат 250-300 хүн хорих ял эдэлж байна. Түүнчлэн жилд 60-70 орчим хүн хорих ял эдлээд суллагдан тус дүүргийн нутаг дэвсгэрт амьдарч хууль сахиулах байгууллагын хяналтад орж байгаа судалгаа байна.

Хорих ял эдлээд хугацаа дуусч суллагдсан, хугацааны өмнө суллагдсан этгээдэд тавих хяналт ажиллагаа өнөөгийн байдлаар тодорхой үр дүнгүй байгаа нь дахин гэмт хэргийн тоо буурахгүй байгаатай шууд холбоотой юм. Иймээс нутгийн захиргааны байгууллага, хууль сахиулах

байгууллагуудын суллагдсан этгээдэд тавих хяналтыг нийгэмшүүлэх ажилтай холбон хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

Хоёр. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр:

Баянзүрх дүүргийн хэмжээнд нийтэд тустай ажил хийлгэх ялын нийт 251 ялтны 77099 цагийн гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулснаас 70 хувь буюу 176 ялтны 78 хувь буюу 60221 цагийн ялыг бүрэн эдлүүлж, 16878 цагийн 75 ялтны үлдэгдэлтэй байна.

Нийтэд тустай ажил хийлгэх ялын тухайд тус дүүргээс ял эдлэх боломжтой байгууллагын судалгааг авахад-БЗД НҮГ-1-ээс 4 хүртлэх ӨНӨААТҮГ, Гэр бүл, хүүхэд залуучуудын хэлтэс гэж хариу ирүүлсэн. Бусад ажлын байранд заасан байгууллагуудад ажиллуулах талаар хамтраагүй байна.

Баянзүрх дүүргийн засаг даргад үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд шүүхээс даалгасан үүрэг, хязгаарлалтыг биелүүлэх талаар зохих туслалцаа үзүүлнэ гэсэн заалтыг үндэслэн 2019 оны 06 сард ШШГБ-аас албан тоотоор хандахад татгалзах зүйлгүй гэж хариу өгсөн ба Баянзүрх дүүргийн 28 хороонд тус заалтыг үндэслэн засаг дарга нарт албан тоотоор хандахад:

-12 хорооноос тус хорооны засаг даргын чиг үүрэг биш тул хамтран ажиллах боломжгүй тухай хариу өгсөн.

-16-р хороо нь тус дүүрэгт бүртгэлтэй этгээдүүдийн гэрийн хаяг холбогдох судалгааг гарган өгсөн.

-20-р хороо нь холбогдох этгээдүүдэд сургалт хийсэн талаар 3 сарын тайланг хүргүүлсэн ба бусад хороо хариу ирүүлээгүй байна.

Дээрх тоо баримтаас харахад хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа, албадлагын арга хэмжээний хэрэгжилтэд оролцох төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа сул байгаа нь харагдаж байна. Иймээс нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх, үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн дүүргийн хэмжээний нийтийн тустай хөдөлмөрт татан оролцуулах нь чухал байна.

БҮЛЭГ 9. “БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 8 ДУГААР ХОРООНЫ ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ НЬ” СУДАЛГААНЫ ДЭД ТАЙЛАН

Судалгааны дэд баг: Онцгой байдлын сургуулийн Гамшгаас хамгаалах албаны тэнхимийн ахлах багш, хошууч Ц.Ганчимэг, тус тэнхимийн багш нарын хамт хийж гүйцэтгэв.

9.1. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Орчин үед гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь гамшгаас хамгаалах менежментээс гамшгийн эрсдэлийг бууруулах менежментэд шилжиж, нийгмийн эмзэг хэсгийг чадавхжуулах, тэдгээрт учирч болзошгүй эрсдэлийг олон нийтийн оролцоотойгоор бууруулахад чиглэгдэж байна.

Тухайлбал, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас 2015 онд Япон улсын Сендай хотноо зохион байгуулсан Дэлхийн бага хурлаас гаргасан “Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ” баримт бичигт гамшгийн эрсдэлийн ойлголт, мэдлэгийг сайжруулах, хөрөнгө оруулалт хийх, гамшгийн эрсдэлийг удирдах засаглал болон бэлэн байдлын чадавхыг бэхжүүлэх, орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн эрсдэлийг бууруулах” үйл ажиллагааг үндсэн чиглэл болгон тусгасан.

Манай орны хувьд Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор батлагдсан Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийн 3.1.2-т “нутгийн иргэдэд түшиглэн гамшгийн эрсдэлийн судалгааг хийх тогтолцоог бүрдүүлэх” 3.3.1-д гамшгийн эрсдэл, эмзэг байдлын судалгаа хийх арга зүйг иргэдэд зааж, тэдний оролцоотойгоор тухайн орон нутгийн гамшгийн эрсдэлийн судалгаа хийхээр тус тус тодорхойлжээ.

Дэлхийн хэмжээнд хүн, амьтан олноор нэрвэгдэж, тухайн орны эдийн засагт ихээхэн хохирол учруулдаг 40 гаруй төрлийн гамшиг болдог бөгөөд манай оронд тэдгээр аюулт үзэгдэл, осол, гамшгийн 20 орчим төрөл нь тохиолддогийн 60 хувь нь нийслэлд гардаг байна.

Тухайлбал, 2013-2017 оны статистик мэдээгээр нийслэлд 16570 аюулт үзэгдэл, осол тохиолдож, 418 хүн амиа алдаж, 27.7 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.³⁷

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, хүн амын шилжилт хөдөлгөөн, Улаанбаатар хотын экосистемийн бүс дэх хүн амын эрчимтэй өсөлт, хэт төвлөрлийн улмаас нийслэл хотод тохиолдох аюулт үзэгдэл, ослын давтамж, түүнд өртөх эмзэг байдал улам бүр нэмэгдэх хандлагатай байна.

Нийслэлийн хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар нийт 13789 удаагийн объектын гал түймэр гарч 100 том хүн, 39 хүүхэд нийт 139 хүн нас барж, 122 хүн түлэгдэж гэмтсэн тоо баримт байна. Мөн 753 айл өрх үерийн аман дээр байрлаж байгаагаас гадна үерт нийт 47 хорооны 6696 өрхийн, 26784 хүн өртөж болзошгүй байна.³⁸

Улаанбаатар хотод тохиолдож байгаа болон тохиолдож болзошгүй гамшиг осолд газар хөдлөлт, гал түймэр, үерийн аюул тооцогддог бөгөөд сүүлийн жилүүдэд тохиолдсон аюулт үзэгдэл, ослын 91 хувийг объектын гал түймэр эзэлж байгаагийн 70 гаруй хувь нь гэр хороололд гардаг байна.³⁹

Иймд нийслэл хот ялангуяа гэр хороолол, гамшгийн эрсдэлтэй бүсэд оршин суугаа хүн ам, иргэдийн гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийж, тэдгээрт учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, гамшгийг даван туулах чадавхи, бэлэн байдлыг тодорхойлох, гамшгийн дараах үйлчилгээг өргөжүүлэх чиглэлээр судалгаа хийх хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Зорилго, зорилт

Судалгааны зорилго нь гамшгийн эрсдэлтэй бүсэд оршин суугаа иргэдэд учирч болох гамшгийн эрсдэлийг засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн хүрээнд үнэлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах /үйл ажиллагаа/ арга замыг тодорхойлох.

Судалгааны үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны иргэдийн гамшгийн эрсдэлийг үнэлэх, түүнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлох
- Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны иргэдэд учирч болох гамшгийн эрсдэлийг засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн хүрээнд бууруулах арга замыг тодорхойлох
- Судалгааны дүгнэлтийг үндэслэн зөвлөмж боловсруулах

³⁷ Нийслэлийн Онцгой байдлын газар

³⁸ Нийслэлийн Онцгой байдлын газар

³⁹ ОБЕГ-ын шифрийн мэдээ

Судалгааны арга зүй, аргачлал

Судалгаанд дараах аргуудыг ашиглана. Үүнд:

Сонгогдсон өрхүүдийн гамшгийн эрсдэлийг хэмжихдээ дараах аргачлалуудыг ашиглана.

Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 125 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээний заавар”-ыг удирдлага болгоно. Энэ нь аюул, эмзэг байдал, чадавхын харилцан хамаарлаар гамшгийн эрсдэлийн түвшинг илэрхийлдэг арга юм.

$$R=H*\frac{V}{C}$$

R-Эрсдэлийн хэмжигдэхүүн,


H-аюулын хэмжигдэхүүн,

V-эмзэг байдлын хэмжигдэхүүн,

C-чадавхын хэмжигдэхүүн

1. Индикаторын арга: Орон нутгийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлт дээр үндэслэсэн нийгмийн тодорхой түвшний эрсдэлийг тойм байдлаар илэрхийлэхэд илүү дөхөмтэй, шийдвэр гаргах албан тушаалтнуудад гамшгийн эрсдэлийн талаарх суурь мэдээллийг бүрдүүлэхэд ашиглагдана.

Схем 9.1. Аюул, өртөнгө, эмзэг байдал, чадавхыг илэрхийлэх индикаторууд буюу шалгуур үзүүлэлтүүд



Гамшгийн эрсдэлийг индикаторын аргаар тодорхойлоход аюул, өртөх байдал, эмзэг байдал, чадавх гэсэн 4 хэсэгт хуваан авч үздэг. Энэ 4 хэсгийг тодорхойлоходоо эдгээрийг илэрхийлэх индикатор буюу шалгуур үзүүлэлтүүдийг сонгон хэрэглэнэ.

Хүснэгт 9.1. Аюул, өртөнгө, эмзэг байдал, чадавхыг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд

Эрсдэлийн үндсэн хэсгүүд	Дэд үзүүлэлт	Индикаторийн нэр
Аюул	Давтамж	Аюулын тохиолдох давтамж
	Хамрах хүрээ	Аюул нутаг дэвсгэрийг хамрах байдал
	Үргэлжлэх хугацаа	Аюулын үргэлжлэх хугацаа
	Эрт зарлан мэдээлэх боломж	Аюулыг урьдчилан таамаглах боломж
Өртөх байдал	Хүн ам	Иргэдийн амь нас, эрүүл мэндийн өртөх байдал
		Иргэдийн эд хөрөнгө өртөх байдал
	Хүрээлэн буй орчин	Ус агаар хөрс өртөх байдал
	Эдийн засаг	Байгууллагын санхүү өртөх байдал
	Дэд бүтэц	Усан хангамж
		Холбоо
		Цахилгаан
Зам		
Эмзэг байдал	Хүн амын эмзэг байдал	Хүн амын нягтрал
		Ажлын байрны эмзэг байдал
	Хүрээлэн буй орчны эмзэг байдал	Ус, хөрс, агаарын эмзэг байдал
	Эдийн засгийн эмзэг байдал	Байгууллагын нөөц
	Дэд бүтцийн эмзэг байдал	Усан хангамжийн эмзэг байдал
		Холбооны эмзэг байдал
		Цахилгааны эмзэг байдал
Авто замын эмзэг байдал		
Чадавхи	Институцийн чадавх ба менежмент	Эрсдэлийн менежмент/гамшгаас хамгаалах удирдлага
		Эрсдэлийн зураг
		Гамшгаас хамгаалах төлөвлөгөө
		Зарлан мэдээлэх чадавхи
		Харилцан ажиллагаа

	Төлөвлөлт хийх инженерийн арга хэмжээ	Газар ашиглалт төлөвлөлт
		Аюулын сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн хийц бүтээц барих, хүчитгэх байдал
	Нийгмийн чадавхи	Гамшгаас хамгаалах сургалт
		Гамшгаас хамгаалах сайн дурын бүлэг
	Эдийн засгийн чадавх	Байгууллагын гамшгийн нөөц
		Эд хөрөнгийн даатгал
		Эрсдэлийг бууруулах олон нийтийн ажил

2. Асуулгын арга: Анхдагч мэдээллийг түүврийн аргаар цуглуулна. Мөн хэмжилтийн аргын үр дүнд сонгогдсон өрхүүдийг асуулгын аргаар чанарын судалгаанд хамруулан дүн шинжилгээ хийнэ.

Түүврийн зохиомж

Нийслэлд гарсан аюулт үзэгдэл, ослын тохиолдол Баянзүрх дүүрэгт хамгийн өндөр байгаа тул тус дүүргийг сонгон авч, хорооны нийт хүн амын нягтрал, өрхийн тоо өндөр, эрсдэлт нөхцөл үүсч болзошгүй 8 дугаар хороог сонгов.

Түүврийн хэмжээ

Анкетын судалгааны түүврийн хэмжээг Улаанбаатар хотод үнэлж 95% итгэх мужид харьцангуй стандарт алдаа 5% байхаар тооцоход түүвэр 367 байхаар тогтсон.

Түүврийн үе шат

Судалгааны түүврийн дизайны үе шатыг мэдээлэл цуглуулалтын зардлын хамгийн бага түвшинд байх, төлөөлөх чадварын үзүүлэлтүүд (түүврийн алдаа)-ийг хүлээн зөвшөөрөгдөхүйц байх зарчмыг баримтлан Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны өрхүүдээс 367 өрхийг сонгон энгийн санамсаргүй түүврийн аргаар судалгааг авна.

Мэдээлэл боловсруулалт

Судалгааны мэдээллийн шивэлтийг CSPro, үр дүнг боловсруулж, анализ хийхэд SPSS25, программ хангамжыг ашиглана.

Хүлээгдэж буй үр дүн

Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны иргэдийн гамшгийн эрсдэлийн өнөөгийн байдлыг шинжилж эрсдэлийг үнэлэх, болзошгүй эрсдэлийг бууруулах арга замыг тодорхойлж, гамшгийг хохирол багатай даван туулах чадавхыг бэхжүүлэх.

9.2. Баянзүрх дүүргийн 8 хорооны товч танилцуулга

Тус 8 дугаар хороо нь 42 га талбайг хамрах бөгөөд баруун талаараа 13 дугаар хороотой, хойд талаараа 16 дугаар хороотой, зүүн талаараа 10 дугаар хороотой хиллэдэг томоохон гэр хорооллын нэг бөгөөд хороо нь байршлаараа 19 хэсэгт хуваагддаг бөгөөд 48 гудамж, 1084 хашаатай газар нутгийн хэмжээ болон хүн амын суурьшилаараа дүүргийн хэмжээнд дээгүүрт ордог хороо юм.

Хорооны нутаг дэвсгэрийн хүрээнд улсын Ерөнхий боловсролын 27,68,92 дугаар сургууль, СӨБ-ийн 32, 177 дугаар цэцэрлэг, хувийн хэвшлийн бүрэн дунд сургууль 2, их дээд сургууль 2 тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Баянзүрх дүүргийн 8-р хорооны төрийн үйлчилгээний бүтэц.

Ажлын алба:

Хорооны цагдаа:

-Засаг дарга

-Хэсгийн байцаагч-1

-Зохион байгуулагч

-Цагдаа-1

-Нийгмийн ажилтан

-Олон нийтийн цагдаа-1

-Халамжийн мэргэжилтэн

-Урамшуулалт эргүүл-3

-Улсын бүртгэгч

-Үйлчлэгч

-Хэсгийн ахлагч-11

-Тохижилт ОНБ-1


Галч-1

Баянзүрх дүүргийн 8 хорооны нутаг дэвсгэр нь уулын энгэрээ дагасан гуу жалга ихтэй, зөөлөн хөрстэй, хөрсний усны нэвчилт, намаг элбэгтэй, шар өвс /зэрлэг/ их хэмжээгээр ургадаг, газар төлөвлөлт буруу төлөвлөгдсөн, айл өрхийн хаягжуулалт эмх цэгцгүй.

Давуу тал: Газар нутгийн хэмжээ том, цэвэр, бохир усанд холбогдох цаашид хот төлөвлөлтөнд орох бүрэн боломжтой.

Сул тал: Гэр хороолол ихтэй. Хотын төвөөс алслагдсан, /хөдөө орон нутгаас шилжин суурьшигчдын тоо их, дэд бүтэц цэвэр бохир ус, цахилгаан шугам сүлжээ муутай.

Зураг 9.1.



Өрх, хүн амын ерөнхий мэдээлэл

Нийт 5874 өрх, 20034 хүн амтай. Нийт хүн амын 55% буюу 8560 хөдөлмөрийн насны хүн, 305 өрх толгойлсон эх, 1840 эмзэг бүлгийн хүүхэд /үүнээс 44 бүтэн өнчин, 528 хагас өнчин/, 1040 өндөр настан, 360 хөгжлийн бэрхшээлтэй иргэн оршин сууж байна.

Хүүхдийн ачаалал-50.3%, хөгшидийн ачаалал-5.1% нийт хүн ам зүйн ачаалал 55.3%⁴⁰ буюу нийт хүн амын 3810 нь 0-9 насны, 1378 нь 20-35 насны хүүхэд залуучууд эзэлдэг.


Мөн амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх нийт өрхийн 40 гаруй хувийг эзэлж байгаа ба нэн ядуу амьдралтай 581 өрх байдаг бөгөөд энэ нь хүн амын шилжилт хөдөлгөөн ихтэй, үүнийг дагасан ажилгүйдэл нэмэгдэж байдагтай холбоотой юм.

⁴⁰ Энэхүү үзүүлэлт нь 15-64 насны нийт хүн амд ногдох 0-14 насны хүүхэд, 65 ба түүнээс дээш насны хүн амын харьцааг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн насны хүн ам болоод хөдөлмөрийн бус насны хүн ам хоорондын харьцаа

9.3. Гамшиг ослын ерөнхий мэдээлэл

Нийслэлийн хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар нийт 13789 удаагийн объектын гал түймэр гарч 100 том хүн, 39 хүүхэд нийт 139 хүн нас барж, 122 хүн түлэгдэж гэмтсэн тоо баримт байна. Үүний 24%-ийг Баянзүрх дүүрэгт гарсан гал түймэр эзэлж байна.

График 9.1. 2014-2019 оны Объектын гал түймрийн харьцуулалт /дүүргээр/




Эх сурвалж Нийслэлийн Онцгой байдлын газрын шифрийн мэдээ

Баянзүрх дүүрэгт сүүлийн 5 жилийн байдлаар 3682 удаагийн аюулт үзэгдэл тохиолдсоны 3246 удаагийн буюу нийт тохиолдлын 86.3%-ийг объектын гал түймэр эзэлж 18 том хүн, 9 хүүхэд өртөж нас барж, 29 хүн гэмтэж түлэгдсэн байна.

Тус дүүрэгт гарсан объектын гал түймрийн статистик тоог 5 жилээр байдлаар харьцуулан үзвэл 8 дугаар хороо хамгийн өндөр буюу хувийг эзэлж байна.

График 9.2. Баянзүрх дүүрэгт гарсан объектын гал түймэр /хороо тус бүрээр/



Тус 8 дугаар хорооны аюулт үзэгдэл ослын статистикийг сүүлийн 5 жилээр авч үзвэл нийт 204 удаагийн гал түймэр, 27 удаагийн аюулт үзэгдэл, осол гарсны 46.5%-ийг ил, задгай хог, хаягдал шатсан дуудлага эзэлж байсан бол 2019 оны байдлаар 48 удаагийн объектын гал түймэр гарсаны 41.6%-ийг ил задгай хог, 29.1%-ийг гэр, өвөл зуны сууц, 10.4%-ийг автомашин шатсан дуудлага тус тус эзэлж байна.

График 9.3. Тус хороонд гарсан гал түймрийн нөхцөл байдал





График 9.4. Тус хороонд гарсан гал түймэрийн шалтгаан нөхцөл



Дээрх статистик тоо баримтад үндэслэн нийслэлийн Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт гамшгийн эрсдэлийн тойм судалгааг хийлээ.

9.4. Гамшгийн эрсдэлийн тойм судалгаа-Индикаторын арга

9.4.1. Үер

Тойм судалгааг үерийн эрсдэлийг шалгуур үзүүлэлтүүдэд харгалзуулан үнэлж, эрсдэлийг тодорхойлох үндсэн хүчин зүйлүүд буюу аюул, өртөнгө, эмзэг байдал ба чадавхад харгалзах индексийг тодорхойлж, тэдгээрт харгалзах индикаторуудыг тус бүрийн индексид шилжүүлэн нэгтгэсэн.

Үерийн аюулыг нэгтгэн дундаж үзүүлэлтээр гаргахад эрсдэлийн түвшин “дунд” буюу 2-р зэрэгт байна.

Хүснэгт 9.2 Үерийн эрсдэлийн түвшин

Аюулт үзэгдлийн төрөл	Аюул	Өртөх байдал	Эмзэг байдал	Чадавхи	Эрсдэлийн түвшин
Үер	82	69	68	61	44.55

Үерийн усан зайлуулах үерийн далан хаалт хангалтгүй байдаг. Мөн Улаанбаатар хотын хур тунадасны хэмжээ буурсан үзүүлэлттэй байгаа хэдий ч хур тунадастай өдрийн тоо болон нэг удаад орох хур тунадасны хэмжээ, аадар тунадасны давтамж нэмэгдэж байгаа нь үерийн аюул, эрсдэлийг үүсгэж байна.

9.4.2.Хөрсний ус

Тойм судалгааг магадлал хамрах хүрээгээр нь аюулын матрицийг тодорхойлоход хамгийн их магадлал хамрах хүрээ ихтэй төрөлд хөрсний ус орж байгаа бөгөөд эрсдэлийн түвшин “дунд” буюу 2-р зэрэгт байна.

Хүснэгт 9.3 Хөрсний усны эрсдэлийн түвшин

Аюулт үзэгдлийн төрөл	Аюул	Өртөх байдал	Эмзэг байдал	Чадавхи	Эрсдэлийн түвшин
Хөрсний ус	82	56	63	76	41,25

Гэр хороолол, орон сууцны хороолол хосолсон бүсүүдэд хамгийн их тулгамдажбайгаа асуудал нь хөрсний бохирдол, орчны хог хаягдлын болж байна. Гэр хорооллын задгай ариун цэврийн байгууламжийн усны цооног шууд хөрсөнд шингэж байгаа, мөн үерийн байгууламж хангалттай бус байдлаас болж усны халиа үүсч хөрс, орчны бохирдлыг үүсгэдэг байна.

9.4.3.Объектийн гал түймэр:

Тус хорооны объектын гал түймрийн эрсдэлийн индекс нь “дунд” буюу 2-р зэрэгт байна.

Хүснэгт 9.4 Объектын гал түймрийн эрсдэлийн түвшин

Аюулт үзэгдлийн төрөл	Аюул	Өртөх байдал	Эмзэг байдал	Чадавхи	Эрсдэлийн түвшин
Объектийн гал түймэр	57	59	61	77	39

Хүний анхаарал болгоомжгүй үйлдэлээс уламжлан үүсэж байгаа бөгөөд голдуу хүний амь нас, эд хөрөнгө, бизнес, амьжиргааны эх үүсвэр өртөж сүйдэн хүмүүсийн амьжиргаа, амьдралын чанарт сөрөг нөлөө үзүүлж байна.

9.4.4.Газар хөдлөлт:

Тус дүүрэг нь бүхэлдээ газар хөдлөлтийн 6-7 магнитудын бүсэд байрладаг бөгөөд газар хөдлөлтийн индикаторын индексийн газар хөдлөлт, халдварт өвчний эрсдэлийн түвшин “бага ” буюу 3-р зэрэгтэй гэж үнэлэгдсэн байна.

Хүснэгт 9.5 Газар хөдлөлтийн эрсдэлийн түвшин

Аюулт үзэгдлийн төрөл	Аюул	Өртөх байдал	Эмзэг байдал	Чадавхи	Эрсдэлийн түвшин
Газар хөдлөлт	41	52	47	80	19.8

9.4.5.Халдварт өвчин

Хүснэгт 9.6 Халдварт өвчний эрсдэлийн түвшин

Аюулт үзэгдлийн төрөл	Аюул	Өртөх байдал	Эмзэг байдал	Чадавхи	Эрсдэлийн түвшин
Халдварт өвчин	43	48	48	78	20.13

Баянзүрх дүүргийн хэмжээнд 10000хүн амд ноогдох халдвартөвчнийтоо өмнөх оны үед 220.1 байсан бөгөөд 2018 онд 173.8 байгаа нь 21 хувиар буюу 46.3-аар буурсан байна.

9.4.6.Дүгнэлт

Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны гамшгийн эрсдэлийн тойм судалгаагаар аюулт үзэгдлийн магадлал, хамрах хүрээгээр нь эрэмбэлж 5 төрлийн гамшгийн аюулыг тодорхойлж эрсдэлийнтүвшинг үнэлсэн.

Хүснэгт 9.7 Нэгтгэсэн хүснэгтээр үзүүлбэл

Аюулт үзэгдлийн төрөл	Аюул	Өртөх байдал	Эмзэг байдал	Чадавхи	Эрсдэлийн түвшин	
Үер	82	69	68	61	44,5	Дунд
Газар хөдлөлт	41	52	47	79	35,6	Бага
Гал түймэр	57	59	61	77	39	Дунд
Хөрсний ус	82	56	63	76	41.25	Дунд
Халдварт өвчин	43	48	48	78	20.13	Бага

Хүснэгтээс харахад тус хорооны иргэдийн гамшгийн эрсдэлийн түвшин “дунд” зэргийн эрсдэлтэй түвшинд тооцогдож байна.

9.5. Асуулгын аргаар авсан судалгааны дүн:

Гамшгийн үеийн бэлэн байдлыг үнэлэх судалгааг дараах 3 бүлгийн хүрээнд анхдагч мэдээллийг түүврийн аргаар цуглуулж боловсруулсан. Үүнд:

- 1.Өрхийн мэдээлэл
- 2.Иргэдийн гамшиг ослын талаарх мэдлэг

3.Үер, гал түймрийн үеийн бэлэн байдал хүрээнд авч үзэж, судалгааны мэдээллийн шивэлтийг CSPro, үр дүнг боловсруулж, анализ хийхэд SPSS25 программ хангамжуудыг ашигласан.

9.5.1.Судалгаанд оролцсон иргэдийн шинж байдал

Гамшгийн үеийн бэлэн байдал, гамшгийн эрсдэлийн түвшнийг үнэлэх судалгааг Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны 349 өрх, иргэнээс сайн дурын үндсэн дээр санал асуулга авсан.

Судалгаанд оролцсон нийт иргэдийн 57.8 хувь нь эрэгтэй, 42 хувь нь эмэгтэй хамрагдсаныг боловсролын түвшингээр нь авч үзвэл магистр буюу түүнээс дээш 4.0 хувь, бакалавр 24.0 хувь, тусгай дунд 3.2 хувь, бүрэн дунд 65.6 хувь, суурь боловсрол 5.2 хувь, боловсролгүй 0.4 хувийг, ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл тогтмол цалинтай ажилтан 34.4%, хувиараа хөдөлмөр эрхлэгч 26.4%, ажил олгогч 2.4%, өрхийн үйлдвэрлэлд цалин хөлсгүй оролцогч, нөхөрлөл хоршооны гишүүн 2.4%, ажилгүй 32.4%-ийг эзэлж байна.

Энэхүү судалгааны онцлог нь судалгаанд хамрагдсан гэр бүлийн өрхийн орлого, нийгмийн эмзэг бүлэг болох хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өндөр настны мэдээллийг цуглуулж,боловсруулалт хийсэн нь ач холбогдолтой байсан.

График 9.5. Боловсролын түвшин, тоо, хувь







График 9.6. Ажил эрхлэлтийн байдал, хувь



9.5.2.Өрхийн мэдээлэл

Судалгаагаар хорооны иргэдэд тулгарч буй аюулт үзэгдлүүд нь иргэдийн оршин суугаа байршил, хотын төвөөс алслагдсан байдал, амьжиргааны хэв маяг зэргээс хамаарч зарим аюулын үзүүлэх эрсдэл, амьжиргаа болон амьдрах орчин, амь нас, эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл харьцангуй байгааг онцолж байна.

График 9.7. Судалгаанд хамрагдсан өрхийн байр, орон сууцны байдал




Тус 8 дугаар хорооны иргэдийн дийлэнх (86.3%) нь тохилог сууцанд амьдардаг, амьдарч буй орчин нөхцөл харьцангуй сайтай давуу тал байгаа нь аюул, эрдэлээс хамгаалах томоохон чадавх болно гэж дүгнэж болохоор байна.

Иргэдийн амьдарч буй сууцны даатгалын талаарх мэдээллийг харахад 26.6% нь даатгалтай бусад өрхийн хувьд даатгал хэрэгтэй гэж бодсон ч хамрагдаагүй, ихэнх хувь нь даатгал хэрэгтэй эсэхийг мэдэхгүй байгаа нь өндөр үзүүлэлттэй байна.

Хүснэгт 9.9. Иргэдийн амьдарч буй сууцны даатгалын талаарх мэдээлэл

Даатгалтай	93	26.6
Даатгуулах хэрэгтэй гэж бодож байна	46	13.2
Мэдэхгүй	144	41.3
Даатгуулах шаардлагагүй	26	7.4

График 9.8. Судалгаанд хамрагдсан өрхийн амьжиргааны түвшингийн үзүүлэлт




Тус хороонд тохиолдож байгаа гал түймэр, үер, хөрсний бохирдол, халдварт өвчин зэрэг аюул нь амьжиргааны эх үүсвэрт хамгийн хүчтэй нөлөөлж, амьжиргааны эх үүсвэрийг алдагдуулах, өрхийн орлогыг бууруулах, сааруулах (амь нас эрсдэх, хөдөлмөрийн чадвараа хагас ба бүтэн алдах, эмчилгээний зардал гарах) зэрэг сөрөг нөлөөллийг үзүүлж эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна.

Судалгаанаас харахад иргэдийн 6% нь ямар нэгэн аюулт үзэгдэл, осолд өртсөн бол тэдний 2.3% нь төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын дэмжлэг, тусламжид хамрагдсан байна.

9.5.3. Иргэдийн гамшиг ослын талаарх мэдлэгийг үнэлэх

Иргэдийн амьдарч буй газарт аюулт үзэгдэл осол (газар хөдлөлт, үер ус, гал түймэр гэх мэт) тохиолдох магадлалыг 11.2% их, 62.2% бага, 25.8% нь мэдэхгүй гэж хариулсан нь олон нийт гамшгийн эрсдэлийг даван туулах, түүнд дасан зохицох тодорхой аргуудтай байгаа ч хамгийн гол нь эрсдэлийг даван туулах нөөц бололцоогоо ашиглаж чаддаггүй, мэдлэг, мэдээлэл дутмаг, амин хувиа аргацаасан байдал зэрэг нь эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байгааг анхаарч эрсдэлийг бууруулах соёлд суралцах нь чухал гэж дүгнэж байна.


График 9.9. Гамшигаас хамгаалах чиглэлээр сургалт, дадлагад оролцсон байдал



Асуулгын дүнгээс харахад гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр иргэдэд чиглэсэн аюулгүй аж төрөх, аливаа гамшгийн үед өөрсдийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг бууруулах чиглэлээр сургалтыг явуулах, түүнчлэн Гамшгаас хамгаалах тухай хуулинд заасан иргэний эрх, үүргийн хүрээнд гамшгаас хамгаалах сургалтад оролцох оролцоог хангах ажлыг сайжруулах шаардлагатай нь харагдаж байна.

Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх мэдээллийг дүүрэг хороо орчимд суурилуулсан зарлан мэдээллийн самбараас мэдээлэл авах байдал хангалтгүй боловч телевизээр 50.9%, гар утсаар 29.1% нь мэдээллийг хүлээн авдаг бөгөөд асуулгад оролцогчдын 41% нь аюулт үзэгдэл болон түүнээс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх мэдээг үнэн бодитой, хүртээмжтэй авч чаддаг, 43% заримдаа, 13.2% нь чаддаггүй гэсэн байна. Дээрх бүгдээс харахад иргэдийн аюулт үзэгдэл, осолд өртөж байгаа үндсэн шалтгаан нь иргэдийн хэнэггүй хариуцлагагүй, санамсар болгоомжгүй байдал, мэдлэг мэдээлэл дутмаг, мэргэжлийн болон орон нутгийн удирдах байгууллагын идэвхи санаачлага, харилцан ажиллагаа хангалтгүй байгаа зэрэг нөлөөлж байна гэж дүгнэж болох юм.

График 9.10. Гамшиг, осол тохиолдсон үед иргэдийн аюулгүй байдлаа хангаж, бусдыг болон өөрийгөө аварч чадах чадвар мэдлэгийг үнэлсэн байдал



Гамшиг ослын үед өөртөө болон бусдад эмнэлэгийн анхны тусламжийг 47.9% үзүүлж чадна, үер болон гал түймрийн аюул тохиолдвол аюулгүй байдлаа хангах арга хэмжээг авч чадна гэж 45.8% нь хариулжээ. Судалгааны дүнгээс харахад иргэд гамшигийг хэрхэн эрсдэл багатай даван туулах вэ гэдэг арга ухаан, ур чадварт суралцах нь хамгийн чухал. Иймд иргэдэд гамшгаас өөрийгөө болон бусдыгаа хамгаалах мэдлэг, боловсрол олгох, мэдлэгийг зөвхөн сургалтаар олгохоос гадна аюулгүй амьдрах хэвшил дадал олгоход чиглүүлж, хандлагыг өөрчлөх нь ач холбогдолтой юм.

Тус хороонд иргэдийн үер усны аюулаас хамгаалах, эрсдэлийг бууруулах байгууламж хангалтгүй үерийн аюулд өртөх эрсдэл өндөр байгааг харуулж байгаа бөгөөд гамшиг аюулт үзэгдлийн дараа хэрэглэх зорилгоор нөөц бэлтгэх талаар мэдэх үү? гэсэн асуултанд 31.8% мэднэ, 63%

мэдэхгүй, танай гэр бүл аюулт үзэгдлийн дараа хэрэглэх хүнс, цэвэр ус, лаа, шүдэнз, дулаан хувцас зэрэг зүйлийн нөөцтэй юу? гэсэн асуултанд 40.5% нь ямарч нөөцгүй, 20.3% нь байх эсэхийг мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна.

Эдгээр нь нэгдүгээрт гамшгийн нөөц бэлдэх хэмжээнд аюулт үзэгдэл, осол тохиолдоогүй, хоёрдугаарт иргэд аливаа гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тооцох хандлага төлөвшөөгүй, гуравдугаарт амьжиргааны түвшин зэрэг олон хүчин зүйлийн нөлөөлөл бий гэж үзэж болох юм.

2019 оны 11 дүгээр сарын байдлаар тус хороонд гарсан гал түймрийн 42%-ийг ил задгай хог шатсан дуудлага эзэлж байсан статистик тоо баримтаас үндэслэн айл өрхүүдийн хог, үнс нурмаа хэрхэн зайлуулдаг талаар судалгаа авсан.

Хүснэгт 9.10. Айл, өрх үнс нурамаа зориулалтын газарт, эсвэл тагтай саванд хийж аюулгүй болгодог эсэхийг асуумжаар авахад

	Судалгаанд оролцсон өрх	Хувь
тагтай саванд	122	35.1
заримдаа	16	4.6
Ил задгай асгадаг	10	2.9
Хариулаагүй	200	57.3

Гэр хорооллын айлууд үнс, нурмаа ил задгай хаядаг, ойр орчмын жалга судагт хогоо асгадаг, гудамжинд ил задгай хаясан хог, төвлөрсөн хогийн цэг дээр үүссэн хур хог ихэнх тохиолдолд гал түймэр гарах эрсдэлийг үүсгэдэг.

Хүснэгт 9.11. Айл, өрхийн цахилгааны утас, цахилгаан хэрэгслийн бүрэн бүтэн байдал

	Судалгаанд оролцсон өрх	Хувь
тийм	22	6.3
заримдаа	40	11.5
үгүй	263	75.4

Дээрх судалгаанаас харахад айл, өрхүүд харьцангуй гэр ахуйн цахилгааны аюулгүй байдлыг хангаж чадсан гэж харж болохоор боловч судалгаанд хамрагдсан айл, өрхийн 43.8% ахуйн хийн зуух ашигладаг бол заавар, зөвлөмжийг дагаж мөрддөггүй гэж хариулсан нь гал түймрийн эрсдэлтэй орчныг бүрдүүлж, гал түймрийн тоо, хохирол нэмэгдэх эрсдэлт хүчин зүйл болж байна.

Түүнчлэн шаардлагатай үед хэрэглэх гал унтраах багаж, хэрэгсэл байгаа эсэх, ашиглаж чадах тухай асуумжаар тодруулахад 65% нь гал унтраах анхан шатны багаж, гал унтраагуур байхгүй гэж хариулжээ. Эндээс харахад иргэдийн галын аюулгүй байдлыг хангах бэлтгэл бэлэн байдал хангагдаагүй байгаа нь гал түймэрт өртөх эрсдэлийг бий болгож байна.

9.5.3 Дүгнэлт:

Судалгаагаар Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны иргэдийн өрхийн бэлэн байдал, гамшгийн эрсдэлийг үнэлэхэд объектын болон ил задгай хог хаягдлын гал түймэр, үерийн ус, хөрсний усны нэвчилт, халдварт өвчин, барилга байгууламжийн хаягжуулалт тодорхой бус хүн амын нягтаршил ихтэй зэрэг нь гал түймрийн эрсдэлийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байгаа хэдий ч судалгаагаар тухайн хорооны нутаг дэвсгэрийн гамшгийн эрсдэл **28-37%** хувь буюу “**дунд эрсдэлтэй**” гэж дүгнэгдсэн байна.

Тус хороонд гарсан объектын гал түймрийг судалж үзэхэд 41.6%-46.5%-ийг ил задгай шатсан хог, хаягдлын дуудлага эзэлж байгаа нь анхаарал татсан гол асуудал тул ил задгай хог, хаягдлыг зайлуулах буюу хог хаягдлын менежментийг сайжруулснаар гал түймрийн эрсдэл, дуудлагыг бүрэн бууруулах боломжтой гэж дүгнэж байна.

Зураг 9.2. Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны гамшигийн эрсдэл бүхий газрууд



Дээрх судалгаанаас дүгнэн үзэхэд иргэд, олон нийтийн гамшгийн эрсдэлийг даван туулах үндсэн механизм нь

1. Иргэдийн хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэх, хамтын оролцоог дэмжих, урамшуулах
2. Олон нийтийг мэдлэг, мэдээллээр хангах, аюулгүй амьдрах зан үйлийг төлөвшүүлэх
3. Мэргэжлийн болон орон нутгийн байгууллагын хариуцлага, эрх үүргийг сайжруулах
4. Ард, иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах нь ач холбогдолтой гэж үзээд дараах санал, зөвлөмжийг хүргэж байна.

9.5.4. Зөвлөмж

Эрх зүй баримт бичгийн хүрээнд

- 51 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт

51.1.Төсвийн ерөнхийлөн захирагч нь жил бүрийн төсвийн багцдаа гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, зардлыг тусгах

- 3 дугаар зүйл. Хог хаягдалтай холбогдох үйл ажиллагаанд тавих хяналт

Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд улсын мэргэжлийн хяналтын байгууллага, бүх шатны Засаг дарга, цагдаа, хог хаягдлын олон нийтийн байцаагч болон хууль тогтоомжоор эрх олгогдсон албан тушаалтан хяналт тавина.

Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд олон нийтийн хяналтыг төрийн бус байгууллага, иргэдийн бүлэг, иргэн тавина.

Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавина.

9.5.5.Санал

Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор дараах бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээ авах саналыг дэвшүүлж байна.

1. Нийтийн эдэлбэр газар байршуулах хогийн савны шаардлагыг хангасан /хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн/ тусгай хогийн бункерыг дараах цэгүүдэд байрлуулах;

2. Эрдэнэтолгойн 40, 47, 50, 52 дугаар гудамжинд;
3. УС-15 байрны гадаа;
4. Харуул-Алтай байрны гадаа;
5. Улаанхуарангийн 2,9 дүгээр гудамж;
6. 32 дугаар цэцэрлэгийн гадаа зэрэг ил задгай хог шатдаг нийт 9 газарт зайлшгүй байршуулах;

**БҮЛЭГ 10. “АЮУЛГҮЙ ХОТ, ДҮҮРЭГ БОЛОХ ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТ, ИНДЕКС, АРГАЧЛАЛЫГ БИЙ БОЛГОХ”
СУДАЛГААНЫ ДЭД ТАЙЛАН**

НЭГ. УЛААНБААТАР ХОТОД АЮУЛГҮЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

9.1. Хүний аюулгүй байдлын мөн чанар

Хүний эрхийн тэр дундаа хувийн эрхийн эхлэх цэг нь хүний амьд явах эрх юм. Хүн бүрийн энэхүү эрхийн чухалыг олон улсын гэрээ, конвенциудад дурдаж, бүхий л талаас нь хамгаалахыг зорьсон байдаг. Хүний амьд явах эрхийн хүрээнд хүний амьд байх төдийгүй амьдрах эрхийн тухай асуудлаар илүү өргөн хүрээтэй тайлбарлах болсон байна. Тиймээс аливаа улсын төрийн эрхэм зорилгын нэг нь хүний амьд явах эрхийг хуулиар болон эдийн засаг, нийгмийн хувьд бодитойгоор хамгаалах явдал юм. Монгол Улсын Үндсэн хуульд хүний амьд явах эрхийг тунхаглан заасан. Монгол Улсын иргэн аюулгүй, эрүүл орчинд аж төрөх эрхтэй.

Өнөөдөр аливаа үйл ажиллагаа явуулах хандлагад үзэл баримтлалын шинжтэй өөрчлөлт гарч байна. Тухайлбал, хүн төвтэй нийгмийн бодлого, шавь төвтэй сургалт, хүн төвтэй бизнес, хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагаа зэрэг нэр томъёо, хандлага бий болж байгааг нэрлэж болно. Аюулгүй байдлын үзэл баримтлалыг ч энэ хандлагаар авч үзэж болох юм. Тодруулж хэлбэл, хүн төвтэй аюулгүй байдлын асуудал. Хүний аюулгүй байдал бол төрийн боломж, хүсэл зоригийн зэрэгцээ хувь хүний хэрэгцээнд тулгуурласан үйлдлээр хангагдана. Хүний аюулгүй байдал хангагдсан эсэхэд түүнийг хангах үүрэгтэй төр хариулт өгөхийн зэрэгцээ, аюулгүй байдлыг мэдрэгч хүн өөрийн дүгнэлтийг өгөх боломжтой байх ёстой.

“Бусармаг явдлыг хараад дуугүй байна гэдэг бол та түүнд оролцож байна гэсэн үг” гэж Францын философич Жан-Жак Руссо хэлсэн байдаг. Эндээс үзвэл аюулгүй байдлыг хангагч субъект нь төр байхаас гадна иргэдийн оролцоо мөн чухал гэсэн санаа урган гарна. Нөгөө талаар, зөвхөн төрийн байгууллагаас тооцоолон гаргадаг гэмт хэрэг, зөрчил, эрүүл мэндийн зэрэг статистик мэдээнд дүгнэлт хийж, аюулгүй байдлын түвшинг тодорхойлох нь өгөөсгөл юм. Аюулгүй байдлын асуудлаар төвлөрүүлсэн иргэдийн мэдээллийг хамтад нь авч үзэж байж аюул заналын талаар бодит дүгнэлт хийх боломж олдоно.

Судлаачид болон эрх бүхий байгууллагын албан ёсны тайлбарт хүний аюулгүй байдлыг өргөн хүрээнд авч үзэж байна. Тухайлбал, НҮБ-аас гаргасан “Хүний аюулгүй байдлын онол, практик” илтгэлд аюулгүй байдлын агуулгыг дараах байдлаар томъёолсон байна (Хүснэгт №1).

Хүснэгт №1. Хүний аюулгүй байдалд учирч болзошгүй аюулын хэлбэрүүд⁴¹

Аюулгүй байдлын төрөл	Гол аюул занал
Эдийн засгийн аюулгүй байдал	Ажилгүйдэл, ядуурал
Хүнсний аюулгүй байдал	Өлсгөлөн
Эрүүл мэндийн аюулгүй байдал	Халдварт өвчин, аюултай хоол хүнс, хоол тэжээлийн дутагдал, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний хүртээмжгүй байдал
Орчны аюулгүй байдал	Байгаль орчны доройтол, нөөцийн хомсдол, байгалийн гамшиг, бохирдол
Хувийн аюулгүй байдал	Бие махбодийн хүчирхийлэл, гэмт хэрэг, терроризм, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хөдөлмөр
Нийгмийн аюулгүй байдал	Үндэстэн хоорондын, шашин шүтлэг болон бусад үнэмшилд суурилсан хурцадмал байдал
Улс төрийн аюулгүй байдал	Улс төрийн хэлмэгдүүлэлт, хүний эрхийн зөрчил

9.2. Хүний аюулгүй байдлыг хангах Монгол Улсын төрийн бодлого, эрх зүйн орчин

Монгол Улсын Монгол Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон

⁴¹ Human security in theory and practice //Human Security Unit Office for the Coordination of Humanitarian Affairs United Nations. USA. 2009. P.7.

байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн” гэж заажээ. Энэ заалт болон хүний аюулгүй байдалтай холбоотой бусад хууль тогтоомж, бодлогын бичиг баримт, хөтөлбөр, төлөвлөгөөнд хүний аюулгүй байдлын тухай авч үзэхдээ хүний эрүүл мэнд, боловсролтой байх тухай асуудлыг эн тэргүүнд чухалчлан авч үзсэн байна.

Бидний үзэж байгаагаар, хүн эхлээд амьд байх, түүний дараа эрүүл, боловсролтой байх тухай яригдах ёстой. Тийм учраас Дотоод хэргийн их сургуулиас ХЗДХЯ-аар уламжлан ажлын хэсэгт санал хүргүүлснийг хүлээн авч Засгийн газрын 2018 оны 233 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичигт “хүний аюулгүй байдал” гэсэн ойлголтыг тэргүүн зэрэгт эрэмбэлсэн.

Түүнчлэн, хүний аюулгүй байдлыг хангах хэд хэдэн чухал баримт бичиг, хөтөлбөр баталсныг дурдвал:

- ҮСХ-ны даргын 2014 онд баталсан “Эрүүл аюулгүй байдлын индекс”;
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт иргэд, оршин суугчдаа дээдэлсэн, тэдний амьдрах эрүүл аюулгүй, тав тухтай орчныг хангасан “Аз жаргалтай хот” болгох зорилт дэвшүүлсэн;
- Засгийн газрын 2015 оны 4 дүгээр тогтоолоор баталсан “Хотжилт ба эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр;
- ҮСХ-ны даргын 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/160 тоот тушаалаар баталсан “Нийслэлийн эрүүл, аюулгүй байдлын индекс тооцох аргачлал”;
- Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны А/77 дугаар тушаалаар баталсан “Хотын хөгжлийн индекс тооцох аргачлал”;
- Засгийн газрын 2018 оны 20 дугаар тогтоолын Нэгдүгээр хавсралт “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлал”, Хоёрдугаар хавсралт “Орон нутгийн хөгжлийн индекс тооцоход шаардагдах мэдээлэл, тэдгээрийг гаргах байгууллагын жагсаалт” зэрэг.

1990-2019 онд Монгол Улсад 600 орчим салбарын болон салбар хоорондын түвшинд урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг батлагдсанаас одоогийн байдлаар 200 гаруй нь хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын дарга С.Төмөрдуламын мэдээлснээс үзвэл Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангах зорилгоор баталсан, Нийслэлийн нутгийн захиргааны 61 байгууллага үйл ажиллагаандаа мөрдөх учиртай 702 стандарт, 619 норм дүрэм, 15 байгууллагын дүрэм, 57 журам хүчин төгөлдөр үйлчилж байна.

Дээрх баримт бичиг, хөтөлбөрүүд агуулгын хувьд боловсронгуй бус, хэрэгжих хугацаа тодорхойгүй, яам, агентлагуудын бодлогын хоорондын уялдааг хангаагүй байгаа нь төрийн албан хаагчид, судлаачдын шүүмжлэлд өртсөөр байгаа юм.

9.3. Нийслэлийн эрүүл, аюулгүй байдлын индекс тооцох аргачлалд хийсэн дүн шинжилгээ


Эрүүл аюулгүй байдлын индекс болон түүний бүрэлдэхүүн хэсэг болох гол үзүүлэлтүүдийн тооцох аргачлалыг Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөрөөс гаргасан Хүний хөгжлийн индекс, Монгол улсын Засгийн газрын 2010 оны “Хөгжлийн индекс тооцох тухай” 88 дугаар тогтоол, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын гаргасан “URBAN HEART”-(Хотын Зүрх) Хотын эрүүл мэндийн тэгш байдлын үнэлгээ, хариу арга хэмжээ гарын авлагыг ашиглан ерөнхий зарчим, үзүүлэлтийн тодорхойлолт, арга зүйд нийцүүлэн боловсруулж, Үндэсний статистикийн хороогоор анх батлуулжээ.

Улмаар 2015 онд уг аргачлалыг шинэчлэн Нийслэлийн эрүүл, аюулгүй байдлын индекс тооцох аргачлалыг баталсан байна⁴². Аргачлалд “Эрүүл, аюулгүй байдал гэж хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчноос эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлж буй

⁴² ҮСХ-ны даргын 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/160 тоот тушаалын хавсралт

сөрөг хүчин зүйлийг тандах, сэргийлэхэд чиглэсэн нөхцөл, шаардлагыг хэлнэ”⁴³ гэж тодорхойлсон. Дээрх аргачлалын дагуу тодорхойлсон үзүүлэлтийг иргэдэд нээлттэй харуулах цахим хуудас 2015 онд зохиож, байршуулсан боловч өнөөдөр түүнийг ашиглах, шинэчлэх ажил бүрэн хийгдэхгүй байна (Зураг №1).

Зураг №1. Эрүүл аюулгүй байдлын индекс тооцох аргачлалын дагуу тодорхойлсон үзүүлэлтийг иргэдэд нээлттэй харуулах цахим хуудас (хөгжүүлэлт хийгээгүй)



Нийслэлийн эрүүл, аюулгүй байдлын индексийг 7 бүлэг, 29 шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дараах дарааллаар тооцохоор заасан.

Хүснэгт №1. Нийслэлийн эрүүл, аюулгүй байдлын индекс тогтоох шалгуур үзүүлэлт

Бүрэлдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Дээд утга	Доод утга	Жин	Эерэг, сөрөг үзүүлэлт
Хүрээлэн буй орчин	Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ	м2	30.3	0	33%	+
	Агаарын бохирдлыг бууруулах зориулалттай түлш, төхөөрөмж ашигладаг гэр хорооллын өрхийн эзлэх хувь	хувь	100	0	33%	+
	Нэг хүнд ногдох ил задгай үүссэн хог хаягдлын хэмжээ	м3	1	0	33%	-
Дэд бүтэц	Хатуу хучилттай авто замын нягтшил	км/км2	40	0	16%	+
	Цахилгаан эрчим хүчний хангамжтай өрхийн эзлэх хувь	хувь	100	0	16%	+
	Сайжруулсан ариун цэврийн байгууламжид холбогдсон өрхийн эзлэх хувь	хувь	100	0	16%	+
	Баталгаат ундны усны хангамжгүй хүн амын эзлэх хувь	хувь	10	0	16%	-
	Баталгаат ус түгээх цэгийн эзлэх хувь	хувь	100	0	16%	+
	Цахим хэрэглээний түвшин	хувь	100	0	16%	+

⁴³ Нийслэлийн эрүүл, аюулгүй байдлын индекс тооцох аргачлал. 2 дугаар зүйл. 2.1.1.

Эрүүл мэнд	Нялхсын эндэгдлийн түвшин	(1000 амьд төрөлтөд ногдох) тоо	100	0	16%	-
	Нэг хүртэлх насны хүүхдийн өргөн дархлаажуулалтын хамралтын дундаж хувь	хувь	100	0	16%	+
	Нэг хүртэлх насны хүүхдийн өсөлтийн хяналтын хувь	хувь	100	0	16%	+
	10000 хүнд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо	тоо	300	0	16%	-
	Халдварт бус өвчний эрт илрүүлэлтийн үзлэгийн хамралтын хувь	хувь	100	0	16%	+
	Тамхигүй орчин бүрдүүлсэн ААНБ-ын эзлэх хувь	хувь	100	0	16%	+
Хувь хүний аюулгүй байдал	Эрүүл, аюулгүй гадна орчин бүрдүүлсэн цэцэрлэг, ЕБС-ийн эзлэх хувь	хувь	100	0	16%	+
	1000 хүнд ногдох гэмт хэргийн тоо	тоо	100	0	16%	-
	1000 хүнд ногдох зам тээврийн осол гэмтлийн тоо	тоо	100	0	16%	-
	21-ээс дээш насны 1000 хүнд ногдох архи, согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчилдэг цэгийн тоо	тоо	30	0	16%	-
	1000 хүнд ногдох теле хяналтын камерын тоо	тоо	200	0	16%	+
	Газар доорх инженерийн шугам сүлжээний тагтай нээлхийний эзлэх хувь	хувь	100	0	16%	-
Боловсрол	СӨБ-ын хамран сургалтын бохир жин	хувь	100	0	33%	+
	Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин	хувь	100	0	33%	+
	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	хувь	100	0	33%	+
Амьжиргааны зохистой түвшин	Нийгмийн халамж, үйлчилгээ шаардлагатай хүн амын эзлэх хувь	хувь	40	0	40%	-
	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	хувь	70	0	40%	+
	Газар өмчилж авсан иргэдийн эзлэх хувь	хувь	100	0	20%	+
Засаглал	Олон нийтийн дунд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрт хамрагдсан иргэдийн хувь	хувь	10	0	50%	+
	Хаягийн бүртгэлгүй оршин сууж буй хүн амын эзлэх хувь	хувь	10	0	50%	-

Эрүүл, аюулгүй байдлын индекс тооцох аргачлалын 2.3-т эрүүл, аюулгүй байдлын индекс шаардлагатай мэдээллийн эх үүсвэрийг дараах эх сурвалжаас авахаар заажээ.

2.3.1. Салбарын яам, агентлагууд

2.3.2. Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

2.3.3. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэс, Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг

2.3.4. Хөндлөнгийн үнэлгээний багийн тайлан

2.3.5. Холбогдох судалгааны тайлан

Эндээс үзвэл эрсдэлт орчны талаар иргэдээс мэдээлэл авах явдал хангалтгүй байгаа нь анзаарагдана. Мөн индексийн шалгуур үзүүлэлтэд аюулгүй орчны талаар дүгнэлт хийхэд хамааралгүй шалгуурууд байгааг онцолж байна. Тухайлбал, Газар өмчилж авсан иргэдийн эзлэх хувь, Олон нийтийн дунд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрт хамрагдсан иргэдийн хувь зэрэг шалгуур нь аюулгүй

орчны индекс тогтооход нөлөө үзүүлэх шалгуур биш гэж үзэж байна. Нийслэлийн эрүүл, аюулгүй байдлын индексийг 7 бүлэг, 29 шалгуур үзүүлэлтийг бүхэлд нь авч үзвэл тэдгээрийг системийн хандлагаар авч үзээгүй, зөвхөн үр дүнгийн шалгуур үзүүлэлт (гарц) зонхилжээ. Жишээ нь, эрүүл мэндийн дөрвөн шалгуур үзүүлэлт буюу Нялхсын эндэгдлийн түвшин, Нэг хүртэлх насны хүүхдийн өргөн дархлаажуулалтын хамралтын дундаж хувь, Нэг хүртэлх насны хүүхдийн өсөлтийн хяналтын хувь, 10000 хүнд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо гэсэн шалгуур нь зөвхөн эцсийн үр дүнгээр хэмжигдэнэ. Эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтэд орц буюу хүн амд харьцуулсан эмнэлгийн ажилтны тоо, эмнэлгийн ор, эрүүл мэндийн үйлчилгээ, эмчилгээ үйлчилгээний чанар гэсэн шалгуур үзүүлэлт байхгүй байгаа нь индексийг бүхэлд нь өрөөсгөл болгож, үр дүнгүй байдалд хүргэхээр байна.

Хамгийн гол нь эдгээр шалгуурт авлига, албан тушаалын гэмт хэргийг тусад нь шалгуур болгоогүй, зөрчлийг оруулаагүй байгаа нь аюулгүй байдлын индекс тогтоох боломжгүйд хүргэнэ.

Хувь хүний аюулгүй байдлын түвшинг тогтооход эрүүл мэндийн байгууллага, түүнчлэн шүүхийн шинжилгээний байгууллагаас ЭМТ маягтын дагуу гаргадаг осол эндэгдэл, нас баралтын мэдээ, гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоог зайлшгүй харгалзах ёстой. Жишээ нь, 2018 онд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын Нэг цэгийн үйлчилгээгээр 157 иргэн буюу гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 126, бэлгийн хүчирхийлэлд өртсөн 31 иргэн үзүүлсэн байна. Эдгээр нь гэмт хэрэг болж бүртгэгдээгүй байж магадгүй юм. Мөн Шүүхийн шинжилгээний байгууллагаас Эрүүл мэндийн яамны мэдээллийн системд оруулдаг нас баралт, түүний шалтгааныг дараах хүснэгтээс харж болно (Хүснэгт №2).

Хүснэгт №2. Нас баралтын шалтгаан (улсын хэмжээнд, 2018 оны дүн)⁴⁴

Нас баралтын шалтгаан		Бүгд	Хүйс	
			Эр	Эм
А		1	2	3
Мохоо зүйлээр хорлох		291	252	39
Зам тээврийн осол		622	456	166
Галт зэвсгийн гэмтэл		27	26	1
Хурц ир үзүүртэй зүйл		82	70	12
Механик амьсгал бүтэлт		495	428	67
Өндрөөс унах		98	78	20
Амьсгаа боох бусад осол		114	89	25
Осгох		248	214	34
Түлэгдэх		40	30	10
Усанд живэх		165	130	35
Хордлого	Угаарын хийн	86	59	27
	Архины	766	631	135
	Хоолны	5	2	3
	Эмний	0	0	0
	Бусад	87	67	20
Цахилгаан гүйдлийн гэмтлээс		8	8	0
Гэнэт нас барах /өвчнөөр/		1146	902	244
Бусад осол		59	50	9
Төрөхтэй холбоотой	Эх	7	0	7
	Ураг, нярай	72	40	32
Эмнэлгийн үйлчилгээний үед		7	5	2

⁴⁴ Шүүхийн шинжилгээний статистик-2018. Уб. 2019.

Шалтгаан тодорхойгүй	67	56	11
Нийт	4492	3593	899

9.4. Орчны аюулгүй байдлын талаар мэдээлэл цуглуулах бусад оролдлого

2019 онд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нийслэлийн нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, хэрэгжиж буй стандартыг мөрдүүлэх зорилтын хүрээнд орчны тохижилт, инженерийн шугам сүлжээ, авто замын засвар үйлчилгээний нөхцөл байдал зэрэгт нэгдсэн үзлэг шалгалт, судалгаа хийх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулжээ. Ажлын хэсгийн хийсэн судалгаанд иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг алдагдуулж буй зөрчил, дутагдал, тэдгээрийн хүчин зүйлсийг бодитоор тодорхойлж, дүгнэлт гаргах, цаашид холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор 54 хүний бүрэлдэхүүнтэй есөн дүүргийн 152 хороонд 14 хоног үзлэг, судалгаа хийж дууссан байна⁴⁵. Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар, Газар зохион байгуулалтын албанаас хийсэн мэдээллээс үзвэл “Иргэдийн ая тухтай амьдрах нөхцөл байдлыг зөрчсөн 5423 асуудал байгааг үзлэг шалгалтаар тодруулан асуудлуудыг бүлэглээд холбогдох байгууллагуудад аюулгүй байдлыг хангуулахаар өгчээ (Зураг №2)

Зураг №2. Орчны тохижилт, аюулгүй байдлын талаар цуглуулсан мэдээлэл



Орчны аюулгүй байдлын талаар мэдээлэл цуглуулах бас нэг оролдлого бол Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 1111 төвийг 2012 оноос ажиллуулж байгаа явдал юм. “Хүнд суртлыг халж, хурдан шуурхай үйлчилгээг эрхэмлэж иргэдийн саналыг 10 сувгаар хүлээн авч, түүнд тодорхой хариулт өгөхөөр тус төвийг байгуулсан” гэж тус төвийн цахим хуудаст дурдсан байх ба байгуулснаас хойш 150,000 орчим санал, хүсэлт, гомдол, талархал хүлээн авчээ. Иргэд хотын аюулгүй байдлын талаар мэдээлж байгаа эсэхийг тогтоохын тулд бид тус төвд 2019 оны 12 дугаар сард бүртгэж авсан мэдээллийг ялган авч шинжилгээ хийлээ. Судалгаагаар дараах байдал ажиглагдав.

Дурдсан сард нийт 410 мэдээлэл ирсэн байх бөгөөд тэдгээрийг ангилж үзвэл хүсэлт 246, гомдол 71, шүүмжлэл 2, талархал 91 байна. Биечлэн ирж өгсөн мэдээлэл 26, бусдыг нь утсаар ярих, мессеж бичих зэргээр ирүүлжээ. Санал хүсэлт, талархлыг холбогдох байгууллагад нь хүргүүлсэн байна. Тухайлбал, НЗДТГ-т 206, Эрчим хүчний яаманд 34, ЭМЯ-нд 29, Улсын их хурлын тамгын газарт 16, НДЕГ 7, Татварын ерөнхий газарт 5, ЦЕГ-т 4, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 4, Зам, тээврийн хөгжлийн яаманд 3, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 1, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт 3, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт 2, Төрийн өмчийн бодлого,

⁴⁵ <https://ulaanbaatar.mn/>

зохицуулалтын газарт 2, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 1, Сангийн яаманд 3 мэдээлэл шилжүүлсэн.

Иргэдийн санал хүсэлтийг олон сувгаар хүлээн авах боломжтой байгаа нь сайшаалтай боловч нийт мэдээллийн багагүй хувийг иргэдийн талархал эзэлж байгаа нь төвийн “иргэдийн хүсэлтийг хүлээн авч, шуурхай шийдвэрлэх” зорилгод нийцэхгүй байгаагаас гадна тус төвийн үйл ажиллагаанд ачаалал нэмэхээр байна. Тухайлбал, “...дүүргийн ийн эрүүл мэндийн төвийн хамт олонд талархал илэрхийлмээр байна. Шинэ ондоо ажлын өндөр амжилт гаргахыг хүсэн ерөөе. Холбогдох газар нь дамжуулж өгнө үү” гэсэн утгатай зар олон байснаас үзвэл тухайн мэдээллийг зохиомлоор дамжуулж байгааг ч үгүйсгэмгүй юм. Бид дээрх мэдээллээс 249 мэдээлэлд дүн шинжилгээ хийлээ. Ингэхдээ, Дэлхийн хотуудын аюулгүй байдлын түвшин (индекс) тогтоох шалгуурт хамаарах эсэхээр нь тодорхойлохыг оролдов. Судалгааны үр дүнгээс үзвэл дэд бүтцийн аюулгүй байдалд холбогдох мэдээлэл 33%, эрүүл мэндийн аюулгүй байдалд холбогдох мэдээлэл 15%, хувь хүний аюулгүй байдалд холбогдох мэдээлэл 4%, цахим орчны аюулгүй байдалд холбогдох мэдээлэл 2%-ийг эзэлж байна (Хавсралт №1).

Бид судалгааны үр дүнд Улаанбаатар хотод аюулгүй орчин бүрдүүлэх бодлогын хэрэгжилт хангалтгүй байна гэж дүгнэж байгаа бөгөөд энэ нь дараах шалтгаантай байна. Үүнд:

1. Эрсдэлт орчны талаар цогц мэдээлэл авах, боловсруулалт хийх, байнга шинэчлэгдэж байх тогтолцоо, технологийн шийдэл бий болгож, хөгжүүлж чадаагүй;
2. Эрсдлийг шуурхай арилгах, хариуцлага тооцох тогтвортой засаглал төлөвшөөгүй.

АРАВ. ДЭЛХИЙН ХОТУУДЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТҮВШИН (ИНДЕКС) ТОГТООЖ БУЙ АРГАЧЛАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

10.1. Аюулгүй байдлын 2019 оны индекс

The Economist Intelligence Unit⁴⁶ буюу Эдийн засгийн тагнуулын албанаас жил бүр Хотуудыг аюулгүй байдлын түвшингээр нь эрэмбэлдэг. NEC группын дэмжлэгтэйгээр гаргадаг тус жагсаалтыг *цахим аюулгүй байдал, эрүүл мэндийн аюулгүй байдал, дэд бүтцийн аюулгүй байдал, хувь хүний аюулгүй байдал гэсэн* дөрвөн үндсэн шалгуур ба дэд шалгуур үзүүлэлтээр гаргаж байна. Эрэмбэ тогтоох бүр дэд шалгуурууд өөрчлөгдөж байгаа нь нийгмийн хөгжлөөс шалтгаалж эрсдэлт хүчин зүйлд өөрчлөлт орж байдагтай холбоотой ажээ. 2015 онд 44 дэд шалгуураар 50 хотыг, 2017 онд 49 шалгуураар 60 хотыг, 2019 онд 57 шалгуураар 60 хотыг эрэмбэлсэн байна.

2019 онд эрэмбэлсэн 60 хотыг 92.0 оноогоор Токио хот тэргүүлж, Сингапур, Осака, Амстредам, Сидней, Торонто, Вашингтон Ди Си, Копенгаген, Сөүл, Мельбурн удаалснаар эхний 10 хот эрэмбэлэгджээ.

Байр	Хот	Оноо	Байр	Хот	Оноо
1	Tokyo	92.0	31	Beijing	70.5
2	Singapore	91.5	32	Shanghai	70.2
3	Osaka	90.9	33	Santiago	69.8
4	Amsterdam	88.0	34	Buenos Aires	69.7
5	Sydney	87.9	35	Kuala Lumpur	66.3
6	Toronto	87.8	36	Istanbul	66.1
7	Washington DC	87.6	37	Moscow	65.8
=8	Copenhagen	87.4	38	Kuwait City	64.5
=8	Seoul	87.4	39	Riyadh	62.5
10	Melbourne	87.3	40	Mexico City	61.6
11	Chicago	86.7	41	Rio de Janeiro	60.9
12	Stockholm	86.5	42	Sao Paulo	59.7
13	San Francisco	85.9	43	Manila	59.2
14	London	85.7	44	Johannesburg	58.6
15	New York	85.5	=45	Lima	8.2
16	Frankfurt	85.4	=45	Mumbai	8.2

⁴⁶ Энэ байгууллага Лондон, Нью-Йорк, Хонконг, Сингапур, Женев хотод төвтэй.

17	Los Angeles	85.2	=47	Bangkok	57.6
=18	Wellington	84.5	=47	Ho Chi Minh City	57.6
=18	Zurich	84.5	49	Baku	56.4
20	Hong Kong	83.7	50	Quito	55.3
21	Dallas	83.1	51	Bogota	55.1
22	Taipei	82.5	52	New Delhi	55.0
23	Paris	82.4	53	Jakarta	54.5
24	Brussels	82.1	54	Casablanca	53.5
25	Madrid	81.4	55	Cairo	48.6
26	Barcelona	81.2	56	Dhaka	44.6
27	Abu Dhabi	79.5	57	Karachi	43.5
28	Dubai	79.1	58	Yangon	41.9
29	Milan	78.1	59	Caracas	40.1
30	Rome	76.4	60	Lagos	38.1

Хотын аюулгүй байдлын түвшинг тодорхойлохдоо үндсэн дөрвөн шалгуур тус бүрийг 25 хүртэл оноогоор дүгнэх бөгөөд энд цахим аюулгүй байдлын асуудлыг бусад аюулгүй байдалтай ижил түвшинд авч үзэх болсон шалтгаан анхаарал татаж байна. Сүүлийн жилүүдэд цахим технологи улам хурдацтай хөгжиж, түүнийг дагалдаж аюулгүй байдлын асуудал хурцаар тавигдах болсон. Тухайлбал, АНУ-д нэгэн гэр бүлийн IP хяналтын камерт хакер нэвтэрч, гэрт байсан 8 настай охинд “Би Санта Клаус байна” гэж хэлсэн тохиолдлыг CNN мэдээлсэн байна⁴⁷. Энэ бол зөвхөн нэг тохиолдлын талаар мэдээлсэн хэрэг юм. Сүүлийн үед манай улсад хяналтын камер суурилуулах нь нийтлэг үзэгдэл болжээ⁴⁸. Түүнчлэн хүүхдээ гар утсаараа харж байх зорилгоор гэртээ, болон цэцэрлэгт IP камер суурилуулах явдал элбэшив. Энэ нь аюулгүй байдалдаа анхаарч буй нэг хэлбэр мөн боловч хакерийн халдлагад өртөх, улмаар ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй эрсдэл дагуулж болзошгүй байна. Дээрх нөхцөл байдал бол цахим аюулгүй байдлын зөвхөн нэг хэлбэр юм.

10.2. Түвшин тогтоох шалгуур үзүүлэлт

Хот бүрт дөрвөн үндсэн шалгуур үзүүлэлтээр оноо өгдөг. Шалгуур бүр 3-12 дэд шалгуураас бүрдэх ба эдгээр нь бодлого, үйл ажиллагаа зэрэг орц, агаарын чанар, гэмт хэргийн гаралт гэх мэт гарцуудыг агуулж байна.

Цахим орчны аюулгүй байдал нь хотын иргэд хувийн нууцаа алдах, эсвэл хүн хулгайлахаас айхгүйгээр интернет болон бусад цахим сувгуудыг чөлөөтэй ашиглах боломжийг талаарх үнэлгээ юм. Орцод иргэдийн цахим аюулын талаарх мэдлэг, ашиглаж буй технологийн түвшин, кибер хамгаалалтын тусгай багууд байгаа эсэхийг дүгнэдэг. Гарц нь файл хулгайлсан давтамж, вирусын халдвар авсан компьютерийн тоогоор хэмжигдэнэ.

Эрүүл мэндийн аюулгүй байдлыг хэмжихдээ хотууд орчин тойрноо тордож буй байдал, тусламж үйлчилгээний түвшин, чанар зэргийг харгалзана. Орцод хотын хүрээлэн буй орчны бодлого, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг авч үздэг бол гарцын шалгуур үзүүлэлтэд агаар, усны чанар, дундаж наслалт, нялхсын эндэгдэл багтана. Хотод гарсан химийн, биологийн болон цацраг идэвхт халдлагад анхаарал хандуулахын тулд түүнийг шинэ дэд үзүүлэлт болгож авсан.

Дэд бүтцийн аюулгүй байдал нь хүний гараар бүтсэн физик орчин, тухайлбал, хотын дэд бүтэц гамшиг, террорист халдлагад өртөж болзошгүй эмзэг байдлыг авч үзнэ. Орцод дэд бүтцийн чанар, тээврийн аюулгүй байдлын сахилга бат зэрэг дэд үзүүлэлтүүдийг харгалзан үзэх бөгөөд гарцад тээврийн хэрэгслийн осол, явган зорчигчдын амиа алдсан тоо, террорист халдлагын тоо зэргийг багтаана.

Хувь хүний аюулгүй байдал нь иргэдийг гэмт хэрэг, хүчирхийлэл болон бусад заналхийллээс хэрхэн хамгаалж буй байдлаар авч үздэг. Орцын үзүүлэлтүүд нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж буй байдал, түүнчлэн улс төрийн тогтвортой байдал зэрэг бодлого шийдвэрийг харгалзан үздэг. Харин гарцад гэмт хэрэг, зөрчил, иргэдийн аюулгүй

⁴⁷ <https://edition.cnn.com/>

⁴⁸ Улаанбаатар хотод байгаа хяналтын камерийн тоо, судалгаа тодорхойгүй байна. Гадаад дотоод орчны хяналтын камерыг бүртгэх Нийслэлийн Засаг даргын 2014 оны 7-р сарын 25-ны өдрийн А/633 тоот захирамж гарсан боловч энэ ажил бүрэн хийгдээгүй.

байдлын ойлголт /иргэдийн оролцоо/, түүнчлэн иргэний үймээн, цэргийн мөргөлдөөн, терроризмын аюул зэрэг шинэ дэд үзүүлэлтүүдийг харгалзан үзэж байна.



2017 онд 49 дэд шалгуураар аюулгүйн түвшинг тодорхойлж байснаа 2019 онд 57 дэд шалгуур болгон нэмэгдүүлсэн. Энэхүү индексийн 57 үзүүлэлтээс 17 нь тоон мэдээлэлд үндэслэсэн, бусад нь чанарын судалгаанд үндэслэсэн байна. 2019 оны үзүүлэлтэд нэмэгдсэн нэг шалгуурыг жишээ болгон дурдвал, нэг сая оршин суугчид оногдох зам тээврийн ослын улмаас нас барсан хүний тоо. Нэмсэн шалгуурууд:

Цахим орчны үзүүлэлтэд: Орон нутгийн чанартай аюул; **Эрүүл мэндийн үзүүлэлтэд:** Хотын түргэн тусламжийн үйлчилгээ; **Дэд бүтцийн үзүүлэлтэд** Агаарын тээврийн байгууламж, Төмөр замын сүлжээ, Цахим аюулгүй байдлын бэлэн байдал, Байгууллагын чадавхи, нөөцийн хүртээмж, Гамшгийн эрсдлийн даатгал Гамшгийн эрсдэлтэй мэдээлэл боловсруулах Зам тээврийн осол эндэгдэл Авто замын сүлжээ Эрчим хүчний сүлжээ; **Хувь хүний аюулгүй байдалд:** Хуулийн байгууллагын тогтолцооны үр нөлөөтэй байдал, Аюулын хяналт шинжилгээ.

Шалгуурыг тоон болон чанарын гэсэн хоёр төрөлд хуваагдана. Индексийн 57 үзүүлэлтийн арван найм нь тоон мэдээлэлд суурилжээ. Жишээлбэл, нэг сая хүн тутамд жилд тохиолддог авто тээврийн ослын давтамж. Гучин нэгэн шалгуур үзүүлэлт нь хотын аюулгүй байдлын чанарын үнэлгээ юм. Тухайлбал, улс төрийн тогтвортой байдлын эрсдэл, дэд бүтцийн чанарын үнэлгээ.

10.3. Орц, гарцын шалгуур ба хэмжих нэгж, мэдээллийн эх сурвалж

Дэлхийн аюулгүй хотын түвшин тогтоох судлаачдын баг 2019 оны 6-р сараас 8-р сарын хооронд өгөгдөл цуглуулсан. Эдийн засгийн тагнуулын албаны мэдээллээс гадна хотуудыг амьдрах чадвар, эрсдлийн болон бусад асуудлаар хэмждэг ижил төстэй байгууллагын албан ёсны эх сурвалжаас хамгийн сүүлийн үеийн нийтэд нээлттэй мэдээллийг ашигласан байна. Анхдагч эх сурвалжид Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Транспаренси Интернэшнл, Касперский лаборатори болон бусад холбогдох хүмүүс орсон (доорх хүснэгтийг үзнэ үү). Боломжтой бол ашиглагдсан өгөгдөл нь Тухайн хотын онцлог шинжтэй, эсвэл түүний оронд улсын ба үндэсний шинжтэй өгөгдлийг ашигладаг.

Хотуудын өгөгдлийг хооронд нь харьцуулах, түүнчлэн хот тус бүрийн онооны нийлбэрийг бүрдүүлэхийн тулд төслийн багийнхан эхлээд цуглуулсан өгөгдлийг харьцуулах шаардлагатай байжээ. Үүний тулд тоон үзүүлэлтийг мин-макс тооцоолол ашиглан 0-100 онооны масштабаар нормчилсон бөгөөд хамгийн сайн оноо 100 оноо, хамгийн муу оноо 0 байна. Чанарын шалгуур үзүүлэлт сайн

нормчлогдсон гэдгийг тайланд дурдсан байна. Зарим тохиолдолд эдгээр оноо 0-100-ийн хооронд хэлбэлзэнэ. Зарим тохиолдолд 1-5 гэсэн оноог ашигласан. 1 нь хамгийн бага буюу сөрөг оноо, 5 нь хамгийн өндөр буюу эерэг оноо юм. Бусад үзүүлэлтүүдийг хоёр, гурав, дөрвөн оноогоор дүгнэхээр тооцоолсон байна.

Аюулгүй байдлын нийлбэр оноог гаргахдаа эхлээд дэд шалгуур тус бүрээр оноог гаргана. Эцэст нь ерөнхийдөө үндсэн 4 чиглэлийн онооны нийлбэр дээр үндэслэсэн байр эзлүүлнэ. Үндсэн шалгуурын оноог гаргахын тулд шалгуур үзүүлэлт бүрийг өгөгдсөн жингийн дагуу дүгнэнэ. Дөрвөн үндсэн чиглэл бүгд ижил жинтэй буюу тус бүр 25, 25 хувьтай байхаар тооцоолжээ.

Эцэст нь бид, шалгуур, дэд шалгуурыг орц, гарц, оноо өгөх аргачлал, мэдээллийн эх сурвалжийг нэгбүрчлэн авч үзлээ (Хүснэгт №2).

10.3.1. Цахим орчны аюулгүй байдал (эзлэх жин 25%)⁴⁹

А. Орц

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Мэдээллийн эх сурвалж
1.1.1. Нууцлалын бодлого	1 – 5 оноо 5 = хүчтэй бодлоготой	Дэлхийн өгөгдлийн сангийн тухай хууль тогтоомжийн судалгаа ⁵⁰ ; Эдийн засгийн тагнуулын албаны судалгаа ⁵¹
1.1.2. Цахим аюулын талаарх иргэдийн мэдлэг	0 – 3 оноо 3 = сайн мэдлэгтэй	Эдийн засгийн тагнуулын албаны судалгаа
1.1.3. Төр хувийн хэвшлийн түншлэл	0 – 2 оноо 2 нягт түншлэлтэй	Эдийн засгийн тагнуулын албаны судалгаа
1.1.4. Ашиглаж буй технологийн түвшин	0 – 100 100 = өндөр	Эдийн засгийн тагнуулын албаны судалгаа
1.1.5. Кибер аюулгүй байдлын баг	0 = none 1 = зөвхөн үндэсний хэмжээний, 2 = үндэсний болон хотын түвшний	Эдийн засгийн тагнуулын албаны судалгаа

А. Гарц

1.2.1. Орон нутгийн чанартай халдлага	(0-3), 0: бага эрсдэлтэй, 3: их эрсдэлтэй	Kaspersky Lab-ийн судалгаа
1.2.2. Вирусын халдвар авсан компьютерийн хувь (тоо)	1 – 5 5 = их	Kaspersky Lab-ийн судалгаа
1.2.3. Интернетэд холбогдсон байдал	%	ITU (Олон улсын цахилгаан холбоо) ⁵²

10.3.2. Эрүүл мэндийн аюулгүй байдал (эзлэх жин: 25%)

А. Орц

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Мэдээллийн эх сурвалж
2.1.1. Хүрээлэн буй орчны бодлого	0 – 100, 100 = сайн	ЭЗТА-ны судалгаа
2.1.2. Эрүүл мэндийн үйлчилгээ	0 – 100, 100 = сайн	ЭЗТА-ны Амьдралын чанарын үзүүлэлт
2.1.3. 1,000 хүнд оногдох орны тоо	#	Дэлхийн банк
2.1.4. 1,000 хүнд оногдох эмчийн тоо	#	ДЭМБ

⁴⁹ Safe cities index 2019 /A report from The Economist Intelligence Unit. 2019. P.37-62.

⁵⁰ Өгөгдлийн сангийн хуультай улсын судалгаа (гарын авлага) //Data protection laws of the world (Full handbook). 2019. <https://www.dlapiperdataprotection.com/> Одоогоор энэ жагсаалтад Монгол Улс багтаагүй байна. Тус гарын авлагад тодорхой улсуудын өгөгдлийн сангийн хамгаалалтын хуулийг маш чанга, чанга, дунд зэрэг, зөөлөн хэм хэмжээтэй гэж ангилсан байна. Тухайлбал, АНУ маш чанга, ОХУ дунд зэрэг, БНХАУ зөөлөн хэм хэмжээ бүхий хууль тогтоомжтой улсын ангилалд багтаж байна.

⁵¹ Economist Intelligence Unit analysis

⁵² International Telecommunication Union

2.1.5. Хүнсний аюулгүй байдал	0 – 100, 100 = сайн	ЭЗТА-ны Дэлхийн хүнсний аюулгүй байдлын индекс
2.1.6. Эмчилгээ үйлчилгээний чанар	1 – 5, 5 = сайн	ЭЗТА-ны Амьдралын чанарын үзүүлэлт

Б. Гарц

2.2.1. Агаарын чанар	PM 2.5-ын түвшин	ДЭМБ
2.2.2. Усны чанар	0 – 100, 100 = сайн	ЭЗТА-ны судалгаа
2.2.3. Наслалт	Жилийн дүн	Дэлхийн банк
2.2.4. Нярайн эндэгдэл	1,000 амьд төрөлт дэх нас баралт	Дэлхийн банк
2.2.5. Хорт хавдраар нас барсан түвшин	100,000 өвчлөгчид ноогдох нас баралт	IARC (Хорт хавдрын судалгааны ОУ-ын агентлаг), ДЭМБ
2.2.6. Биологи, хими, цацраг идэвхт зэвсэг ашигласан халдлагын тоо	Сүүлийн 10 жилийн халдлагын дундаж	Global Terrorism Database
2.2.7. Хотын түргэн тусламжийн үйлчилгээ	0: Түргэн тусламжийн үйлчилгээ байхгүй, эсвэл 1 цагаас удаан хугацаанд тусламж хүргэдэг 1: 10 минутаас 1 цагийн дотор тусламж хүргэдэг 2: 10 минутын дотор тусламж хүргэдэг	ЭЗТА

10.3.3. Дэд бүтцийн аюулгүй байдал (эзлэх жин: 25%)

А. Орц

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Мэдээллийн эх сурвалж
3.1.1. Тээврийн аюулгүй байдлыг хангаж буй байдал	0 – 10, 10 = сайн	ДЭМБ; ЭЗТА-ны судалгаа
3.1.2. Явган зорчигчийн найрсаг байдал	0 – 5, 5 = сайн	ЭЗТА-ны судалгаа
3.1.3. Гамшгийн менежмент / бизнес төлөвлөгөө	1 – 5, 5 = сайн	ЭЗТА-ны судалгаа

Б. Гарц

3.2.1. Байгалийн гамшгийн улмаас нас барсан тохиолдол	Сүүлийн 5 жилийн дундаж	EM - DAT
3.2.2. Авто ослоор нас барсан тохиолдол	Сая хүн тутамд эзлэх тоон үзүүлэлт	ДЭМБ
3.2.3. Ядуусын хороололд амьдардаг хувь (амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэн ⁵³)	Хотын хүн амд эзлэх хувь	НҮБ
3.2.4. Дэд бүтэц, байгууламжид халдсан тохиолдол	Сүүлийн 10 жилийн дундаж	Терроризмтэй тэмцэх байгууллага
3.2.5. Байгууллагуудын чадавхи, нөөц	0-1, 1 = сайн	ЭЗТА-ны судалгаа
3.2.6. Гамшгийн эрсдэлийн даатгал	0: байхгүй; 1: байгаа	ЭЗТА-ны судалгаа
3.2.7. Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх иргэдийн мэдлэг	0: Үгүй 1: Хэсэгчилсэн төлөвлөгөөтэй; 2: Үндэсний хөгжлийн төлөвлөгөөтэй	ЭЗТА-ны судалгаа
3.2.8. Агаарын тээврийн байгууламж	0-4, 0 = сайн	ЭЗТА-ны судалгаа
3.2.9. Автозамын сүлжээ	0-4, 0 = сайн	ЭЗТА-ны судалгаа
3.2.10. Эрчим хүчний сүлжээ	0-4, 0 = сайн	ЭЗТА-ны судалгаа
3.2.11. Төмөр замын сүлжээ	0-4,	ЭЗТА-ны судалгаа

⁵³ Улаанбаатар хотын хувьд амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэн (өрх) гэсэн шалгуур тохиромжтой. Учир нь манай улс, хотод аль ч хороонд бага орлоготой болон их орлоготой айл өрх зэрэгцэн амьдарч байх нь нийтлэг байна.

	0 = сайн	
3.2.12. Кибер аюулгүй байдлын бэлэн байдал	0-4, 0 = сайн	ЭЗТА-ны судалгаа

10.3.4. Хувь хүний аюулгүй байдал (эзлэх жин: 25%)

А. Орц

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Эх сурвалж
4.1.1. Цагдаагийн үйл ажиллагаа	0 – 1, 1 = хувь хүний аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөтэй, 0 = үгүй	ЭЗТА-ны судалгаа
4.1.2. Олон нийтэд суурилсан эргүүл	0 – 1, 1 = байгаа, 0 = байхгүй	ЭЗТА-ны судалгаа
4.1.3. Гэмт хэргийн байрзүйн систем (Available street-level crime data)	0 – 1, 1 = байгаа, 0 = байхгүй	ЭЗТА-ны судалгаа
4.1.4. Гэмт хэргийн хяналтын систем (криминалистикийн тоо бүртгэл)	0 – 2, 0 = байхгүй 1 = туслах чанартай техник ашигладаг 2 = Байгаа: технологийг хяналтын болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ашигладаг	ЭЗТА-ны судалгаа
4.1.5. Хувийн аюулгүй байдлын хэмжүүр	0 – 1, 1 = байгаа, 0 = байхгүй	ЭЗТА-ны судалгаа
4.1.6. Галт зэвсэгтэй холбоотой хууль тогтоомж, түүний хэрэгжилт	0 – 10, 10 = чанд мөрддөг	Gun Policy.org, ЭЗТА-ны судалгаа
4.1.7. Улс төрийн тогтвортой байдал	0 – 100, 0 = эрсдэлгүй	ЭЗТА-ны судалгаа
4.1.8. Хуулийн байгууллагуудын тогтолцооны үр ашигт байдал	≤20%:хамгийн өндөр оноо	ЭЗТА-ны судалгаа
4.1.9. Аюултай бодисын хяналт	0 = үгүй 1: Зөвхөн улирлын чанартай ажилладаг 2: Аюуллыг сэрэмжлүүлэх тогтолцоотой	Дэлхийн цаг уурын байгууллага

Б. Гарц

4.2.1. Зөрчил	1 – 5, 5 = өндөр эрсдэлтэй	ЭЗТА-ны судалгаа
4.2.2. Хүч хэрэглэсэн гэмт хэргийн гаралт	1 – 5, 5 = өндөр эрсдэлтэй	ЭЗТА-ны судалгаа
4.2.3. Зохион байгуулалттай гэмт хэрэг	0 - 4, 4 = өндөр эрсдэлтэй	ЭЗТА-ны судалгаа
4.2.4. Авлигын түвшин	Scale 0 – 100, 100 = эрсдэлгүй	Transparency International
4.2.5. Хар тамхины хэрэглээ	Хүн амд эзлэх хувиар	UN Office on Drugs and Crime; Local data sources
4.2.6. Террорист халдлага	Сүүлийн 10 жилийн дунджаар	Global Terrorism Database
4.2.7. Террорист халдлагын шинж	Хүний аминд хүрсэн халдлага, сүүлийн 10 жилийн дунджаар	Global Terrorism Database
4.2.8. Жендерийн аюулгүй байдал	100,000 хүн тутам дахь хохирогчийн тоогоор	ДЭМБ
4.2.9. Аюулгүй байдлын талаарх ойлголт	0 – 100, 100 = аюулгүй	Numbeo
4.2.10. Терроризмын аюул	Rating 0 – 4, 0 = тэвчиж үл болох, 4 = Зөвшөөрөгдөх хэмжээнд	ЭЗТА-ны судалгаа
4.2.11. Цэргийн мөргөлдөөний аюул	Rating 0 – 4, 0 = тэвчиж үл болох, 4 = Зөвшөөрөгдөх хэмжээнд	ЭЗТА-ны судалгаа
4.2.12. Иргэний үймээн самууны аюул	Rating 0 – 4, 0 = тэвчиж үл болох, 4 = Зөвшөөрөгдөх хэмжээнд	ЭЗТА-ны судалгаа

10.4. ДЭД ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

1. Бид судалгааны үр дүнд Улаанбаатар хотод аюулгүй орчин бүрдүүлэх бодлогын хэрэгжилт хангалтгүй байна гэж дүгнэж байгаа бөгөөд энэ нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Эрсдэлт орчны талаар цогц мэдээлэл авах, боловсруулалт хийх, байнга шинэчлэгдэж байх тогтолцоо, технологийн шийдэл бий болгож, хөгжүүлж чадаагүй;
- Эрсдэлт нөхцөл байдлыг шуурхай арилгах, хариуцлага тооцох тогтвортой засаглал төлөвшөөгүй.

2. Дэлхийн хотуудын аюулгүй байдлын түвшин (индекс) тогтоож буй аргачлалыг Улаанбаатар хотын аюулгүй байдлын түвшинг тогтооход нутагшуулан ашиглах боломжтой.

Бид дээрх дүгнэлтэд хүрсний дүнд дараах тодорхой саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. “Хүн төвтэй аюулгүй байдал” гэсэн ойлголт, үзэл баримтлалыг судалж төлөвшүүлэх;
2. Дэлхийн хотуудын аюулгүй байдлын түвшин (индекс) тогтоож буй аргачлалыг гүнзгийрүүлэн судалж, Улаанбаатар хот болон бусад хот, суурин газарт нутагшуулан ашиглах хувилбарыг боловсруулах;
3. Дэлхийн хотуудын аюулгүй байдлын түвшин тогтоох судалгаанд хамрагдаж, Улаанбаатар хотын аюулгүй байдлын эрэмбийг тодорхойлуулах боломжийг эрэлхийлэх;
4. Боловсруулсан аргачлалын дагуу эрсдэлт орчны талаар байгууллага, иргэдээс цогц мэдээлэл авах, түүнийг шалгаж тодорхойлох, дүгнэх, өдөр тутам шинэчлэгдэх, ил тод, амьд системийг бий болгох;
5. Дээрх системийг бүтээхдээ мэдээллийн технологийн ололт ашиглаж өгөгдөл боловсруулах ухаалаг программ зохиох, өндөр хүчин чадалтай техникийг хэрэглээнд нэвтрүүлж, бүх нийтийн оролцоог хангах;
6. Улаанбаатар хотын тодорхой дүүрэг, хороог сонгон авч, шинжлэх ухаан, технологийн орчин үеийн ололт, өндөр технологид суурилсан, аюулгүй байдлын баталгаат “загвар бүс” бий болгох;
7. Аюулгүй байдлын түвшинг ахиулах, бууруулах явдал нь холбогдох албан тушаалтныг урамшуулах, хариуцлага тооцох шалтгаан болдог механизмыг бүрдүүлж, Улаанбаатар хотын аюулгүй байдлын засаглалыг төлөвшүүлэх.

---0---



ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ХҮРЭЭЛЭН

*Энэхүү судалгааны тайлан, зөвлөмжийг
зөвхөн албан хэрэгцээнд зориулав.*

“БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ”

КРИМИНОЛОГИ СУДАЛГААНЫ ЗӨВЛӨМЖ

Захиалагч:

Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал,
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл

Гүйцэтгэгч:

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн
“Судлаач хуульчдыг дэмжих эрдэмтэн сан” ТББ

Улаанбаатар хот
2019

**“БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ”
КРИМИНОЛОГИ СУДАЛГААНЫ ЗӨВЛӨМЖ**

“Баянзүрх дүүргийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл” сэдэвт криминологи судалгааны ажлын үр дүнг үндэслэн дараах санал, зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хандан гаргаж байна.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтрах байгууллага
Нэг. Баянзүрх дүүргийг хөгжүүлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:				
1.	Баянзүрх дүүргийн урт хугацааны хөгжлийн бодлого, стратегийг төлөвлөн хэрэгжүүлэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлыг тусган хэрэгжүүлэх;	2045 он хүртэл	Дүүргийн ИТХ, ЗДТГ	Нийслэлийн ИТХ, ЗДТГ
2.	Баянзүрх дүүргийн дунд хугацааны хөгжлийн стратегийг төлөвлөн хэрэгжүүлэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлыг тусган хэрэгжүүлэх;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ	Нийслэлийн ИТХ, ЗДТГ
3.	Баянзүрх дүүргийн нийгэм, эдийн засгийн хөгжил, үндсэн чиглэлийг төлөвлөн хэрэгжүүлэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлыг тусган хэрэгжүүлэх;	2020-2021 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ	Нийслэлийн ИТХ, ЗДТГ
4.	<p>“Баянзүрх дүүрэгт Мэдээлэл, шуурхай удирдлагын жишиг төв”-ийг цогц байдлаар байгуулж, камерын хяналтын нэгдсэн системд холбох ажлыг гүйцэтгэх.</p> <p>Үүний тулд:</p> <ul style="list-style-type: none"> - Аюулгүй байдлын хувьд анхаарал татаж байгаа байршлуудыг ухаалаг камерын бүрэн хяналтад авах; -“Нарантуул” олон улсын худалдааны төв, түүний орчныг бүрэн камержуулж, хүнийг гадна төрхөөр таних систем суурилуулах; -Аж ахуйн нэгж, байгууллагуудын хяналтын камеруудыг цагдаагийн нэгдсэн сүлжээнд холбох; -Дүүргийн нутаг дэвсгэр дэх ЗЦ-ын постуудыг камерын хяналтанд авах; -Гэрээт харуул хамгаалалтын албаны камеруудыг цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээнд холбох. -СӨХ, ШТС, Дэлгүүр, Ломбардууд, Гэрээт харуул хамгаалалтын албаны камеруудыг цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээнд холбох. 	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ, Цагдаагийн газар	Нийслэлийн ИТХ, ЗДТГ, ХЗДХЯ, ЦЕГ
5.	<p>“Баянзүрх дүүргийн хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын орон тоог нэмэгдүүлэх, алба хаагчдыг чадавхжуулах хөтөлбөр” хэрэгжүүлж ажиллах;</p> <ul style="list-style-type: none"> -Баянзүрх дүүргийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, шүүн таслах, гамшиг ослоос хамгаалах чиг үүрэг бүхий цагдаа, прокурор, шүүх, онцгой байдлын байгууллагуудын орон тоог нэмэгдүүлэх асуудлыг дүүргийн хөгжлийн бодлоготой уялдуулан холбогдох шатанд танилцуулж, үе шаттайгаар шийдвэрлүүлэх; -Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор баталсан жишиг нормативт нийцүүлэн цагдаагийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиг үүрэг бүхий орон тоог 2 дахин нэмэгдүүлэх, энэ нормативыг шинэчлэх санаачлага гарган шинэчлүүлэх; -Цагдаагийн алба хаагчдын албандаа хандаж буй эерэг хандлагыг дэмжих, үнэнч шударгаар үр бүтээлтэй ажиллах нөхцөл, баталгааг бий болгох үүднээс “цагдаагийн алба хаагчдын цалин, хангамж”-ийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх; 	2020-2021 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ	Нийслэлийн ИТХ, ЗДТГ, ЦЕГ, ХЗДХЯ, СЯ

	-Дүүргийн цагдаа, прокурор, шүүх, онцгой байдлын байгууллагуудыг шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, дэвшилтэт технологи, өндөр технологиор үе шаттай хангах.			
6.	Цагдаагийн байгууллагад хүн, хүчний дэмжлэг үзүүлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд туссанаар “ олон нийтийн байцаагч ”-ийг ажиллуулах асуудлаар шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх;	2020-2021 он	Дүүргийн ИТХ, ГХУСАЗСЗ, ЗДТГ	Нийслэлийн ИТХ, ЗДТГ
Хоёр. Баянзүрх дүүргийг аюулгүй дүүрэг болох чиглэлээр:				
7.	Дэлхийн хотуудын аюулгүй байдлын түвшин (индекс) тогтоож буй аргачлалыг эрдэмтэн, судлаач, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор гүнзгийрүүлэн судалж, Баянзүрх дүүрэгт нутагшуулан ашиглах хувилбарыг боловсруулж, туршин нэвтрүүлэх;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ, Цагдаагийн газар	Нийслэлийн ИТХ, ЗДТГ, ХЗДХЯ, ЦЕГ
8.	Боловсруулсан аргачлалын дагуу эрсдэлт орчны талаар байгууллага, иргэдээс цогц мэдээлэл авах, түүнийг шалгаж тодорхойлох, дүгнэх, өдөр тутам шинэчлэгдэх, ил тод, амьд системийг бий болгон, Баянзүрх дүүргийн хороо, хэсэг бүрийн аюулгүй байдлын эрэмбийг мэдээллийн өндөр технологи, өгөгдөл боловсруулах ухаалаг системийн тусламжтайгаар тодорхойлох алхамыг хийх;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ, Цагдаагийн газар	Нийслэлийн ИТХ, ЗДТГ, ХЗДХЯ, ЦЕГ
9.	Дүүргийн тодорхой хороо, хэсгийг сонгон авч, шинжлэх ухаан, технологийн орчин үеийн ололт, өндөр технологид суурилсан, баталгаат “аюулгүй орчин” (аюулгүйн баянбүрд) бий болгох туршилтыг эхлүүлэх;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ, Цагдаагийн газар	Нийслэлийн ИТХ, ЗДТГ, ХЗДХЯ, ЦЕГ
10.	Аюулгүй байдлын түвшинг ахиулах, бууруулах явдал нь холбогдох байгууллагын ажлыг дүгнэх, албан тушаалтныг урамшуулах, хариуцлага тооцох үндсэн үзүүлэлт, үндэслэл болдог механизмыг бүрдүүлж, Баянзүрх дүүрэгт аюулгүй байдлын засаглалыг тогтоон төлөвшүүлэх ажлыг санаачлах;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ, Цагдаагийн газар	Нийслэлийн ИТХ, ЗДТГ, ХЗДХЯ, ЦЕГ
11.	Баталгаат аюулгүй орчинг бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүг төвлөрүүлэх, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ, Цагдаагийн газар	Нийслэлийн ИТХ, ЗДТГ, ХЗДХЯ, ЦЕГ
12.	Дүүргийн хэмжээнд дагаж мөрдөж буй хууль, эрх зүйн орчныг судлан аюулгүй байдлын стандартуудыг бий болгох. Жишээ нь: Канад, Норвеги, Швейцар, Англи зэрэг улс орны стандартуудыг бейнмаркинг хийх аргачлалаар нэвтрүүлэх, шинээр боловсруулах;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ, Цагдаагийн газар	Нийслэлийн ИТХ, ЗДТГ, ХЗДХЯ, ЦЕГ
13.	Дүүргийн хэмжээнд аюулгүй байдлын эрсдэлийн шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх /security risk analysis/;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ, Цагдаагийн газар	Нийслэлийн ИТХ, ЗДТГ, ХЗДХЯ, ЦЕГ
14.	Аюулгүй байдлын хувийн үйлчилгээг бодлогоор дэмжих уялдаа холбоог сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх /Харуул хамгаалалтын алба, мэдээллийн болон эдийн засгийн аюулгүй байдлын үйлчилгээ/;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ, Цагдаагийн газар	Нийслэлийн ИТХ, ЗДТГ, ХЗДХЯ, ЦЕГ
15.	Цагдаагийн байгууллагаас аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай нягт хамтран ажиллах, тухайн байгууллагуудад тавих хяналтыг өндөржүүлэх;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ, Цагдаагийн газар	Нийслэлийн ИТХ, ЗДТГ, ХЗДХЯ, ЦЕГ
16.	Харуул хамгаалалтын байгууллагуудыг дан ганц периметрийн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэхээс гадна гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг идэвхтэй явуулах нөхцөлөөр хангах, зарим замын хөдөлгөөний зөрчилд сануулга, торгууль ногдуулах эрх өгөх, мөн урамшуулах	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ, Цагдаагийн газар	Нийслэлийн ИТХ, ЗДТГ, ХЗДХЯ, ЦЕГ

	тогтолцоог бий болгох. (Өөрийн хариуцсан нутаг дэвсгэр, объектод гэмт гэмт хэрэг, зөрчил гаргаагүй аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг урамшуулах)			
Гурав. Их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээр:				
17	Их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухааны байгууллагууд, эрдэмтэн, судлаач, энтерпренеруудтэй хамтран тус Дүүргийг хөгжүүлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр think tank судалгааны төв байгуулан ажиллуулах;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ, Цагдаагийн газар, холбогдох нэгж	Их, дээд сургууль Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, ШУА-ны харьяа хүрээлэнгүүд
18	Дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төлөөллийг оролцуулсан баг бүрэлдэхүүнийг Япон, Гүрж, БНХАУ, БНСУ зэрэг гадаад улсад ажиллуулж энэ чиглэлээр туршлага судлуулах;	2020-2021 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ	Нийслэлийн ИТХ, ЗДТГ
19	Дотоод хэргийн их сургуулийн материаллаг баазад түшиглэн “Цагдаагийн клиник төв, пост”, “Аврах, гал унтраах клиник анги” -ийг байгуулан ажиллуулах; -Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн хэлтсүүдэд ДХИС-ийн сонсогч, суралцагч нарыг дадлага хийлгүүлэх, эдгээр хэлтсүүдийн алба хаагч, тасгийг клиникийн сургалтын төв, дадлагын удирдагч багшаар ажиллуулах талаар гаргасан ЦЕГ-ын дарга, ДХИС-ийн захирлын хамтарсан тушаалыг ажил хэрэг болгох	2020-24 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ	ДХИС, ЦЕГ, НЦУГ
Дөрөв. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр:				
20	“Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль” -иар дүүргийн бүх төрийн байгууллага, хороодод сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;	2020 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ, Хороодын Засаг дарга нар, Цагдаагийн газар, Прокурор, Шүүх	МУГХУСАЗЗ, ХЗДХЯ, ЦЕГ, УЕПГ, ШЕЗ
21	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг дүүргийн хэмжээнд уялдуулан зохицуулж, зохион байгуулах үүрэг бүхий ажлын албыг байгуулж, орон тооны нарийн бичгийн даргыг бий болгон ажиллуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах;	2020 он	Дүүргийн ИТХ, ГХУСАЗСЗ, ЗДТГ	МУГХУСАЗЗ, ХЗДХЯ, ЦЕГ, УЕПГ, ШЕЗ
22	Цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, онцгой байдал, мэргэжлийн хяналт, худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс зэрэг төрийн байгууллагуудын үйл ажиллагааг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгод чиглүүлэн уялдуулан зохицуулах;	2020 он	Дүүргийн ИТХ, ГХУСАЗСЗ, ЗДТГ	МУГХУСАЗЗ, ХЗДХЯ, ЦЕГ, УЕПГ, ШЕЗ
23	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 22.1-д заасны дагуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэгч байгууллага гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын судалгааг хоёр жил тутамд явуулах аргачлал, гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааг гурван жил тутам улсын хэмжээнд, эсхүл тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд, эсхүл тодорхой гэмт хэрэг, зөрчлийн төрлөөр олон нийтийн дунд зохион байгуулах аргачлалын дагуу	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ГХУСАЗСЗ	МУГХУСАЗЗ, ХЗДХЯ

	явуулсан судалгааны үр дүнг бодлого, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх ⁵⁴ ;			
24	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.1-д заасны дагуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг Салбар зөвлөл, төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллагын түвшинд хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлж, үйл ажиллагаанд нь дүгнэлт хийх аргачлалын дагуу явуулсан хөндлөнгийн үнэлгээний дүнг үндэслэн бодлого, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх;	2020-2024 он	Дүүрийн ИТХ, ГХУСАЗСЗ	МУГХУСАЗЗ, ХЗДХЯ
25	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, түүнтэй тэмцэж ирсэн уламжлалыг судлан, дэвшилттэй, үр дүнтэй арга барил, аргачлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;	Байнга	Дүүргийн ИТХ, ЗДТГ, Хороодын Засаг дарга нар, Цагдаагийн газар, Прокурор, Шүүх	МУГХУСАЗЗ, ХЗДХЯ, ЦЕГ, УЕПГ, ШЕЗ
26	Дүүргийн нутаг дэвсгэрт хүүхэд, залуучууд, иргэд, ахмад настнууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, спортоор хичээллэх таатай орчин бүрдүүлэхэд чиглэсэн “Эрүүл дүүрэг” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх: - Хувийн хэвшилтэй хамтран ажиллах шинэ арга хэлбэрийг эрэлхийлэх; - Байгууллага, хамт олны дунд биеийн тамир, спортыг дэмжих соёлыг түгээн дэлгэрүүлэх; -Спорт заал, усан бассейнуудыг барьж ашиглалтад оруулах; -Сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг, сургалт явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдэд дэмжлэг үзүүлэх; -Бүжиг, хөдөлгөөн дасгалаар хичээллэх орчинг бүрдүүлэх; -Явган аялах, ууланд авирах маршрутуудыг бий болгох, орчныг бүрдүүлэх.	Байнга	Дүүргийн ИТХ, Бие тамир спортын нэгж	Бүх төрийн байгууллага
27	“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг дүүргийн хэмжээнд холбогдох байгууллагуудтай хамтран төрийн бүх шатны байгууллага, хороо, иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулах;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ, Хуулийн хэлтэс	ХЗДХЯ
Тав. Шийдвэр гүйцэтгэх албаны чиглэлээр:				
28	Тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдэж тус хорооны нутаг дэвсгэрт оршин сууж байгаа ял тэнссэн, хорихоос суллагдсан, хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн хүмүүст тавих хяналтыг сайжруулж, гэмт хэрэг зөрчил үйлдэгдэж болзошгүй эмзэг цэг газруудад хяналт тавих;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	ЦЕГ, ШШГЕГ
29	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа нээлттэй, хаалттай хорих ангиудад жилд дунджаар Баянзүрх дүүргийн харьяат 250-300 хүн хорих ял эдэлж байна.Түүнчлэн жилд 60-70 орчим хүн хорих ял эдлээд	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ, Цагдаагийн газар,	ЦЕГ, ШШГЕГ

⁵⁴ Эдгээр судалгаа нь гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх байгууллага, тэдгээрийн албан ёсны тоо мэдээнээс хараат бус байх бөгөөд гэмт хэрэг, зөрчлийн бодит нөхцөл байдлыг тогтоох, гэмт хэрэг, зөрчлийн нийгэмд үзүүлж байгаа нөлөөлөл, хор уршгийг тогтоох зорилготой байна.

	суллагдан тус дүүргийн нутаг дэвсгэрт амьдарч хууль сахиулах байгууллагын хяналтад орж байгаа судалгаа байна. Хорих ял эдлээд хугацаа дуусч суллагдсан, хугацааны өмнө суллагдсан этгээдэд тавих хяналтын үйл ажиллагаа өнөөгийн байдлаар тодорхой үр дүнгүй байгаа нь дахин гэмт хэргийн тоо буурахгүй байгаатай шууд холбоотой. Иймд хорих ял эдлээд хугацаа дуусч суллагдсан, хугацааны өмнө суллагдсан этгээдэд нутгийн захиргааны байгууллага, хууль сахиулах байгууллагуудын зүгээс тавих хяналтыг нийгэмшүүлэх ажилтай холбон хэрэгжүүлэх;		Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	
30	Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа, албадлагын арга хэмжээний хэрэгжилтэд оролцох төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа сул байгаа нь харагдаж байна. Иймээс нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх, үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн дүүргийн хэмжээний нийтиэд тустай хөдөлмөрт татан оролцуулах;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	ЦЕГ, ШШГЕГ
Зургаа. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын менежментийг сайжруулах чиглэлээр:				
31	Цагдаагийн байгууллага, алба хаагчийн хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, цагдаагийн алба, алба хаагчийн нэр хүндийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлыг цогцоор зохион байгуулах; ⁵⁵	Байнга	ЦЕГ	ХЗДХЯ
32	Цагдаагийн байгууллагаас нэгдсэн арга хэмжээ, аян, уриалга (challenge) хэлбэрийн аян, арга хэмжээнд хэт анхаарал хандуулж байгаа нь цагдаагийн үйл ажиллагааны тогтвортой хөгжил, иргэдийн аюулгүй байдлыг хангах “засаглал” төлөвшихөд саад болж байна. Иймд гэмт хэрэг, зөрчилтэй зөвхөн нэг удаагийн компани т ажил явуулж тэмцэх бус, тогтвортой үйл ажиллагаа, “засаглал”-ыг бий болгож байж үр дүнд хүрэх; ⁵⁶	Байнга	ЦЕГ	ХЗДХЯ
33	Цагдаагийн газар, хэлтсүүдийн бие даасан байдлыг хангах, дүүргийн онцлогт тохирсон, харьцангуй бие даасан менежмент нэвтрүүлж ажиллах боломжийг эрэлхийлэх, туршин нэврүүлэх; ⁵⁷	2020-2024 он	Дүүрэг дэх Цагдаагийн газар	ЦЕГ, ХЗДХЯ

⁵⁵Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцэх, доромжлох, дарамтлах, хүч хэрэглэх, түүнчлэн амь насанд нь халдах тохиолдол сүүлийн үед нэмэгдэх болсон. Иймд Цагдаагийн байгууллага, алба хаагчдын үүрэг гүйцэтгэх эрх зүйн болон үйл ажиллагааны орчинд шинэчлэл хийх зайлшгүй шаардлага бий болжээ. Юуны өмнө, цагдаагийн алба хаагчийн үндсэн үүрэгт ажил болох гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд холбогдолгүй ажилд дайчлан оролцуулах явдал нийтлэг байгаа нь судалгааны явцад тогтоогдсон. Тухайлбал, автомашины татвар хураах, газар чөлөөлөх, албадан нүүлгэх зэрэгт оролцож байгаа нь хүн хүчийг тарамдуулах, албандаа итгэлгүй болох, алба хаагчийн нэр хүндийг олон нийтийн дунд унагаахад хүргэж байна.

⁵⁶Түүнчлэн, нэгдсэн арга хэмжээ, аян, уриалга (challenge) хэлбэрийн түр зуурын арга хэмжээнд хэт анхаарал хандуулж байгаа нь цагдаагийн үйл ажиллагааны тогтвортой хөгжил, иргэдийн аюулгүй байдлыг хангах “засаглал” төлөвшихөд саад болж байна. Жишээ нь зөвхөн Цагдаагийн 1 дүгээр хэлтэст 2018 онд “Автомашин”, “Хаус”, “Сургууль-аюулгүй орчин”, “Хяналт-1”, “Хамтын ажиллагаа”, “Эмзэг хяналт шалгалт”, “Илрүүлэлт”, “Эргүүл”, “Хоёрдогч түүхий эд”, “Нийтийн байр”, “Архигүй өдөр”, “Тамхины хяналт”, “Хуулийн хэрэгжилт”, “Аккумулятор”, “Шөнийн хяналт”, “Хөршийн хяналт”, “Хамтын ажиллагаа”, “Сар шинэ”, “Нийтийн эргүүл”, “Эргүүл-1000”, “Тамхины ишгүй байгууллага-Тамхигүй орчин”, “Ломбард”, “Хориглосон өдөр” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ 23-ыг зохиожээ. Зүй нь гэмт хэрэг, зөрчилтэй зөвхөн компани т ажил явуулж тэмцэх бус, тогтвортой үйл ажиллагаа, “засаглал”-ыг бий болгож байж үр дүнд хүрэх зүй тогтолтой.

⁵⁷Төрийн байгууллагууд нийгэм, соёл, хүмүүжил, олон нийтийн гэсэн тодотголтой төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах нь хэр хэмжээнээс хэтэрч, ажлын цагийн дийлэнхийг түүнд зарцуулах болсон нь үндсэн ажлаа чанартай хийх боломжгүйд хүргэж, алба хаагчдын үйл ажиллагаанд зохиомол ачаалал үүсгэсээр ирсэн. Энэ үзэгдэл Баянзүрх дүүргийн Цагдаагийн хэлтсийн үйл ажиллагааг ч тойроогүй байна. Тухайлбал, 1 дүгээр хэлтсийн 2018 оны үйл ажиллагааны тайланд “сургалт, мэдээлэл, сурталчилгаа, өдөрлөг зэрэг 254 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан. Цагдаагийн ерөнхий газар, Нийслэлийн цагдаагийн газрын удирдлагаас ирүүлсэн 21 албан даалгавар, үүрэг чиглэл тус бүрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, ажлын чиглэл, үүргийг хэрэгжүүлэх, зөрчихгүй байх талаар 8 заалт бүхий баталгааг 170 алба хаагчаас бичгээр гаргуулан авч, сахилга, хариуцлагын зөвлөгөөнийг 3 удаа зохион байгуулсан”

34	Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр явуулах үндсэн үүрэгт ажлыг дэмжин урамжуулах тогтолцоог бий болгох . Үндсэн чиг үүргийн албан хаагчдыг нийт бие бүрэлдэхүүний 75-аас доошгүй хувьд хүргэх. Албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцлага тооцох, үнэлэх, урамшуулах мэдээллийн технологийн ололтод суурилсан ухаалаг тогтолцоо бий болгох. Захиргаа, санхүү, хүний нөөц, дүн бүртгэлийн зэрэг чиглэлээр ажиллах хүний нөөцийн чадавхийг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх;	2020-2024 он	Дүүрэг дэх Цагдаагийн газар	ЦЕГ, ХЗДХЯ
35	Хэлтэс, түүний хариуцаж буй нутаг дэвсгэрийн онцлогийг харгалзсан бүтэц, зохион байгуулалтыг бий болгох, туршин нэвтрүүлэх. Тухайлбал, Цагдаагийн 3 дугаар хэлтсийн үйл ажиллагааг малын хулгайтай тэмцэх, малчин өрхийн аюулгүй байдлыг хангах, мөн замын хөдөлгөөний аюулгүй байдалд түлхүү хандуулах, Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн үйл ажиллагааг орон байрны болон халаасны хулгай, архи дан согтуурах, мансууруулах бодис, хар тамхитай хийх тэмцэлд, Цагдаагийн 3 дугаар хэлтсийн үйл ажиллагааг автомашины эд анги хулгайлах, танхайрах зэрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд бие бүрэлдэхүүний хүч, нөөцийг төвлөрүүлэх гэх мэт. Энэ нь цагдаагийн хэлтсүүдийн нийтлэг бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг өөрчлөх санаа биш бөгөөд дурдсан чиглэлд нэмэлт хүчийг чиглүүлэх зөвлөмж юм.	2020-2024 он	Дүүргийн ИТХ, Дүүргийн Цагдаагийн газар	ЦЕГ, ХЗДХЯ
36	Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж буй нөхцөл байдлыг харгалзан тодорхой цэгүүдэд “кобан” байгуулах. Кобаныг Япон улсаас анх нутагшуулахдаа цагдаагийн пост хэлбэрээр байгуулж байсныг өөрчилж тухайн нутаг дэвсгэрт оршин суугч цагдаагийн ажилтныг түшиглэсэн кобан байгуулж турших. Эхний ээлжинд 3 байршилд байгуулж, үйл ажиллагааг нь төлөвшүүлэх шаардлагатай. -Тодруулбал, Нарантуул худалдааны төв, Мянган оюутны байр, Гачуурт тосгоны малчин өрхүүдийн дунд оршин суугч цагдаагийн ажилтанд түшиглэсэн кобан байгуулах	2020-2024 он	Дүүргийн ИТХ, Цагдаагийн газар	ЦЕГ, ХЗДХЯ
37	Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт ашиглалтад орж буй орон сууц, хотхонд цагдаагийн алба хаагчийн төлөөллийг оруулж , тухайн орон сууц, хотхоны аюулгүй байдлыг хангуулахад цагдаагийн алба хаагчтай нягт хамтран ажиллах;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ, Цагдаагийн газар	-
38	Машинт болон явган хосолсон эргүүл бий болгож ажиллуулах. Судлаач, практик ажилтнууд явган, машинт, мотоцикльт, морьт, дугуйт, завьт, нохойт эргүүлийн талаар санал дэвшүүлдэг боловч нийслэл, дүүргийн нутаг дэвсгэр, хүн амын суурьшил, цаг уурын онцлогоос үзвэл машинт-явган хосолсон эргүүл байх нь зохимжтой байна. Хэлтсүүдэд эргүүлийн	2020-2024 он	Дүүргийн ИТХ, Дүүрэг дэх Цагдаагийн газар	ЦЕГ, ХЗДХЯ

гэжээ. Дүүргийн цагдаагийн хэлтсүүдийн хүний нөөц хангалтгүй байгаатай зэрэгцэн удирдлага, зохион байгуулалтын шинжтэй, дээрх дутагдлууд оршиж байгааг засах шаардлагатай гэж дүгнэж байна. Өөрөөр хэлбэл, Цагдаагийн хэлтсүүдийн бие даасан байдлыг хангах, дүүргийн онцлогт тохирсон, харьцангуй бие даасан менежмент нэвтрүүлж ажиллах боломжийг эрэлхийлэх, туршин нэвтрүүлэх шаардлагатай.

	автомашин дутмаг байгаа нь судалгаанаас харагдсан. Нэг хэлтэст дунджаар хөдөлгөөнт эргүүлийн, жижүүрийн, эрүүгийн цагдаагийн тасгийн, мөрдөн байцаах тасгийн, хэлтсийн даргын зэрэг 10 орчим автомашин ашиглаж байгаа нь учир дутагдалтай. Цагдаагийн байгууллагын автомашины хангалт, гүйлтийн жишиг нормативаас үзвэл дүүргийн гурван хэлтсийн хэмжээнд зөвхөн хөдөлгөөнт эргүүлийн машин 23 шаардлагатай. Үүн дээр нэмж 10 мөрдөгч, эрүүгийн мөрдөгчийн дунд 1 автомашин байх жишиг стандарттай гэж үзвэл дүүргийн цагдаагийн хэлтсүүдийн хэмжээнд 10 автомашин шаардлагатай байна. Түүнчлэн бидний судалгааны дүнд дэвшүүлж буй зөвлөмжийн нэг нь хэргийн газрын үзлэгийн бүрэлдэхүүний удирдлага, зохион байгуулалтын шинэ хэлбэр бөгөөд энэ үйл ажиллагаанд хэргийн газрын явуулын лаборатори машин 3-ыг авч ашиглахаар төсөөлөгдөж байна.			
39	Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр ажиллаж ирсэн, туршлагатай ахмад ажилтнуудаар яриа таниулга хийж, зөвлөгөө өгүүлж, алба хаагчдыг чадавхжуулах, туршлагажуулах ажлыг зохион байгуулах;	Улиралд нэгээс доошгүй яриа таниулга хийх	Цагдаагийн газар, Прокурор, Шүүх	МУГХУСАЗЗ, ХЗДХЯ, ЦЕГ, УЕПГ, ШЕЗ, Ахмадын хороо
40	Гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг харгалзан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах төсвийг аймаг, дүүрэг, хороодод тэнцвэртэй хуваарилуулах, зарцуулах: -Баянзүрх дүүргийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах төсөв нийслэлийн хэмжээнд 20-оос доошгүй хувийг эзэлсэн байх;	2020-2024 он	ИТХ, ЗДТГ,	МУГХУСАЗЗ, ХЗДХЯ, Нийслэлийн ИТХ, ГХУСАЗСЗ
41	Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн иргэн, хуулийн этгээдэд оногдуулсан ял, шийтгэлийн торгуулийн орлогыг дүүргийн төсөвт бүрэн төвлөрүүлэх арга хэмжээ авч, түүний 40-оос доошгүй хувийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулдаг байх хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах;	Жил бүр	ИТХ, ГХУСАЗСЗ, ЗДТГ, Цагдаагийн газар, Прокурор, Шүүх	МУГХУСАЗЗ, ХЗДХЯ, Нийслэлийн ИТХ, ГХУСАЗСЗ
42	Улс, нийслэлийн хэмжээнд өндөр үзүүлэлттэй байгаа тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, сааруулах эрх зүй, нийгэм, эдийн засаг, зохион байгуулалтын цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;	Жил бүр	ИТХ, ГХУСАЗСЗ, ЗДТГ, Цагдаагийн газар, Прокурор, Шүүх	МУГХУСАЗЗ, ХЗДХЯ, Нийслэлийн ИТХ, ГХУСАЗСЗ
43	Гэмт хэрэг, зөрчлийн гаралтаар өндөр үзүүлэлттэй хороо, хэсэгт чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх замаар гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, сааруулах;	Жил бүр	ИТХ, ГХУСАЗСЗ, ЗДТГ, Цагдаагийн газар, Прокурор, Шүүх	МУГХУСАЗЗ, ХЗДХЯ, Нийслэлийн ИТХ, ГХУСАЗСЗ
44	Гэмт хэрэг, зөрчлийн гаралт, шалтгаан нөхцөлд үндэслэн цагдаагийн эргүүл, хяналтыг оновчтой зохион байгуулж, үр дүнтэй байдлаар ажиллуулах: -Эргүүлийн салааг байгуулж, ажиллуулах; -Шөнийн цагаар эргүүл хийх;	2020 он	ИТХ, ГХУСАЗСЗ, ЗДТГ, Цагдаагийн газар	МУГХУСАЗЗ, ХЗДХЯ, Нийслэлийн ИТХ, ГХУСАЗСЗ
45	“Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх дэд хөтөлбөр” боловсруулан, хэрэгжүүлж ажиллах.	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ГХУСАЗСЗ,	МУГХУСАЗЗ, ХЗДХЯ, Нийслэлийн

	<p>-Мал, мал бүхий иргэдийн судалгаанд тулгуурлан тэдэнд зориулсан урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>-Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдэд чиглэсэн ажлыг зохион байгуулах;</p> <p>-Мал, мах бэлтгэлийн чиглэлийн аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа худалдаа, үйлчилгээ эрхлэгч нарт чиглэсэн урьдчилан сэргийлэх ажлыг хийх;</p> <p>-Мал хулгайлахтай холбоотой гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, мөрдөн шалгах чиг үүрэг бүхий алба хаагчдыг мэргэшүүлж ажиллуулах.</p>		ЗДТГ, Цагдаагийн газар, Хороод	ИТХ, ГХУСАЗСЗ
46	<p>“Амралт сувилал, аялал жуулчлал, зугаалга ба аюулгүй байдал” аян арга хэмжээг улирлын чанартай хэрэгжүүлж ажиллах.</p> <p>-БЗД-ийн 20-р хороо Гачууртыг амралт сувилал, аялал жуулчлал хөгжсөн бүс болгон хөгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, тус хорооны уугуул иргэдийн амралт сувилал, аялал жуулчлалын салбарт өрсөлдөх боломжийг нээж өгөх, тус хорооны иргэдэд энэ салбарт үйл ажиллагаа явуулах хөнгөлттэй зээл тусламж олгох, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх</p>	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ГХУСАЗСЗ, ЗДТГ, Цагдаагийн газар, Хороод	МУГХУСАЗЗ, ХЗДХЯ, Нийслэлийн ИТХ, ГХУСАЗСЗ
47	<p>Хүнд нөхцөлд амьдарч байгаа болон нийгмийн эмзэг бүлгийн хүүхдийг /гэр оронгүй, эцэг, эхийн хараа хяналтаас гарсан, сургууль завсардсан, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж байгаа/ халамж, асрамжийн үйлчилгээ, дотоод, гадаадын санхүүжилттэй хөтөлбөр, төсөлд хамруулах ажлыг зохион байгуулах;</p>	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ГХУСАЗСЗ, ЗДТГ, Цагдаагийн газар, Хороод	МУГХУСАЗЗ, ХЗДХЯ, Нийслэлийн ИТХ, ГХУСАЗСЗ
48	<p>Дүүргийн хэмжээнд “Архидан согтуурахтай тэмцэх дэд хөтөлбөр” боловсруулж, хэрэгжүүлэх</p> <p>-Архи согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн засаг даргын ажлын алба олгож байгааг өөрчлөх тухай санал гаргаж уг саналдаа цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн дүүргийн Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс олгодог, цуцалдаг байхаар тусгах;</p>	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ГХУСАЗСЗ, ЗДТГ, Цагдаагийн газар, Хороод	МУГХУСАЗЗ, ХЗДХЯ, Нийслэлийн ИТХ, ГХУСАЗСЗ
49	<p>“Хөршийн хяналт дэд хөтөлбөр”-ийг дүүргийн хэмжээнд хэрэгжүүлж ажиллах:</p> <p>-Дүүргийн хороо, хэсгүүдэд "хөршийн холбоо" үүсгэх ажлыг зохион байгуулж, удирдлагаар хангах, идэвхтэй ажиллаж буй хөршийн холбоодыг урамшуулах;</p>	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ГХУСАЗСЗ, ЗДТГ, Цагдаагийн газар, Хороод	МУГХУСАЗЗ, ХЗДХЯ, Нийслэлийн ИТХ, ГХУСАЗСЗ
50	<p>Баянзүрх дүүргийн Цагдаагийн хэлтсүүдийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа, түүн дотроос хэргийн газрын үзлэгээр ул мөр, эд мөрийн баримт цуглуулсан байдал, гэмт хэргийг халуун мөрөөр нь илрүүлж, нотолсон байдалд дүн шинжилгээ хийхэд нааштай үр дүн харагдахгүй байна.</p> <p>-Хими, биологи, физикийн магадлах шинжилгээг Цагдаагийн I хэлтэс 638, II хэлтэс 546, III хэлтэс 450, криминалистикийн шинжилгээг I хэлтэс 423, II хэлтэс 517, III хэлтэс 479-ийг, цогцост хийх шинжилгээ I хэлтэс 181, II хэлтэс 217, III хэлтэс 249-ийг, гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ I хэлтэс 1069, II хэлтэс 1151, III хэлтэс 746-г Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээр хийлгэсэн нь бусад дүүргүүдээс харьцангуй өндөр үзүүлэлт.</p> <p>-Нийслэлийн Шүүхийн шинжилгээний газрын криминалистикийн шинжээчид мэргэжилтнээр</p>	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ГХУСАЗСЗ, ЗДТГ, Цагдаагийн газар	МУГХУСАЗЗ, ХЗДХЯ, ШШҮХ

	<p>ажилласан хэргийн газрын үзлэгийн тоо Баянзүрх дүүргийн хэмжээнд 5236 байгаа нь нийслэлийн хэмжээнд хамгийн өндөр буюу дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдийн нийт хийсэн хэргийн газрын үзлэгийн 25% болж байгаа юм. Харин Нийслэлийн шүүхийн шинжилгээний албаны Баянзүрх дүүрэг дэх Криминалистикийн лабораторид хийсэн шинжилгээ нийслэлийн бусад дүүргүүд дэх лабораторитой харьцуулбал хамгийн доогуур үзүүлэлттэй байна.</p> <p>-Иймд хэргийн газрын үзлэг хийх, ул мөр, эд мөрийн баримт цуглуулах ажиллагаа явуулахад бүтэц, зохион байгуулалтын дараах өөрчлөлт хийх нь үр дүнтэй.</p> <p>а) Хэргийн газрын үзлэг хийх ажиллагааны зохион байгуулалтад тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлохдоо юуны өмнө цагдаагийн байгууллагад тулгамдаж байгаа асуудалд анхаарал хандуулах, өөрөөр хэлбэл цагдаагийн байгууллагын байр сууринаас асуудалд хандах нь зүйн хэрэг. Учир нь хууль тогтоомжоор хэргийн газрын үзлэг хийх үндсэн чиг үүрэг нь цагдаагийн байгууллагад хамаардаг. Үүнийг ЭХШШТХ-ийн холбогдох хэм хэмжээнээс гадна Цагдаагийн албаны тухай хууль, ЦБҮАЖ-аас харж болно. Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-т “гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэргийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах” нь цагдаагийн байгууллагын чиг үүрэгт хамаарч байна. Түүнчлэн, ЦБҮАЖ-ын 206-д зааснаар “Хэргийн газрын үзлэг гэж мөрдөгч гэмт хэрэг гарсан байдал, гэмт хэрэг үйлдэгдсэн эсэх, гэмт хэргийг хэн үйлдсэнийг тогтоохын тулд ул мөр, баримт сэлт, эд мөрийн баримтыг илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах ажиллагааг” ойлгоно. Эндээс үзвэл, хэргийн газрын үзлэгийг зохион байгуулах, ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж, бэхжүүлэх үүргийг цагдаагийн байгууллага (мөрдөгч) -ын эрх хэмжээний асуудал болно.</p> <p>Иймд Цагдаагийн хэлтсүүдийн бүтцэд хэргийн газрын үзлэгээр ул мөр, эд мөрийн баримт цуглуулах нэгж (мэргэжилтэн-мөрдөгч)-ийг бий болгох. Ингэснээр хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцож буй ШШҮХ-ийн дүүрэг дэх лабораторийн шинжээчдийн орон тоогоор ШШҮХ-ийн нарийн мэргэжлийн шинжээчдийн орон тоог өргөжүүлэх боломж олгоно. Цагдаагийн хэлтэс тус бүрт хэргийн газрын үзлэгээр ул мөр, эд мөрийн баримт илрүүлж, бэхжүүлэх чадвар бүхий 4 мэргэжилтэн буюу нийт гурван хэлтсийн хэмжээнд 12 мөрдөгчийг Дотоод хэргийн их сургуульд 3-6 сарын хугацаанд давтан сургаж, томилж ажиллуулах боломжтой.</p>			
51	<p>Цагдаагийн гурван хэлтэс тус бүрийн бүтцэд Криминалистикийн лаборатори байгуулах. Ингэснээр гэмт хэргийг халуун мөрөөр нь илрүүлэхэд мэдэгдэхүйц дэвшил гарна. Тус лаборатори мөр судлалын (гарын мөрний, хөлийн мөрний, эвдлэгч багаж, зэвсгийн), галт зэвсгийн, бичиг баримт судлалын зэрэг гол төлөв адилтгалын шинжилгээ хийхээс гадна шуурхай лавлагааны тоо бүртгэл хөтөлж, гэмт хэргийг халуун мөрөөр нь илрүүлэх, гэмт этгээдийг эрэн сурвалжлах ажиллагаанд оролцох юм.</p>			

	Цагдаагийн хэлтсүүдийн Криминалистикийн лаборатори дор дурдсан үйл ажиллагаа явуулна. Үүнд: - ул мөр, эд мөрийн баримтад криминалистикийн зарим төрлийн шинжилгээ хийх; - ам зураг гаргах; - гарын хээний нэгдсэн санд мөр илгээх, хайлт хийх; - программын тусламжтайгаар хэргийн газрыг тодотгон дүрслэх;			
52	Баянзүрх дүүрэг автомашин эзэмшигчийн тоогоор нийслэлийн хэмжээнд эхний байр эзэлдэг. Үүнээс гадна зүүн бүсийн автовокзал, техникийн зах, зүүн чиглэлийн гол автозам дайран өнгөрч байгаа нь зам тээврийн осол, зөрчил өндөр байх нэг нөхцөл болдог. Дүүргийн хэмжээнд гарсан ослын 98 хувь нь жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан байх бөгөөд хурд хэтрүүлэх явдал багагүй хувийг эзэлж байна. Иймд эхний ээлжинд Баянзүрх дүүрэгт бүртгэлтэй автомашинуудыг чиптэй болгож (автомашин салхины шилэнд наадаг оношлогооны наалтыг чиптэй болгох), зарим чиглэлийн зам дагуу хүлээн авагч антенн суурилуулж турших. Ингэснээр автомашины хурдыг тодорхойлох, үзлэг оношлогоонд орсон эсэхийг шалгах, хулгайлагдсан машины байршлыг тогтоох зэрэг мэдээлэл авах боломжтой болно. Улмаар туршилтын үр дүнг харгалзан нийслэл, улсын хэмжээнд шинэ технологи нэвтрүүлэх эхлэл болох юм.			
Долоо. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр:				
53	Баянзүрх дүүргийг хөгжүүлэх бодлогын хүрээнд зам, замын дэд бүтцийн хөгжлийг мэргэжлийн байгууллагаар төлөвлөлт хийлгэж, замын түгжрэл үүсэхгүй байх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах бодлого баримтлан хэрэгжүүлэх;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ТЦА	УИХ, ЗГ, Нийслэлийн ИТХ-д танилцуулах
54	Зам тээврийн осол, хэрэг гарсан тохиолдолд даатгалаар зохицуулалт хийх, үнэлгээ болон даатгалын зохицуулалтыг бодлого тодорхойлох түвшинд танилцуулж, эрх зүйн орчныг боловсронгуй болгуулах;	2020-2024 он	Дүүргийн ТЦХ, ТЦА	УИХ, ЗГ, Нийслэлийн ИТХ-д танилцуулах
55	Нэг дуудлагад дунджаар 23.1 минут зарцуулж байгаагаас 11.2 минутыг хэмжилт хийхэд зарцуулж байна. Мэргэшсэн алба хаагчийг бүсийн байцаагчаар ажиллуулах шаардлагатай байна. Шинэ ажиллаж байгаа байцаагч автомашин жолоодох үедээ богино долгионы станцаар ярих, дуудлага мэдээлэл авах зэрэг хүндрэлтэй нөхцөлд ажиллахаар тэвдэх, стресст орох үүний улмаас ажлаас халшрах шинж илэрч байна. Мөн хэргийн газарт хэмжилт хийх, автомашинд үзлэг хийх, эд мөрийн баримтыг хамгаалах, замын хөдөлгөөн зохицуулахад 2 алба хаагч үүрэг гүйцэтгэх шаардлагатай. Бүсэд нэг байцаагч ажилласнаар цагдаагийн алба хаагч өөрөө замын хөдөлгөөний дүрэм зөрчих байдал ажиглагдаж байгаа бөгөөд ХЗДХ-ийн сайдын 2019 оны А/101 дугаар тушаалаар баталсан “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам”-ыг зөрчиж үүрэг гүйцэтгэж байна. Иймд Замын цагдаагийн хэлтсийн орон тоог нэмэгдүүлэх;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ТЦХ	Нийслэлийн ИТХ, ЗДТГ, ТЦА
56	Баянзүрх дүүргийн зам тээврийн осол, хэргийн гаралт, дуудлага, мэдээллийн ачааллыг харгалзан, шуурхай байдлыг хангах үүднээс албаны машин, техник хэрэгслээр хангах;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ТЦХ	Нийслэлийн ИТХ, ЗДТГ, ТЦА

57	Дэлхий нийтэд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэхийн тулд урд урдаасаа мөргөлдөх, эгц хажуугаас мөргөх ослыг багасгах нь илүү үр дүнтэй аргад тооцогдож байна. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эрсдэлийн түвшинг тогтоохын тулд хэдэн огтлолцсон уулзварын хөдөлгөөнийг тойрог хэлбэрээр зохион байгуулсан гэдгийг харгалзан үздэг болжээ. Гэрлэн дохионы зохицуулгатай уулзвар автомашин мөргөлдөж болзошгүй 32 цэг байдаг бол тойрог хөдөлгөөн 8 цэгтэй байна. Тойрог хөдөлгөөн хурдыг тодорхой интервалд зохицуулж байдаг. Гэрлэн дохионы зохицуулгатай уулзвар автомашины хурдыг “0” болгодог ч гэсэн зарим тохиолдолд өсгөж байдагаараа эрсдэлтэй их байдаг. Мөн замын дагуу олон огтлолцолгүй болгосноор ослын тоо буурна, тойрог хөдөлгөөн дээр бага зэрэг нэмэгдэх боловч хохирол багасна. Иймд уулзваруудыг “тойрог” болгох ажлыг үе шаттай хэрэгжүүлэх.	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ТЦХ	Нийслэлийн ИТХ, ЗДТГ, ТЦА
58	ДХИС-ийн баруун урд уулзварын ачаалал нэмэгдэх тул тойрог хөдөлгөөнтэй уулзвар болгох;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ТЦХ	Нийслэлийн ИТХ, ЗДТГ, ТЦА
59	Төв зам дагуу гарц байхгүй замын дунд “арал, тусгаарлагч” хийлгэх замаар зам тээврийн ослыг бууруулах;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ТЦХ	Нийслэлийн ИТХ, ЗДТГ, ТЦА
60	Замын хажуугаар унадаг дугуйн замыг тохижуулж, ашиглалтанд хүлээж авах;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ТЦХ	Нийслэлийн ИТХ, ЗДТГ, ТЦА
61	Тээврийн цагдаагийн хэлтэст түшиглэн ДХИС-ийн сонсогч, суралцагчдын “Клиник дадлага сургалтыг явуулах байдлаар тээврийн цагдаагийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ТЦХ	ДХИС
62	Тээврийн цагдаагийн хэлтсийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шаардлагатай орон тоог нөхөх зорилгоор олон нийтийн байцаагч нарыг ажиллуулах;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ТЦХ	Нийслэлийн ИТХ, ЗДТГ, ТЦА
63	Төв байгууллагаас хэрэгжүүлж буй жолоочийн сахилга, хариуцлага, хөдөлгөөнд оролцох ухамсар, соёлыг дээшлүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах.;	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ТЦХ	Нийслэлийн ИТХ, ЗДТГ, ТЦА
64	Жолооны курсуудыг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд зохимжит байдлаар татан оролцуулах, жолооны курсын баг, суралцагч нараар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомжийг сургууль, байгууллагуудад сургалт явуулах, таниулах аян арга хэмжээг тогмол зохион байгуулах	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ТЦХ	Нийслэлийн ИТХ, ЗДТГ, ТЦА
Найм. Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр:				
65	Агаарын бохирдлоос үүдэлтэй хүн амын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр: Цэцэрлэг сургууль болон сургуулийн дотуур байрны халаалтыг цэвэр түлшинд (шингэрүүлсэн хийн түлш, нийлэг шатдаг хий, шингэрүүлсэн байгалийн хийн түлш болон байгалийн шахсан хий, занараас байгалийн хий, диметил эфир, төвийн халаалт, цахилгаанаар халаах) шилжүүлэх замаар хүүхдийн агаарын бохирдлын өртөлтийг бууруулах. Иймд Цэцэрлэг, сургуулиудад НЕРА шүүлтүүрийг агааржуулалтын хоолойнд суурилуулах.	2020-2024 он	Дүүргийн ИТХ, ЗДТГ	Мэргэжлийн хяналт, ОБХ
66	Агаарын бохирдлыг бууруулахад нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд шаардагдах зардал, агаарын бохирдлыг бууруулах дарамт шахалтаас	Байнга	Дүүргийн ИТХ, ЗДТГ, Эрүүл	ОБХ, Нийгмийн ажилтан нар

	<p>ангижрахын тулд хэрэгжүүлэх стратегийн арга хэмжээнүүдийг цаг алдалгүй хэрэгжүүлэх;</p> <p>-Өрхийн эмнэлгийн түвшинд уушгины хатгалгааг эмчлэх, вакцинжуулах замаар уушигны хатгалгааны тохиолдлыг бууруулах;</p> <p>-Агаарын бохирдлоос үүдсэн өвчний эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах: 6 сар хүртэл хүүхдийг дан хөхөөр хооллох; хоол тэжээлийн дутал, цайрын дутлыг илрүүлж нөхөх;</p> <p>-ЕБС-ийн хичээлийн хөтөлбөрт агаарын бохирдол-эрүүл мэндийн талаарх мэдээллийг суулгаж өгсөнөөр гэр хороололд оршин суудаг хүүхдүүд цэвэр түлшний хэрэглээ, агаарын бохирдлын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөний талаар мэдлэгтэй болох улмаар мэдээлэл, мессэжийг эцэг, эхчүүдээ дамжуулан түгээх боломжтой;</p> <p>-Судалгаа болон агаарын чанарыг сайжруулахад чиглэгдсэн бодлогын хэрэгжилтийн үр нөлөөний үнэлгээ хийх хүний нөөц, тоног төхөөрөмж, арга зүйг хөгжүүлэх;</p> <p>-Агаарын бохирдлыг ДЭМБ-ын агаарын чанарын зөвлөмжид заасан түвшинд хүртэл бууруулж, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулахад яамд болон олон улсын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах;</p> <p>-Агаарын бохирдол үүсгэж буйг торгох бус харин агаарын бохирдлыг бууруулахад дэмжлэг үзүүлсэн хувь хүн, өрх гэр, албан байгууллагыг урамшуулах, хөхүүлэн дэмжих механизмыг эрчимжүүлэх;</p> <p>-Агаарын бохирдлын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнээс үрьдчилан сэргийлэх, эрчим хүчний хэмнэлттэй техник технологи хэрэглэх талаар хүн амд мэдлэг олгох мэдээлэл, сургалт сурталчилгааны компани ажлыг бусад салбарын оролцоотойгоор хамтран зохион байгуулах;</p> <p>-Гэр хорооллын өрхөд агаарын бохирдол ихтэй үед авах арга хэмжээний тогтолцоо бүрдүүлэх, иргэдийг сэрэмжлүүлэх;</p>		<p>мэндийн төв, Болвсролын хэлтэс, Хороод</p>	
67	<p>Хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр:</p> <p>Гэр хорооллын бүсэд үйл ажиллагаа эрхэлдэг албан байгууллагуудад стандартын бус ариун цэврийн байгууламж хэрэглэхгүй байх, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, тэдгээрийг цуглуулах, хадгалах, устгах байгууламж байгуулах;</p>	<p>Байнга</p>	<p>Дүүргийн ИТХ, ЗДТГ, Эрүүл мэндийн төв, Болвсролын хэлтэс, Хороод</p>	<p>ОБХ, Нийгмийн ажилтан нар</p>
68	<p>“Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах” үндэсний хөтөлбөрт хөрсний бохирдлын тандалтын тогтолцоог бэхжүүлэх, эргэн мэдээллэх боломжийг нэмэгдүүлэх талаар оруулах.</p>	<p>2020-2021</p>	<p>Дүүргийн ИТХ, ЗДТГ, Эрүүл мэндийн төв, Болвсролын хэлтэс, Хороод</p>	<p>ОБХ, Нийгмийн ажилтан нар</p>
69	<p>Гэр хорооллын айл өрх, албан байгууллага, нийтийн эзэмшил газар дахь нүхэн жорлон, угаадасны нүхийг стандарт шаардлагыг хангуулах, халдваргүйжүүлэх, дүүрсэн үед соруулах арга хэмжээ авахыг шаардах;</p>	<p>Байнга</p>	<p>Дүүргийн ИТХ, ЗДТГ, Эрүүл мэндийн төв, Хороод</p>	<p>Мэргэжлийн хяналт, ОБХ, Нийгмийн ажилтан нар</p>
70	<p>Авто угаалга, засварын газар, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрууд, хүнс, бараа худалдааны зэрэг худалдаа, үйлчилгээний газруудын цэвэр, стандартын</p>	<p>Байнга</p>	<p>Дүүргийн ИТХ, ЗДТГ, Эрүүл</p>	<p>Мэргэжлийн хяналт, ОБХ,</p>

шаардлага хангуулах асуудалд онцгойлон анхаарч ажиллах		мэндийн төв, Хороод	Нийгмийн ажилтан нар
--	--	---------------------	----------------------

СУДАЛГААНЫ БАГ